



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

**СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН
ЭМХЭТГЭЛ - I
(2014 ОН)**

**УЛААНБААТАР ХОТ
2015 ОН**



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

**СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН
ЭМХЭТГЭЛ - I
(2014 ОН)**



УЛААНБААТАР ХОТ
2015 ОН

DDC
363.251001 42
C-701

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

Т.Мэндсайхан	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор /Ph.D/
С.Билгүүн	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн номын сан, мэдээлэл хариуцсан ахлах референт /LL.M/
Э.Өлзийлхам	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгаа хариуцсан ахлах референт /MA, LL.M/

ЭМХЭТГЭСЭН:

Ц.Мандах	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач, хууль зүйн ухааны доктор /LL.D/
----------	---

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД:

Судлаачид:

А.Ариунболд
Ц.Ариунболд
Х.Билгүнзаяа
Ц.Мандах /LL.D/
Б.Одонгэрэл
Э.Өлзийлхам
Э.Өсөхжаргал
Г.Солонго
Т.Түмэнцэцэг
С.Энхмэнд

Шүүгчид:

Г.Алтанчимэг
Т.Ганчимэг
П.Золзаяа
Э.Лхагвасүрэн
Ж.Оюунтунгалаг /LL.D/

Цаасны хэмжээ:
Хэвлэсэн тоо:
Хэвлэлийн хуудас:
Хэвлэлийн компани:

ISBN 978-99973-2-867-0

ӨМНӨТГӨЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бүх шатны шүүхийг судалгаа, мэдээллээр хангах, шүүн таслах ажлын болон захиргааны ажлын практикийг судлах, шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг сургаж дадлагажуулах хуульд заасан чиг үүргийг нэгтгэн зохион байгуулах зорилгоор Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнг 2014 оны 4 дүгээр сард байгуулсан билээ.

Тус хүрээлэнг байгуулснаас хойш нэг жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн судалгааны ажлыг эмхэтгэн эрхэм шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд, судлаач Та бүхэнд толилуулж байна.

Шүүх судлал, салбар эрх зүй, процессын эрх зүйн чиглэлийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гарц, арга замыг тодорхойлох, шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд өнгөрсөн хугацаанд тус хүрээлэнгээс бодлогын судалгаа, зөвлөмж, лавлагаа зэрэг судалгааны ажлыг гүйцэтгэсэн бөгөөд урьд нь хэвлэгдээгүй учир шүүх эрх мэдэл, процессын эрх зүйн чиглэлийг шимтэн судалдаг, сонирхдог судлаач, ажилтнуудын хүртээл болохоос гадна энэ чиглэлээр цаашид хийгдэх гүнзгийрүүлсэн судалгааны эх сурвалж болно гэж найдаж байна.

Эмхэтгэлийг хүлээн авсан та бүхэн судалгааны ажлыг цаашид боловсронгуй болгох, сайжруулах талаарх санал, зөвлөмж, шүүмжээ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн хаягаар хүргүүлнэ үү.

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ГҮЙЦЭТГЭХ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР

Т.МЭНДСАЙХАН

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт	1
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ	1
ЦАГДАН ХОРИХ АРГА ХЭМЖЭЭГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК БА ХҮНИЙ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ	2
Нэг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь цагдан хорих арга хэмжээ	3
Хоёр. Шүүхийн практик	7
Гурав. Цагдан хорих арга хэмжээ ба хүний эрхийн тулгамдаж буй асуудал	11
Дөрөв. Гадаад улсын сайн туршлага	14
Дүгнэлт	21
ИЖИЛ ТӨСТЭЙ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	22
Нэг. Хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг	23
Хоёр. Танхайрах болон бусдын бие махбодид хүнд, хүндэтэр, хөнгөн гэмтэл санаатайгаар учруулах гэмт хэрэг	32
Дүгнэлт	37
ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ	41
ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРИЙН ҮНДЭСЛЭЛ, ТӨРӨЛ	42
Удиртгал	42
Нэг. Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, дүн шинжилгээ	42
Хоёр. Анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилсөн, хүчингүй болгосон үндэслэл, процессын зөрчил	44
Гурав. Анхан шатны шүүхийн шийдвэрт орсон өөрчлөлт, хүчингүй болсон байдлыг маргааны төрлөөр ангилах нь	47
ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЛТ БА ШҮҮГЧИЙН АЧААЛАЛ	63
Удиртгал	63
Нэг. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, статистик үзүүлэлт	63
Хоёр. Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдсэн хэргийн дүн шинжилгээ	68
Гурав. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэлт шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж байгааг шийдвэрлэх арга зам, санал, зөвлөмж	92
ХҮҮХДИЙН АСРАМЖЛАГЧИЙГ ТОГТООХ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭР	103
Удиртгал	103
Нэг. Хүүхдийн асрамжлагчийг тогтоох эрх зүйн зохицуулалт	104
Хоёр. Шүүхийн практик	110
Гурав. Хүүхдийн асрамжлагчийг тогтоох хэргийг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам	113
ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ	119
НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗАРТАЙ ХОЛБОГДОХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙН ПРАКТИК	120
Удиртгал	120
Нэг. Нийтийн эдэлбэр газрын эрх зүйн зохицуулалт, нийтийн эдэлбэр газарт холбогдсон эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа	120

Хоёр. Маргаан хянан шийдвэрлэж байгаа өнөөгийн байдал.....	131
Дүгнэлт.....	133
ШҮҮХ СУДЛАЛ	135
ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ, ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ШҮҮХИЙН ЭДИЙН ЗАСАГТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ЛАВЛАГАА	136
Нэг. Шүүхийн иргэдийн төлөөлөгч: Тайваний шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцооны хэтийн төлөв.....	136
Хоёр. Шүүгчийн сонгон шалгаруулалт: Шүүгчийн сонгон шалгаруулалтад жендэрийн харьцааг харгалздаг олон улсын туршлага.....	141
Гурав. Шүүхийн төсөв: Шүүхийн төсвийг боловсруулж, батлуулж байгаа гадаад орны туршлага.....	147
Хавсралт	153
“Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь цагдан хорих арга хэмжээ ба хүний эрх, тулгамдсан асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмж	153



Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АИХ	Ардын Их Хурал
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
ЗХХШТХ	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУЭШ	Олон улсын эрүүгийн шүүх
ОХУ	Оросын Холбооны Улс
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
ФСЭЗХ	Философи, социологи, эрх зүйн хүрээлэн
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ШСМСХ	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн
ШУА	Шинжлэх ухааны академи
ЭБША	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭПХ	Эрүүгийн процессын хууль (ХБНГУ)



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ



ЦАГДАН ХОРИХ АРГА ХЭМЖЭЭГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК БА ХҮНИЙ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ¹

“Цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэж буй шүүхийн практик ба хүний эрхийн хэрэгжилт” сэдэвт бодлогын судалгааны хүрээнд цагдан хорих арга хэмжээг авах үндэслэл, эрх зүйн зохицуулалт, 2013-2014 онд цагдан хорих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн шүүхийн статистик мэдээ, шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн дунд явуулсан санал асуулга² зэрэгт дүн шинжилгээ хийж, хүний эрхийн тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлсон. Олон улсын сайн туршлагыг АНУ болон ХБНГУ зэрэг улсын жишээн дээр судалж, Монгол Улсад нэвтрүүлж болох санал, зөвлөмжийг боловсруулсан болно.

Удиртгал

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны /ЭБША/ үе шат бүрт хүний эрхийг хангаж, хамгаалах шаардлага тулгамддаг. Учир нь ЭБША-ны нэг талд яллах чиг үүрэгтэй прокурор тэргүүтэй төрийн албадлагын аппарат, нөгөө талд гэм буруутай болохыг нь шүүх тогтоогоогүй цагт гэм буруугүйд тооцогдох Үндсэн хуульд тунхагласан зарчмаас өөр бараг хамгаалалтгүй шахам иргэн байгаа тэнцвэргүй нөхцөлд явагддаг.³ Монгол Улс шинэ Үндсэн хуулиа баталж, эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах зорилтыг дэвшүүлснээс хойш энэ чиглэлд хууль тогтоомжийн хүрээнд болон хуулийн байгууллагын үйл ажиллагааны практикт багагүй өөрчлөлт, шинэчлэлийг хийж байгаа хэдий ч ЭБША-д хүний эрх зөрчигдөх асуудал гарсаар байна.

Цагдан хорих арга хэмжээ нь хүний халдашгүй, чөлөөтэй байх салшгүй эрхийг хөнддөг тул энэ арга хэмжээг авахад үндэсний төдийгүй олон улсын төвшинд эрх зүйн хамгаалалт тогтоодог. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 болон 10.3 дахь хэсэгт Монгол Улс “олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”, “олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, “олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус заасан. Монгол Улс одоогийн байдлаар 40 гаруй хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, үүргээ шударгаар биелүүлэх ёстой. Тухайлбал, НҮБ-ын 1945 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 9 дүгээр зүйлд “Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй”, 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт /ИУТЭОУП/-ын⁴ 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “...Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй” гэж заасан. Түүнчлэн НҮБ-аас гаргасан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр

¹ Тус судалгааг ШЕЗ-ийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгаа хариуцсан ахлах референт Э.Өлзийлхам, судалгаа хариуцсан референт Х.Билгүнзаяа, судлаач А.Ариунболд нар гүйцэтгэсэн болно.

² Тус судалгаанд нийт 142 шүүгч, прокурор, өмгөөлөгч буюу нийслэлийн болон орон нутгийн 66 шүүгч, нийслэлийн 46 прокурор, 30 эрүүгийн хэргийн өмгөөлөгч хамрагдсан.

³ ХЗҮХ, “Эрүүгийн байцаан шийтгэх хууль дахь шүүхээс хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах талаарх зохицуулалт” судалгаа, 18 дахь тал.

⁴ Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан.

хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц"-д Монгол Улс 2002 онд нэгдэн орсон бөгөөд НҮБ-ын гишүүн орны хувьд НҮБ-аас 1988 онд баталсан "Цагдан хорих болон хорих ял эдэлж байгаа хүмүүсийг хамгаалах зарчмууд" -ыг⁵ дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Цагдан хорих арга хэмжээг гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу авах асуудлыг Монгол Улс Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, цагдан хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэж баталгаажуулжээ.

Иймд цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хүний эрхийг дээдлэн, олон улсын болон дотоодын хууль тогтоомжийг чандлан сахиж, зайлшгүй шаардлагатай тохиолдолд л цагдан хорих арга хэмжээг авч, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хязгаарлах ёстой.⁶ Бусдын халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдах үндэслэл нь, нэгдүгээрт, тухайн этгээд Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн газар дээрээ баригдсан, хоёрдугаарт, гэмт хэрэг үйлдсэн байж болох хангалттай сэжиглэл байгаа, гуравдугаарт, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон байх явдлууд болно. Эдгээр үндэслэлүүд байгаа нь хангалттай тогтоогдоогүй нөхцөлд "байж магадгүй" гэсэн хардалтаар бусдын халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдаж хэрхэвч болохгүй. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдах эрх бүхий албан тушаалтан хангалттай үндэслэл байгаа нөхцөлд халдах ажиллагааг хийхдээ гагцхүү хуулиар тогтоосон журмыг чанд баримтлах үүрэгтэй байдаг.⁷

Нэг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь цагдан хорих арга хэмжээ

1.1. Цагдан хорих арга хэмжээ авах үндэслэл, эрх зүйн зохицуулалт

ЭБША нь гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зохих ял шийтгэлийг оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангах зорилготой. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах нь төрийн хүсэл зориг давамгайлсан албадлагын (императив) шинжтэй байдаг тул энэ арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хүний эрх хөндөгдөж байдаг. Гэтэл Үндсэн хуулиар баталгаажуулсан халдашгүй, чөлөөтэй байх эрх нь хэн боловч дур мэдэн халдаж болохгүй туйлын эрх болно.⁸ Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг гагцхүү хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын санал болгосноор шүүгчийн захирамжаар хуульд заасан хугацаанд нийгмээс тусгаарлаж, хүний эрх, эрх чөлөөний зарим хэсгийг тодорхой хугацаагаар хязгаарлаж байгаа албадлагын арга хэмжээ болдог.⁹

⁵ UN Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention or Imprisonment.

⁶ Henry.F. Fradella "Criminal procedure for the criminal justice professional" 2012. p.60-70.

⁷ Г.Совд, "Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх" Харьцуулсан эрх зүй, Улаанбаатар, 1999 он. 52 дахь тал.

⁸ Мөн тэнд, 51 дэх тал.

⁹ Д.Ширэндэв, "Цагдан хорих ТСАХ-г хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал" магистрын дипломын ажил, Улаанбаатар, 2012 он. 20 дахь тал.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль /ЭБШХ/-ийн 68 дугаар зүйлд цагдан хорих арга хэмжээ, түүнийг авах үндэслэл, журмыг, 69 дүгээр зүйлд цагдан хорьж мөрдөх хугацаа, түүнийг сунгах журмыг хуульчилж зохицуулсан. Энэ зохицуулалтын дагуу Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно.¹⁰ Харин хүндэвтэр гэмт хэргийн хувьд өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн бол цагдан хорьж болохоор заажээ.¹¹

ЭБША дахь цагдан хорих арга хэмжээг гагцхүү шүүх эцсийн шийдвэрийг гаргаж авах бөгөөд ЭБШХ-д заасан үндэслэл, шаардлага байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих газар, үндэслэлийг тодорхой заасан тогтоол үйлдэж, прокурорт танилцуулна. Прокурор нь шүүхэд танилцуулна.¹² Шүүгч шаардлагатай гэж үзсэн, эсхүл өмгөөлөгч хүсэлт гаргасан бол өмгөөлөгч, прокурорыг байлцуулан сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих эсэх асуудлыг шийдвэрлэж нэн даруй захирамж гаргадаг. Шүүгч цагдан хорихоос татгалзсан бол сэжигтэн, яллагдагчийг дахин цагдан хорих саналыг гагцхүү цагдан хорих шинэ үндэслэл, шалтгаан бий болсон тохиолдолд шүүхэд ирүүлнэ. Цагдан хорих нь гагцхүү өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг авах боломжгүй тохиолдолд хэрэглэдэг, ЭБШ албадлагын эцсийн арга хэмжээ юм.¹³ НҮБ-ын Хүний эрхийн хорооноос “сэжигтэн оргон зайлах, нотлох баримтыг устгах, гэрчид нөлөөлөх, эсвэл гишүүн орны нутаг дэвсгэрийн харьяаллаас зугтах өндөр магадлалтай байгаа онцгой тохиолдолд цагдан хорих арга хэмжээг авч, харин бусад тохиолдолд сэжигтнийг батлан даалтад гаргах шаардлагатай” гэж онцолсон байна.

1.2. Цагдан хорьж мөрдөх хугацаа

Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорьж мөрдөх хугацааг гэмт хэргийн ангиллаас хамаарч харилцан адилгүй хуульчилж өгсөн. Сэжигтнийг цагдан хорьж мөрдөх хугацаа 14 хоног бөгөөд үүнд баривчлагдсан хоногийг оруулан тооцно. Яллагдагчийг хорьж мөрдөх үндсэн хугацаа 2 сар хүртэл байдаг бөгөөд энэ хугацаанд сэжигтнээр цагдан хоригдсон хоногийг мөн оруулан тооцдог. ЭБШХ-д хэргийн ээдрээ, төвөгтэй байдлыг харгалзан хорьж мөрдөх хугацааг сунгах зохицуулалтыг заасан. Тухайлбал, яллагдагчийг хорьж мөрдөх хугацааг сунгахдаа хүндэвтэр гэмт хэрэгт 4 сараас, хүнд гэмт хэрэгт 12 сараас, онц хүнд гэмт хэрэгт 24 сараас хэтрүүлж болохгүй. Эрүүгийн хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2,¹⁴ 84 дүгээр зүйл,¹⁵ 91 дүгээр зүйлийн 91.2,¹⁶ 145

¹⁰ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.1.

¹¹ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.2.

¹² Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.3.

¹³ Б.Ганболд, “Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй”, Улаанбаатар, 2008 он. 322 дахь тал.

¹⁴ Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах

¹⁵ Хорлон сүйтгэх

¹⁶ Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах

дугаар зүйлийн 145.4,¹⁷ 177 дугаар зүйлийн 177.2,¹⁸ 302 дугаар зүйлд¹⁹ заасан гэмт хэргийн яллагдагчийг ЭБШХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэгт заасан хугацаанаас илүү хугацаагаар хорьж мөрдөх шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно.²⁰ Эндээс үзвэл ЭБШХ-д заасны дагуу хорьж мөрдөх нийт хугацаа дээд тал нь 30 сар байх боломжтой юм.

Хүснэгт 1. Цагдан хорьж мөрдөх үндсэн болон дээд хугацаа

№	Хугацаа	Сэжигтэн	Яллагдагч	Насанд хүрээгүй этгээд
1.	Үндсэн хугацаа	14 хоног	2 сар	1 сар
Хорьж мөрдөх дээд хугацаа				
2.	Хөнгөн гэмт хэрэг	-	-	-
3.	Хүндэвтэр гэмт хэрэгт	-	4 сар	2 сар
4.	Хүнд гэмт хэрэг	-	12 сар	4 сар
5.	Онц хүнд гэмт хэрэг	-	24 сар	8 сар

Хорьж мөрдөх хугацааг сунгах тохиолдолд мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө прокурорт хүргүүлж, прокурор шүүгчид танилцуулна.²¹ Шүүгч 72 цагийн дотор захирамж гаргах бөгөөд хорьж мөрдөх хугацааг сунгахдаа нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.²² 2014 онд улсын хэмжээнд цагдан хорих хугацааг сунгах тухай 3228 шүүгчийн захирамж гарсан нь өмнөх онтой харьцуулахад 12.3 хувиар буурсан бол цагдан хорих хугацааг сунгахдаа татгалзах тухай 114 шүүгчийн захирамж гарсан нь өмнөх онтой харьцуулахад 16.3 хувиар өссөн байна.²³

Энэ бодлогын судалгааны ажлын хүрээнд цагдан хорих арга хэмжээ авахтай холбоотой нийт 99 прокурорын санал, 117 шүүгчийн захирамжийг судалсан бөгөөд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих хугацааг сунгах саналыг гаргахдаа мөрдөн байцаагч, прокурор нь шүүгчид хугацаа хэтрүүлэн танилцуулдаг тохиолдол ажиглагдсан тул цаашид хууль сахиулагчид хуулийн хугацааг чандлан сахих шаардлагатай байна. Мөн түүнчлэн судалгаанаас харахад зарим тохиолдолд цагдан хорих нийт хугацаа 30 сар болсон хэдий ч мөрдөн байцаалт болон прокурорын хяналтын шатанд хугацаа дуусахаас 3-7 хоногийн өмнө шүүхэд хэргийг шилжүүлдэг, шүүх түүнийг үргэлжлүүлэн хорих шийдвэр гаргадаг хирнээ шүүхийн хорьсон хугацааг

¹⁷ Хүний хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлах

¹⁸ Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар зандалчлах

¹⁹ Төрлөөр устгах

²⁰ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4.

²¹ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5.

²² Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 69 дүгээр зүйлийн 69.6.

²³ Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, Монгол Улсын шүүхийн тайлан (2014 он), Улаанбаатар, 2015 он. 197 дахь тал.

цагдан хоригдсон 30 сарын хугацаанаас гадуур тооцож,²⁴ яллагдагчийг үргэлжлүүлэн цагдан хорьсон тохиолдлууд байгаа тул хууль сахиулагчид ЭБШХ-д заасан цагдан хорих дээд хугацааг чанд баримтлах шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

Шүүгч цагдан хорих тухай шийдвэр гарсан тохиолдолд энэ тухай сэжигтэн, яллагдагчийн гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн эсхүл өмгөөлөгчид 24 цагийн дотор мэдэгдэх үүрэгтэй. Шүүхийн практикт энэ асуудлыг шүүгч өөрийн захирамжид зааж, мөрдөн байцаагч, хяналтын прокурорт биелүүлэхийг даалгадаг. Шүүгч цагдан хорихоос татгалзсан бол сэжигтэн, яллагдагчийг дахин цагдан хорих саналыг зөвхөн цагдан хорих шинэ үндэслэл, нөхцөл бий болсон тохиолдолд шүүхэд ирүүлнэ.²⁵ Харин өмнө ирсэн тогтоолд тусгагдсан үндэслэлээр цагдан хорих асуудлыг дахин авч хэлэлцэхгүй. Шүүгч цагдан хорих хугацааг сунгах тухай саналыг 72 цагийн дотор хянаж, цагдан хорих хугацааг сунгасан, эсхүл сунгахыг татгалзсан захирамж гаргана. Судалгаанд яллагдагчийг шүүхээс тэнсэн харгалзах хугацаанд дахин гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдэхээс сэрэмжлэх, мөрдөн байцаалтаас оргон зайлж болзошгүй, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах зэргээс сэрэмжлэх зорилгоор шүүгч яллагдагчийн хорьж мөрдөх хугацааг сунгах тухай захирамжийг гаргасан байна.

1.3. Гомдол гаргах, хянан шийдвэрлэх

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.12 дахь хэсэгт иргэд “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэж заажээ. ЭБШХ-ны үед оролцогч нь тодорхой байцаан шийтгэх ажиллагаа явуулах, хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоох, түүнчлэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхэд гаргах эрхтэй.²⁶ Цагдан хорих арга хэмжээ авах, хүчингүй болгох, өөрчлөх талаар гаргасан шүүхийн шийдвэрт тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид, түүний эзгүйд томилсон шүүгчид гомдол гаргаж болно гэж заажээ. Ерөнхий шүүгч болон түүний томилсон шүүгч 48 цагийн дотор шийдвэрээ гаргах бөгөөд түүнд дахин гомдол гаргах эрхгүй байдаг.²⁷ 2014 онд улсын хэмжээнд 230 цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжид гарсан гомдлыг хянан шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 7.5 хувиар өссөн дүнтэй байна.²⁸

Судалгааны ажлын хүрээнд Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг авч үзэхэд прокурорын талаас өмгөөлөгчийн зүгээс дэвшүүлж буй гомдлын хууль зүйн үндэслэлд ямар хариу өгсөн нь тодорхойгүй, “шүүгчийн захирамж нь хууль ёсны тул хэвээр үлдээх саналтай байна” гэсэн томъёоллоор гаргасан байгаа нь шүүхээс хэрхэн мэтгэлцэх зарчмыг хангасан нь тодорхойгүй байна. Ихэнх тохиолдолд Ерөнхий

²⁴ Г.Оюунболд, “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ: уламжлал, шинэчлэл”, *Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь цагдан хорих арга хэмжээ ба хүний эрх, тулгамдсан асуудлууд* сэдэвт хэлэлцүүлэгт тавьсан илтгэл, 2014 он.

²⁵ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.5.

²⁶ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.

²⁷ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 114 дүгээр зүйлийн 114.2, 114.3.

²⁸ Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, Монгол Улсын шүүхийн тайлан (2014 он), Улаанбаатар, 2015 он. 197 дахь тал.

шүүгчээс цагдан хорих тухай захирамжийг хэвээр үлдээсэн байгаа бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт ямар үндэслэлээр шийдвэрийг гаргасныг тодорхой дурдах шаардлагатай байна. Ингээгүй тохиолдолд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хязгаарлалтыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийгдсэн гэдэг ойлголтыг сэжигтэн, яллагдагчид төдийлөн өгч чадахгүй байгааг цаашид онцгой анхаарах шаардлагатай байна.

Хоёр. Шүүхийн практик

2.1. Шүүхээс цагдан хорих арга хэмжээ авсан статистик мэдээ, дүн шинжилгээ²⁹

2014 онд улсын хэмжээнд нийт 3721 хүнийг цагдан хорьсон нь өмнөх оноос 111 хүнээр буюу 3.1 хувиар өссөн байна.³⁰ Цагдан хоригдсон хүмүүсээс 1815 хүн нь сэжигтэн, 1906 хүн нь яллагдагч байгаа бол 106 насанд хүрээгүй этгээд, 176 эмэгтэй хүн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад сэжигтнээр цагдан хоригдсон хүмүүсийн тоо 174 хүн буюу 8.7 хувиар, насанд хүрээгүй этгээдийн тоо 26 хүн буюу 19.7 хувиар тус тус буурсан бол яллагдагчаар цагдан хоригдсон хүмүүсийн тоо 285 хүн буюу 17.6 хувиар, эмэгтэйчүүдийн тоо 25 хүн буюу 16.6 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Харин шүүхийн шатанд 323 хүн цагдан хоригдсон нь өмнөх оноос 153 хүн буюу 90 хувиар өссөн байна. /Хүснэгт 2/

Хүснэгт 2. Цагдан хоригдсон хүмүүсийн тоон мэдээ

Он	Цагдан хорих зөвшөөрөл олгосон хүний тоо	Үүнээс				Цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан хэдэн хүний хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хэрэгсэхгүй болгосон	Үүнээс ЭБШХ-ийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгосон	Шүүхийн шатанд цагдан хоригдсон хүний тоо
		Сэжигтэн	Яллагдагч	Насанд хүрээгүй	Эмэгтэй				
2013	3610	1989	1621	132	151	267	-	-	170
2014	3721	1815	1906	106	176	250	3	2	323

2014 онд улсын хэмжээнд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай 3870 шүүгчийн захирамж гарсан нь өмнөх онтой харьцуулахад 7.4 хувиар өссөн байна. Мөн онд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай 225 шүүгчийн захирамж гарсан нь өмнөх онтой харьцуулахад 5.5 хувиар буурсан байна. Харин сэжигтэн, яллагдагчийг өөр газар шилжүүлэн цагдан хорихоос татгалзсан тухай шүүгчийн захирамж гараагүй байна. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй

²⁹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ нь эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааны дүн мэдээг улирал тутам гаргадаг бол баривчлах, цагдан хорих арга хэмжээ авсан тухай мэдээг хагас жил тутам гаргаж байна.

³⁰ Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, Монгол Улсын шүүхийн тайлан (2014 он), Улаанбаатар, 2015 он. 196 дахь тал.

болгох тухай шүүгчийн захирамж өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн дүнтэй байна. /Хүснэгт 3/

Хүснэгт 3. Цагдан хорих арга хэмжээг авахтай холбоотой гаргасан шүүгчийн захирамж

№	Утга	2013 он	2014 он
1.	Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай	3603	3870
2.	Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай	238	225
3.	Сэжигтэн, яллагдагчийг өөр газар шилжүүлэн цагдан хорих тухай	124	110
4.	Сэжигтэн, яллагдагчийг өөр газар шилжүүлэн цагдан хорихоос татгалзах тухай	4	0
5.	Цагдан хорих хугацааг сунгах тухай	3681	3228
6.	Цагдан хорих хугацааг сунгахаас татгалзах тухай	98	114
7.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох тухай	41	85
8.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх тухай	1368	1361
9.	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжид гарсан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай	214	230

2014 онд улсын хэмжээнд цагдан хорьсон үндэслэлүүдийг өмнөх онтой харьцуулахад “онц хүнд гэмт хэрэг үйлдсэн” 6.6 хувиар, “хүнд гэмт хэрэг үйлдсэн” 5.4 хувиар, “онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн” 77.8 хувиар, “оргон зайлсан” 6.9 хувиар, “оргон зайлж болзошгүй” гэсэн үндэслэл 6.7 хувиар буурсан дүнтэй байгаа бол “удаа дараа гэмт хэрэг үйлдсэн” 53 хувиар, “өмнө авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн” гэсэн үндэслэл 12.2 хувиар тус тус өссөн байна. /Хүснэгт 4/

Хүснэгт 4. Цагдан хорих зөвшөөрөл олгосон үндэслэл

№	Үндэслэл	2013 он	2014 он
1.	Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн	686	641
2.	Хүнд гэмт хэрэг үйлдсэн	846	800
3.	Удаа дараа гэмт хэрэг үйлдэж байсан	181	277
4.	Онц аюултай гэмт хэрэгтэн хэрэг үйлдсэн	18	4
5.	Өмнө авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн	164	184
6.	Оргон зайлсан	204	190
7.	Оргон зайлж болзошгүй	1620	1512

Шүүхээс цагдан хорих арга хэмжээ авч байгаа үндэслэлүүдээс “оргон зайлж болзошгүй” гэсэн үндэслэл 1512 байгаа нь нийт цагдан хоригдсон хүмүүсийн 40.6 хувийг эзэлж байна. “Оргон зайлж болзошгүй” гэсэн үндэслэлийг нарийвчлан тодорхойлсон тодорхойлолт, хуулийн тайлбар үгүйлэгдэж байна. Гэтэл энэ үндэслэл нь практикт хэт субъектив байдлаар шийдвэрлэгддэг гэж зарим судлаачид шүүмжилж байна. Тухайлбал, хууль зүйн ухааны доктор Д.Баярсайхан “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оргон зайлж болзошгүй гэсэн үндэслэл нь хэт субъектив бөгөөд хэнийг баривчлах, хэнийг цагдан хорих эсэх асуудал нь бараг үзэмжийн гэж ойлгоход хүргэдэг”³¹ гэж үзсэн байна. Мөн зарим үндэслэл, тухайлбал, “удаа дараа гэмт хэрэг үйлдэж байсан” этгээдийг шууд цагдан хорьж байгаа нь сэжигтэн, яллагдагчийн урьд ял шийтгүүлсэн байдал нь хүндрүүлэх нөхцөл болж байдгийн илэрхийлэл бөгөөд энэ

³¹ Д.Баярсайхан, “Эрх зүйн сэтгэлгээний орчин цагийн асуудал” Улаанбаатар, 2012 он. 81 дэх тал.

нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэх Эрүүгийн хуулийн зарчмыг алдагдуулахад хүргэж байна.³²


Цагдан хорих арга хэмжээг авах тухай 117 шүүгчийн захирамжийг цагдан хорих үндэслэл, хэргийн төрлөөр ангилан судлахад сэжигтэн, яллагдагчийг 40 буюу 34.2 хувь нь хүндэвтэр гэмт хэрэгт, 43 буюу 36.8 хувь нь хүнд гэмт хэрэгт, 34 буюу 29.1 хувь нь онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан цагдан хорьсон байна. Хүндэвтэр гэмт хэрэгт сэжиглэгдэн цагдан хоригдож байгаа хүмүүсийн дийлэнх нь Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2, 148 дугаар зүйлийн 148.2, 181 дүгээр зүйлийн 181.2.1, 192 дугаар зүйлийн 192.1 дэх хэсэгт заасан өмчлөх эрх, нийгмийн аюулгүй байдал болон хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон байгаа бол онц хүнд гэмт хэргийн хувьд Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэгт заасан хүнийг санаатай алах гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчид эзэлж байна. Сэжигтэн, яллагдагчаар цагдан хорьж байгаа үндэслэлд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргон зайлж болзошгүй болон дахин гэмт хэрэг үйлдэхээс сэрэмжлэх зорилготой гэсэн үндэслэлүүдийг дурдсан байна.

2.2. Цагдан хорих арга хэмжээний талаарх шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн дунд явуулсан санал асуулгын дүн

Цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлэх явцад учирч буй бэрхшээлийг тодорхойлох үүднээс нийт 142 шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн дунд судалгаа явуулсан ба судалгаанд оролцогчдын 66 буюу 46.5 хувь нь шүүгч, 46 буюу 32.4 хувь нь прокурор, 30 буюу 21.1 хувь нь өмгөөлөгч байсан. Санал асуулгаар “ЭБША дахь цагдан хорих арга хэмжээ авч байгаа тогтолцоог өөрчлөн сайжруулах шаардлагатай юу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 81 хувь нь “тийм” гэж хариулсан бол 14.1 хувь нь “үгүй”, 4.9 хувь нь “мэдэхгүй” гэж хариулсан байна. Цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлж байгаа практикийг боловсронгуй болгохын тулд нэн тэргүүнд авах ёстой арга хэмжээг 42.3 хувь нь “цагдан хорих арга хэмжээний процессын тодорхойгүй байдлыг сайжруулах”, 28.5 хувь нь “хууль, эрх зүйн орчинг шинэчлэх хэрэгтэй” гэжээ. /График 1/ Үүнээс үзэхэд өнөөгийн цагдан хорих арга хэмжээ авч буй үндэслэл, процесс ажиллагааг шинэчлэн, өөрчлөх нь зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд энэ арга хэмжээг хууль, эрх зүйн орчинг шинэчлэхээс эхлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

³² Г.Оюунболд, “Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд ОУЭЗ-н зарчмууд” Шүүх эрх мэдэл (2014 он, №3), 86 дахь тал.

График 1. Асуулт 2: “Цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлж байгаа практик, тогтолцоог боловсронгуй болгохын тулд нэн тэргүүнд авах ёстой ямар арга хэмжээ байна вэ?”



Цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлэхэд сэжигтэн, яллагдагчийн өмгөөлүүлэх эрх болон мэтгэлцэх зарчмын хэрэгжилтийг зөвхөн шүүхийн шатанд хэрэгжиж байна гэж 34.8 хувь, хангалтгүй хэрэгжиж байна гэж 45.7 хувь нь үзсэн нь шүүх цагдан хорих арга хэмжээг авахдаа сэжигтэн, яллагдагчийн байцаан шийтгэх ажиллагаан дахь эрхийн хэрэгжилтийг бүрэн хангах үүднээс давхар хяналт тавьж, зөвхөн яллах талын бус өмгөөлөх талын хүсэлт, тайлбарыг сонсон шүүхийн өмнөх шатанд мэтгэлцэх зарчмын хэрэгжилтийг бүрэн хангах шаардлагатай гэдгийг харуулж байна. /График 2/

График 2. Асуулт 3: “Цагдан хорих арга хэмжээг гүйцэтгэх явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрх, мэтгэлцэх зарчмын хэрэгжилт хэр хангагдаж байна вэ?”



Судалгаанд оролцогчдын 62.4 хувь нь цагдан хорих арга хэмжээг ногдуулахад хэрэглэж буй түгээмэл үндэслэл гэдэгт “оргон зайлж болзошгүй” гэж үзсэн бол 16.9 хувь “өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн”, 10.3 хувь нь “удаа дараа ял шийтгэгдэж байсан”, 9.6 хувь нь “онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэг

үйлдсэн” зэрэг үндэслэлүүдийг тус тус сонгосон байна. Судалгаанд оролцогчдын 64.8 хувь нь оргон зайлж болзошгүй гэдэгт “тодорхой оршин суух хаяггүй”, 26.6 хувь нь “удаа дараа гэмт хэрэг үйлдэж байсан”, 8.6 хувь нь “оршин суух хаягийн шилжилтийг эрх бүхий албан тушаалтанд мэдэгдээгүй” гэж үзсэн байна. /График 3/ Гэсэн хэдий ч энэ судалгааны хүрээнд авч үзсэн 117 шүүгчийн захирамжид “оргон зайлж болзошгүй” гэсэн үндэслэлээр цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагчийн хувьд “тодорхой оршин суух хаяггүй” гэсэн хоёр хүн, “оршин суух хаягтай боловч хаяган дээр оршин суудаггүй” гэсэн гурван хүнийг цагдан хорьсон байна. “Дэлхийн эрүүгийн процессын жишиг хууль”-ийн 177 дугаар зүйлийн 2(a)-д оргон зайлж болзошгүй гэсэн хангалттай үндэслэлийг тогтоосон тохиолдолд хэрэглэж болохоор заажээ. Иймд цаашид “оргон зайлж болзошгүй” гэсэн үндэслэлийг нарийвчлан тодорхойлж, хангалттай баримт нотолгоонд тулгуурладаг жишиг тогтоох нь цагдан хорих арга хэмжээг авахад хүний эрхийг хангаж хамгаалах нэг чухал хамгаалалт болох юм.

График 3. Асуулт 5: “ЭБШХ-д заасан “оргон зайлж болзошгүй” гэсэн үндэслэлд юу хамааруулж ойлгож байна вэ?”



Цагдан хорих арга хэмжээ нь сэжигтэн, яллагдагчид хэрэглэх эцсийн арга хэмжээ байх ёстой гэсэн олон улсын зарчим байдаг. Гэтэл одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа ЭБШХ-аар таслан сэргийлэх арга хэмжээ авах эрэмбэ, дараа байхгүй байгаагийн дээр өөр төрлийн арга хэмжээ авах боломж дутмаг байгааг эрдэмтэн, судлаачид тэмдэглэсээр байна. ЭБШХ-д нийт 5 төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авч болохоор хуульчилсан бөгөөд судалгаанд оролцогчдын 60 хувь нь ЭБШХ-д заасан таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Гурав. Цагдан хорих арга хэмжээ ба хүний эрхийн тулгамдаж буй асуудал

3.1. Цагдан хорих арга хэмжээн дэх хүний эрхийн дотоодын болон олон улсын эрх зүйн хэм хэмжээ

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хэнийг ч дур мэдэн албадан саатуулах ёсгүй гэж тунхагласан байдаг.³³ Энэ үндсэн баталгаа нь тухайн хүн гарцаагүй нотлох баримттайгаар, эсхүл хэргийн газарт үйлдэл дээрээ баривчлагдахаас бусад үед эрүүгийн хэрэгт холбогдуулан дур мэдэн хоригдохоос хамгаалсан агуулгатай юм.

³³ НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 9 дүгээр зүйл.

Хүний эрхийн суурь зарчмыг хангах үүднээс аливаа хүнийг албадан саатуулах эрх зүйн үндэслэл нь олон улсын хувьд дараах нэгдмэл байр суурьтай байдаг. Энэ байр суурь нь олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажиж, аливаа улсын дотоодын хэм хэмжээнд нөлөө үзүүлэх ёстой. Европын конвенцид хүнийг цагдан хорих үндэслэл нь дараах байдлаар илэрнэ. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуульд заасан зайлшгүй шаардлага, үндэслэлийн дагуу хязгаарлах;
- Тухайн этгээдийг гэмт хэргээ үйлдээд зугтахаар завдсан хангалттай үндэслэл байгаа үед болон эрх бүхий хуулийн байгууллагын өмнө зайлшгүй байлгах шаардлагатай тохиолдолд;
- Эрх бүхий хуулийн байгууллагад шилжүүлэх зорилгоор хуулийн дагуу саатуулсан болон насанд хүрээгүй гэмт хэрэгтнийг сургалтын байгууллагын удирдлагад хянан харгалзуулахаар саатуулах;
- Тухайн этгээдийг халдварт өвчин тараахаас урьдчилан сэргийлэх, сэтгэцийн өөрчлөлттэй, согтуу, мансууруулах бодис хэрэглэсэн болон орон гэргүй хүмүүсийг хууль ёсоор саатуулах;
- Тухайн улс руу зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэх, эсхүл тухайн улсаас албадан гаргах, шилжүүлж байгаа этгээдийн эсрэг авсан хууль ёсны саатуулах арга хэмжээ³⁴ зэрэг юм.

Дээрх үндэслэлийг шүүх хэрэглэхдээ гэмт хэрэг үйлдсэн талаар хангалттай нотолгоо, гэрчийн мэдүүлэг, үндэслэл бүхий баримтад үндэслэж аливаа этгээдийг цагдан хорих шийдвэр гаргадаг.

ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 9(2)-т зааснаар баривчлагдсан этгээд дараах эрх эдэлнэ. Үүнд:

- Хувийн эрх чөлөөг нь хязгаарлаж, баривчлах үед баривчилж байгаа үндэслэлийн талаар тайлбар авах;
- Өөрийнх нь мэддэг хэл дээр тухайн этгээдэд ямар ял тулгаж байгааг аль болох даруй мэдэгдэх буюу эхний байцаалт дээр сонсгох;
- Өөрийнх нь мэддэг хэл дээр эдгээр эрхийг нэн даруй, тодорхой таниулах зэрэг болно.

Дээрх суурь эрхийг баталгаажуулахаас гадна эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдлаас урьдчилан сэргийлж, цагдан хорих шатанд ЭБША-г зохих ёсоор явуулахын тулд процессын болон техникийн шинжтэй баталгаануудыг чанд хэрэгжүүлэх шаардлагатай.³⁵ Үүнд, цагдан хоригдож байгаа хүн нэг бүр дээр бүртгэл хөтлөх, байцаалтын тодорхой журам ба удирдамжтай байх, байцаалтын үед электрон бичлэгийн хэрэгслээр бичлэг хийх, холбогдох байгууллагууд зөвхөн албан ёсны хорих байранд хүнийг цагдан хорих зэрэг болно.³⁶

ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 9(3)-т шүүх хуралдааны өмнө суллах тухай заахдаа тухайн орны үндэсний эрүүгийн эрх зүйн тогтолцоонд альтернатив, хорихоос

³⁴ Европын Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах конвенцийн 5 дугаар зүйл.

³⁵ Г.Оюунболд, "Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ: уламжлал, шинэчлэл", *Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь цагдан хорих арга хэмжээ ба хүний эрх, тулгамдсан асуудлууд* сэдэвт хэлэлцүүлэгт тавьсан илтгэл, 2014 он.

³⁶ Мөн тэнд.

бусад хэлбэрийн арга хэмжээг авах нөхцөл бүрдсэн байна гэж заажээ. Түүнчлэн шүүхээр даруй хянуулах шаардлагын зэрэгцээ ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 9(4), Европын Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах конвенцийн 5 дугаар зүйлийн 5(4)-т шүүхээс хорих үндэслэлийг шалгах шийдвэр */writ of habeas corpus/* гаргуулах өргөдөл гаргах эрхийг баталгаажуулж, улмаар хүний эрх чөлөөг хязгаарлах явц болон эрх зүйн үндэслэлийг тодорхой хугацаанд шалгадаг нь “хорих хугацаа нь хатуу тогтоосон хязгаартай байна”³⁷ гэсэн заалтад тулгуурладаг байна.

3.2. Цагдан хорих арга хэмжээний хэрэгжилт ба хүний эрхийн зөрчил, тулгамдаж буй асуудал³⁸

ЭБША дахь албадлагын онцгой төрөл болох цагдан хорих арга хэмжээг хэрэглэхдээ хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь хүний эрхийг дээдлэн, хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх ёстой. Гэтэл цагдан хорих арга хэмжээ авч буй процесс ажиллагааг сайжруулах шаардлагатай, уг арга хэмжээ нь прокурор, шүүгчийн үзэмжийн асуудал болсон мөн эрүүдэн шүүхийн нэг хэлбэр болж байна гэсэн шүүмжлэл байсаар байна. Тухайлбал, мөрдөн байцаалтын шатанд хөндлөнгийн хяналт сул байгаагаас эрүүгийн хэргийг мөрдөн шалгах явцад харгис, хэрцгий, хүнлэг бусаар харьцах, айлган сүрдүүлэх, доромжлох, төрөл бүрээр дарамтлах, удаан хугацаагаар хорьж залхаах зэргээр эрүүдэн шүүж, хэрэг хүлээлгэх явдал байгаа тухай НҮБ-ын Эрүүдэн шүүлтийн асуудлаарх Тусгай илтгэгч тайландаа дурдсан байна.³⁹

Цагдан хорих арга хэмжээ нь таслан сэргийлэх эцсийн арга хэмжээ байх ёстой. ЭБШХ-д цагдан хорихоос бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээний төрлийг хуульчилсан. Гэтэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь сэжигтэн, яллагдагчид бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой байхад заавал цагдан хорихыг урьтал болгож байна.⁴⁰ НҮБ-ын Цагдан хоригдсон, хорих ял шийтгүүлсэн хүнийг хамгаалах тухай зарчмуудын 39-д “...цагдан хорих арга хэмжээг зөвхөн хуульд тусгайлан заасан үндэслэлийн дагуу шүүн таслах ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх, шударга ёсыг хамгаалах үүднээс хэрэглэж болно”, мөн НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайлан илтгэлийг хэлэлцсэн 2010 оны 49 дүгээр хуралдаанаас гарсан зөвлөмжид “...цагдан хорих арга хэмжээг эцсийн шатанд авах ёстой байтал нэн түрүүнд авах гээд байдаг нь Хорооны анхаарлыг татаж байна” гэж дүгнэсэн. Иймд заавал цагдан хорих биш бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах нөхцөл боломжийг нягтлан шалгаж үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

³⁷ European Court of Human Rights, *Assenov and Others vs Bulgaria* (1998.19.28).

³⁸ Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ 2014 оны 6 дугаар сарын 9-ний өдөр “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь цагдан хорих арга хэмжээ ба хүний эрх, тулгамдсан асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг Хууль зүйн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн үндэсний комисс, Монголын Хуульчдын холбооны Өмгөөлөгчдийн хороо зэрэг 10 гаруй байгууллагын төлөөлөгчдийн дунд зохион байгуулж, хэлэлцүүлгээс 12 заалт бүхий зөвлөмжийг гаргасан. (*Тус эмхэтгэлийн Хавсралтаас харна уу*)

³⁹ Н.Лүндэндорж, Ч.Өнөрбаяр, М.Батсуурь, “Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” бодлогын тойм судалгаа, Улаанбаатар, 2010 он, 22-23 дахь тал.

⁴⁰ Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл” Улаанбаатар, 2009 он. 123-147 дахь тал.

Өмгөөлүүлэх, мэтгэлцэх боломж. НҮБ-ын “Цагдан хорих болон хорих ял эдэлж байгаа хүмүүсийг хамгаалах зарчмууд”-ын 11 дүгээр зарчимд “Хэнийг ч шүүх байгууллагын өмнө нөхцөл байдлаа тайлбарлах боломж өгөхгүйгээр цагдан хорьж болохгүй. Цагдан хоригдсон этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй” гэж заажээ. ЭБШХ-д шүүгч шаардлагатай гэж үзсэн, эсхүл өмгөөлөгч хүсэлт гаргасан тохиолдолд яллах, өмгөөлөх талыг оролцуулан шүүгч шийдвэрлэхээр заасан. Гэтэл практикт сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих асуудал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын саналыг үндэслэж өмгөөлөх талын оролцоог хангалттай төвшинд хангадаггүй. Цагдан хорих асуудлыг зөвхөн мөрдөн байцаагч, прокурорын саналыг үнэлэх бус өмгөөлөх талын нотлох баримт, тайлбар зэргийг заавал сонсох нь мэтгэлцэх зарчмын гол агуулга болно.

Хувь хүний нэр төр. Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, нэр төр, хувийн нууцыг хуулиар хамгаалан баталгаажуулж өгсөн. Гэмт хэрэгт сэрдэгдэж, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан этгээдийг шүүхээр гэм буруутай нь эцэслэн тогтоогдоогүй байхад гэмт хэрэг үйлдсэн мэтээр олон нийтийн дунд хэлэлцэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах зэрэг хүний нэр төр, алдар хүндийг зөрчих сөрөг үзэгдэл гарч байна. Гэм буруутай нь шүүхээр тогтоогдохоос өмнө хэнийг ч гэм буруутайд тооцож үл болно гэж хүний эрхийн олон улсын гэрээ конвенц⁴¹ болон дотоодын хууль тогтоомжоор хориглодог. Иймд хууль сахиулах байгууллагаас шалгаж байгаа аливаа хэргийн талаар нийтэд мэдээлэл хийхдээ сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг гэм буруутай болохыг нь тогтоогоогүй бөгөөд тогтоохоор мөрдөн шалгаж байгаа тухай тусгайлан сануулдаг, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ч олон нийтэд энэ талаар мэдээлэхдээ тодорхой дүрэм, журмын дагуу хүргэдэг байх соёлыг төлөвшүүлэх нь чухал байна.

Үүнээс дүгнэн үзвэл ЭБША-д хүний эрх, эрх чөлөөг хөндсөн аливаа хязгаарлалт нь зөвхөн хангалттай нотлох баримтад тулгуурласан, хуулиар тогтоосон үндэслэл, журамд нийцсэн байх учиртай. Хүний салшгүй эрхийг хөндөж, нийгмээс тусгаарлан хорьж мөрдөх ажиллагаа нь гарцаагүй тохиолдолд хэрэгжүүлэх эцсийн арга хэрэгсэл бөгөөд түүнийг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлдэг байх, тийм нөхцлийг холбогдох хууль тогтоомжоор бүрдүүлэх шаардлагатай. Үүний тулд цагдан хорих арга хэмжээг авах үндэслэл нь сэжиг таамаг төдийхөнд бус гарцаагүй баримтад тулгуурласан байх, хангалттай тодорхой байхын зэрэгцээ цагдан хорих шийдвэрийг талуудын адил тэгш оролцоонд тулгуурлан гаргах, цагдан хорихоос бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг судалсны үндсэн дээр хууль тогтоомжоор нэвтрүүлэх нь зүйтэй юм.

Дөрөв. Гадаад улсын сайн туршлага

4.1. АНУ-ын туршлага

АНУ нь 50 муж улсаас бүрдсэн холбооны улс тул цагдан хорих арга хэмжээ */pre-trial detention/*-г Холбооны болон Муж улсуудын хуулиар тус тус зохицуулдаг.

⁴¹ Тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон ИУТЭОУП.

Холбооны хэмжээнд Гэмт хэрэг болон эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль⁴² /*Crime and Criminal Procedure Code*-ийн “Шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны өмнө сэжигтэн, яллагдагчийг суллах эсвэл цагдан хорих тухай” /*Release and detention pending judicial proceedings*/ 207 дугаар бүлэгт заасны дагуу зохицуулж байна. АНУ-д зөвшөөрлийн шүүхийн болон шүүгчийн /*magistrate judge*/ тогтолцоо⁴³ хэрэгждэг бөгөөд эдгээр нь цагдан хорих арга хэмжээ, батлан даалт, үзлэг, нэгжлэг хийх зөвшөөрөл олгох, баривчлах зөвшөөрөл, түүнчлэн мөрдөн байцаах ажиллагаа болон нэмэлт мөрдөн байцаалт хийх процессыг ханган ажилладаг.⁴⁴ Өөрөөр хэлбэл, зөвшөөрлийн шүүх нь шүүн таслах ажиллагааны өмнөх шатны албадлагын арга хэмжээг процессын бүх төвшинд шийдвэрлэдэг байна. Зөвшөөрлийн шүүх нь Америк төдийгүй бусад олон улсын төвшинд шүүх эрх мэдлийн салшгүй хэсэг болон эрх, үүргээ хэрэгжүүлж байна. Тухайлбал, Английн зөвшөөрлийн шүүх нь эрүүгийн процесс эхлэх үеэс АНУ-ын нэгэн адил үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.⁴⁵

Монгол Улсад батлан даалт, үзлэг, оршин суух газраасаа гадагш явахгүй гэх мэт албадлагын арга хэмжээний бусад төрлийг прокурорын зөвшөөрлөөр авдаг бол АНУ-д сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих эсвэл батлан даалтаар суллах зэрэг албадлагын бусад арга хэмжээг шүүх шүүн таслах ажиллагааны үеэр бус анхнаасаа оролцож, шийдвэр гаргадаг нь олон улсын хэм хэмжээнд заасан хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх зөрчигдөхөөс хамгаалсан процедур болдог байна. Цаашилбал, Америкийн эрүүгийн процессын тогтолцоо нь мэтгэлцэх зарчимд тулгуурладаг бөгөөд шүүхийн өмнөх шатанд шүүгчийн өмнө сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгч нь яллах чиг үүргийг хэрэгжүүлж буй прокурортой адил төвшинд, ижил эрхтэйгээр цагдан хорих арга хэмжээ авах шаардлага байгаа эсэхийг хууль ёсны нотлох баримтын хүрээнд мэтгэлцэн шийддэг онцлогтой. Ийнхүү шүүх мөрдөн байцаагч, прокурорын гаргасан үндэслэлийн дагуу цагдан хорих арга хэмжээ авахаар хязгаарлагдах бус ЭБША-ны бүхий л үе шатанд оролцдог нь хүний халдашгүй, чөлөөтэй байх, гэм буруутай нь шүүхийн өмнө нь нотлогдоогүй байхад эрүүгийн хариуцлагад татагдахгүй байх зарчмын баталгаа болж өгдөг.

Зөвшөөрлийн шүүхийн шүүгч нь сэжигтэн, яллагдагчийг шүүхийн өмнөх шатанд цагдан хорих эсэх шийдвэрээ гаргахдаа цагдан хорихоос өөр альтернатив арга хэмжээг хэрэглэхийг урьтал болгоно.⁴⁶ Үүнд, хууль сахиулах байгууллагын хяналтад оруулах, оршин суугаа газраасаа гадагш явахгүй байх тухай баталгаа гаргуулах, эрүүл мэндийн болон сэтгэцийн эмнэлэг зэрэг мэргэшсэн байгууллагын хяналт дор харгалзах зэрэг хэд хэдэн альтернатив албадлагын арга хэмжээ байдаг бөгөөд үүнээс хамгийн нийтлэг хэрэглэдэг нь батлан даалт юм.⁴⁷ Сэжигтэн, яллагдагчийг суллах гол үндэслэл нь тухай этгээд шүүхийн өмнө дуудсан цагт бэлэн байх бөгөөд түүнийг сулласан нь нийтийн болон хувь хүний аюулгүй байдалд харшлахгүй байх нөхцлийг хангасан байна. Үүний дээр сэжигтэн, яллагдагчийг цагдан

⁴² 18 U.S.Code. Crime and Criminal Procedure Code.

⁴³ Federal Magistrates Act of 1968.

⁴⁴ http://en.wikipedia.org/wiki/United_States_magistrate_judge (2014-08-10)

⁴⁵ Magistrates' Courts Act 1980, England.

⁴⁶ 18 U.S. Code § 3142 - Release or detention of a defendant.

⁴⁷ http://www.justicepolicy.org/uploads/justicepolicy/documents/bailfail_executive_summary.pdf (2014-08-10)

хорихгүйгээр суллахад дахин гэмт хэрэгт холбогдохгүй байх, ажил үүргээ үргэлжлүүлэх, хэрэв ажилгүй бол ажил идэвхтэй хайх, боловсролын хөтөлбөрт хамрагдах, галт зэвсэг эзэмшихгүй байх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхгүй байх зэрэг нөхцлүүдийг заадаг.⁴⁸

Дараах үндэслэлээр сэжигтэн, яллагдагчийг цагдан хорьж болно. Үүнд:

- 10 ба түүнээс дээш хугацаагаар хорих ялтай хүчирхийллийн гэмт хэрэгт сэжиглэгдсэн;
- Бүх насаар нь хорих ял эсвэл цаазаар авах ялтай гэмт хэрэгт сэжиглэгдсэн;
- 10 ба түүнээс дээш ялтай хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт сэжиглэгдсэн;
- Бага насны хохирогчтой гэмт хэрэгт сэжиглэгдсэн, эсвэл зэвсэг ашигласан гэмт хэрэгт сэжиглэгдсэн зэрэг болно.

Зөвшөөрлийн шүүхийн шүүгч дээрх цагдан хорих үндэслэлийг харгалзан үзэхдээ сэжигтэн, яллагдагчийг хүчирхийллийн гэмт хэрэгт холбогдсон эсэх, түүний эсрэг цугларсан нотлох баримтын үнэ цэнэ, тухайн этгээдийн зан төлөвийн тодорхойлолт, сэжигтэн, яллагдагчийг сулласнаар бусад хүмүүст аюул учрах магадлал зэргийг авч үзнэ. Гэмт хэргийн төрлөөсөө буюу ноцтой гэж тооцогдсон хэргүүд дээр батлан даалтыг төдийлөн хэрэгжүүлдэггүй байна. Ингэхдээ хүний эрхийн баталгааг хангах, зайлшгүй ажиллагаа */due process/*-г явуулж хэвшсэн төдийгүй АНУ-ын Үндсэн хуулиар баталгаажсан байдаг. АНУ-ын Үндсэн хуулийн 8 дугаар нэмэлтэд барьцааны хэмжээг хэт өндөр тогтоож болохгүй хэмээн заасан байдаг. Цагдан хорих арга хэмжээг хэрэглэхдээ хүний эрхийн хамгаалалт, зайлшгүй ажиллагаа хангалттай төвшинд хэрэгждэг нь АНУ-ын Үндсэн хуулийн 5, 8, 14 дүгээр нэмэлт, цагдан хорих талаар Америкийн Барын Холбооноос */American Bar Association/* гаргасан стандарт, төрөлжсөн Эрүүгийн хууль дахь нарийн бөгөөд дэлгэрэнгүй зохицуулалтууд зэргээс харагддаг.

4.2. ХБНГУ-ын туршлага

4.2.1. Цагдан хорих арга хэмжээ авч буй эрх зүйн үндэслэл, хэрэгжилт

1990 оны 10 дугаар сарын 3-ны өдөр ХБНГУ (Баруун Герман) нь Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улстай (Зүүн Герман) нэгдэж, холбооны 16 муж улстай ХБНГУ үүсэн бий болсон. Хэдийгээр энэ үйл явц социалист систем задран унасантай холбоотойгоор үүсэн бий болсон хэдий ч бусад улс орнуудын нэгэн адил “шилжилтийн улс орон”-ы тоонд оролгүйгээр Баруун Германы эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжууд нь шинээр үүссэн холбооны муж улсуудад нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.⁴⁹

1950 оноос хойш ХБНГУ нь Европын Зөвлөлийн */European Council/* гишүүн улс байсан бөгөөд 1973 онд НҮБ-ын ИУТЭОУП болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭОУП)-ыг соёрхон баталсан.⁵⁰ Түүнчлэн 1952 онд Европын Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах конвенц болон 1989 онд

⁴⁸ 18 U.S. Code § 3142 - Release or detention of a defendant, Part C.

⁴⁹ “An analysis of minimum standards in pre-trial detention and the grounds for regular review in the Member States of the EU: Germany”, JLS/D3/2007/01, p.1.

⁵⁰ Ratification status of UN International Covenants <http://www2.ohchr.org/english/bodies/ratification/4.htm> (2014-10-13)

Европын конвенцийн цаазаар авах ялыг халах тухай 6 дугаар протоколыг соёрхон баталсан.⁵¹ Герман Улс нь Европын Холбоог байгуулах үеэс гишүүн улсын тоонд багтаж байсан бөгөөд 1990 оноос хойш Европын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх конвенцид нэгдэн орсон. Харин НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь гутаах, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг 2008 онд соёрхон баталсан байна.⁵² Германд олон улсын гэрээ, конвенцийг соёрхон батлагдсан үеэс хойш дотоодын хуулийн салшгүй нэг хэсэг болж байдаг. Тухайлбал, 1952 оноос хойш Европын Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах конвенц нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилж ирсэн.

Цагдан хорих арга хэмжээг Германы Эрүүгийн хууль болон Эрүүгийн процессын хууль /ЭПХ/-р зохицуулдаг. Энэ арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд Үндсэн хуулийн эрх зүйг дээдлэх зарчим нь ЭБША-ны тулгуур зарчим болж байдаг бөгөөд гэм буруугүйд тооцох зарчим, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх болон тэнцвэртэй байх зарчмын эх сурвалж болдог.⁵³

ЭПХ-аар цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрх зүйн тодорхой хамгаалалтуудыг */habeas corpus/* заадаг. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2 дахь хэсэгт зааснаар эрх чөлөөг хязгаарлах, хязгаарлах хугацааг сунгах тухай шийдвэрийг гагцхүү шүүгч гаргана. Хэрэв эрх чөлөөг ийнхүү хязгаарлах нь шүүхийн шийдвэрийг үндэслээгүй бол шүүгчийн шийдвэрийг заавал гаргуулах ёстой. Цагдаагийн байгууллага тухайн этгээдийг баривчилсан өдрөөс хойш дахин нэг өдөр л цагдан хорих эрхтэй. Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлийн 104.3 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэгт сэжиглэгдсэн аливаа этгээдийг түүнийг баривчилсан өдрөөс хойш 48 цагийн дотор шүүхэд хүргүүлэх бөгөөд шүүгчээс түүнийг баривчлах болсон үндэслэлийг мэдэгдэж, мэтгэлцэх зарчмаар хангана. Шүүгч нэн даруй баривчлах үндэслэлийг заасан шийдвэрийг гаргах эсхүл сэжигтнийг суллана. Ийнхүү шүүхээс цагдан хорих арга хэмжээг авах бөгөөд цагдаагийн ажилтан гагцхүү гарцаагүй аюул заналхийлсэн үед л сэжигтнийг баривчлах эрх эдэлнэ. Энэ шийдвэрээ 48 цагийн дотор шүүхээр баталгаажуулах ёстой. Цагдан хорих арга хэмжээ авах дэс дарааллыг хүснэгт 5-д харуулав.

Хүснэгт 5: ХБНГУ-д цагдан хорих арга хэмжээг авах тухай шийдвэр гаргах, хэрэгжүүлэх хугацаа

Цаг хугацаа	ЭБША	Хууль зүйн үндэслэл	Шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан	Цагдан хорих газар
0.00	Баривчлах	ЭПХ-ийн 127 дугаар зүйл	ЭПХ-ийн 127 дугаар зүйлийн "иргэнийг баривчлах" тухай: Үйлдэл дээрээ баригдсан хэн бүхнийг эсхүл үүнээс хойш тэр даруй ЭПХ-ийн 127 дугаар зүйлийн 127(2): цагдан хорих үндэслэл бий болж "зайлшгүй аюул" нүүрлэсэн бөгөөд	Цагдаагийн газар (Дотоод хэргийн яам)

⁵¹ Ratification status for the Council of Europe conventions http://www2.ohchr.org/english/bodies/ratification/9_b.htm (2014-10-13)

⁵² Ratification status of UN International conventions http://www2.ohchr.org/english/bodies/ratification/9_b.htm (2014-10-13)

⁵³ Constitution of the Federal Republic of Germany ("Grundgesetz").

			шүүгчтэй хугацаанд нь холбоо тогтоох боломжгүй бол цагдаагийн ажилтан болон прокурор шийдвэр гаргана.	
Нэн даруй, хамгийн ихдээ 48 цагийн дараа		ЭПХ-ийн 125 дугаар зүйл ЭПХ-ийн 128, 115 дугаар зүйл	Прокурор Дотоодын шүүхийн шүүгч	
6 сар				Цагдан хорих газар эсвэл ердийн шоронгийн цагдан хорих өрөө (Хууль зүйн яам)
6 сар гаруй (Өөр хязгаар байхгүй)	Хэргийн хамрах хүрээ өргөн эсхүл төвөгтэй байдлыг үндэслэн хугацааг сунгана (үгүй бол суллана); 3 сар бүр цагдан хорих үндэслэлийг хянана.	ЭПХ-ийн 121 дүгээр зүйл	ЭПХ-ийн 121 дүгээр зүйлийн 121(2), 122 дугаар зүйлийн 122(4): Бүс нутгийн Дээд Шүүх	

4.2.2. ХБНГУ-ын цагдан хорих үндэслэл:

- 1) ЭПХ-ийн 112 дугаар зүйлийн 112.1 дэх хэсэгт зааснаар сэжигтнийг тухайн гэмт хэрэгт сэжиглэх “ноцтой сэжиг”, баривчлах үндэслэл байгаа бол цагдан хорино.⁵⁴ Өөрөөр хэлбэл, цагдан хорих нэг ба түүнээс дээш үндэслэл байхаас гадна “ноцтой сэжиг” байх ёстой. Сэжигтэн, яллагдагч нь тухайн гэмт хэргийг үйлдсэн гэх өндөр магадлалтай бөгөөд түүнийг үгүйсгэх эрх зүйн үндэслэл байхгүй гэдэг нь хэрэгт хамаарах бүхий л нотлох баримтаар нотлогдох ёстой.⁵⁵ Гэсэн хэдий ч хэргийн ач холбогдол, ялын хэмжээтэй тохирохгүй бол цагдан хорих арга хэмжээг авч болохгүй.⁵⁶
- 2) ЭПХ-ийн 112 дугаар зүйлийн 112.2 дахь хэсэгт зааснаар дараах үндэслэл байгаа тохиолдолд сэжигтэн, яллагдагчийг баривчилна:
 - оргон зайлах, нуугдах, эсхүл оргон зайлах, нуугдах эрсдэлтэй;
 - нотлох баримтыг цуглуулахад саад учруулах, хуйвалдах, устгах, нотлох баримтыг хуурамчаар үйлдэх;
 - гэрч, шинжээч болон бусдад зүй бусаар нөлөөлөх өндөр эрсдэлтэй бөгөөд

⁵⁴ German Code of Criminal Procedure (“Strafprozessordnung”).

⁵⁵ “An analysis of minimum standards in pre-trial detention and the grounds for regular review in the Member States of the EU: Germany”, JLS/D3/2007/01, p.15.

⁵⁶ Мөн тэнд.

эдгээрээс улбаалан хэргийн бодит байдлыг тогтооход саад учирч болзошгүй.

3) ЭПХ-ийн 112 дугаар зүйлийн 112.2, 112.3 болон 112(а) хэсэгт зааснаар тодорхой төрлийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа сэжигтэн, яллагдагчийг цагдан хорино. Үүнд “эрсдэл” байгаа эсэхийг хэрэгт хамаарах нотлох баримтаар баталгаажуулсан байх ёстой. Дараах үндэслэл үүнд хамаарна:

- онц хүнд гэмт хэрэгт сэжиглэж байгаа;
- шинээр ижил төстэй гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх шаардлага зэрэг болно.

Онц хүнд гэмт хэрэг гэдэгт Эрүүгийн хуулийн⁵⁷ 308 дугаар зүйлийн 308.1-308.3 дахь хэсэгт заасан тэсэрч дэлбэлэх үйлдлээс болж хүний амь нас эрсэдсэн, Эрүүгийн хуулийн 129 дүгээр зүйлийн 129(а), 129(б) хэсэгт зааснаар террорист байгууллага байгуулах, Эрүүгийн хуулийн 211, 212, 226 дугаар зүйл, 306 дугаар зүйлийн 306(б), 306(с) хэсэгт заасан террорист байгууллага байгуулах, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, хүндрүүлэх нөхцөлтэйгөөр хүний амийг бүрэлгэх, бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулах, галдан шатаах, үүнээс болж хүний амь нас эрсэдсэн зэрэг тохиолдолд цагдан хорино.

Ижил төрлийн гэмт хэрэг давтан үйлдэх магадлалтай гэдэгт ЭБШХ-ийн 112 дугаар зүйлийн 112(а) дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хуулийн 174, 174(а), 176-179, 238 дугаар зүйлийн 238.2 болон 238.3 дахь хэсэгт заасан бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргүүд орно. Түүнчлэн Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйлийн 89(а), 125 дугаар зүйлийн 125(а), 224-227, 243, 244, 249-255, 260, 263 дугаар зүйл, 306 дугаар зүйлийн 306(с) болон 316(а) дахь хэсэгт заасан төрийн эсрэг гэмт хэрэг, зэвсэгт бослого гаргах, бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулах, бусдын эд хөрөнгийн эсрэг гэмт хэрэг зэрэгт сэжиглэгдэж байгаа тохиолдолд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих үндэслэл болно.

Тэнцвэртэй байх зарчим гэдэгт цагдан хорих тодорхой хэмжээний шалгуур тавигдах ёстой. Тухайлбал, хэрэв хорих ялын хэмжээ нэгээс илүү жил байгаа тохиолдолд дээрх төрлийн гэмт хэргийг давтан үйлдэх эрсдэл байгаа үед л цагдан хорих үндэслэл болно. Хэрэв хорих ялын хэмжээ нь 6 сараас хэтрэхгүй бол нотлох баримтыг устгах эрсдэлтэй гэсэн үндэслэлээр цагдан хорихгүй.

Сэжигтэн, яллагдагч нь ЭБША-ны аль ч үед өөрөө эсхүл мөрдөн байцаагчаар дамжуулан өмгөөлөгчтэйгээ холбоо тогтоох боломжтой. ЭПХ-ийн 136 дугаар зүйлийн 136.1 дэх хэсэгт зааснаар анх байцаагдах үеэс эхлүүлэн өмгөөлөгчтэйгээ уулзах эрхтэй. Зарим тохиолдолд буюу 3 сараас дээш хугацаагаар цагдан хоригдсон бол өмгөөлөгчийг заавал оролцуулах шаардлагатай. ЭПХ-ийн 104 дүгээр зүйлийн 104.4 дэх хэсэгт зааснаар сэжигтнийг баривчлах болсон тухай мэдээллийг ар гэр, төрөл садангийн хүнд нь заавал мэдэгдэнэ. Энэ эрхээсээ сэжигтэн, яллагдагч татгалзах эрхгүй болно. ЭПХ-ийн 128, 115 дугаар зүйлийн 115.3 дахь хэсэгт зааснаар баривчлагдсан этгээдийн хэргийг шүүхээр заавал хянуулна. ЭПХ-ийн 114 дүгээр зүйлд зааснаар шүүгч баривчлах шийдвэрт цагдан хорих арга хэмжээ авах тухай шийдвэрийг зааж, сэжиглэх үндэслэл болон цагдан хорих үндэслэлийг тусгана.

⁵⁷ Criminal Code of the Federal Republic of Germany (“Strafgesetzbuch”).

ХБНГУ-ын ЭПХ-д сэжигтэн, яллагдагч өөрөө татгалзсанаас бусад тохиолдолд цагдан хорих арга хэмжээ авах тухай асуудлыг прокурор, өмгөөлөх талыг оролцуулан шийдвэрлэхээр заажээ. Энэ нь гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээд өөрөө сайн дураараа эрхээсээ татгалзсанаас бусад тохиолдолд заавал тайлбар, баримтыг нь сонссоны үндсэн дээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар хуульчилсан.

4.2.3. Цагдан хорихоос өөр төрлийн арга хэмжээ авах тухай

ХБНГУ-д сэжигтэн, яллагдагчид дараах цагдан хорихоос өөр төрлийн арга хэмжээ авдаг. Үүнд:⁵⁸

- эрх бүхий байгууллагад оршин суух хаяг өөрчлөгдсөн тухай мэдээлж байх;
- тодорхой газар, бүс нутагт орохгүй байх;
- тогтсон цаг хугацаанд тодорхой газарт байх;
- Герман Улсын хилээр гарахгүй байх;
- тогтоосон хугацаанд цагдаагийн газарт бүртгүүлж байх;
- сэжиглэгдэж байгаа гэмт хэрэгтэй холбоотой бусад аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх. Тухайлбал, тодорхой ажил, мэргэжлээр ажиллахгүй байх;
- мөнгө барьцаалах;
- донтолтын эсрэг албадан эмчилгээнд хамрагдах;
- гадаад паспорт, иргэний үнэмлэхээ хураалгах;
- гэрийн хорионд орж, электрон гав зүүх.

Дээрхээс харахад ХБНГУ-д Монгол Улстай харьцуулахад харьцангуй олон төрлийн цагдан хорих арга хэмжээний альтернатив хувилбаруудыг хэрэглэдэг байна. Монгол Улсын ЭБШХ-д цагдан хорихоос гадна оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах, батлан даалтад өгөх, эд хөрөнгө барьцаалах, цэргийн албан хаагчийг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх зэрэг таслан сэргийлэх арга хэмжээний бусад төрлийг хуульчилсан. Иймд цагдан хорихоос бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг ХБНГУ-ын жишиг мөн өөрийн орны онцлогт тулгуурлан нэмэгдүүлэх шаардлага урган гарч байна. Тухайлбал, сэжигтэн, яллагдагчийг гэрийн хорионд байлгах, тогтоосон газарт тогтмол бүртгүүлж байхыг даалгах, тодорхой нутаг дэвсгэрийг зааж, түүнээс гарахыг хориглох, тодорхой газар очих, эсхүл хүнтэй уулзах, ойртохыг хориглох таслан сэргийлэх арга хэмжээний төрлийг хэрэглэж болно. Ингэснээр гэм буруутай нь эцэслэн тогтоогдоогүй байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг заавал “эрсдэлтэй орчин”-д удаан хугацаагаар хорьдог, хорьсны дараа мэдүүлэг тайлбар авдаг уламжлалт практик, түүнтэй холбоотой хүний эрхийн зөрчил дутагдлыг арилгах, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн онцлогт тохирсон таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх төдийгүй ЭБША-д хүний эрхийг хангаж хамгаалахад чухал алхам болох юм.

⁵⁸ Fair Trials International, “Pre-trial Detention Comparative Research: Germany”, p.12.

Дүгнэлт

Энэ бодлогын судалгаанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл, журам, эрх зүйн зохицуулалт, өнөөгийн практик зэрэг асуудлуудыг авч үзлээ. Цагдан хорих арга хэмжээ авч байгаа өнөөгийн практикийг судлахад цагдан хорих эцсийн шийдвэрийг шүүх гаргаж, цагдан хорионы асуудал хариуцсан шүүгчийг ажиллуулан байцаан шийтгэх ажиллагаанд “шүүхийн хамгаалалт”-ыг нэвтрүүлсэн, шүүхийн практикт талуудыг байлцуулан цагдан хорих арга хэмжээг шийдвэрлэдэг зэрэг эерэг үр дүн ажиглагдаж байгаа боловч сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих дийлэнх үндэслэлийг “оргон зайлж болзошгүй” гэсэн үндэслэл эзэлж байгаа нь ЭБША-д субъектив үзэмжээр хандах нөхцлийг бүрдүүлсэн гэх шүүмжлэлийг дагуулж байна. Цагдан хорих арга хэмжээ нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хөнддөг албадлагын арга хэмжээ болохын хувьд эрүүгийн процессын ажиллагааны эцсийн арга байх ёстой гэдэг нийтлэг жишиг олон улсад тогтжээ. Энэ хүрээнд гэрийн хорионд байлгах, электрон гав зүүлгэж зорчин явах газар, хугацааг нь хянадаг, тодорхой цагт цагдаагийн байгууллагад ирж бүртгүүлдэг байх зэрэг цагдан хорих арга хэмжээний альтернатив хувилбаруудыг хэрэглэдэг байна. Монгол Улсын хувьд цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээний төрөл харьцангуй цөөн байгаа нь эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулж байгаа хууль тогтоомжийн төсөлд энэ асуудлыг анхаарах шаардлагатайг харуулж байгаа юм.

Цагдан хорих арга хэмжээ авах журмын хувьд сэжигтэн, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахдаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, прокурорт танилцуулаад прокурор шүүхэд уламжлах эрх зүйн зохицуулалттай байна. Энэ нь цагдан хорих арга хэмжээг авахдаа хэргийг мөрдөн шалгах, яллах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа талын санал, нотлох баримтад “үндэслэн шийдвэрлэж” байна гэсэн шүүмжлэлийг дагуулдаг. Түүнчлэн цагдан хорих арга хэмжээг сунгах үндэслэл, журам, сэжигтэн, яллагдагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгчийг байлцуулан дээрх шийдвэрийг гаргах талаар хуульд тухайлсан журам заагаагүй байгаа юм. Эндээс үзвэл цагдан хорих арга хэмжээ нь хүний эрх, эрх чөлөөг хөндсөн албадлагын шинжтэй арга хэмжээ байдгийн хувьд цагдан хорих арга хэмжээ авах, сунгахад талуудад адил тэгш оролцох нөхцөл, бололцоог судалж, хуульчлан тогтоох шаардлагатай юм. Энэ нь “шүүх байгууллагын өмнө хэнийг ч нөхцөл байдлаа тайлбарлах боломж өгөхгүйгээр цагдан хорьж болохгүй. Цагдан хоригдсон этгээд хуульд заасан үндэслэл, журмын дагуу өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй” гэсэн олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгааждаг.

Судалгааны үр дүнд тулгуурлан ЭБША дахь цагдан хорих арга хэмжээг авах үндэслэл, журмыг боловсронгуй болгох чиглэлээр дараах **саналыг** дэвшүүлж байна:

- Цагдан хорих арга хэмжээг авах үндэслэлээс “оргон зайлж болзошгүй” үндэслэлийн шалгуурыг хуульд нарийвчлан тусгах;
- Цагдан хорих арга хэмжээг авах, сунгахдаа яллах болон өмгөөлөх талын адил тэгш оролцоог бүрдүүлж, тэдний тайлбар, хүсэлт, нотлох баримтыг хэлэлцэх талаар хуулийн зохицуулалтыг бүрдүүлэх;

- Цагдан хорих арга хэмжээ нь таслан сэргийлэх арга хэмжээ болохын хувьд сэжигтэн, яллагдагчийг дахин гэмт хэрэг үйлдэх, хэрэгт ач холбогдолтой баримт сэлт, нотлох баримтыг устгах, өөрчлөхөөс сэргийлэх, шаардлагатай тохиолдолд хууль, шүүхийн байгууллагад хүрэлцэн ирэх нөхцлийг хангах зорилготой бөгөөд олон улсын зарим туршлагыг судалбал цагдан хорьж мөрдөх хугацаа харьцангуй богино байна. Иймд цагдан хорьж мөрдөх хугацааг олон улсын нийтлэг стандартад нийцүүлэн богиносгох асуудлыг судалж, шийдвэрлэх;
- Цагдан хорихоос өөр төрлийн таслан сэргийлэх албадлагын арга хэмжээний төрлийг нэмэгдүүлж, цагдан хорих нь ЭБША дахь хамгийн эцсийн арга хэмжээ байх нөхцлийг бүрдүүлэх;
- Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг цуцлах, сэжигтэн, яллагдагчийг суллах үндэслэл, журмыг хуульд тусгаж хэрэгжүүлэх;
- Зарим улсын шүүхийн тогтолцоонд байдаг Зөвшөөрлийн шүүх /Magistrates Court/⁵⁹ -ийн тогтолцоог Монгол Улсад байгуулах шаардлагатай эсэхийг нарийвчлан судлах нь зүйтэй байна.

-оОо-

ИЖИЛ ТӨСТЭЙ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ⁶⁰

Удиртгал

Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглодог. Иймд шүүгч гэмт хэргийн зүйлчлэл буюу нийгэмд аюултай тодорхой үйлдэл, эс үйлдэхүй Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй нийцсэнийг тогтоох ажиллагааг хэрэгжүүлэхдээ туйлын няхуур хандах шаардлагатай байдаг. Учир нь гэмт хэргийг зөв зүйлчлэх нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хуулийг дээдлэх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны /ЭБША/ арга хэрэгслийг (тухайлбал, таслан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох) зөв хэрэглэх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд шударга, ялгамжтай ял ногдуулах, хугацаанаас өмнө тэнсэн суллах зэрэг олон асуудлыг зөв шийдвэрлэхэд шууд нөлөөлдөг.⁶¹ Гэмт хэргийн зүйлчлэлийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага хийж, шүүгч шийтгэх тогтоолоороо эцэслэн шийдвэрлэдэг.⁶² Иймд энэ судалгаанд ижил төстэй хянан шийдвэрлэгдэж байгаа гэмт хэргүүд болох Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл буюу хүн худалдаалах болон Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл буюу биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг болон Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйл буюу танхайрах гэмт хэрэг болон Эрүүгийн хуулийн 96, 98, 99 дүгээр зүйл буюу бусдын бие

⁵⁹ Зөвшөөрлийн шүүх нь цагдан хорих арга хэмжээ, батлан даалт, үзлэг, нэгжлэг хийх зөвшөөрөл олгох, сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгох, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих зэргээр эрүүгийн процессын ажиллагаанд шүүхийн хамгаалалтыг хэрэгжүүлдэг.

⁶⁰ Тус судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ-ийн судалгаа хариуцсан ахлах референт Э.Өлзийлхам, судлаач Ц.Ариунболд, гэрээт судлаач Б.Одонгэрэл нар хамтран гүйцэтгэсэн болно.

⁶¹ С.Нарангэрэл, "Эрх зүйн эх толь бичиг", Улаанбаатар, 2008 он, 141 дэх тал.

⁶² Мөн тэнд.

махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл санаатайгаар учруулах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэлийн асуудлуудыг судалсан болно.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь улс үндэстэн дамнасан шинжтэй болж, гэмт бүлэг бүлэглэлүүдэд их хэмжээний ашиг орлого өгдөг хууль бус бизнес болон өргөжиж байна. Тухайлбал: Дэлхийд жил тутам хүн худалдаалах гэмт хэргээс олж буй хууль бус ашиг орлого 31.6 тэрбум ам доллар байна гэсэн судалгаа байна. Монгол Улсад ч хүн худалдаалах гэмт хэргийн гаралт нэмэгдэж, түүний цар хүрээ, үйлдэгдэх байдал нарийсаж, хохирогчдын тоо өссөөр байгаа юм. Жишээлбэл, 2000 оны энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдыг 2013 онтой харьцуулахад 10 дахин өссөн байна. Монгол Улс хоёр хөрш орон болох ОХУ болон БНХАУ, мөн БНСУ зэрэг улсын хүн худалдаалах гэмт хэргийн дамжуулагч орон болж байгаа бөгөөд Хятад улс, үүний дотор Хонгконг болон Макаогийн Тусгай Засаг Захиргааны Бүс, БНСУ, Бүгд Найрамдах Сингапур Улс, Тайвань, Бүгд Найрамдах Турк Улс, Япон, Малайз, АНУ, Бүгд Найрамдах Чех Улс, ХБНГУ, Бүгд Найрамдах Индонези Улс, Тайландын Вант Улс зэрэг орнуудад монгол иргэд хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн зорилготойгоор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж байна.⁶³ БНХАУ-ын нийслэл Бээжин хотод болсон Хятад, Монгол хоёр улсын консулын уулзалтаар Монгол Улс ОХУ, БНХАУ-ын дундах хүнийг хил дамжуулан худалдаалах төв цэг болжээ гэж албан ёсоор хүлээн зөвшөөрсөн.⁶⁴ Энэ нь Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг төрийн эрүүгийн бодлогоор зохицуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. Монгол Улсын шүүхээр хянан шийдвэрлэж байгаа хүн худалдаалах гэмт хэрэг, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах төрлийн гэмт хэргийн шалтгаан, зүйлчлэлийн асуудал, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тохирсон ял шийтгэлийг оногдуулах зэрэгт мэдээлэл, судалгаа ихээхэн шаардлагатай тул энэ төрлийн гэмт хэргийг сонгон судалсан болно.

Түүнчлэн танхайрах гэмт хэрэг нь Монгол Улсын шүүхээр хянан шийдвэрлэж буй нийт гэмт хэргийн 13 орчим хувийг дангаар эзэлж байна.⁶⁵ Танхайн гэмт хэргийн үйлдэл нь хүний амь бие, эрүүл мэндэд ямар нэгэн байдлаар халдаж байдаг тул бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учруулсан байдаг тул танхайн гэмт хэргийг үүнтэй ижил төстэй гэмт хэрэг болох бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл санаатай учруулах гэмт хэрэгтэй харьцуулан судалсан бөгөөд 2014 онд энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн зарим шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн болно.

Нэг. Хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг

1.1. Эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хууль болон бусад холбогдох хуульд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчлан эрүүгийн хариуцлага оногдуулах болжээ.

⁶³ АНУ-ын Төрийн Департамент, "Хүн худалдаалах гэмт хэргийн тухай тайлан", 2010 он. 238 дахь тал.

⁶⁴ Ц.Эрдэнэ. "Та бид хүний наймааны төв цэгт амьдарч байна". Ардын эрх сонин. 2006.11.08. №217/495/.

⁶⁵ Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны мэдээ 2011, 2012, 2013 он.

Түүнчлэн олон улсын гэрээ конвенцид нэгдэн орж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг хэрэгжүүлж байгаагийн нэг илрэл нь 2000 оны НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц /цаашид “Палермогийн конвенц” гэх/-ийн нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” протокол /цаашид “Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг протокол” гэх/-д нэгдэн орсон явдал юм.⁶⁶ Энэ протоколын 3 дугаар зүйлд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолтыг оруулсан байдаг.⁶⁷

Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг Протоколын 3 дугаар зүйлийн “а” хэсэгт заасан хүн худалдаалах гэмт хэргийн тухай тодорхойлолт үндсэн гурван элементийг агуулсан байдаг бөгөөд үүнд үйл хөдлөл, арга хэрэгсэл болон зорилго зэрэг багтдаг. Хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь “элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх, орогнуулах, хүлээж авах” зэрэг *үйл хөдлөлөөр* “заналхийлэх, хүч хэрэглэх болон бусад дарамтлалын хэлбэр ашиглах, хүчээр авч явах, залилах, хуурах, эрх мэдлээ урвуулан ашиглах, шан харамж өгөх” *арга хэрэгслээр* биеийг нь үнэлүүлэн мөлжих, хүчээр ажил үйлчилгээ хийлгүүлэх, боолчлох, зарцлах, хүний эрхтнийг авах зэрэг *зорилготойгоор* үйлдэгдсэн гэмт хэргийг хэлнэ. Иймд Палермогийн конвенцийг соёрхон баталж байгаа улс орнууд өөрийн хууль тогтоомждоо хүн худалдаалах гэмт хэргийн тухай тодорхойлолтыг энэ байдлаар зааж өгөх үүрэг хүлээдэг.

Монгол Улсын Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэрэг гэдгийг “Хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, түүнчлэн өөр хүнийг эрхшээлдээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, ашиг олгон хахуульдах аргаар хүнийг хүн худалдаалах гэмт үйлдэлд элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан дамжуулсан, хүлээн авсан бол эд хөрөнгийг хурааж, гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэсэн. Харин Дэлхийн Эрүүгийн жишиг хуульд (цаашид “Жишиг хууль” гэх) 1. Аливаа этгээд дараах мөлжлөгийн зорилготойгоор хүн худалдах гэмт хэргийг үйлдсэн байна:

- Хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, шилжүүлсэн, ажиллуулсан, хүлээн авсан;
- Дараах аргаар:
 - заналхийлсэн, хүч хэрэглэсэн эсвэл хүчирхийллийн бусад хэлбэрээр;
 - хулгайлсан;
 - залилсан;
 - хууран мэхэлсэн;
 - эрх мэдлээ ашигласан, эмзэг байдлыг далимдуулсан;
 - хэн нэгний хяналтанд дор байгаа хүний зөвшөөрлийг авахын тулд төлбөр болон өөрт ашигтай зүйлийг авсан, өгсөн.⁶⁸

⁶⁶ Монгол Улс 2008 оны 5-р сарын 16-ны өдөр тус протоколд нэгдэн орж, соёрхон баталсан болно.

⁶⁷ Э.Өлзийлхам, “Хүний эрхэд суурилсан хандлага ба хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэх нь”, Шүүх эрх мэдэл (2014 он, №3), 73 дахь тал.

⁶⁸ Жишиг хуулийн 102 дугаар зүйл.

Мөлжих⁶⁹ гэдэгт “Наад зах нь бусдыг биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих буюу бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно” гэж мөн заасан бол Монгол Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн тайлбар хэсэгт “мөлжих” гэдгийг худалдаалагдсан хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно гэжээ. Түүнчлэн Жишиг хуульд мөлжлөг гэдэгт биеийг нь үнэлүүлэх буюу бусад төрлийн бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох болон хараат байлгах, эд эрхтнийг нь авах зэргийг хэлнэ гэсэн байна. Эндээс үзвэл хүн худалдаалах гэмт хэрэг нь аливаа хэлбэрээр хүнийг мөлжих зорилгоор төрөл бүрийн хуульд заасан аргыг ашиглан элсүүлсэн, дамжуулсан, тээвэрлэсэн, хүлээн авсан гэх мэт үйлдлүүд байх ба мөлжих зорилгыг хангахдаа хүнийг биеийг нь үнэлүүлсэн, албадан хөдөлмөрлүүлсэн, боолчилсон, эд эрхтнийг нь авсан байдаг нь харагдаж байна.

Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг нь хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулах болон биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн түүнчлэн биеэ үнэлэхэд зуучилсан, тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр үйлчилсэн үйлдлүүдийг ойлгоно. Биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах нь нийгмийн хор хохирлын хувьд өргөн хүрээг хамардаг бөгөөд гэм буруутай этгээд биеэ үнэлэхийг зохион байгуулаад зогсохгүй бусдын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулдаг.⁷⁰ Энэ гэмт хэргийн үйлдэгдэх арга нь хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх байдлаар илэрдэг бөгөөд ингэхдээ бусдыг зодох, бие махбодид гэмтэл учруулах, эсхүл хохирогчийн өөрт нь болон ойр дотны хүмүүст нь хүч хэрэглэх, гэмтэл учруулах, нэр төрд халдахаар сүрдүүлэх зэргээр тухайн этгээдийг эрхшээлдээ оруулдаг. Түүнчлэн хүч хэрэглэхгүйгээр хуурч мэхлэх аргыг ашиглан тус гэмт хэргийг үйлдэх тохиолдол байдаг. Тухайлбал, ятгах, магтах, зуучлах, амлалт өгөх, төөрөгдөлд оруулах зэргээр хүч хэрэглээгүй, хэрэглэхийг заналхийлсэн шинжгүй байдаг.⁷¹ Биеэ үнэлэх газар байгуулсан, тус үйл ажиллагааг санхүүжүүлсэн, зуучилсан, тээврийн хэрэгсэл, орон байраар хангасан бол биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, бие үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болдог. Биеэ үнэлэх гэдэг нь сэтгэл болон дур хүсэлд үндэслээгүй, хариу төлбөртэйгөөр өөр өөр хүнтэй бэлгийн харьцаанд удаа дараалан орохыг хэлэх ба төлбөрийн талаар урьдчилан тохиролцсон байдаг.⁷²

1.2. Гэмт хэргийн бүрэлдэхүүний асуудал

Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодруулан авч үзвэл:

⁶⁹ Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг протоколын 3 дугаар зүйл.

⁷⁰ Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, Улаанбаатар, 2013 он. 329 дахь тал.

⁷¹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, Улаанбаатар, 2013 он. 329 дахь тал.

⁷² http://prokuror.mn/?page_id=1758 (2014-11-04)

- 1) Гэмт хэргийн объект нь хүний эрх, эрх чөлөө байна.⁷³
- 2) Объектив тал нь хүн худалдаалсан үйлдэл байх ба ингэхдээ хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, элсүүлсэн, дамжуулсан, тээвэрлэсэн, орогнуулсан, хүлээн авсан зэрэг нэг буюу хэд хэдэн үйлдлээр дамжин илэрсэн байхыг шаарддаг.
- 3) Субъект нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй этгээд байж болно.
- 4) Субъектив тал нь гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр илэрдэг. Сэдэлт нь ашиг олох, мөлжих зорилготой шунахайн сэдэлттэй байна.⁷⁴

Харин биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг авч үзвэл:

- 1) Объект нь нийгмийн ёс суртахуун, эмэгтэйчүүдийн хувийн эрх чөлөө, эрүүл мэнд, нэр төр байна.
- 2) Объектив шинж нь бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг байнга зохион байгуулах, биеэ үнэлэх газар байгуулсан, биеэ үнэлэхийг санхүүжүүлсэн, биеэ үнэлэхэд зуучилсан, биеэ үнэлэхэд тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн үйлдлээр илэрнэ.
- 3) Субъект нь 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай, Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй этгээд байна.
- 4) Субъектив тал нь гэм буруугийн шууд санаатай хэлбэртэй бөгөөд ашиг хонжоо олох шунахайн сэдэлттэй байна.

1.3. Гэмт хэргийн зүйлчлэл

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулиар хүн худалдах, худалдан авах гэмт хэргийг анх удаа хуульчилж, “хүн худалдсан буюу худалдан авсан бол” гэж оруулж байсан бол 2008 онд нэмэлт өөрчлөлт орж, хүн худалдаалах гэмт хэргийг зүйлчлэх болсон. Тус хуулийн хэрэгжилтийн эхний шатанд хуулийн зүйл, үг утгын тайлбар болон ЭБША-ны нэг мөр ойлголт байхгүйгээс гэмт хэргийг зүйлчлэхэд ихээхэн хүндрэлтэй байсан. Тухайлбал, 2003 онд үйлдэгдсэн Р гэгч этгээдэд холбогдох эрүүгийн хэрэгт анх хохирогчдыг караокед дуулуулна хэмээн хууран мэхэлж, БНХАУ руу авч явсан ч бэлгийн мөлжлөгөд ашиглах зорилгоор бусдад шилжүүлсэн, байнгын шинжтэй хил давуулж байсан үйлдлийг нарийвчлан шалгаагүй төдийгүй БНХАУ-д ЭБША явуулах боломжгүй учир сэжигтний мэдүүлгийг үндэслэн хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байдаг.⁷⁵

Энэ тохиолдолд хохирогчийн мэдүүлгийг нотлох баримтын хэмжээнд үнэлээгүй, хохирогчийн мэдүүлгийг эх сурвалжаа зааж чадаагүй бол нотлох баримт гэж үздэггүй зэргээр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахгүй завшуулах байдлаар шийдвэрлэгдсэн нь цөөнгүй байсан. 2008 оноос өмнөх эрүүгийн хэргийн шийдвэрлэлтэд зүйлчлэлийн асуудал ихээхэн маргаантай байсан ба 2008 онд Хууль

⁷³ Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, Улаанбаатар, 2013 он. 310-311 дэх тал.

⁷⁴ Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, Улаанбаатар, 2013 он. 310-311 дэх тал.

⁷⁵ Г.Оюунболд, Б.Одонгэрэл, Г.Тамир, “Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт”, ХЗҮХ, Судалгааны тайлангийн эмхэтгэл 1 дүгээр боть, Улаанбаатар, 2012 он. 457 дахь тал.

зүйн үндэсний хүрээлэнгээс хавтаст хэргийн судалгаагаар судлагдсан хэргүүдээс Б, Г нарт холбогдох хэрэгт хохирогчид насанд хүрээгүй байдлыг анхааран үзээгүй хууртсан гэх байдал нь биеэ үнэлэхийг зохион байгуулах, татан оролцуулах хэлбэр болохгүй гэдгийг анхааран үзээгүй байна. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийг прокурорын шатанд өөрчилж, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.3-аар зүйлчилж байсан бол сүүлдээ хэргийн зүйлчлэл өөрчлөгдөж 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсгээр зүйлчилсэн нь ял завшуулсан гэж үзэхээр байна.

Түүнчлэн сүүлийн 3 жилд Эрүүгийн хуулийн 113 болон 124 дүгээр зүйлтэй холбогдуулан Монгол Улсын шүүхээр шийдвэрлэсэн шийдвэрт хийсэн судалгаанаас үзэхэд зүйлчлэлийг өөрчилсөн, зарим холбогдогчийн хэргийг хэрэгсэхгүй болгосон хэргүүд байна. Тухайлбал, 2013 оны 4 дүгээр сарын 26-нд Баянзүрх дүүргийн эрүүгийн шүүх хуралдаанаар прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 дугаар зүйлийн 113.2.1, 113.2.2, 113.2.10 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэн ирүүлснийг мөн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсэг болгон өөрчлөн шийдвэрлэсэн байна. Ингэхдээ шүүх бүрэлдэхүүн тухайн хэргийг өөрчлөн зүйлчилж буй шалтгаанаа тайлбарлахдаа “Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор биеийг нь үнэлэх ингэхдээ хохирогчийн хүсэл зоригоос гадуур, тулган шаардаж хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, хохирогчийг бэлгийн харьцаанд оруулдаг, мөн хохирогч этгээдийг бусад хүмүүсийн мэдэлд бүрмөсөн буюу тодорхой хугацаагаар төлбөртэйгээр шилжүүлдэг, бэлгийн хүчирхийлэлд оруулсны орлого бүхэлдээ гэмт этгээдийн ашиг болдог, түүнчлэн биеэ үнэлэхийг урьдчилан мэдээгүй байдаг гэсэн шинжүүдийг агуулсан байдаг” гэжээ.⁷⁶ Эндээс үзэхэд биеэ үнэлэхэд зуучлах хэргийг хүн худалдаалах гэмт хэргээс ялгаж зүйлчилж байгаа гол шинжүүдийг Монгол Улсын шүүхийн практикт дараах байдлаар авч үзэж байгаа жишиг байна. Үүнд:

- 1) Хохирогч нарын хүсэл зоригоос гадуур тулган шаардаж буюу хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлж эсвэл хууран мэхэлж бэлгийн болон бусад мөлжлөгөд өртүүлээгүй байх;
- 2) Хохирогч нарыг бүрмөсөн буюу түр хугацаагаар бусад хүмүүсийн мэдэлд төлбөртэйгээр шилжүүлээгүй;
- 3) Орлогын зохих хувийг өөрсдөө авдаг байх буюу орлогыг бүрэн шилжүүлдэггүй;
- 4) Хохирогч нар биеэ үнэлнэ гэдгээ урьдчилан мэдэж байсан;
- 5) Хохирогч нар шүүгдэгчид гомдол санал, нэхэмжлэх зүйлгүй байх.

Дээрх гэмт хэргийн зүйлчлэл өөрчлөгдсөн хэргийн тухайд шинжлэн үзвэл хэдийгээр тухайн 2 хохирогчдод хүч хэрэглэх, хууран мэхлэх аргыг ашиглаагүй боловч санхүүгийн бололцоо муутай оюутан болон гэр бүлийнхний өвчтэй зэрэг бусад эмзэг байдлыг далимдуулан бусдыг элсүүлсэн, дамжуулсан үйлдэл байгаа нь хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг бүрэн агуулж байна. Тухайлбал, хохирогч Ц-ийн “сургалтын төлбөрөө олох гээд мөнгө хэрэгтэй байгаагаа хэлсэн..., хамтдаа газар үзэхээр БНХАУ-ын Эрээн хот явсан Монголоос гараад Эрээн хотод ирснийхээ дараа биеэ үнэлж богино хугацаанд их мөнгө олж болно гэсэн..., гадаад паспорт гаргуулах мөнгийг хувааж төлсөн, миний замын зардлыг дааж ирсэн..., Ян Пин гэх хүн БНХАУ-

⁷⁶ Шүүхийн шийтгэх тогтоол. 2013 оны 198 тоот шүүхийн шийтгэх тогтоол.

ын Эрээн хотод ирэнгүүтээ бидний гадаад паспортыг хурааж авсан..., өдөрт 4-5 удаа бэлгийн харьцаанд оруулдаг байсан...” гэсэн мэдүүлгүүд мөн хохирогч С-ийн “намайг Эрээн хотод хүргэж өгөөд маргааш нь буцсан, миний гадаад паспортыг хурааж авсан..., хүргэж өгөөд мөнгө авдаг гэж сонссон” зэрэг мэдүүлгээс тухайн хохирогчдын эмзэг байдлыг ашигласан, гадаад паспортыг хураан авч эрхшээлдээ оруулсан ба 4-5 удаа бэлгийн харьцаанд ордог, 7 хоногийн дараа авах ёстой хөлсийн тодорхой хувийг авч байсан нь бэлгийн мөлжлөгөд өртүүлсэн шинж байгаа юм.

Шүүхийн мэдээ⁷⁷-нээс үзэхэд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргүүдийн цөөн хувийг тодруулбал 4 хэрэг тутмын 1 нь шүүхээр хэлэлцэгдэн шийдвэрлэгдэж, зарим хэргийн зүйлчлэлийг өөрчилж, 124 дүгээр зүйлээр ял оногдуулдаг нь харагдаж байна.

Дээрх нөхцөл байдлыг авч үзэхэд Эрүүгийн хуульд тодорхой бус байдаг зарим ойлголт, тухайлбал, мөлжлөгөд өртөнө гэдгээ урьдчилан мэдэж байсан, орлогын тодорхой хувийг авдаг, гадаад паспорт болон бусад зүйлийг барьцаалан эрхшээлдээ байлгах зэрэг практикт хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргүүдийн бүрэлдэхүүний шинж, зүйлчлэлийн талаар нэг мөр ойлголттой болгох нь зүйтэй байна. Түүнчлэн шүүхийн шийдвэрт анализ хийх явцад ЭБШХ-ийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан “Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ” гэсэн гэм буруугүйд тооцох зарчмын дагуу хэрэгт хандаж, хүн худалдаалах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 124 дүгээр зүйлээр зүйлчлэн хөнгөн ял шийтгэж байгаа нь харагдсан.

Шүүхээс эсхүл прокурорын хяналтын шатанд хэргийн зүйлчлэл өөрчлөгдөж, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл болж байгаа нь ихэнх тохиолдолд “хохирогчдоос таныг биеэ үнэлсний төлөө төлбөр төлдөг байсан уу, та биеэ үнэлснийхээ төлөө төлбөр авдаг байсан уу” мөн “хүч хэрэглэж байсан уу, одоо гомдол санал байна уу”⁷⁸ зэрэг асуулт тавьдагтай холбоотой байна. Гэтэл дээрх төлбөрийн тодорхой хувийг авч байсан нь тухайн этгээдийн анхан шатны амьдралын хэрэгцээг хангах хэмжээний төлбөр эсхүл биеэ үнэлж хуримтлуулж буй төлбөр байсан уу гэдэгт анхаарлаа хандуулаагүй байгааг анхаарах шаардлагатай. Хүн худалдаалах гэмт хэргийн биеэ үнэлэхэд бусдын татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс ялгахдаа төлбөр авсан гэдэг хариултаас бусад асуудлыг үл анхаарч, мөлжих зорилгыг үгүйсгэж, 124 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг байна гэж үзэх хандлага байгааг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, зохион байгуулах болон хүн худалдаалах гэмт хэрэг гэсэн энэ 2 гэмт хэргийг ялган зүйлчлэхээс гадна тэдгээрийг Эрүүгийн хуулийн 123, 126, 108, 109 дүгээр зүйлд заасан гэмт хэргээс ялган зүйлчлэхийг анхаарах хэрэгтэй. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулахдаа хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх арга хэрэглэдэг ба энэ нь бусдыг зодох, бие махбодид гэмтэл учруулах, эсхүл хохирогчийн өөрт нь болон ойр төрлийн

⁷⁷ “Хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн байдал”, судалгааны тайлан, Улаанбаатар, 2010 он. 12 дахь тал.

⁷⁸ Хууль Сахиулах Их Сургууль, “Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам”, судалгааны тайлан, Улаанбаатар, 2014 он.

хүмүүст хүч хэрэглэх, зодох, хүчиндэх, нэр төрд нь халдана гэж сэтгэл зүйн дарамт шахалт үзүүлсэн эсэхийг шалгах шаардлагыг агуулж байгааг анхаарах нь зүйтэй. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулахдаа бие махбодид нь гэмтэл учруулсан, хүн худалдсан, хүчиндсэн нь тогтоогдвол нийлмэл гэмт хэргээр зүйлчилнэ.

Эрүүгийн хуулийн 124 зүйлээр гэмт хэргийг зүйлчлэхэд бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулсан, биеэ үнэлэхийг байнга зохион байгуулсан, биеэ үнэлэх газар байгуулсан, биеэ үнэлэхийг санхүүжүүлсэн, биеэ үнэлэхэд зуучилсан, биеэ үнэлэхэд тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн зэргийг тогтоох мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийг хангах зорилгоор орон байр, тээврийн хэрэгсэл, бусад зүйлсийг хураах, битүүмжлэх зэрэг нотолгооны үйл ажиллагааг нэн даруй гүйцэтгэж, гэмт этгээдийн эд хөрөнгийн байдлыг шалган тогтоож, торгуулийн ял оногдуулах нөхцлийг хангах зэргийг авч үзэх хэрэгтэй байна.

1.4. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх Монгол Улсад үйлчилж буй хууль тогтоомжийн өнөөгийн байдал

Монгол Улсад 2002 оны Эрүүгийн хуульд анх удаа хүн худалдаалах гэмт хэргийг хуульчлан оруулсан боловч үүнээс өмнө буюу 2000 онд Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд “Хүний биеийг нь үнэлүүлэх зорилгоор гадаадад гаргасан бол 3-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх” заалтыг шинээр оруулсан нь хүний биеийг нь үнэлүүлж ашиг олох зорилгоор худалдах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг шийдвэрлэх анхны заалт байсан.⁷⁹ Хэдийгээр 2002 онд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд “Хүн худалдах, худалдан авах” гэмт хэргийг зүйлчилсэн боловч хүлээлгэх хариуцлагын хэрэгжилт хангалтгүй, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан хэргүүд хэрэгсэхгүй болох явдал түгээмэл байсан.⁸⁰ Иймд хүн худалдаалах гэмт хэргийн Эрүүгийн хууль тогтоомжийн зарим зүйл, заалтыг зөв хэрэглэх талаар УДШ-ээс тайлбар гаргасан ба мөн 2008 оны нэмэлт өөрчлөлтөөр Эрүүгийн хуульд тайлбар оруулсан нь тус гэмт хэргийг зүйлчлэхэд онол, практикийн ач холбогдлыг бий болгосон.

Цаашилбал, УИХ-ын 2010 оны 48 дүгээр тогтоолоор “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” шинээр батлагдсан ба энэ үзэл баримтлалын 3.4.4-т “Иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах” заалт шинээр орж батлагдсан нь хүн худалдаалахтай тэмцэх төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх суурь болсон билээ. 2012 оны 01 дүгээр сарын 19-нд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль батлагдаж, үүнтэй холбоотойгоор Зар сурталчилгааны тухай, Садар самуун явдалтай тэмцэх, Эрүүл мэндийн, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн, Иргэний бүртгэлийн, Эрүүгийн болон ЭБШ хуулиудад нэмэлт өөрчлөлт орсон нь эрх зүйн орчин бүрдүүлэх чухал арга хэмжээ авсаар байгаагийн илрэл болсоор байна.

Үүний үр дүнд Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйл⁸¹-ээс “биеэ үнэлэх” гэснийг хассанаар насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оруулсан нь олон улсын

⁷⁹ С.Гантулга, З.Төрмандах “Хүн худалдаалах гэмт хэрэг” Улаанбаатар, 2008 он. 17 дахь тал.

⁸⁰ Б.Бат-Эрдэнэ, “Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал”, Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал сэдэвт олон улсын бага хурал, 2012 он.


⁸¹ Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах.

болон дотоод баримт бичгийн дагуу хүн худалдаалах гэмт хэрэгт тооцогдох, Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн 123.2 дахь хэсгийг хүчингүй болгож, 123.3 дахь хэсгийн “Энэ хэргийг насанд хүрээгүй хүнд хүч хэрэглэж буюу” гэснийг хассанаар 18 насанд хүрээгүй хүнийг садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлсийг бэлтгэхэд ашигласан, ашиглахын тулд хүч хэрэглэсэн бол Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр зүйлчлэгдэх, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр тодорхойлсон гэмт хэргийн бүрэлдэхүүнээс “хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулах” гэсэн объектив талын шинжийг тодорхойлсон хэсгийг хассанаар энэхүү шинж бүхий үйлдэл нь Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр зүйлчлэгдэх боломж бүрдсэн байна.⁸²

1.5. Монгол Улсын хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, бие үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн нөхцөл байдал

Цагдаагийн ерөнхий газраас авсан гэмт хэргийн статистик мэдээнээс үзэхэд Монгол Улсад хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, бие үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг тогтмол бүртгэгдэж, нийгмийн хор аюул нэмэгдэх хандлагатай байна.

График 1. 2008-2014 онд Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, бие үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн тоо⁸³



Дээрх судалгаанаас үзэхэд хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, бие үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн гаралт тогтмол бүртгэгдэж байгаа боловч эрх зүйн зохицуулалтын боловсронгуй бус байдал, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчид энэ гэмт хэргийн талаар нэгдсэн ойлголтгүй, энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөх ажиллагаа явуулах арга зүй дутмаг, гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо хангалттай бүрдээгүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан цагдаагийн болон тагнуулын байгууллагад бүртгэгдэх

⁸² Б.Бат-Эрдэнэ, “Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал”, Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал сэдэвт олон улсын бага хурал, 2012 он.

⁸³ Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвийн статистик дүн мэдээ.

энэ төрлийн гэмт хэргийн тоо бодит амьдралд үйлдэгдэж буй хэргийн тооноос харьцангуй бага байна гэж үзэх үндэслэлтэй байна.⁸⁴

Түүнчлэн, бүртгэгдсэн гэмт хэрэгт мөрдөх ажиллагаа явуулахдаа гэмт хэргийн бүрэлдэхүүнийг болон эрүүгийн хэрэгт нотлогдвол зохих нөхцөл байдал, тухайн хэргийн онцлог байдал зэргийг тогтоож чадаагүйгээс шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хэрэгсэхгүй болох, зүйлчлэл өөрчлөгдөж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 124 дүгээр зүйлд заасан биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг болох тохиолдол цөөнгүй байгаа⁸⁵ нь судалгааны явцад харагдаж байна. Жишээлбэл, зөвхөн хохирогчийн мэдүүлэгт үндэслэн хэргийг зүйлчлэх, сэжигтний мэдүүлгийг эх сурвалжаа зааж чадаагүй байдлыг түүнд ашигтайгаар шийдвэрлэх зэргээр эдгээр хэргүүдийг ялган зүйлчлэхэд шүүхийн шатны болон эрүүгийн хянан шийдвэрлэх бусад шатны явцад ч хүндрэл учирч байна.

График 2. Хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал





График 3. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн болон шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн харьцуулалт



⁸⁴ Хууль Сахиулах Их Сургууль, “Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам”, судалгааны тайлан, Улаанбаатар, 2014 он.

⁸⁵ Мөн тэнд

1.6. Хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, бие үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдалд дүн шинжилгээ хийх нь⁸⁶

Сүүлийн 3 жилд Эрүүгийн хуулийн 113 болон 124 дүгээр зүйлээр шийдвэрлэсэн шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийхэд нийт 17 хэрэг байгаагаас 4 нь гурван шатны шүүхээр, 4 нь давж заалдах шатны шүүхээр үлдсэн 9 нь анхан шатны шүүхээр шийдвэрлүүлсэн байна. Эрүүгийн хуулийн 113, 124 дүгээр зүйлийн 124.2-оор давхар зүйлчилсэн хэрэг 3 байгаа нь нийт хэргийн 17.6 хувийг эзэлж байна.

Асуудал 1: Судалгааны явцад нийт дүн шинжилгээ хийсэн шийтгэх тогтоолоос гурав нь Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.3-аар нийт 9 шүүгдэгчид яллах дүгнэлт үйлдэн ирүүлсний 5 холбогдогчийн хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан ба 1 холбогдогчид Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлийг баримтлан хорих ялыг хөнгөрүүлж оногдуулсан байна.

Асуудал 2: Шүүхийн практикт Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр зүйлчлэхээс илүүтэйгээр Эрүүгийн хуулийн 124 зүйлээр зүйлчлэх хандлага элбэг төдийгүй тэдгээр ял шийтгүүлсэн гэмт хэрэгтний ихэнх нь тэнсэн харгалздаг, зарим нь Өршөөлийн хуульд хамрагдаж хорих ялаас хэлтрүүлсэн байна. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр прокуророос яллах дүгнэлт үйлдэн ирүүлсэн боловч шүүх бүрэлдэхүүн мөн хуулийн 124 дүгээр зүйлээр өөрчлөн зүйлчилсэн хэрэг 1 байна.

Асуудал 3: Эд хөрөнгө хурааж, улсын орлого болгосон тохиолдол байгаа хэдий ч төдийлөн түгээмэл бус мөн хохирогч гомдол нэхэмжилсэн болон хохирлыг нөхөн төлүүлсэн нь бараг байхгүй байна. Ялангуяа, мөрдөн байцаалтын шатанд “чи өөрөө дуртайдаа биеэ үнэлээ биз дээ” гэсэн хандлага, түүнчлэн зарим эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлтэй болж, хүүхэд гаргасан байдаг тул энэ асуудлаас түргэн салах сонирхолтой болсон байдаг учраас хохирол нэхэмжлэх байдал байдаггүй нь ажиглагдаж байна.

Хоёр. Танхайрах болон бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл санаатайгаар учруулах гэмт хэрэг

2.1. Танхайрах гэмт хэрэг

Танхайрах гэмт хэрэг нь нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээг зөрчин хувийн явцуу ашиг сонирхлыг нийгэм, хамт олны эсрэг сөргүүлэн тавьж байдаг. Энэ төрлийн гэмт хэрэг нь бусдыг доромжлох, айлган сүрдүүлэх, хүч хэрэглэн зодох, эд хөрөнгийг эвдэн сүйтгэх зэргээр нийгэм, иргэдийн ашиг сонирхолд эд материалын болон сэтгэл санааны ноцтой хор уршиг учруулах зэрэг үйлдлээр илэрдэг.


⁸⁶ Энэ хэсгийн судалгааг УДШ-ийн 2009, 2010, 2011, 2012, 2013 оны тайлан мэдээ, 2002-2008 оны энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн ХЗҮХ-ийн судалгааны тайлан, түүнчлэн сүүлийн 3 жилд шүүхээр шийдвэрлэсэн 17 шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийж судалсан.

Танхайрах төрлийн гэмт хэргийг 2002 оны Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.1-д “Бусдыг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг ноцтой зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан хүндэвтэр гэмт хэргийн тоонд ордог.

Танхайн төрлийн гэмт хэргээр ял шийтгүүлсэн хүний тоо улсын хэмжээнд нийт ял шийтгүүлсэн хүний 15 орчим хувийг эзэлж байна. ШСМСХ-ийн шүүн таслах ажиллагааны статистикийн мэдээнээс үзэхэд танхайрах төрлийн гэмт хэрэг нийт шийдвэрлэж байгаа гэмт хэргийн 13 орчим хувийг эзэлж байна. Сүүлийн гурван жилд танхайрах гэмт хэргийн тоо буурах төлөвтэй байгаа бөгөөд 2011 онд 863 хэрэг, 2012 онд 819 хэрэг, 2013 онд 729 хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна.⁸⁷ /График 4/

Танхайн төрлийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлыг сүүлийн гурван жилийн дунджаар авч үзвэл нийт танхайн гэмт хэргийн тал орчим хувь нь нийслэлд гарч байна. Танхайн гэмт хэргийг Хэнтий, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн шүүхэд хамгийн их шийдвэрлэсэн бол Баян-Өлгий, Ховд, Өвөрхангай аймгуудад хамгийн бага тоогоор шийдвэрлэсэн байна.

График 4. Шүүхээр шийдвэрлэсэн танхайрах гэмт хэргийн тоо



Танхайрах төрлийн гэмт хэргээр ял шийтгүүлсэн хүний тоо 2011 онд 1327, 2012 онд 1172 байсан бол 2013 онд 1119 болж сүүлийн гурван жилд дараалан буурсан байна.

2.2. Танхайрах гэмт хэргийн зүйлчлэлийн зарим асуудал

Эрүүгийн хууль хэрэглэх эрх бүхий субъектын хамгийн анхаарах асуудал бол хуульд тусгагдсан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг практикт хэрхэн хэрэглэх, зүйлчлэх асуудал болдог. Танхайрах гэмт хэргийн шинжийг нарийвчлан тогтоох нь зөв зүйлчлэх үндэс болно. Үйлдэгдсэн гэмт хэргийн шинж эрүүгийн эрх зүйн хэм хэмжээн дэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй бүрэн нийцэж байгааг шүүхээс тогтоон шийдвэрлэхэд дараах хүчин зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

⁸⁷ Шүүхийн ерөнхий зөвлөл, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны мэдээ 2011, 2012, 2013 он.

1. Танхайрах гэмт хэргийн нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн олон нийтийг илтэд хүндэтгэн үзээгүй заавал байх шинжүүд нь ямар хэлбэрээр, ямар нөхцөлд илэрсэн байхыг хэрэг нэг бүрт тал бүрээс нь нарийвчлан тогтооход анхаарах. Тухайлбал, ёс хонзон, хардалт, уур хорсол зэрэг хувийн сэдэлтээр харилцан зодолдохдоо бие биедээ гэмтэл учруулсан ба учруулаагүй үйлдлийг танхайрах гэмт хэрэг хэмээн зүйлчилж болохгүй;
2. Танхайрах гэмт хэргийн бүрэлдэхүүний заавал байх шинж нь танхайн сэдэлтээр олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчих явдал мөн.⁸⁸

Танхайрах гэмт хэргийг зөв зүйлчлэхэд нийгмийн хэв журам гэсэн ойлголтыг зөв тодорхойлохыг шаарддаг. Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэрэг болон захиргааны зөрчлөөс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар УДШ-ийн 2007 оны 10 дугаар сарын 29 ний өдрийн 41 дүгээр тогтоолд “Нийгмийн хэв журам” гэдэгт “нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээг ойлгоно. Энэхүү хэм хэмжээг хууль тогтоомж, зан заншил, ёс суртахууны шаардлагын алинаар нь ч тогтоосон байж болно”⁸⁹ гэж тайлбарласан. Гэхдээ олон нийтийн газар нийгмийн хэв журам гэсэн ойлголтод шууд утгаараа хамаарахгүй орон зайд үйлдэгдсэн гэмт хэргийг танхайн гэмт хэрэг гэж зүйлчлэх үндэстэй тохиолдлууд практикт гардаг. Тухайлбал, Монгол Улсын амьдралын хэв маягаас шалтгаалан хөдөө орон нутагт, хүн цөөнтэй газар, эзгүй хээр танхайрах үйлдэл гаргаж зэрлэгээр авирласан хэрэг ихээхэн гардаг тул танхайн хэргээр зүйлчлэх шаардлага гардаг.

Танхайрах гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг тул олон нийтийг илтэд үл хүндэтгэн хүч хэрэглэхээр заналхийлж, нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн үйлдэл хийснээр төгссөнд тооцдог, хор уршиг учирсан байхыг шаарддаггүй. Эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэргийг үйлдэж, төгссөн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээс гадна гэмт хэргийг үйлдэхээр бэлтгэх, завдсан үед хариуцлага хүлээлгэх заалттай. Танхайрах гэмт хэргийн бусад оролцогч мэдээгүй, тэдэнтэй тохиролцоогүй гэмт хэрэг үйлдсэнийг зөрчиж гүйцэтгэсэн гэх бөгөөд зөрчиж гүйцэтгэсэн хэрэгт тухайн этгээд зөвхөн өөрөө эрүүгийн хариуцлага хүлээнэ.⁹⁰

Танхайн гэмт хэргийн хамгийн гол анхаарах зүйл нь танхайн сэдэлт байдаг.⁹¹ Танхайрах гэмт хэрэг нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс гэмт хэргийн сэдэлт, санаа зорилго зэрэг субъектив талын шинж, мөн үйлдэл, үр дагавар

⁸⁸ USAID, ХЗҮХ. Танхайрах гэмт хэрэг, сургалтын гарын авлага, Улаанбаатар, 2007 он. 7 дахь тал.

⁸⁹ Монгол Улсын Дээд шүүхийн 41 дүгээр тогтоол. 2007 он.

⁹⁰ USAID, ХЗҮХ. Танхайрах гэмт хэрэг, сургалтын гарын авлага, Улаанбаатар, 2007 он. 45 дахь тал.

⁹¹ Танхайн сэдэлт гэдгийг “иргэд хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээгээр хэрэгжиж ёс суртахууны болон хүмүүсийн зан үйлтэй холбогдох нийтээр хүлээн зөвшөөрсөн хэв журмыг зөрчин тухайн орчиндоо илтэд хүндэтгэлгүй хамаа бус хандсан, үйлдэлдээ элдэв юмсыг эсхүл зэвсэг хэрэгсэл түүнтэй адилтгах зүйлсийг хэрэглэх, хэрэглэхээр завдах эсхүл үүнийгээ хатуу ширүүн үгээр илэрхийлэн орчны хүмүүсийг айлган сүрдүүлж түгшээх, жигшил дургүйцлийг төрүүлэх зэргээр хэрцгий догшин авирлан нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчсөн шууд санаатай үйлдэл болохыг ойлгоно” гэж тодорхойлжээ. С.Жанцан. “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй.” Улаанбаатар, 2002 он. 469 дэх тал.

зэрэг объектив талын шинжээр ялгагдана. Харин тодорхой сэдэлттэй, тухайлбал, хувийн таарамжгүй харьцаа, эр эмийн халдлага, хохирогчийн зүй бус ажиллагаа зэргээс үүдэн өөр хоорондоо маргалдсан, зодолдсон, доромжилсон, бие махбодид нь гэмтэл учруулсан нь олон нийтийг илтэд хүндэтгэн үзээгүй буюу нийгмийн хэв журмыг бүдүүлгээр зөрчөөгүй байвал хүний амь бие, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэргээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

2.3. Бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр болон хөнгөн гэмтэл учруулах гэмт хэрэг

Танхайн гэмт хэргийг зүйлчлэхэд бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл санаатай учруулсан хэрэгтэй ижил байдлаар голчлон зүйлчилдэг. Иймд танхайн гэмт хэрэг болон бусдын биед гэмтэл учруулах гэмт хэргийн зүйлчлийн зааг ялгааг нарийн гаргах шаардлагатай.


Монгол Улсын Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-д “Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан, өөрөөр хэлбэл амь биед нь аюултай гэмтэл учруулсан буюу хараа, сонсголгүй болгосон, эрхтнээс нь хагацуулсан, ажиллагаагүй болгосон, нүүрийг засаршгүй эвдэж дүрсийг алдагдуулсан, хүүхэд дутуу гаргуулсан буюу ураг зулбуулсан, сэтгэцийн өвчтэй болгосон, түүнчлэн хөдөлмөрийн чадварыг бүрмөсөн алдагдуулсан бол таваас дээш долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан бөгөөд Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн 96.2.1-д “танхайн сэдэлтээр” хүнд гэмтэл учруулсныг 181 дүгээр зүйлд заасан танхайрах гэмт хэргээр зүйлчлэх, эсвэл 181 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг дээрх зүйлээр зүйлчлэх тохиолдол гарсаар байна.⁹²

Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах нь тухайн гэмтэл учирсан тэр үедээ хүний амь насанд аюулгүй, 96 дугаар зүйлд заасан ноцтой үр дагаварт хүргэхгүй зэргээрээ хүнд гэмтэл учруулахаас ялгаатай байна. Эрүүгийн хуулийн 98 дугаар зүйлд заасан гэмт хэргийн объект нь иргэдийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангаж байгаа нийгмийн харилцаа юм. Энэ гэмт хэргийн объектив тал нь бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулсан үйлдэл, хүний бие махбодид хүндэвтэр гэмтэл учруулсан хор уршигтай үр дагавар, гэмт үйлдэл болон гэмт үр дагаврын хоорондох шалтгаант холбоо зэрэг юм. Субъектив тал нь санаатай гэм буруугийн хэлбэртэй, шууд ба шууд бус санаатай байна. Ихэвчлэн санаа нь тодорхой бус байдаг. Тухайн гэмт хэргийн зорилго сэдэлт янз бүр байна. Субъект нь 14 нас хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хувь хүн байна.⁹³ Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны мэдээнээс үзвэл сүүлийн 3 жилд энэ төрлийн гэмт хэрэг өсөх хандлагатай байна. /График 5/

⁹² USAID, ХЗҮХ. Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг сургалтын гарын авлага, Улаанбаатар, 2007 он.

⁹³ Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-зайделийн сан. “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”. 2013 он. 283 дахь тал.

График 5. Бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулах гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо



Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах нь эрүүл мэндийг нь түр хугацаагаар сарниулсан буюу хөдөлмөрийн чадварыг бага хэмжээгээр алдагдуулах, эсхүл энэ хоёр үр дагаварт нэгэн зэрэг хүргэх байдлаар илэрдэг. Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн объект нь иргэдийн эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангаж байгаа нийгмийн харилцаа бөгөөд объектив тал нь бусад хүний бие махбодь, эрүүл мэндэд хөнгөн гэмтэл учруулсан нийгэмд аюултай үйлдэл /эс үйлдэхүй/, хүний бие махбодид хөнгөн гэмтэл гэдэг нь эрүүл мэндийг нь түр хугацаагаар сарниулсан буюу хөдөлмөрийн чадварыг бага хэмжээгээр алдагдуулах байдлаар илэрнэ.

2.4. Шүүхийн практик

Танхайн гэмт хэргийн зүйлчлэлийн асуудлыг илүү ойлгомжтой болгох зорилгоор тодорхой гэмт хэргийн шийдвэрлэсэн байдлыг судалсан. Үүнд:

1) Хэргийн товч агуулга:

Нийслэлийн иргэн Н хөдөө орон нутагт нэгэн сувиллын газарт амраад буцах өдрөө тухайн газраас хонь худалдан авчээ. Хонь худалдан авсан айлын эзэн тухайн үед гэрт нь зочилж байсан нутгийн иргэн Б-г хонь төхөөрч өгөхийг хүсчээ. Хонь худалдан авсан айлд иргэн Н, Б болон бусад хүмүүс 1 шил архи зэргийг ууж дуусгаад гэрээс гарахад Б, Н-ээс дахин архи байна уу хэмээн асуухад Н байхгүй гэж хэлээд голын эрэг рүү явж, Б хонийг төхөөрчээ. Хэсэг хугацааны дараа Н эргэн ирж, миний хонины мах хаана байна гэж асуухад Б “нохойд хаяад өгчихсөн” гэж хэлчихээд дээлээ өмсч байх үед нь Н уурлан хутга авч Б-ийн мөрөн тус газар хутгалжээ. Хохирогч Б шүүхэд гомдол гаргасан байна.

2) Шүүхээс шийдвэрлэсэн байдал:

Прокуророос ирүүлсэн яллах дүгнэлтэд тусгаснаар иргэн Н нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ үл ялих зүйлээр шалтаглан, зэвсгийн чанартай зүйл хэрэглэн бусдыг хутгалж, бие махбодид хүндэвтэр гэмтэл учруулж, танхайрсан гэмт хэрэгт холбогдсон хэмээн яллах дүгнэлт ирүүлсэн байна.

Анхан шатны шүүхээс: Иргэн Н-г согтуугаар зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, танхайрах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйлийн 181.3-т зааснаар шүүгдэгч Н-г 3 жил 5 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэсэн байна.

Давж заалдах шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч Н, шүүгдэгчийн өмгөөлөгч Д нарын гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 1 дэх заалтад "...Шүүгдэгч Н-ыг согтуугаар зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, танхайрах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцсугай..." гэснийг "... Н-ыг бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл санаатай учруулсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцсугай..." гэж хэргийн зүйлчлэлийг өөрчлөн шийдвэрлэсэн байна.

3) Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Тус гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэлийн асуудлыг бүхэлд нь дүгнэвэл танхайн төрлийн гэмт хэрэг, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэгтэй ижил төстэй болох нь харагдаж байна. Энд танхайн гэмт хэрэг нь эмх замбараагүй гэнэт үүссэн шинжтэй байдаг гэж давж заалдах шатны шүүх хуралдаанд тайлбарласан прокурорын тайлбар, гэмт хэрэг үйлдэхээс өмнө танхайн гэмт хэргийн үндсэн шинж тэмдэг болох бусдыг илтэд үл хүндэтгэж, хэрүүл маргаан үүсгэж, нийгмийн хэв журмыг зөрчсөн үйлдэл хийгээгүй байхад танхайрах гэмт хэрэг гэж зүйлчлэх нь буруу гэж үзсэн хяналтын шатны шүүх хуралдааны тайлбарыг гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад харгалзан үзэж, гэмт хэргийг зүйлчлэхдээ гэмт хэргийн үйлдлийн дараалал, зүйл ангийн талаарх ойлголтын шинж тэмдгүүдийг харгалзан үзэх шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт

Энэ судалгаанд ижил төстэй хянан шийдвэрлэгдэж байгаа гэмт хэргүүд болох Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл буюу хүн худалдаалах болон Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл буюу биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг бөгөөд Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйл буюу танхайрах гэмт хэрэг болон Эрүүгийн хуулийн 96, 98, 99 дүгээр зүйл буюу бусдын бие махбодид хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл санаатайгаар учруулах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, гэмт хэргийн бүрэлдэхүүн, зүйлчлэлийн асуудлуудыг судалсан болно. Ингээд эдгээр 4 төрлийн гэмт хэргийг зүйлчлэхэд анхаарах дараах зүйлүүдийг дэвшүүлж байна. Үүнд:

- Хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн хувьд хоёуланд нь бэлгийн мөлжлөг байдаг. Ялгаа нь биеийг нь үнэлүүлээд тодорхой хэмжээний төлбөрийн хувийг өгдөг, ихэнх хувийг өгдөг, огт төлбөр өгөхгүйгээр мөлждөг. УДШ-ийн 2008 оны 3 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоолын 4.3-т заасан "хүн худалдаалах гэмт хэрэгт хохирогчийн биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсны орлого бүхэлдээ гэмт этгээдийн ашиг болно, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн хувьд тодорхой хэсэг нь гэмт этгээдийн мэдэлд шилжинэ" гэж тайлбарласан байдаг учраас маш бага хэмжээний төлбөр өгсөн хэдий ч энэ нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлж байна. Тэгвэл практикт гэмт этгээд биеийг нь үнэлүүлсний төлбөрөөс тодорхой хэмжээний хувийг өгөхдөө амьдралын наад захын хэрэгцээг хангах маш бага хэмжээний гарын мөнгө

- өгдөг бол зарим тохиолдолд орлогын 70 хувь буюу мөнгөн хуримтлал үүсэх хэмжээний мөнгө өгдөг ч тохиолдол байдаг.
- Нутаг дэвсгэрийн тухайд хүн худалдаалах болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг нь хилийн гадна үйлдэгдэж болдог, хүн худалдаалах гэмт хэргийн тухайд хил давуулан худалдаалсан нь хүндрүүлэх бүрэлдэхүүн болдог бол биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн тухайд ийм эрх зүйн зохицуулалт байдаггүй. Гэтэл шүүхийн практикт хил давуулсан бол Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бол Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл гэж үзэж зүйлчлэх нь цөөнгүй байна.
 - Дээрх 2 гэмт хэргийн хувьд хохирогч, гэрчийн мэдүүлгэд үндэслэн бусад нотлох баримтыг шаардахгүйгээр шүүхийн шийдвэр гаргах хандлагатай байгаа нь тухайлбал, хохирогч өөрөө биеэ үнэлэхээ мэдэж байсан гэсэн үндэслэлээр түүнийг бусдын эрхшээлд байсан, гадаад паспортыг хураан авсан, аваачиж өгсөн этгээдэд хүлээн авагч тал төлбөр төлсөн зэрэг асуудлыг хөндөөгүй орхигдуулсан байдаг.
 - Түүнчлэн шүүхээс Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор биеийг нь үнэлэх, ингэхдээ хохирогчийн хүсэл зоригоос гадуур, тулган шаардаж хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, хохирогчийг бэлгийн харьцаанд оруулдаг, түүнчлэн эрх, эрх чөлөө гэмт этгээдээс бүрэн хамааралтай боолчлогдох шинжтэй байдаг бол Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн хувьд эрх чөлөө бүрэн хязгаарлагдсан шинжгүй байна гэж УДШ-ээс тайлбарласан нь зүйлчлэлийн асуудалд эргэлзээ төрүүлж, бүрэн хязгаарлагдах болон хязгаарлагдаагүй гэдгийг тайлбарлах шаардлагыг бий болгодог.
 - Биеэ үнэлэхийг урьдчилан мэдээгүй байдаг гэсэн үндсэн шинжийг баримтлан зүйлчлэлийн асуудалд ханддаг байдал тогтсон бөгөөд биеэ үнэлэхийг мэдэж байсан боловч бусдын бүрэн хяналтад орж өдөр шөнөгүй бэлгийн мөлжлөгөд өртүүлэх болон хоол унд өгөхгүй, бие махбодид нь халдаж зодох, дарамтлах зэрэг байдал үүсэхийг таамаглаагүй байсан нь зарим хохирогчдын мэдүүлгээс харагдаж байна. Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг протоколын 3 дугаар зүйлийн "... хохирогч өөрийг нь мөлжих буюу биеийг нь үнэлүүлэх гэж байгааг зөвшөөрснийг хэрэгсэхгүй ..." гэсэн заалттай зөрчилдөж байна.
 - Танхайн гэмт хэргийг шийдвэрлэхдээ гэмт хэргийн бүрэлдэхүүн, тэр дундаа тухайн хэргийн үйлдлийн дарааллыг анхааралтай ажиглах шаардлагатай байна. Тухайлбал, судалгаанд гарсан нэг жишээнд гэмт хэргийн зүйлчлэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 181 дүгээр зүйл буюу танхайн гэмт хэргээр зүйлчлэгдэн анхан болон давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг хяналтын шатны шүүхээр 98 дугаар зүйл буюу бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг болж өөрчлөгдсөн байна. Тус гэмт хэргийн зүйлчлэл танхайн гэмт хэргээс бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулах болж өөрчлөгдсөн шалтгаан нь хохирогч Б анх удаа уулзсан, огт

танихгүй хүнээр тоглоом хийж, бухимдуулснаас болж тухайн хүн гэмт хэрэг үйлдэх болсон гэж үзсэн байна. Тус гэмт хэргийг шийдвэрлэхэд үйлдлийн дарааллыг онцгойлон анхаарсан байна.

- Танхайн гэмт хэргийг хүндрүүлэх нөхцлөөр зүйлчлэхдээ гэрч, хохирогчийн мэдүүлгүүдийг сайтар анхаарах шаардлагатай бөгөөд зэвсэг хэрэглэн бусдын бие махбодид хөнгөн гэмтэл учруулсан тохиолдолд хүндрүүлэх нөхцөлтэйгээр зүйлчилдэг. Харин гэрч хохирогчийн мэдүүлгүүд зөрүүтэй, нотлох баримт хангалтгүй байгаа тохиолдолд 181.3 буюу хүндрүүлж зүйлчилж болохгүй. Судалгаанаас харахад бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатайгаар учруулсан хэргээр зүйлчилж болох байсан хэрэг нь орой үдшийн цагаар иргэдийн амгалан тайван байдал алдагдуулж, орц байрны гадаа бусадтай маргалдаж, орилж хашгирсан гэсэн үндэслэлээр танхайн хэргээр зүйлчлэгдэж, Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь заалтын дагуу ял шийтгүүлсэн тохиолдол байна.
- Танхайрах гэмт хэргийг бусдын бие махбодид хүндэвтэр болон хөнгөн гэмтэл санаатай учруулах гэмт хэргээс ялган зүйлчлэх хамгийн гол ялгаа нь олон нийтийг хамарсан, нийгмийн хэв журмыг зөрчих явцдаа бусдын бие махбодийг гэмтээх үйлдэл гаргасан бол танхайрах хэргийн зүйлчлэлээр, ахуйн хүрээнд хувь хүний эрүүл мэндийн эсрэг чиглэсэн бол бусдын бие махбодид хүндэвтэр болон хөнгөн гэмтэл санаатай учруулсан гэмт хэргийн төрлөөр зүйлчилнэ.

Санал, зөвлөмж

1. Хил давуулан үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн хувьд ихэвчлэн БНХАУ-ын Эрээн хот, Бээжин хотноо үйлдэгдэж байгаа тул энэ улсад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах боломжгүй гэдэг үндэслэлээр шүүхийн өмнөх шатанд нотлох баримт дутуу бүрдүүлж байгааг шүүхийн шатанд анхааран үзэх.
2. Биеэ үнэлээд төлбөрийн тодорхой хувийг авсан бол хүн худалдаалах гэмт хэрэг биш, мөлжлөгөд автуулаагүй байна гэж үзэх хандлагыг өөрчлөх. Өөрөөр хэлбэл, амьдралын наад захын хэрэгцээг хангах төдий гарын мөнгө өгөх, эсвэл олсон орлогын тодорхой хувийг өгч байгаа нэртэй хэдий ч хуурамч өрийн сүлжээ үүсгэн түүндээ суутгаж авах зэргээр мөлжиж байгаа байдлыг анзааран ийм тохиолдлыг Эрүүгийн хуулийн 113 буюу хүн худалдаалах гэмт хэрэгт тооцож зүйлчлэх.
3. Хүч хэрэглэх болон хүч хэрэглэхээр заналхийлээгүй боловч хууран мэхэлж хилийн чанадад аваачих, очсон хойно нь биеэ үнэлнэ гэж хэлдэг бөгөөд аргагүй байдалд оруулан бэлгийн мөлжлөгөд өртүүлсэн боловч урьдчилан хэлсэн, өөрөө зөвшөөрөөд үлдсэн гэж тайлбарладаг тохиолдол энэ хэрэгт цөөнгүй байна. Гэтэл үнэн хэрэг дээрээ яах ч аргагүй байдалд оруулсан, гадаад паспорт болон бусад зүйлийг хураан авч оргон зугтах боломжийг хаагдуулсан байдаг зэргээр эрх чөлөөг нь бүрэн хязгаарладаг нь түгээмэл байгааг анхаарч хүч хэрэглээгүй боловч зугтах боломжийг хаагдуулсан байдлыг хүн худалдаалах гэмт хэрэг гэж зүйлчлэх.

4. Шүүх хэргийг шийдвэрлэхдээ хохирогчийн хохирлыг барагдуулах талаар анхаарах, ялангуяа сэтгэл санааны болон бие махбодид дам учирсан хохирлыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах шийдвэр гаргах. Тухайлбал, нийт 17 шийтгэх тогтоолын 2 нь Монгол Улсын Иргэний хуулийн 497.1 болон 505.1 дэх хэсэгт зааснаар 2 хохирогчид 599,000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн нь хохирол нөхөн төлүүлэлт 11% байна. Иймд цаашид эдгээр гэмт хэргийн хохирогчдод сэтгэл санаа, бие махбодийн хохирлыг нөхөн төлүүлэх жишгийг шүүхэд тогтоох, түүнчлэн сэтгэл зүйчид хандах төлбөрийг гэмт хэрэгтнээр гаргуулдаг байх, бие махбодид нь хүчээр гоо сайхны мэс засал хийлгэсний хор хохирлыг төлүүлэх гэх мэт.
5. УДШ-ийн 2008 оны 3 сарын 26-ны 12 тоот тогтоолд тайлбарласан Эрүүгийн хуулийн 113 болон 124 дүгээр зүйлийг ялган зүйлчлэх тайлбарыг дахин нягталж, тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй. Тухайлбал, хохирогч биеэ үнэлнэ гэдгээ урьдчилан мэдсэн бол хүн худалдаалах гэмт хэрэг гэж тооцохгүй байгаа нь олон улсын хэм хэмжээг зөрчсөн төдийгүй гэмт этгээд ял завших, тэднийг өөгшүүлсэн үйлдэл болсоор байгааг анхаарах шаардлагатай.
6. Танхайрах гэмт хэрэг нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээс гэмт хэргийн санаа, зорилго зэрэг субъектив талын шинж, мөн үйлдэл, үр дагавар зэрэг объектив талын шинжээрээ ялгагдана. Танхайрах гэмт хэргийг зүйлчлэхэд гол анхаарах тулгуур асуудал бол танхайрах сэдэлтийг тогтоох нь нэн чухал болдог. Танхайрах сэдэлтгүйгээр дээр дурдсан олон нийтийн газруудад хувийн сэдэлтээр гэмт хэрэг үйлдвэл танхайрах гэмт хэрэг үгүйсгэгдэн гэдгийг анхаарах.
7. Олон нийтийн газар нийгмийн хэв журам гэсэн ойлголтод шууд утгаараа хамаарахгүй орон зайд үйлдэгдсэн гэмт хэргийг танхайн гэмт хэрэг гэж зүйлчлэх үндэстэй тохиолдлууд гардаг. Монгол Улсын амьдралын хэв маягаас шалтгаалан хөдөө орон нутагт, хүн цөөтэй газар эзгүй хээр танхайрах үйлдэл гаргаж зэрлэгээр авирласан хэрэг ихээхэн гардаг тул танхайн хэргээр зүйлчлэх.
8. Бусдын бие махбодид хүндэвтэр болон хөнгөн гэмтэл санаатай учруулах гэмт хэргийг танхайрах гэмт хэргээс ялган зүйлчлэх хамгийн гол ялгаа нь олон нийтийг хамаарсан, нийгмийн хэв журмыг зөрчих явцдаа бусдын бие махбодийг гэмтээх үйлдэл гаргасан бол танхайрах хэргийн зүйлчлэлээр, ахуйн хүрээнд хувь хүний эрүүл мэндийн эсрэг чиглэсэн бол бусдын бие махбодид хүндэвтэр болон хөнгөн гэмтэл санаатай учруулсан гэмт хэргийн төрлөөр зүйлчлэх зэрэг болно.

-оОо-

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ



ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРИЙН ҮНДЭСЛЭЛ, ТӨРӨЛ⁹⁴

Удиртгал

Шүүхийн шинэтгэлийг эрчимжүүлэх, агуулгын хувьд бодит үр дүнд хүргэхэд шат шатны шүүхээс гарах шийдвэр хоорондын зөрүүтэй байдлыг багасгах, шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг хангах явдал чухал нөлөө үзүүлнэ. Шүүхийн шийдвэр тогтвортой байх нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл тул анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр хууль хэрэглээний болон процессын зөрчилгүй нэгдмэл байх, хуулийг нэг мөр ойлгох явдлыг хангах нь чухал юм. Шүүхийн шийдвэр хууль ёсны байх гэдэгт “хэрэг, маргааны талаар материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээг тэдгээрийн агуулга, зорилго, үзэл санаанд нийцүүлэн, шүүхээс оновчтой, зөв тайлбарлан хэрэглэсэн тохиолдол”⁹⁵-ыг авч үздэг.

Судалгааны хүрээнд 2012, 2013 онд УДШ-ээр хянагдсан 573 иргэний хэргийн шийдвэр*, магадлалыг цуглуулж, анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон шалтгаан, нөхцлийг судалж, дүн шинжилгээ хийж, процессын зөрчил болон хууль хэрэглээний нийтлэг алдаа, зөрчлийг илрүүлэн цаашид авч хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг боловсруулсан болно.

Нэг. Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал, дүн шинжилгээ


Анхан шатны шүүхүүд 2011 онд 30368 иргэний хэргийг шийдвэрлэснээс 1803 хэрэг буюу нийт хэргийн 6 хувьд нь давж заалдах, 1089 буюу 3.5 хувьд нь хяналтын шатны шүүхэд хандсан бол 2012 онд анхан шатны шүүхээр 27792 хэргийг шийдвэрлэсэн бөгөөд үүний 1650 буюу 5.9 хувьд нь давж заалдах шатны шүүхэд, 955 хэрэг буюу 3.4 хувьд нь хяналтын шатны шүүхэд ханджээ.

⁹⁴ Тус судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ-ийн судалгаа хариуцсан референт Т.Түмэнцэцэг, судлаач Э.Өсөхжаргал, Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч П.Золзаяа, Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч, хууль зүйн ухааны доктор Ж.Оюунтунгалаг /LL.D/, Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч Г.Алтанчимэг нар хамтран гүйцэтгэсэн болно.

⁹⁵ Монгол Улсын Дээд шүүхийн 21 дүгээр тогтоол, “Шүүхийн шийдвэрийн тухай” 2006.04.24.

* Судалгаанд зөвхөн Нийслэлийн хэмжээнд 2012-2013 онд шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрийг авч үзсэн болно.

График 1. Иргэний хэргийн шүүхийн нийт шийдвэрлэсэн хэргийн тоо



Түүнчлэн 2013 онд 35314 хэргийг анхан шатны шүүхээс шийдвэрлэсний 1837 хэрэг буюу 5.2 хувь нь давж заалдах шатны шүүхээр, 983 хэрэг буюу 2.7 хувь нь хяналтын шатны шүүхээр тус тус шийдвэрлэгдсэн байна.

График 2. Анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүхийн магадлалаар өөрчлөлт оруулсан байдал




Давж заалдах шатны шүүх 2011 онд 1803 хэрэг хүлээн авч шийдвэрлэснээс 973 шийдвэрийг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 54 хувийг хэвээр үлдээж, 440 шийдвэр буюу 24.4 хувьд өөрчлөлт оруулсан байна. Анхан шатны шүүхийн 390 шийдвэр буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 21.6 хувийг хүчингүй болгожээ. Харин 2012 онд 1634 хэрэг хүлээн авч шийдвэрлэснээс 843 шийдвэр буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 51.6 хувийг хэвээр үлдээж, 393 шийдвэрийг буюу 24 хувьд өөрчлөлт оруулж, 398 шийдвэрийг буюу 24.4 хувийг хүчингүй болгосон байна.

Түүнчлэн 2013 онд 1806 хэрэг хүлээн авч шийдвэрлэснээс 821 хэргийг буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 45.5 хувийг хэвээр үлдээж, 492 шийдвэрийг буюу 27.2 хувьд өөрчлөлт оруулж, 493 шийдвэрийг буюу нийт 27.3 хувийг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон магадлал 2009 оноос тогтвортой буурч байсан боловч 2012 оноос 2013 онд анхан

шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдсэн магадлал 25.2 хувиар, хүчингүй болгож шийдвэрлэсэн магадлал 23.8 хувиар тус тус өсчээ. Харин анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн магадлалын тоо 2.6 хувиар буурсан байна. Эндээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон, өөрчлөлт оруулсан магадлалын тоо өсч, хэвээр үлдээж шийдвэрлэсэн магадлалын тоо буурч байгаа нь шүүхийн шийдвэрийн тогтвортой байдал буурч байгааг харуулж байна.

График 3. Давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон, хэвээр үлдээсэн байдал



Хяналтын шатны шүүхээс давж заалдах шатны шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн шийдвэр 2011-2012 онд 90 хэрэг буюу 16.5 хувиар буурсан, 2012-2013 онд 11 хэргээр буюу 2.4 хувийн бага зэрэг өсөлттэй байна. Харин хүчингүй болгосон шийдвэр, магадлалын хувьд 2011-2012 онд 37 хэргээр буюу 35.2 хувиар өсч, 2012-2013 онд 2 хэргээр буюу 1.4 хувиар буурчээ. Эдгээр статистик үзүүлэлтээс харахад шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон, өөрчлөлт оруулсан магадлал, тогтоолын тоо өсч, хэвээр үлдээсэн магадлалын тоо буурч байгаа нь шүүхийн шийдвэрийн чанар, тогтвортой байдлыг хангах шаардлага гарч байна.

Хоёр. Анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилсөн, хүчингүй болгосон үндэслэл, процессын зөрчил

Хууль зүйн шинжлэх ухаанд Standard of review⁹⁶ буюу дээд шатны шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг хууль ёсны дагуу хянах дүрмийн тухай ойлголт байдаг. Зарим улс оронд шүүхийн шийдвэрийг бүхэлд нь эсвэл гомдлын үндэслэлээр хязгаарлагдан эсхүл, дээд шатны шүүхээс хууль хэрэглээний хувьд хянан үзэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил болон үйл баримтын маргааныг хянадаг. Монгол Улсын хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийг “давж заалдах шатны шүүх”⁹⁷-

⁹⁶ Bryan A. Garner, editor, Black's Law Dictionary 9th ed. West Group, 2009. p.1535.

⁹⁷ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (2002) 168 дугаар зүйлийн 168.1.

ээс хууль хэрэглээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, маргааны үйл баримтын нотлох баримтын талаас нь бүхэлд нь хянах онцгой эрхтэй. Харин хууль хэрэглээний болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын талаас нь “хяналтын шатны шүүх”⁹⁸-ээс хянадаг. Шүүхийн шийдвэрийг хянаж нэмэлт, өөрчлөлт оруулсан эсхүл хүчингүй болгосон тохиолдолд дээд шатны шүүх үндэслэлээ тодорхой зааж магадлал, тогтоолд тусгах журамтай.

Хүснэгт 1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтлэг илэрч буй алдаа, зөрчлүүд

Д/д	Процессын зөрчлүүд	Тоо	Эзлэх хувь
1.	Талуудын хооронд эрх зүйн харилцаа, маргааны үйл баримтыг буруу тодорхойлсон	16	7.5
2.	Нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг тодруулаагүй	35	16.5
3.	Хэрэгт ач холбогдол бүхий хүсэлтийг шийдвэрлээгүй	7	3.3
4.	Хөөн хэлэлцэх хугацааг буруу тодорхойлсон	1	0.4
5.	Нотлох баримтууд ач холбогдолгүй гэж үзсэн үндэслэл нь тодорхойгүй, ойлгомжгүй, дутуу бүрдүүлсэн зэрэг нотлох баримтын үнэлгээтэй холбоотой асуудал /шинжээчийн дүгнэлт/	91	42.7
6.	Зохигчдод хэргийн материал, эрх, үүргийг зохих ёсоор танилцуулаагүй, хурлын тов мэдэгдээгүй	34	16
7.	Улсын тэмдэгтийн хураамжийн талаар гаргасан хүсэлтийг шийдвэрлээгүй, буруу шийдвэрлэсэн	6	2.8
8.	Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт хууль баримтлалгүй шийдвэрлэсэн	7	3.3
9.	Үг үсэг, техникийн шинжтэй алдаа гаргасан	6	2.8
10.	Гуравдагч этгээдийн эрх ашиг, хэргийн оролцогчийг зөв тогтоогоогүй	6	2.8
11.	Хууль бус бүрэлдэхүүнээр, эсхүл иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оруулалгүй хэргийг шийдвэрлэсэн	4	1.9
Нийт		213	100

Дээр дурдсан процессын зөрчлийг ангилсан нэгдмэл шалгуур байхгүй тул судалгааны хүрээнд нийтлэг байдлаар илэрсэн зөрчлийн шинж байдлаар нэгтгэн авч үзсэн болно. Судалгаанаас үзэхэд “нотлох баримтуудыг ач холбогдолгүй гэж үзсэн үндэслэл тодорхойгүй, ойлгомжгүй, дутуу бүрдүүлсэн зэрэг нотлох баримтыг үнэлэхтэй холбоотой” асуудлаар 91 зөрчил илэрсэн нь нийт зөрчлийн 42.7 хувийг эзэлж байна. Шүүгч аливаа хэргийг шийдвэрлэхдээ хууль ёсны дагуу хэрэгт авагдсан, ач холбогдол бүхий нотлох баримтын хүрээнд өөрийн дотоод итгэл үнэмшлээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг. Түүнчлэн “шүүх нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг тодруулаагүй, сөрөг нэхэмжлэлийг үнэлээгүй” гэх үндэслэлээр 35 хэрэг буюу нийт зөрчлийн 16.5 хувь, “зохигчдод эрх, үүрэг, хэргийн материалыг танилцуулах, хурлын тов мэдэгдэх ажиллагааг зохих ёсоор хийгээгүй, баримтжуулаагүй” гэх үндэслэлээр 34 хэрэг буюу 16 хувь байгаа нь өндөр үзүүлэлт юм.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, нотлох баримтын үнэлгээтэй холбоотой буруу шийдвэр гаргасан зарим шийдвэр, магадлалыг авч үзье.

Жишээ 1: Хэргийн товч агуулга:

⁹⁸ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн (2002) 172 дугаар зүйлийн 172.2.

Нэхэмжлэгч Э нь “Л.Т” ХХК-д холбогдуулан Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Чойжин ламын сүм музейн баруун талын “С.Р” ресторан байрлах 2 давхар барилгын В блокийн 44 хувийн хөрөнгө оруулагч, 1 дүгээр давхрын өмчлөгчөөр тогтоолгохыг хүссэн нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагаас 44 хувь биш 42 хувьд хөрөнгө оруулалт хийснийг зөвшөөрч тус барилгын 1 давхрыг бүхэлд нь өмчлөгчөөр тогтоолгоно гэсэн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэж маргаж, тус барилгын 1 дүгээр давхрын зүүн болон баруун хэсэгт зөвшөөрөлгүй барьсан өргөтгөлүүдийг буулгуулах сөрөг нэхэмжлэл гаргаж талууд маргажээ.

1) *Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

Анхан шатны шүүхээс: Иргэний хуулийн 108 дугаар зүйлийн 108.1, 476 дугаар зүйлийн 476.1, 478 дугаар зүйлийн 478.8 дахь хэсэгт заасныг баримтлан Э-г Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Чойжин ламын сүм музейн баруун талын “С.Р” ресторан байрлах хоёр давхар барилгын 44 хувийн хөрөнгө оруулагч, “С.Р” рестораны зориулалтаар одоо эзэмшиж, ашиглаж буй В блокийн 1 дүгээр давхрын өмчлөгчөөр тогтоож, мөн барилгын давхрын зүүн болон баруун хэсэгт нэхэмжлэгч Э-ийн зөвшөөрөлгүй барьсан өргөтгөлүүдийг буулгуулахыг хүссэн сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байна.

2) *Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ:*

Анхан болон давж заалдах шатны шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ хэрэгт цугларсан нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлээгүй, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлд эрх зүйн дүгнэлт өгч чадаагүйн зэрэгцээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн нь шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй байна.

Нотлох баримт үнэлэх: В блокийн 44 хувийн хөрөнгө оруулагчаар тогтоохдоо 2001 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн протокол, 2003 оны бүх хөрөнгө оруулагч нарын хуралдаж тооцоо нийлсэн 01/03 тоот протокол, 2004 оны хөрөнгө оруулалтын талаар шийдвэрлэсэн 01/04 тоот протокол, 2006 оны өмчлөлийн хувь хэмжээ тогтоосон протокол зэргийг тайлбартаа дурдсан хэдий ч 2001 болон 2004 оны протокол хэрэгт авагдсан байна. Түүнчлэн тус хоёр протоколд маргааны зүйл болж буй барилгад талууд 49, 51 хувиар хөрөнгө оруулалт хийх талаар дурдсан байхад нэхэмжлэлийн шаардлагад байгаа 44 хувь болон 1 дүгээр давхрын өмчлөгч болох талаар дурдаагүй байхад нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болгон шийдвэрлэсэн байна.

Аудитын газрын шинжээчийн шийдвэрийг үндэслэл болгон хэргийг шийдвэрлэсэн байх бөгөөд тэрхүү аудитын газрын шинжээчийн дүгнэлтэд дээр дурдсан 3 протоколыг үндэслэл болгон дүгнэлт гаргажээ. Энэ нь шүүхийн шийдвэрийг

анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтын үндсэн дээр гаргах, шийдвэрийн үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг шүүхээс хэрхэн үнэлж байгаа тухай заах ИХШХШТХ-ийн 116 дугаар зүйлийн 116.3, 118 дугаар зүйлийн 118.4 дэх хэмэгт заасан шаардлагуудыг хоёр шатны шүүх бүрэн хангаж чадаагүй байна.

Хууль зөрчиж барьсан барилгын өргөтгөлийг буулгуулах буюу газар чөлөөлүүлэх агуулга бүхий шаардлагыг гаргасан сөрөг нэхэмжлэлийг хариуцагч гаргах эрхгүй, харин газрын асуудал хариуцсан эрх бүхий этгээд гаргах ёстой гэсэн шүүхийн дүгнэлт нь Иргэний хуулийн 91, 92 дугаар зүйлийн холбогдох заалттай нийцсэн гэхэд учир дутагдалтай юм.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн шинжээчийн 051 дүгээр дүгнэлтээр нэхэмжлэгчийн оруулсан хөрөнгийн хэмжээг өмнөх шинжээчийн дүгнэлтээс үнийн дүнг багаар тогтоосон бөгөөд тус шинжээчийн дүгнэлтийг заавал баримтлах албагүй гэж дүгнэсэн хоёр шатны шүүхийн дүгнэлт ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэгт заасан шаардлагад нийцэж байгаа эсэхэд үндэслэл бүхий дүгнэлт өгсөн гэж үзэх боломжгүй юм.

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шүүх бүрэлдэхүүнийг татгалзсан хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэнээ давж заалдах шатны шүүх танилцуулаагүйгээс гадна 2012 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн шүүх хуралдааны товыг өмнөх өдөр нь буюу 7 дугаар сарын 30-ны өдөр Сүхбаатар аймагт байхад мэдэгдсэн нь шүүх хуралдаанд оролцох боломжоор хангаагүй байх ба түүнчлэн шүүх хуралдааныг шөнийн цагаар хийх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн алдаа, зөрчлүүд гаргажээ.

Утга найруулга, техникийн шинжтэй алдаа: Шүүх хуралдаанд зөвхөн нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч оролцсон бөгөөд шүүх хуралдааны тэмдэглэлд тэдгээр нь шүүх бүрэлдэхүүнийг татгалзахгүй гэснийг тусгасны дараа “оролцогчид шүүх бүрэлдэхүүнийг татгалзсан” гэсэн нь техникийн шинжтэй алдаа хэдий ч тус тэмдэглэлийн үнэн зөв байдалд эргэлзээ төрүүлснийг дурдах нь зүйтэй юм.

Гурав. Анхан шатны шүүхийн шийдвэрт орсон өөрчлөлт, хүчингүй болсон байдлыг маргааны төрлөөр ангилах нь


Судалгааны гуравдугаар бүлэгт хууль хэрэглээний хувьд гаргаж буй нийтлэг, алдаа зөрчлийг маргааны төрлөөр авч үзье.

3.1. Гэрээний эрх зүйн маргаан

Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2012 онд 27792 хэрэг хянан шийдвэрлэгдсэн бөгөөд үүнээс 5243 хэрэг буюу 18.8 хувийг гэрээний эрх зүйн маргаан эзэлж байсан бол 2013 онд 35314 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэнээс 7022 хэрэг буюу 19.8 хувийг гэрээтэй холбоотой маргаан эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулбал 1 хувиар өссөн үзүүлэлт юм. Шүүхээс худалдах, худалдан авах, зээл, ажил гүйцэтгэх, түрээсийн гэрээтэй холбоотой маргааныг илүүтэй шийдвэрлэж байна.

График 4.

Гэрээний маргааныг шийдвэрлэсэн байдал



Судалгааны явцад гэрээтэй холбоотой 402 шийдвэр, магадлал, тогтоолыг судалснаас хууль хэрэглээний хувьд нийтлэг байдлаар дараах зөрчлүүд илэрчээ.

Худалдах, худалдан авах гэрээний маргааныг шийдвэрлэхдээ зохигчдын хооронд үүссэн маргаан, гэрээнээс татгалзах тухай Иргэний хуулийн 205 дугаар зүйлийн 205.1 дэх хэсэгт заасан гэрээнээс татгалзах агуулгатай байхад шүүх гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үүсэх гэрээний хариуцлага болох алданги гаргуулахаар шийдвэрлэсэн нь 232 дугаар зүйлийн 232.6 дахь хэсэгт заасан үүргийн гүйцэтгэлийг хангах аргын мөн чанарт нийцэхгүй байна. Талууд гэрээний үндсэн үүргээс татгалзсан байхад нэмэлт үүргийг хүлээлгэх боломжгүй юм.

Түүнчлэн зээлийн гэрээтэй холбоотой маргаанд гэрээний хүчин төгөлдөр байдлын талаар дүгнэлт өгөөгүй, Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.1-д заасан хэлцлээс үүсэх үр дагаврыг 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт зааснаар арилгах үүрэгтэй байтал Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1 дэх хэсэгт зааснаар үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэж үзсэн нь хууль хэрэглээний хувьд алдаатай шийдвэр юм. Түүнчлэн Иргэний хуулийн 453 дугаар зүйлийн 453.1 дэх хэсэгт зааснаар зээлдэгч авсан зээлээ хугацаандаа төлөөгүй бол түүнээс хэтэрсэн хугацааны хүү, нэмэгдүүлсэн хүү шаардах эрхтэй байхад шинэ гэрээ байгуулах нэрийдлээр хүүгээс хүү тооцох хууль зүйн үндэслэлгүйг шүүх анхаараагүй, зохигчдын хооронд байгуулагдсан зээлийн гэрээг өмнөх зээлийн гэрээтэй холбож үзээгүй зэргээр хуулийг буруу хэрэглэсэн байна.

Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 289 дүгээр зүйлийн 289.2.1-д зааснаар хөлслөгчийн буруугүйгээр хөлслөн авсан эд хөрөнгө ашиглах боломжгүй болсон бол хөлс төлөхөөс татгалзах эрхтэй байтал хуулийн заалтыг буруу тайлбарлан хэрэглэжээ.

Үүнээс гадна гэрээний эрх зүйн маргаан нь төлбөр, хүү, алданги гаргуулахтай илүүтэй холбогдох тул үнийн дүнг үнэн зөв тооцох асуудалд анхааралтай хандах шаардлагатай байна. Судалгаанаас үзэхэд тооцооллын алдааг анхан шат, давж заалдах шатны шүүхүүдээс шийдвэрлэсэн хэрэгт аль алинд нь гарчээ.

Анхан шатны шүүхээс маргааныг шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн агуулгыг тодруулаагүй, хууль хэрэглээний хувьд алдаатай шийдвэрлэсэн зарим шийдвэрийг авч үзье.

Жишээ 2: Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч Н түрээсийн гэрээ байгуулан Т-н өмчлөлийн орон сууцыг 3 жилийн хугацаатай, сард 2 сая төгрөгийн түрээс төлөхөөр, аж ахуйн зориулалтаар ашиглахаар тохиролцон гэрээ байгуулжээ. Түрээсийн гэрээний 5 сарын төлбөрт 10 сая төгрөг, барьцаанд 2 сая төгрөг төлсөн бөгөөд 5 сарын хугацаа дууссаны дараа түрээсийн төлбөр нэмэгдэж, байр, цахилгааны төлбөр нэмж авахаар болсныг Т амаар мэдээгджээ. Хэрвээ энэ шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй бол байрыг суллаж өгөхийг Т шаардсан байна. Улмаар Н энэхүү шаардлагыг зөвшөөрөлгүй, Т-тэй маргалдаж Н-ийн биед гэмтэл учруулжээ. Иймд нэхэмжлэгч Н эмчилгээ хийлгэсэн төлбөр болох 2 сая төгрөг, түрээсийн гэрээ цуцалснаас учирсан хохирол буюу олж болох байсан орлого болох 8 сая төгрөг, нийт 10 сая төгрөгийг Т-ээс нэхэмжилж шүүхэд ханджээ.

1) Шүүхээс шийдвэрлэсэн байдал:

Анхан шатны шүүхээс: Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3, 318.4, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар түрээсийн гэрээг бичгээр байгуулах, үл хөдлөх эд хөрөнгийн газар бүртгүүлэх гэсэн шаардлагыг хангаагүй тул гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэж, эд хөрөнгөнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.1, 505 дугаар зүйлийн 505.1-д зааснаар хэргийг шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхээс: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээжээ.

2) Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ:

Анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй байна.

Хууль хэрэглээний алдаа: Шүүхийн шийдвэрийн хувьд Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3, 318.4, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар шийдвэрлэсэн нь хууль хэрэглээний хувьд алдаатай, нэхэмжлэлийн шаардлагын агуулгыг бүрэн гүйцэд тодруулаагүй алдааг гаргажээ. Энэ нь Иргэний хуулийн 294 дүгээр зүйлийн 294.2.3-т заасан "хөлслүүлэгчийн санал болгосон зах зээлийн үнэд тохирсон нэмэгдэл хөлс төлөхөөс хөлслөгч татгалзсан" бол гэрээг дуусгавар болгох, түүнчлэн 299 дүгээр зүйлийн 299.1 дэх хэсэгт заасан "хөлслөгч нь хөлслөн авсан эд хөрөнгийн эзэмшлийг өмчлөгчийн болон бусад халдлагаас хуульд заасан арга хэрэгслээр хамгаалах эрхтэй" байтал өмчлөгчийн орон байрыг Н хаяж явсан нь дээрх хуулийн зохицуулалтаар гэрээ дуусгавар болсонд тооцохоор байна.

Хэдийгээр талууд түрээсийн гэрээг улсын бүртгэлд бүртгүүлээгүй боловч Иргэний хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасны дагуу хүсэл зоригоо илэрхийлэн хэлцэл хийж, нэг тал нь түрээсийн төлбөр төлж, нөгөө тал нь орон сууцыг

ашиглуулж байсан тул Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.1 дэх хэсэгт зааснаар түрээсийн гэрээний харилцаа үүссэн байна.

Түүнчлэн нэхэмжлэлийн шаардлага болсон эрүүл мэндэд учирсан хохирлын талаар Улаанбаатар Сонгдо, БНСУ-д хийлгэсэн эмчийн магадлагаа, гэрчийн мэдүүлэг зэрэг баримтуудаар эрүүл мэндэд учруулсан хохирлыг тогтоох боломжгүй байхад анхан шатны шүүхээс ИХШХШТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.2.2-т “шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл тайлбар, түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, өгөх” үүрэгтэй байтал нотлох баримтаа гаргаж өгөөгүй байхад хэргийг буруу шийдвэрлэсэн алдаа гарчээ.

3.2. Өмчлөх эрх, хэлцэл хүчин төгөлдөр бус гэж тооцох маргаан:

Өмчлөх эрх, хэлцэл, гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахтай холбоотой 265 шийдвэр магадлалыг судлахад хууль хэрэглээний хувьд нийтлэг байдлаар дараах алдааг гаргасан байна.

Шүүхээс өмчлөх эрхийн маргааныг хянан шийдвэрлэхэд Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсэгт заасан “хууль бус эзэмшигч” мөн эсэхийг тогтоохтой холбоотой дүгнэлтийг хийхэд Иргэний хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1, 92 дугаар зүйл, 100 дугаар зүйлийн 100.1, 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсэгт заасан талаар дүгнэлт өгөөгүй, эсхүл эдгээр заалтын шаардах эрхийн үндэслэл болгон шийдвэрлэсэн байна. Тухайлбал, газар эзэмших эрх нь хүчингүй болсон тохиолдолд газрын өмчлөгч, түүний дээрх объектын өмчлөгч нарын хоорондын маргааныг шийдвэрлэхэд Иргэний хуулийн 85 дугаар зүйлийн 85.2 дахь хэсэгт заасан газрын үндсэн бүрдэл хэсэг гэсэн ойлголтыг буруу тайлбарлаж, 119 дүгээр зүйлийн 119.1, 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсгийг хэрэглэсэн байна.

Түүнчлэн хууль ёсны өмчлөгчийн шаардах эрхийг тодорхойлсон Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсгийг хэрэглэхдээ хүчин төгөлдөр бус хэлцлийн үр дагаврыг тодорхойлсон тус хуулийн 56 дугаар зүйлийн 56.5, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнөөс үүсэх үүргийн 492 дугаар зүйлийн 492.1.1 дэх заалтыг давхар баримталж, хууль хэрэглээний алдаа гаргажээ.

Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 нь хүчин төгөлдөр бус хэлцлийн дагуу талууд өгсөн, авсан бүх зүйлээ буцаах буюу хэлцэл хийгдэхээс өмнөх байдалд сэргээх агуулгатай зохицуулалт, харин 492 дугаар зүйлийн 492.1.1 нь хууль болон гэрээнд заасан үндэслэлгүйгээр бусдын эд хөрөнгийг олж авсантай холбоотой үүргийн зохицуулалт юм. Өмчлөх эрхтэй холбоотой шаардах эрхийн үндэслэлийг үүргийн эрх зүйн хүрээнд шийдвэрлэх нь Иргэний хуулийн системчлэлийн хувьд буруу юм.

Иймд хууль хэрэглээний алдаатай шийдвэр гаргасан анхан шатны шүүхийн шийдвэрийг авч үзье.

Жишээ 3: Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч Э-ийн газар дээр хууль бусаар амьдарч байгаа Ө-с өмчлөгч өөрийн газрыг чөлөөлүүлэхээр маргажээ. Ө-ийн хувьд тухайн газар дээр 10-аад жил амьдарч байгаа бөгөөд газрын албанд тухай газрыг өмчилж авах талаар хөөцөлдөж

байгаа, нэхэмжлэгч Э нь удаан хугацаанд тус газар дээр амьдарч байгаагүй тул нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй гэж талууд маргажээ.

1) *Шүүхээс шийдвэрлэсэн байдал:*

Анхан шатны шүүхээс: Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.2, 106.4, 183 дугаар зүйлийн 183.1 дэх заалтыг баримтлан Ө-ийн хууль бус эзэмшлээс газар чөлөөлүүлэхээр шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийдвэрийн "...Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.2, 106.4..." гэснийг хасаж, "Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1..." гэж өөрчилж, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээсэн байна.

Хяналтын шатны шүүхээс: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээжээ.

2) *Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ:*

Анхан шатны шүүх Иргэний хуулийн нэхэмжлэгчийн шаардах эрхийн холбогдох зохицуулалтыг буруу хэрэглэж, хууль ёсны эзэмшигчид хамааралтай заалт хэрэглэсэн байна.

Хууль хэрэглээний алдаа: Анхан шатны шүүх хариуцагчийн хууль бус эзэмшлээс маргааны зүйл болох газрыг чөлөөлж, нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн атлаа өмчлөлийн зүйлийн эзэмшилтэй холбоогүй шаардлага гаргах өмчлөгчийн эрхийг тодорхойлсон Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг шийдвэрийн үндэслэл болгосон нь хуулийн хэрэглэвэл зохих зүйл, заалтыг хэрэглээгүй алдаа гаргажээ.

3.3. *Хөдөлмөрийн маргаан:*

Хөдөлмөрийн эрх зүйн маргааны хувьд хэргийг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэлд дурдаж буй асуудал бие даасан нэхэмжлэлийн шаардлага, эсхүл түүний үндэслэл аль нь болохыг тодорхойлж, холбогдох хуулийн зохицуулалтыг баримтлах ёстой байдаг. Гэтэл ажлаас халсан, сахилгын шийтгэл ногдуулсан тушаал хүчингүй болгуулах, эрүүл мэнд, нийгмийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийлгэх зэрэг шаардлагууд нь бие даасан нэхэмжлэлийн шаардлага мөн эсэхийг тодорхой болголгүй хэргийг шийдвэрлэх явдал түгээмэл байна. Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д зааснаар ял шийтгүүлсэн тогтоол хүчин төгөлдөр болсонтой холбоотойгоор хөдөлмөрийн гэрээг цуцлах зохицуулалтыг Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан зөвхөн төрийн жинхэнэ албан хаагчид хамаарах буюу төрийн үйлчилгээний албан хаагчид хамаарахгүй байх зохицуулалттай холбож тайлбарлаагүй, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасан хөдөлмөрийн гэрээнд заагаагүй өөр ажилд шилжүүлж ажиллуулсан тухай маргааныг шийдвэрлэхдээ тус хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зааснаар хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүйд ажилтан буруугүй болохыг анхаараагүй хэргийг шийдвэрлэсэн байна.

Ажлаас үндэслэлгүй халагдсан, ажилд эргүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах тухай маргааныг хянан шийдвэрлэхдээ нотлох баримтыг зохих журмын дагуу үнэлээгүй, хууль хэрэглээний хувьд алдаатай шийдвэрлэсэн дараах тохиолдлыг авч үзье.

Жишээ 4: Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч Б нь “Ө.С” ХХК-д редактороор ажиллаж байгаад 2013 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 13/07 тоот тушаалаар ажлаас үндэслэлгүй халагджээ. 2013 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс орон тоо цомхотгож байгаа гээд “3 сарын цалинтай тэнцэх мөнгө аваад ажлаасаа гарах уу, улс төрийн албанд ажиллах санал тавихаар нь “тэтгэмжээ аваад ажлаасаа гаръя” гэхэд эрхлэгч нь “чөлөөлөгдөх өргөдлөө өг” гэснээр өргөдлөө өгөхөд Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-д заасныг баримтлалгүй 38 дугаар зүйлийн 38.1.1-д заасныг баримтлан ажилтан өөрөө хүссэн гэсэн үндэслэлээр ажлаас чөлөөлж, тэтгэмж олгоогүй байна. Иймд 2013 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр хүртэлх цалин 900,000 төгрөг, өмгөөлөгчийн хөлс 300,000 төгрөгийг гаргуулж, ажилд эгүүлэн тогтоолгохоор нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Хариуцагчийн зүгээс нэхэмжлэгч Б нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн, 2012 оны 12 дугаар сарын 18, 2013 оны 1 дүгээр сарын 11, 2013 оны 1 дүгээр сарын 15-ны өдрүүдэд хийгдсэн редакцын албадын хурлаас өөр албанд шилжүүлэх санал тавихад хүлээн зөвшөөрөөгүй нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлтэй байна гэж ойлгосон ба энэ талаар хурлын тэмдэглэлд тусгагдсан болно. Нэхэмжлэгч Б-г ажлаас чөлөөлөгдөх хүсэлт, өргөдлөө өгч гаргах үед орон тоо, бүтэц өөрчлөгдөөгүй, ажил үүргээ гүйцэтгээд явах бүрэн боломжтой байсан. Өөрийн хүсэлтээр гарсан тул ажил олгогч ажилтанд ажлаас халагдсаны тэтгэмжийг өгөх хуулийн зохицуулалт байхгүй гэж талууд маргажээ.

1) Шүүхээс шийдвэрлэсэн байдал:

Анхан шатны шүүхээс: Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасан ажлаас буруу халсан үндэслэл тогтоогдоогүй тул “Ө.С” ХХК-ны редакторын ажилд эгүүлэн авахаар тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин олговорт 900,000 төгрөг, эрх зүйн туслалцаа өмгөөлөгчөөс авсны зардалд 300,000 төгрөг тус тус гаргуулахыг хүссэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч Б-г ажилд эгүүлэн тогтоож, “Ө.С” ХХК-аас 1,499,992 төгрөгийг гаргуулж, өмгөөллийн зардалд 300,000 төгрөг гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай” гээд шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээсэн байна.

Хяналтын шатны шүүхээс: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээжээ.

2) Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ:

Анхан шатны шүүхээс өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн гэж дүгнэсэн нь хуульд нийцээгүй, хэргийг шийдвэрлэхдээ хэрэгт цугларсан нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлээгүй, нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлд эрх зүйн дүгнэлт өгч чадаагүйн зэрэгцээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг

зөрчсөн нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй байна.

Нотлох баримт үнэлэх: Нэхэмжлэгч Б нь “Ө.С” ХХК-ны ерөнхий эрхлэгчид хандаж гаргасан “2013 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн орон тооны цомхотгол хийхтэй холбогдуулж намайг улс төрийн албанд сэтгүүлчээр ажиллах санал тавьсан, миний бие сэтгүүлчээр ажиллах бодолгүй байгаа тул ажлаас чөлөөлж өгнө үү” гэсэн өргөдөл хүсэлт нь “Улс төрийн албанд сэтгүүлчээр ажиллуулах тухай” “Ө.С” ХХК-ний ерөнхий эрхлэгчийн саналд тайлбар өгснийг үүрэгт ажлаас өөрийн санаачилгаараа халагдсан гэж үзэх боломжгүй, энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт заасантай нийцэхгүйг анхан шатны шүүхээс авч үзээгүй байна.

Ажилтны эрхэлж буй ажил, албан тушаалын орон тоо хасагдсан бол ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-д зааснаар хөдөлмөрийн гэрээг өөрийн санаачилгаар цуцлах ёстой бөгөөд энэ үндэслэл нь мөн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасан үүргийг үүсгэдэг тул ажил олгогчийн хуульд нийцээгүй дээрх тушаал нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөнөөс гадна ажилтныг ажлаас үндэслэлгүй халсан гэж үзэх нөхцөл болсныг анхаараагүй алдаа гаргажээ.

3.4. Гэр бүлийн эрх зүйн маргаан:

Гэр бүлийн эрх зүйн маргаан нь 2012 онд шийдвэрлэсэн нийт иргэний хэргийн 14 хувь, 2013 онд 12.1 хувийг тус тус эзэлсэн⁹⁹ нь өмнөх оноос 1.9 хувиар буурсан үзүүлэлт юм. Сүүлийн 5 жилд шийдвэрлэсэн гэр бүлийн эрх зүйн маргааны 80 хувийг гэрлэлт цуцлалттай холбоотой хэрэг, маргаан эзэлжээ.

Гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгө, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг тогтоох, энэ тухай ойлголтыг нэг мөр болгох шаардлагатай байна. Түүнчлэн гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгийг хамтран өмчлөх дундын эд хөрөнгөнд тооцон шийдвэрлэсэн алдаа, зөрчлүүд байна. Тухайлбал, гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгө, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийн талаарх Иргэний хуулийн 126, 127 дугаар зүйлд заасан зохицуулалт, түүнчлэн гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваахдаа мөн хуулийн 126 дугаар зүйлийн 126.1, 129 дүгээр зүйлийн 129.2, 129.4 дэх хэсгийг тус тус буруу тайлбарлан хэрэглэсэн байна.

Үүнээс гадна хүүхдийн тэтгэлэг, асрамж тогтоохтой холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхэд Хүүхдийн эрхийн тухай конвенц, Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3 дахь заалт, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.2 дахь заалтуудыг буруу тайлбарлан хэрэглэсэн байна. Түүнчлэн Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйл, мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасныг буруу тайлбарлаж хүүхдэд нэмэлт зардал зайлшгүй шаардагдах нөхцөл байдлыг тодруулалгүй хэргийг шийдвэрлэжээ.

⁹⁹ Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан (2013 он), Улаанбаатар, 2014 он. 95 дахь тал.

Тухайлбал, анхан болон давж заалдах шатны шүүхээс гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгө, дундын өмчлөлийн хөрөнгийг хуваахдаа дараах байдлаар алдаатай шийдвэр гаргасан байна.

Жишээ 5: Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч У нь С-тэй 1998 онд гэрлэлтээ батлуулсан бөгөөд 1998 оны 11 дүгээр сард охин Н, 2001 онд охин Х, 2004 онд хүү Г, 2007 онд хүү Ц нар төржээ. Мөнгө, хардалтын улмаас байнга хэрүүл гарч хамт амьдрах боломжгүй болсон тул гэрлэлт цуцлуулж, хүүхдийн тэтгэлэг тогтоолгож, 4 хүүхдээ эх У-ийн асрамжид авч, байшингийн өмчлөгчөөр тогтоолгож, гэр бүлийн гишүүний дундын эд хөрөнгөөс гаргуулахаар шүүхэд ханджээ. Хариуцагчийн зүгээс хүү Ц-ийн төрсөн эцэг мөн эсэхийг тогтоолгохоор сөрөг нэхэмжлэл гаргаж маргасан байна.

1) Шүүхээс шийдвэрлэсэн байдал:

Анхан шатны шүүхээс: Баянзүрх дүүргийн шүүхээс Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт зааснаар С болон У нарын гэрлэлтийг цуцалж, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7 дахь хэсэгт зааснаар хүүхдүүдийг эхийн асрамжид үлдээн тэтгэлэг тогтоож, хүү Ц-ийн эцэг нь С биш болохыг тогтоож, Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.1, 126.3, 129 дүгээр зүйлийн 129.2 дахь хэсэгт зааснаар Баянзүрх дүүргийн 6 дугаар хороонд байрлах 2 өрөө орон сууцыг хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болохыг тогтоож, тус орон сууцыг У, Н, Х, Г, Ц нарын өмчлөлд үлдээж, У-с 5.359.833 төгрөгийг гаргуулж С-д олгохоор шийдвэрлэсэн байна. Харин орон сууцыг бусдад түрээсэлсний улмаас олсон орлогыг гаргуулах тухай нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт "...нэхэмжлэгч У-с 75,000 төгрөгийг, хариуцагч С-с 75,000 төгрөгийг тус тус гаргуулж, "Б.Э" ХХК-д олгосугай" гэснийг "...хариуцагч С-с 75,000 төгрөгийг гаргуулж, нэхэмжлэгч У-д олгосугай" гэж өөрчилж, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхээс: Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байна.

2) Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ:

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх ИХШХШТХ-ийн 116 дугаар зүйлийн 116.2 дахь заалтын шаардлагыг бүрэн хангаагүй байна.

Хууль хэрэглээний алдаа: Шүүх У болон С нарын гэр бүлийн дундын өмчлөлийн хөрөнгийг хуваарилахдаа тэдгээрийн хуваарьт өмч, гэр бүлийн гишүүний дундын хөрөнгийг нарийвчлан тодорхойлоогүй.

Түүнчлэн гэрлэгчдийн насанд хүрээгүй хүүхэд одоо хэний асрамжинд байгаа хийгээд тэдгээрийн эрүүл мэнд, сурч хүмүүжих бололцоо, эцэг, эхийн хэний асрамжид байвал хүүхдүүдийн эрх ашигт нийцэхийг шүүх сайтар хянан үзээгүй байна.

Гэрлэгчдийн хүүхдүүд болох Г, Х, Н нараас шүүх асрамжийн талаар санал авсан нь хэлбэрийн хувьд хуулийн шаардлагыг хангасан мэт боловч тус асуудлыг нарийвчлан тодруулсны үндсэн дээр хэргийг шийдвэрлэх нь зүйтэй байжээ.

3.5. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих:

Бусдын эд хөрөнгийг үндэслэлгүйгээр авсантай холбоотой маргааныг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг буруу хэрэглэсэн дараах зөрчлүүд байна. Үүнд, Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 225 дугаар зүйлийн 225.1, 492 дугаар зүйлийн 492.1.1-д заасан үндэслэлтэй ялгаж авч үзэлгүй хэргийг шийдвэрлэсэн бол Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д заасан бусдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэхээр хэн нэгэн этгээдэд хөрөнгө шилжүүлсэн этгээд тус зүйлийг олж авсан этгээдээс хөрөнгөө буцаан шаардах эрхтэй гэсэн зохицуулалтыг 495 дугаар зүйлийн 495.1 дэх хэсэгтэй давхар баримтлан шийдвэрлэжээ.

Цаашид үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой маргаанд бусдын эд хөрөнгийг устгасан, хольсон, захиран зарцуулснаас хөрөнгөжсөнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 119, 120 дугаар зүйл, 495 дугаар зүйлийн 495.1, 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг анхаарч, хэргийг шийдвэрлэх шаардлагатай юм. Үүргийн эрх зүйн өөр өөр төрөл, өмчийн эрхийн зохицуулалтыг нарийн зааглан тайлбарлаж хэрэглэх шаардлагатайг анхаарах хэрэгтэй байна.

Шүүхээс үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд дараах байдлаар алдаатай шийдвэр гаргасныг авч үзье.

Жишээ 6: Хэргийн товч агуулга:

Нэхэмжлэгч “М.П.К”-д Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсээс хяналт шалгалт хийсэн бөгөөд Татварын ногдуулалт, төлөлтийг шалгажээ. Энэ шалгалтаар “Х.Ц” ХХК-д бичилт хийж өгсөн 005889774 тоот дугаартай НӨАТ-ийн падааны борлуулалтыг тайлагнаагүй тухай дурдаж, 53.717.900 төгрөгийн татварыг нөхөн төлүүлэхээр болжээ. “Х.Ц” ХХК нь тухайн НӨАТ-ын баримтыг хуурамчаар бүрдүүлсэн гэж нэхэмжлэгчийн зүгээс үзэж, татварын нөхөн төлөх төлбөрийг нэхэмжилсэн байхад хариуцагч “Х.Ц” ХХК нь энэхүү шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэж маргажээ.

1) Шүүхээс шийдвэрлэсэн байдал:

Анхан шатны шүүхээс: Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д зааснаар хариуцагч “Х.Ц” ХХК-иас 37.602.530 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэж, нэхэмжлэлийн шаардлагаас 16.115.370 төгрөгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийдвэрт заасан Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1-д заасан үндэслэл тогтоогдохгүй байх тул нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна.

Хяналтын шатны шүүхээс: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байна.

2) Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ:

Давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн шаардлага болон үндэслэлийн агуулгыг эрх зүйн үүднээс зөв дүгнэж чадаагүйн зэрэгцээ хэрэгт авагдсан нотлох баримтыг ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлд заасан журмын дагуу үнэлээгүй байна.

Хууль хэрэглээний алдаа: Анхан шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг дангаар хэрэглэсэн нь учир дутагдалтай болжээ. Нэхэмжлэгч татварын улсын байцаагчийн актад зааснаар хариуцагчаас аж ахуйн нэгжийн орлогын болон нэмэгдсэн өртгийн нөхөн татварт 38,181,820 төгрөг, хүүд 57,200 төгрөг, алдангид 206,100 төгрөг, торгуульд 15,272,800 төгрөг, нийт 53,717,900 төгрөг гаргуулахыг нэхэмжилсэн ба эдгээрээс хүү, торгууль, алдангийн талаарх шаардлага нь үндэслэлгүй хөрөнгөжсөнөөс учирсан хохирлыг арилгуулах агуулгатай байх тул энэ шаардлагын үндэслэлийг Иргэний хуулийн 495 дугаар зүйлийн 495.1 дэх хэсэгт заасан зохицуулалтаар шийдвэрлэх нь зүйтэй юм.

Хариуцагч “Х.Ц” ХХК НӨАТ-ын тайландаа хасалт хийлгэснээр үндэслэлгүй хөрөнгөжсөн бол Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1 дэх хэсэгт заасан шаардлагыг татварын улсын байцаагч гаргах ёстой боловч татварын улсын байцаагчийн актаар нөхөн татварыг нэхэмжлэгч төлөх болсон тул түүнд тус шаардах эрх шилжсэн гэж үзнэ.

3.6. Гэм хор

Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэгт заасан гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий үндэслэл болон тусгай төрлийн гэм хорын зохицуулалтыг ялган авч үзээгүй эсхүл гэрээний үүргийн болон үүргийн ерөнхий зохицуулалтуудыг гэм хорын маргаанд хэрэглэсэнтэй холбоотойгоор хууль хэрэглээний алдаа түгээмэл гаргасан байна. Түүнчлэн сэтгэл санааны хохирлыг арилгахтай холбоотой маргаанд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2, 511 дүгээр зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалтуудыг зөв тайлбарлан хэрэглээгүй зөрчил гаргажээ. Бусдын учруулсан гэм хорыг хариуцан арилгах тухай 499 дүгээр зүйлийн зохицуулалтад хамааралтай үүрэгт гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий зохицуулалт болох 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг баримталсан алдаа байна. Тухайлбал, Иргэний хуулийн 505 дугаар зүйлийн 505.1 дэх хэсгийг баримтлан бусдын эрүүл мэндэд учирсан хохирлыг арилгах ёстой байтал 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсгийг баримтлан хэргийг шийдвэрлэсэн байна.

3.7. Өв залгамжлал

Иргэний хэрэг, маргаанд өв залгамжлалын асуудлаар шийдвэрлэж байгаа хэргийн тоо 2012 онд 48 байсан бол 2013 онд 31 хэрэг болж 17 хэргээр буюу өмнөх оноос 55 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэргээс харахад өвлөх эрх хуульд заасан үндэслэлээр илүүтэй шийдвэрлэгддэг. Учир нь Монгол Улсад гэрээслэлээр өв залгамжлахтай холбоотой маргаан түгээмэл бус байна.

Улс орнууд өв залгамжлалын тусгайлсан эрх зүйгээр тус харилцааг голчлон зохицуулдаг боловч хөрөнгийн эрх зүй болон гэр бүлийн эрх зүйн хүрээнд

гэрлэгчдийн эрхийг хангах нөхцлийг зохих хэмжээнд хамруулах ба ялангуяа, гэрээслэх, өв хүлээн авах зарим харилцааг гэрээний эрх зүйгээр ч тодорхойлох явдал байна.¹⁰⁰

Өв залгамжлалын маргааны хувьд хууль хэрэглээний алдаатай шийдвэрлэсэн дараах шийдвэрийг авч үзье.

Жишээ 7: Хэргийн товч агуулга:

Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороонд Д-н ээжид 1988 онд Улаанбаатар хотын Гүйцэтгэх захиргаанаас 3 өрөө байр өгчээ. Харин С гэгчид хажуу 1 өрөөг улсаас мөн өгч түүндээ 10 жил амьдарч байгаад нас барсан байна. Д нь С-г асарч, халамжилж байсан бөгөөд нас барсны дараа 1 өрөөний ашиглалтын зардлыг төлж, 4 өрөө болгон амьдарч байжээ. 2009 онд С-н амьдарч байсан 1 өрөөний өмчлөх эрхийг өвлөх эрхийн гэрчилгээгээр ач хүү П авсан болохыг олж мэдээд П-ийн өвлөх эрхийн гэрчилгээ болон нотариатын үйлдлийг хүчингүй болгуулахаар шүүхэд ханджээ.

1) Шүүхээс шийдвэрлэсэн байдал:

Анхан шатны шүүхээс: Иргэний хуулийн 515 дугаар зүйлийн 515.6, 520 дугаар зүйлийн 520.1.1, 531 дүгээр зүйлийн 531.1, 531.2, 1997 оны Нотариатын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.9, 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэгт зааснаар хариуцагч П, нотариатч Э нарт холбогдох өв залгамжлах эрхийн гэрчилгээг хүчингүй болгуулах, өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгосон нотариатын үйлдлийг хүчингүй болгуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.7, 105 дугаар зүйлийн 105.1, 528 дугаар зүйлийн 528.2, 528.3, Нотариатын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.9, 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэгт зааснаар П болон нотариатч Э нарт холбогдох нэхэмжлэгчийн шаардлагыг бүхэлд нь хангаж, өвлөх эрхийн гэрчилгээ олгосон нотариатч Э-ийн үйлдлийг хүчингүй болгож, П-д олгосон 83 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээг хүчингүйд тооцсон байна.

Хяналтын шатны шүүхээс: Давж заалдах шатны шүүхийн магадлалын тогтоох хэсэгт “9 дүгээр зүйлийн 9.4.7, 105 дугаар зүйлийн 105.1” гэснийг “515 дугаар зүйлийн 515.5” гэж, “хүчингүй болгосугай гэснийг хүчингүй болгож, Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хороонд байрлах 12 м.кв нэг өрөө орон сууцыг төрийн өмчлөлд шилжүүлсүгэй” гэж өөрчлөн, магадлалын бусад хэсгийг хэвээр үлдээжээ.

2) Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ:

Анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хууль зүйн шаардлагыг хангаагүй байна.

Хууль хэрэглээний алдаа: Нэхэмжлэгч Д нь хуульд зааснаар болон гэрээслэлээр өвлөх эрхийн аль нь ч үүсээгүй тул өвлөх эрхийн талаар маргах эрхгүй этгээд юм.

Хариуцагч П нь Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.2-т зааснаар нэг өрөө орон сууцны өмчлөгч С-ийн хууль ёсны өвлөгч мөн боловч Иргэний хуулийн 528

¹⁰⁰ Т.Мэндсайхан, “Олон улсын хувийн эрх зүй”, Улаанбаатар, 2008 он. 179 дэх тал.

дугаар зүйлийн 528.2 дахь хэсэгт зааснаар өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор хууль заасны дагуу өвийг хүлээн авах талаар ямар нэгэн үйлдэл хийгээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 10 жил өнгөрсөн байх тул Иргэний хуулийн 528 дугаар зүйлийн 528.3 дахь хэсэгт зааснаар өвийг хүлээн авахаас татгалзсан гэж үзнэ.

Иймд Иргэний хуулийн 515 дугаар зүйлийн 515.5 дахь хэсэгт зааснаар хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөх эрхээ алдсан бол өвлөгдвөл зохих эд хөрөнгө эзэнгүй эд хөрөнгийн нэгэн адил төрийн өмчлөлд шилжих байтал анхан шатны шүүхээс хуулийг буруу хэрэглэж алдаа гаргажээ.

3.8. Бусад маргаан

Шүүхээс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой байдаг. Иргэний хэргийн шүүхээс гарсан шийдвэрүүдийг биелүүлэхэд эд хөрөнгийн албадан дуудлага худалдаа, үнэлгээтэй холбоотой маргаан гарч байна.

2012 оны иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн 15530 хэрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 10694 хэрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдсэн бол 2013 онд 15938 шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт 10953 шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдсэн байна.¹⁰¹

Эд хөрөнгийн үнэлгээ, албадан дуудлага худалдаа, шийдвэр гүйцэтгэлийг цуцлуулах тухай маргааныг хянан шийдвэрлэхэд хууль хэрэглээний алдаатай шийдвэрлэсэн дараах тохиолдлыг авч үзье.

Жишээ 8: Хэргийн товч агуулга:

Хан-Уул дүүргийн шүүхийн 2012 оны 122 дугаар шийтгэх тогтоол, Нийслэлийн шүүхийн 2012 оны 508 дугаар магадлалаар Н-ээс 164,582,388 төгрөг гаргуулж Б-д олгохоор шийдвэрлэсэн. Энэ хэрэгт битүүмжлэгдсэн эд хөрөнгө болох Баянгол дүүрэгт байрлах 50 дугаар байрны 108 тоотын орон сууцыг хохирогч Б-ийн хохиролд тооцуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлжээ.

Харин нэхэмжлэгчийн зүгээс Баянгол дүүрэг дэх тус орон сууц нь Н-ийн өмчлөлийн хөрөнгө биш учраас тус байрыг хураалгахгүй гэж маргажээ.

1) Шүүхээс шийдвэрлэсэн байдал:

Анхан шатны шүүхээс: Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4.7, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4, 87 дугаар зүйлийн 87.3 дахь хэсэгт заасныг баримтлан гомдол гаргагч Л, О нарын өмчлөлийн орон сууцыг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас битүүмжилсэн шийдвэрийг хүчингүй болгон битүүмжлэлээс чөлөөлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хүчингүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхээс: Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Хяналтын шатны шүүхээс: Сүхбаатар дүүргийн шүүхийн шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хянан шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаажээ.

¹⁰¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2013 оны статистик дүн мэдээ.

2) *Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ:*

Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй байна.

Нотлох баримт үнэлэх, тогтоох: Эд хөрөнгө битүүмжлэх, хураах ажиллагаа нэг өдөр явагдаж байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 36, 38 дугаар зүйлд заасан зарим зохицуулалтад нийцсэн эсэх талаар хоёр шатны шүүх дүгнэлт хийгээгүй.

Тухайлбал, тус хуулийн 36 дугаар зүйлийн 36.4, 36.5, 36.7 дахь хэсэгт зааснаар битүүмжилсэн эд хөрөнгийг худалдан борлуулах зорилготой бол хураан авах хугацааг шийдвэр гүйцэтгэгч тогтоох ёстой бөгөөд энэ тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй бол битүүмжилсэн эд хөрөнгийг хураан авах, харин тогтоосон хугацаанд төлбөрийг төлсөн бол шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийг битүүмжилснийг хүчингүй болгоно. Түүнчлэн, шаардлагатай бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад эд хөрөнгийг битүүмжлэхийн хамт тухайн эд хөрөнгийг хураан авч болох боловч дээрх актуудад энэ шаардлага болон үндэслэлийн талаар дурдаагүй байна.

Эд хөрөнгө битүүмжлэх тогтоолд шийдвэр гүйцэтгэгч “2012 оны 12 дугаар сарын 10-ны дотор орон сууцыг султган чөлөөлж, хүлээлгэн өгөхийг мэдэгдье” гэж заасан атлаа эд хөрөнгө битүүмжлэх, хураах ажиллагааг нэг өдөр хийсэн үйл баримтын талаар анхан болон давж заалдах шатны шүүхээс ач холбогдол бүхий дүгнэлт өгөөгүй байна.

Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2012 оны 508 дугаар магадлалд “уг орон сууцыг бусад нэр заасан эд хөрөнгийн хамт хохирогч Б-ээс хулгайлсан мөнгөөр авсан болох нь нотлох баримтуудаар тогтоогдсон” гэж тодорхой заасан тул энэхүү үйл баримтын талаар хийсэн хоёр шатны шүүхийн дүгнэлт ИХШХШТХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэгт заасан “шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг дахин нотлохгүй” гэх зарчмыг зөрчжээ.

Битүүмжлэгдсэн эд хөрөнгийн үнэлгээг ямар үндэслэлээр тогтоосон болох нь ойлгомжгүй байгаа нь ИХШХШТХ-ийн 187 дугаар зүйлийн 187.1, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан шаардлагад нийцсэн эсэх талаар дүгнэлт хийгээгүй зэрэг зөрчлүүд илэрчээ.

Дүгнэлт

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн онцгой үйл ажиллагааны эцсийн үр дүн бөгөөд зөрчигдсөн эрхийн хамгаалалтын илэрхийлэл болсон шүүхийн шийдвэрийг эрх зүйт ёсонд хууль зүйн үндэслэлтэй, шударга ёсонд нийцсэн, процессын болон материаллаг эрх зүйн зарчим, хэм хэмжээнд зохицсон агуулга, хэлбэртэй байлгах, эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажиллагаанд бүх шатны шүүхээс гарч буй аливаа шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх учиртай. Энэ бодлогын судалгаанд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарсан алдаа, зөрчлийг илрүүлэх, судлах, тодорхойлох улмаар цаашид анхаарвал зохих асуудлыг гаргаж ирэхийг зорив.

Судалгааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчлийг хэрэг тус бүрээр судалсан бөгөөд нийтлэг байдлаар дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

1) *Нотлох баримтыг зөв тогтоох, үнэлэх*

Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт гэж байхгүй боловч шүүгч өөрийн итгэл үнэмшлээр хэрэгт цугларсан баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоодог хэдий ч нотлох баримтын үнэлгээ нь тухайн шүүгчийн мэдлэг, ур чадвараас мөн хамаарна. Иймд хэргийг үнэн зөв шийдвэрлэхэд нотлох баримтыг тогтоох, үнэлэх, ач холбогдолтойд тооцох асуудалд анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

2) *Нэхэмжлэлийн шаардлага, агуулгыг тодруулах, зөв тогтоох*

Хэрэг, маргааны агуулга, шаардлагыг тодруулах, тогтоох асуудлыг анхааралгүй хэргийг шийдвэрлэх нь шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцэхгүй. Нэхэмжлэлийн агуулга, шаардлагыг үнэн зөв тогтоосноор шүүхийн шийдвэр үнэн, зөв бодитой гарна. Хэрэг, маргааны агуулга, шаардлагыг буруу тогтоож шийдвэрлэснээс давж заалдах болон хяналтын шатанд өөрчлөлт орох, хүчингүй болох үндэслэл болж байна.

3) *Хэргийн оролцогчийн эрх, үүргийг хангах*

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчид болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид шүүх хуралдааны тов мэдэгдэхгүй, эрх үүрэг танилцуулахгүй, шүүх хуралдаанд оролцогчийн эрхийг хангалгүй хэргийг шийдвэрлэж байна. Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн боловч хуралдаанд хүрэлцэн ирэх боломжит хугацааг харгалзан үзээгүй, хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан үзэлгүй хэргийг шийдвэрлэсэн зэрэг нийтлэг зөрчлүүд илэрчээ.

4) *Гэрээний эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал*

Иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд гэрээтэй холбоотой маргаан ихэнх хувийг эзэлдэг бөгөөд хуулийг зөв тайлбарлах, хэрэглэх асуудлаар нийтлэг зөрчил илэрч байна.

Түүнчлэн хэрэг, маргаанд эрх зүйн ач холбогдол бүхий дүгнэлт хийгээгүй, хэргийн бодит байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоогоогүй, зохигчдын хооронд үүссэн маргааны талаар эрх зүйн дүгнэлт өгөөгүй, нэхэмжлэлийн шаардлагад зааснаас өөр асуудлыг шийдвэрлэсэн зэрэг зөрчлүүд тодорхой хувийг эзлэх тул үүсэх үр дагаврын талаарх хуулийн зохицуулалтуудыг буруу тайлбарлан хэрэглэжээ. Гэрээний эрх зүйн маргааныг шийдвэрлэсэн шийдвэрээс үзэхэд гэрээг тайлбарлах, гэрээний харилцааг зөв тогтооход анхаарах шаардлагатай байна.

Гэрээний эрх зүйн хэрэг, маргаан нь төлбөр, хүү, алданги гаргуулах асуудалтай холбогддог тул үнийн дүнг үнэн зөв тооцох асуудалд анхааралтай хандах ёстой. Судалгаанаас үзэхэд үнийн дүнг тогтоохдоо нэлээдгүй алдаа гарсан байх бөгөөд энэ төрлийн алдаа нь анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн хэрэгт аль алинд нь гарч байна.

5) *Өмчлөх эрх, хэлцэл хүчин төгөлдөр бус гэж тооцох маргааныг хянан шийдвэрлэх асуудал*

Өмчлөх эрхийн маргааныг хянан шийдвэрлэхэд Иргэний хуулийн холбогдох зохицуулалтуудыг буруу тайлбарлан хэрэглэх, эрх зүйн зөв дүгнэлт өгөөгүй, хуулийг буруу хэрэглэсэн зэрэг зөрчлүүд илэрсэн. Тухайлбал, Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх хэсгийн “хууль бус эзэмшил” гэсэн агуулгыг гаргахтай холбоотой

дүгнэлтийг хийхэд Иргэний хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1, 92 дугаар зүйл, 100 дугаар зүйлийн 100.1, 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсэгт заасан талаар дүгнэлт өгөөгүй, эсхүл эдгээр заалтын шаардах эрхийг үндэслэл болгон шийдвэрлэсэн нь алдаатай байна.

Түүнчлэн өмчлөх эрхийн маргааныг Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар шийдвэрлэх тул эдгээр хуулийг нэг мөр хэрэглэх, тайлбарлахад цаашид анхаарах нь зүйтэй байна.

6) Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх асуудал

Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл нь хууль, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд үндэслэсэн эсэхийг шалгах, хөөн хэлэлцэх хугацаа, шүүхэд энэ талаар гомдол гаргах хугацаа зэргийг анхааралгүй хэргийг шийдвэрлэсэн зөрчлүүд байна

Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл тус бүрийн онцлог, түүнтэй холбоотой заавал шалгах нөхцлүүдийг Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцүүлэн тодруулах, хэрэглэх асуудалд анхаарах шаардлагатай байна.

7) Гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх асуудал

Гэр бүлийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгө, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг тогтоох, энэ тухай ойлголтыг нэг мөр болгох шаардлагатай байна. Гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгийг хамтран өмчлөх дундын эд хөрөнгөнд тооцон шийдвэрлэсэн алдаа, зөрчлүүд байна.

Түүнчлэн хүүхдийн асрамжлагчийг тогтоохдоо хүүхдийн эрх ашигт нийцэхгүй, бодит байдалд хэрэгжүүлэх боломжгүй шийдвэрийг гаргасан, Гэр бүлийн тухай хуулийг буруу тайлбарлан хэрэглэх зөрчлүүд түгээмэл гарчээ.

8) Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх асуудал

Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд Иргэний хуулийн эд хөрөнгө буцаан шаардах эрх, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн эд хөрөнгийг захиран зарцуулснаас үүсэх хариуцлага, сайн дураараа эсхүл андуурч үүрэг гүйцэтгэснээс үндэслэлгүй хөрөнгөжсөн эд хөрөнгөө шаардах эрхийг хэрэгжүүлэхдээ хууль хэрэглээний алдаа гаргасан.

9) Гэм хорын маргааныг хянан шийдвэрлэх асуудал

Иргэний хэргийн шүүхээс гэм хор учруулснаас үүсэх үүргийн ерөнхий үндэслэл болон тусгай төрлийн гэм хорын зохицуулалтыг ялган авч үзээгүй эсхүл гэрээний үүргийн болон үүргийн ерөнхий зохицуулалтуудыг гэм хорын маргаанд хэрэглэсэнтэй холбоотойгоор хууль хэрэглээний алдаа түгээмэл гарсан байна.

Сэтгэл санааны хохирлыг арилгахтай холбоотой маргаанд Иргэний хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалтуудыг зөв тайлбарлан хэрэглээгүй зөрчил гарчээ.

10) Бусад маргааныг хянан шийдвэрлэх асуудал

Шүүгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримталж буй хуулийн агуулгыг өөрөөр ойлгох, хуулийн зүйл, хэсгийг зөрүүтэй хэрэглэх, буруу тайлбарлах байдал түгээмэл байна. Тодруулбал, шаардах эрхийн үндэслэлийг буруу тогтоох, гэрээтэй холбоотой маргаанд гэрээний харилцааг буруу тодорхойлох, хөөн хэлэлцэх

хугацааг анхаарахгүй орхих, гэрээний үнийн дүнтэй маргаанд тооцооллын алдаа гаргах болон техникийн алдаа гарч байна.

Санал, зөвлөмж:

“Давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн шийдвэрийн үндэслэл, төрөл” сэдэвт бодлогын судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илэрсэн нийтлэг алдаа, зөрчлийг судалж, тогтоон шүүхийн шийдвэрийг хууль ёсны, үндэслэл бүхий байхад анхаарч дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1) Шүүгчид хэрэгцээтэй сургалт зохион байгуулах

ШСМСХ-гээс шүүгчдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулахдаа судалгааны тайлан болон хавсралтад байгаа материалын хүрээнд сургалтын хөтөлбөрийг боловсруулах замаар материаллаг болон процессын хуулийн хэрэглээ, онолын мэдлэг нэмэгдүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг хэрхэн баримтлах талаарх үр дүнтэй сургалтыг зохион байгуулах шаардлагатай байна. Судлаачдын зүгээс дараах сургалтын сэдвүүдийг санал болгож байна. Үүнд:

1.1. Процессын эрх зүйн чиглэлээр:

- Хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчигдөхөөс сэргийлэх;¹⁰²
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд маргааны үйл баримтад хамааралтай нотлох баримтыг тогтоох, үнэлэх, шинжлэн судлах;
- Хэрэг, маргааны үйл баримтыг зөв тогтоох, нэхэмжлэлийн шаардлагыг тодруулах арга зам

1.2. Хууль хэрэглээний сургалтын чиглэлээр:

- Хууль тогтоомжийн хэрэглээг сайжруулах

1.3. Хууль зүйн техникийн сургалтын чиглэлээр:

- Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангалттай, зөв тайлбарлах, шүүхийн шийдвэрийн бичилтийн ур чадварыг нэмэгдүүлэх

Түүнчлэн шүүгчийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдол бүхий өргөн хүрээний мэдлэг, ур чадвар олгох, хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах хэрэгцээтэй байна. Сургалтын үр дүнд шүүгчид мэргэжил, арга зүй, практикийн ур чадвараа нэмэгдүүлж, цаашид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа, зөрчлүүд багасах боломжтой болно.

2) Хэргийн хөдөлгөөний менежментийг боловсронгуй болгох

Судалгаанаас үзэхэд шүүгчийн ажлын ачаалал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой байх тул цаашид хэргийн хөдөлгөөний менежментийг боловсронгуй, үр нөлөөтэй болгох зайлшгүй шаардлага тулгарч байна. Энэ нь шүүгчдийн гаргаж байгаа энгийн болон процессын журам зөрчих байдлыг бууруулж, хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

3) Судалгааны ажлыг цаашид үргэлжлүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх

¹⁰² Хүснэгт № 1-ийн 3, 6, 7, 10 болон 11

Шүүхийн шийдвэр шат шатандаа хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх, шийдвэрийн боловсруулалтыг сайжруулах, хуулийн зохицуулалтыг нэг мөр, зөв хэрэглэх явдлыг хангах, шүүгчдэд зориулсан сургалтын үр нөлөөг дүгнэх зорилгоор энэ судалгааг 2 жил тутам зохион байгуулах саналтай байна. Энэ нь судалгааны хүрээнд санал болгосон чиглэлээр хийгдсэн сургалтын үр дүнг давхар үнэлэх боломжтой болгоно.

-оОо-

ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЛТ БА ШҮҮГЧИЙН АЧААЛАЛ¹⁰³

Удиртгал

Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар бүлэгт зааснаар шүүхээс онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг хэд хэдэн хэргүүд байдаг. Эдгээр хэргийг шүүх хүсэлт гаргасан иргэн, холбогдох хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэдэг.

Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны сүүлийн 3 жилийн статистик мэдээнээс үзвэл онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэж байгаа хэргүүд сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа нь шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж байна. Цаашлаад эрхийн маргаангүй, эрх зүйн ач холбогдол бүхий эдгээр үйл явдлуудыг шүүх тогтоож, шийдвэрлэж байгаа нь оновчтой эсэх талаар тухайлан авч үзэн, дүн шинжилгээ хийж, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж байгаа хэрэг тус бүрээр судлан үзэх зайлшгүй шаардлагатай тул энэ судалгааг гүйцэтгэв.¹⁰⁴

Нэг. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, статистик үзүүлэлт

1.1. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба Монгол Улсын болон зарим гадаад улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын хувьд иргэний хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааг ИХШХШТХ-ийн 13 дугаар бүлэг буюу 133-155 дугаар зүйлүүдэд тусгагдсан журмын дагуу хэрэгжүүлдэг. Нэхэмжлэлээр үүсэх иргэний хэрэгт материаллаг эрх зүйн маргаан заавал байдаг. Харин онцгой ажиллагааны журмаар шүүх эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болоход нөлөөлөх үйл явдал болон эрх зүйн байдлыг тогтоодог тул энэ хэрэгт эсрэг сонирхол бүхий маргалдагч тал байдаггүй. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа нь эрх зүйн ямар нэгэн

¹⁰³ Тус судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ-ийн судлаач, хууль зүйн ухааны доктор Ц.Мандах /LL.D/ ахалж, судлаач Э.Өсөхжаргал оролцож хамтран гүйцэтгэсэн болно.

¹⁰⁴ Тус судалгааг хийж гүйцэтгэхэд цаг заваа гаргаж ярилцлагад хамрагдсан шүүгчид болох: Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчид: М.Болормаа, Ц.Алтанцэцэг, С.Буд, Д.Энхтуяа, Н.Оюунтуяа, С.Энхбаяр, Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгчид: З.Доржнамжин, О.Номуулин, түүнчлэн судалгааны ажилд туслалцаа үзүүлсэн тус хүрээлэнд туслах судлаачаар ажиллаж байсан Э.Ууганзаяа, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн ангийн төгсөх курсын оюутан Б.Хосжаргал нарт талархлаа илэрхийлье. Санал зөвлөмжөө Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ-ийн хаягаар ирүүлнэ үү.

маргаангүй байх ба үүнд зөрчигдсөн эрхийг сэргээх асуудал үүсэхгүй. Эрх зүйн маргаангүй байна гэдэг нь эсрэг талын зохигч байхгүйгээр нэг талын хүсэлтэд үндэслэгдэнэ.

1.1.1. Монгол Улсад онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны түүхэн хөгжил

Монгол Улсад онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх хуулийн зохицуулалт анх 1967 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан “БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хууль” -ийн 20 дугаар бүлэгт “Байцаан шийтгэх онцгой ажиллагаа” гэдэг нэрээр тусгагдаж, тус хуулийн 175 дугаар зүйлд¹⁰⁵ дараах хэргүүдийг байцаан шийтгэх онцгой ажиллагааны журмаар хэлэлцэхээр заасан. Үүнд:

- 1) Хууль цаазын ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох;
- 2) Иргэнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах;
- 3) Сэтгэл мэдрэлийн өвчтэй буюу ухаан солио туссан тул иргэнийг эрх олох, үүрэг бий болох чадваргүй гэж зарлах;
- 4) Эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх;
- 5) Үрэгдсэн хэргийн буюу тогтоол гүйцэтгэлийн ажиллагааг сэргээх;
- 6) Иргэний гэр бүлийн байдал буруу бүртгэгдсэн явдлыг тогтоох зэрэг 6 төрлийн хэргийг заасан.

УИХ-аас 1994 оны 5 дугаар сарын 9-ний өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /ИХШХШТХ/ 11 дүгээр бүлэгт хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааг тусгаж, 136 дугаар зүйлийн 136.7 дахь хэсэгт “аж ахуйн нэгжийг дампуурсанд тооцох, ноёрхогч болохыг тогтоох болон эдгээр адил төрлийн бусад үйл явдлыг тогтоох тухай”¹⁰⁶ гэсэн шинэ заалт нэмсэн.

Одоо мөрдөгдөж байгаа 2002 оны ИХШХШТХ-ийн 13 дугаар бүлэгт Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүдийг заасан ба өмнөх 1994 оны хуулиас ялгаатай тал нь хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах зэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүдийн тоонд оруулж, эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох асуудалд хүний ажиллаж байсан байдал тогтоох, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, хүүхдээ тэжээн тэтгэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах, эцэг, эх байх эрхийг сэргээх, нас тогтоох¹⁰⁷ гэсэн үйл явдлуудыг тус тус шинээр оруулж, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг хэргийн тоог нэмэгдүүлсэн. Түүнчлэн 2007 болон 2014 оны ИХШХШТХ-ийн нэмэлт өөрчлөлтөөр 133 дугаар зүйлд “Хуулийн этгээдийг дампуурсанд тооцох”, “Иргэний хэргийн

¹⁰⁵ ХЗҮХ, ШУА-ын ФСЭЗХ, МУИС-ийн Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төв, Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төв, “Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл” 5 дугаар боть. Улаанбаатар, 2010 он. 511-512 дахь тал.

¹⁰⁶ ХЗҮХ, ШУА-ын ФСЭЗХ, МУИС-ийн Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төв, Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төв, “Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл” 5 дугаар боть. Улаанбаатар, 2010 он. 314 дэх тал.

¹⁰⁷ Мөн тэнд. 150-151 дэх тал.

үрэгдсэн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх” гэсэн шинэ заалтуудыг тус тус оруулж өгсөн. Дээрх процессын ажиллагааг түүхэн үүднээс авч үзвэл онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэргүүд нэмэгдэх хандлагатай нь харагдаж байна.

1.1.2. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог шинжүүд

Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтэд үндэслэн үүсгэнэ. Хүсэлтийн агуулга нь эрх зүйн ач холбогдол бүхий үйлдэл буюу үйл явдлыг тогтоолгоход чиглэсэн байдаг ба дараах онцлог, шинжтэй байна. Үүнд:

- Онцгой ажиллагаа нь шүүхэд хүсэлт гаргах буюу нэг талын үйл ажиллагаагаар хэрэгждэг;
- Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргийг ИХШШТХ-ийн 82 дугаар зүйлд заасны дагуу шүүгч дангаар шийдвэрлэдэг;
- Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд ИХШШТХ-ийн 6 дугаар зүйлд заасан мэтгэлцэх зарчим хэрэгждэггүй. Хэдийгээр мэтгэлцэх зарчим үйлчлэхгүй ч тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээд, сонирхогч этгээдүүд оролцох тохиолдолд мэтгэлцэх зарчим хязгаарлагдмал хүрээнд хэрэгжиж болдог;

Онцгой ажиллагаанд хариуцагч байдаггүй ч хоорондоо зөрүүтэй ашиг сонирхол байхыг үгүйсгэж болохгүй. Хүсэлтийг аль нэг иргэн, хуулийн этгээд эсэргүүцэх, тэдгээр нь ашиг сонирхлоо хөндөгдөнө гэж үзэж болох юм. Ийм тохиолдолд эсэргүүцэж, ашиг сонирхлоо хөндөгдөнө гэж байгаа этгээдийг ИХШШТХ-ийн 29 дүгээр зүйлд зааснаар гуравдагч этгээдийн нэгэн адил хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна. Харин гуравдагч этгээдээр оролцуулж байгаа этгээдэд хэргээ мэдүүлэх эрхээ бүрэн эдлэх боломжийг шүүх олгох ёстой.¹⁰⁸

Онцгой ажиллагаанд маргалдагч тал байдаггүй тул онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэж, хүсэлтийг хангасан шийдвэрт давж заалдах болон хяналтын журмаар гомдол ховор гардаг.¹⁰⁹

1.2. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх зарим гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт

1.2.1. Оросын Холбооны Улсын эрх зүйн зохицуулалт дахь “Онцгой ажиллагаа”

ОХУ-ын эрдэмтэн Я.А.Борисова нь “Онцгой ажиллагаа” гэдгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг төрөл ба нэхэмжлэлээр үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгаатай тал нь эрхийн талаар маргаан байдаггүй, хууль зүйн хувьд эсрэг тэсрэг ашиг сонирхол буюу маргаантай талууд байдаггүй гэж тодорхойлсон байдаг.¹¹⁰

Оросын Холбооны Улсын Иргэний процессын тухай хуулийн 27 дугаар бүлэгт онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэх хэргүүдийг нарийн тусгасан. Тус бүлэг

¹⁰⁸ Монгол Улсын Дээд Шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, Улаанбаатар, 2014 он. 342 дахь тал.

¹⁰⁹ Д.Хуяг, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд”, Улаанбаатар, 2013 он. 198 дахь тал.

¹¹⁰ Мөн тэнд, 196 дахь тал.

нь Монгол Улсын ИХШХШТХ-ийн 13 дугаар бүлэгт заасан онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэх хэргүүдтэй ерөнхийдөө төстэй байна. ОХУ-ын Иргэний процессын тухай хуулийн 262 дугаар зүйлд:¹¹¹ Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүдийг заасан ба шүүх дараах хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ. Үүнд:

- (1) Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох;
- (2) Хүүхэд үрчлэх харилцаа үүсгэх;
- (3) Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах;
- (4) Иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах, иргэнийг бүрэн чадамжгүйд тооцох, 14-18 хүртэлх насны насанд хүрээгүй этгээдийн өөрийн орлогоо захиран зарцуулах эрхийг нь хязгаарлах, хасах;
- (5) Насанд хүрээгүй иргэнийг эрх зүйн бүрэн чадамжтайд тооцох;
- (6) Хөдлөх эд хөрөнгийг эзэнгүйд тооцох болон эзэнгүй үл хөдлөх хөрөнгийг орон нутгийн өмчид тооцох;
- (7) Үнэт цаасыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг болон захиалсан үнэт цаасны эзэмшигчийн эрхийг сэргээх;
- (8) Иргэнийг албадан шинжилгээ хийлгэхээр сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх, сэтгэцийн үзлэг шинжилгээг албадан хийх;
- (9) Иргэний байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг залруулах, өөрчлөх;
- (10) Нотариатын үйлдэл хийсэн болон түүнийг үйлдэхээс татгалзах тухай;
- (11) Шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх.

Түүнчлэн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан ихэнх улсуудад онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Иргэний процессын тухай хуульд тусгасан байна.¹¹²

Монгол Улсын ИХШХШТХ-ийн дагуу онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгддэг хэргүүдийг ОХУ-ын дээрх хэргүүдтэй харьцуулахад Монгол Улсын ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлд заасан хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох, нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах, хуулийн этгээдийг дампуурсанд тооцох зэрэг хэргүүд нь ОХУ-ын Иргэний процессын тухай хуульд тусгагдаагүй байна. Эдгээрээс харахад, Монгол Улсын онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг хэргүүдийн төрөл¹¹³ нь ОХУ-ыг бодвол илүү өргөн хүрээг хамарч байна.

1.2.2. БНХАУ-ын эрх зүйн зохицуулалт дахь “Иргэний хэргийн онцгой ажиллагаа”

БНХАУ-д Одоо мөрдөгдөж байгаа БНХАУ-ын Иргэний заргын (процессын) тухай хуулийн 15 дугаар бүлэгт хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх тухай тусгасан ба тус хуулийн 160 дугаар зүйлд “Ардын шүүх нь

¹¹¹ <http://www.zakonrf.info/gpk/262/> (2014-07-30) Гражданский процессуальный кодекс РФ, Статья 262. Дела, рассматриваемые судом в порядке особого производства.

¹¹² Тухайлбал Бүгд Найрамдах Беларусь Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Армени Улс, Бүгд Найрамдах Украин Улс, Бүгд Найрамдах Гүрж улсуудын Иргэний процессын эрх зүйг түүвэр байдлаар судлан үзэв.

¹¹³ Энд онцгой ажиллагааны журмаар тогтоодог эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлуудыг хамруулан авч үзэв.

сонгуулийн сонгогчийн эрхтэй холбоотой хэрэг, иргэнийг сураггүй алга болсонд тооцох эсвэл нас барсныг зарлах хэрэг, иргэний эрх зүйн чадамжийг хязгаарлах буюу чадамжгүйд тооцох болон эд хөрөнгийг эзэнгүй болсныг тогтоох хэргийг шийдвэрлэхдээ энэхүү бүлгийн журмыг баримтална” гэж заасан. БНХАУ-ын Иргэний заргын тухай хуулийн 161 дүгээр зүйлийн дагуу онцгой ажиллагааг хянан шийдвэрлэдэг Ардын шүүхийн анхан шатны шүүхийн шийдвэр нь эцсийнх буюу давж заалдах боломжгүй байдаг. Харин сонгогчийн эрхтэй холбоотой сонгуулийн хэргийг шүүх бүрэлдэхүүнээр, бусад хэргүүдийг шүүгч дангаар шийдвэрлэдэг.¹¹⁴

БНХАУ-д онцгой ажиллагааны талаар эрдэмтэн, судлаачид өөр өөрийн байр суурьтай байдаг ба онцгой ажиллагааны журмыг хуульд хэрхэн тусгах талаар 3 төрлийн байр суурь давамгайлдаг: нэгдүгээрт, одоогийн БНХАУ-ын дагаж мөрдөж байгаа онцгой ажиллагааны журмыг дэмжих байр суурийг баримтлагчид; хоёрдугаарт, онцгой ажиллагааны журмыг илүү өргөн хүрээнд авч үзэх байр суурийг баримтлагчид; гуравдугаарт, иргэний хэрэгт эрхийн маргаан байхгүй аливаа хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх ёстой гэж үздэг байр суурийг баримтлагчид. Энэ нь онцгой ажиллагааг илүү өргөн хүрээнд авч үздэг ба хоёрдугаар байр сууриаас ялгаатай нь олон төрлийн хэмжүүрээр хэмжих бус шууд ердийн журмаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа болон онцгой ажиллагаа гэж эрхийн маргаантай болон маргаангүйгээр нь ангилж хэргүүдийг хянан шийдвэрлэх явдал байдаг.¹¹⁵

Дээрхээс харахад, одоо мөрдөгдөж байгаа БНХАУ-ын иргэний процессын тухай хуулийн дагуу онцгой ажиллагааны журмаар цөөн төрлийн хэргийг хянан шийдвэрлэж байна.

1.2.3. Англи-Саксоны эрх зүйн бүл дэх “Онцгой ажиллагаа”

Англи-саксоны эрх зүйн бүлд багтдаг улсууд жишгийн эрх зүйтэй тул эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудын адилаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг “кодексжуулдаггүй” бөгөөд онцгой ажиллагааны журмыг хуульдаа тусгадаггүй болно. Түүнчлэн Англи-саксоны эрх зүйн бүлд хамаарах улсын эрдэмтэн, судлаачдын ном зохиол, онолын бүтээлд энэ тухай ойлголт, нэр томъёо төдийлөн байдаггүй байна. Хэдийгээр Англи-саксоны эрх зүйн бүлд багтдаг улс орнуудад энэ талаарх хуулийн нарийвчилсан зохицуулалт байдаггүй ч заргын бус маргаангүй хэргүүдийг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж байдаг.

Англи-саксоны эрх зүйн бүлд хамаарах улс орнуудын заргын бус хэрэгт (*non-contentious case*) дараах хэргүүд ордог. Үүнд, гэрээслэлийн бичиг баримтыг нягтлан шалгах, нас барагчийн болон эрх зүйн чадамжгүй иргэний эд хөрөнгийг захиран зарцуулах, иргэнийг эрх зүйн чадамжгүйд тооцох буюу асран хамгаалагч томилох, зарим төрлийн итгэмжлэгдсэн хөрөнгийг тогтоох, шүүхийн барьцаанд байгаа данснаас мөнгө гаргуулах, үл хөдлөх эд хөрөнгийг хамгаалалтад авах, үнэт цаас, облигацийн жинхэнэ эзэмшигчийн нэр, хаягийг нийтэд мэдээлэх, өмгөөлөгчид

¹¹⁴ Civil Procedure Law of the People's Republic of China, Article 161
<http://www.china.org.cn/english/government/207339.htm> (2014-08-04)

¹¹⁵ Жанг У Шэнг, “Эрхийн маргаангүй хэргийн процессын талаарх эргэцүүлэл болон шинэчлэл” Хятадын Эрх зүй сэтгүүл, 2011:(03). (章武生《非讼程序的反思与重构》[J],《中国法学》2011(03))

сахилгын шийтгэл оногдуулахаар хүсэлт гаргах, эзэнгүй өмч хөрөнгийг улсын өмчид шилжүүлэх зэрэг болно.


Гадаад улс орнуудын шүүхэд онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэдэг хэдий ч хэргийн төрөл, тоо нь харьцангуй цөөн байдаг нь ажиглагдаж байна.

Хоёр. Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдсэн хэргийн дүн шинжилгээ

2.1. Онцгой ажиллагааны журмаар түгээмэл шийдвэрлэгдсэн хэргийн судалгаа, дүн шинжилгээ

Монгол Улсын шүүн таслах ажиллагааны сүүлийн 3 жилийн тайлан мэдээнээс харахад, Монгол Улсын шүүхээс нийт хянан шийдвэрлэсэн иргэний хэрэгт онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэсэн хэрэг 2011 онд 36.7 хувь, 2012 онд 33.4 хувь, 2013 онд 44 хувийг тус тус эзэлж байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт бөгөөд энэ нь шүүгчийн ажлын ачаалалд нөлөө үзүүлж байна гэж үзэхээр байна.

График 1. ИХШХШТХ-иар шийдвэрлэгдсэн хэргийн тоон үзүүлэлт /2011, 2012, 2013 он/



Дээрх ИХШХШТХ-иар 2011 онд шийдвэрлэгдсэн хэргийг 2012 онтой харьцуулахад 1890 хэргээр буюу 20.4 хувиар буурсан боловч 2012 онд шийдвэрлэгдсэн хэргийг 2013 онтой харьцуулбал 6309 хэргээр буюу 40.5 хувиар өссөн байна.

Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны статистик мэдээ болон анхан шатны шүүхээс ирүүлсэн мэдээнд үндэслэн онцгой ажиллагааны журмаар түгээмэл шийдвэрлэгддэг 7 төрлийн хэргийг дэлгэрэнгүй судлан, дүн шинжилгээ хийж, шүүгчийн ачааллыг тодорхойлов.¹¹⁶

2.1.1. Хүний ажиллаж байсан байдлыг тогтоох

Ажиллаж байсан байдлыг тогтоох нь хүний тэтгэвэр, тэтгэмж авах эрх бий болох нөхцлийг бүрдүүлдэг. Ажиллаж байсан байдлаа тогтоолгох хүсэлтийг объектив талаас нь авч үзвэл улс орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн шинэ харилцаанд шилжих үед буюу 1990 оноос 1995 он хүртэлх хугацаанд тухайн үеийн улсын үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагууд олноор хувьчлагдсан, татан буугдсан, дампуурч үйл ажиллагаа нь зогссон, нэрээ өөрчилсөн зэргээс

¹¹⁶ Онцгой ажиллагааны журмаар түгээмэл шийдвэрлэгддэг хэргүүдийг шүүхийн статистик мэдээ, шүүгчээс авсан санал асуулгын дүнд тулгуурлан сонгон авсан болно.

шалтгаалж ажиллаж байсан байгууллагаас хөдөлмөрийн дэвтэр болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бичилт хийгдээгүйн улмаас ажилласан жил нь тогтоогдох боломжгүй болсон тохиолдолд ажилласан жилээ тогтоолгохоор шүүхэд хүсэлт гаргадаг. Түүнчлэн 1995 оноос 2000 оныг хүртэлх хугацаанд даатгуулагч иргэд нь нийгмийн даатгалд хамрагдаж чадаагүй тохиолдлууд гарсан байна. Субъектив талаас нь авч үзвэл, тухайн хүсэлт гаргагч хуулиар олгосон нөхөн олговор, хөнгөлөлт, тэтгэвэр авах зорилгоор ажилласан жил тогтоолгохоор хүсэлт гаргадаг.

Нийгэм, улс төрийн өөрчлөлтөөс шалтгаалж, өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас дээрх онд иргэдийн нэлээд хувь нь ажил хөдөлмөр эрхлээгүй, эрхлэх боломжгүй болсон, тэтгэврийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй, төлөх боломжгүйгээс ажилласан хугацаа нь тасарсан байх тохиолдлуудыг харгалзан УИХ-аас 2012 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-ийг баталсан. Мөн хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн А/57 дугаар тушаалаар “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулах иргэний нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх журам”-ыг баталсан. Энэ журмын дагуу хүсэлт гаргаж, бүртгүүлэх иргэн нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр байхгүй бол ажилласан хугацааг сэргээн тогтоосон тухай шүүхийн шийдвэрийг бүрдүүлж, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын байцаагчид өгдөг. Энэ хууль, журамтай холбоотойгоор шүүхийн журмаар ажилласан жилээ тогтоолгох хүсэлт дээрх онуудад ихээр нэмэгдсэн байна.

Түүхэн хөгжлөөс үзвэл ажиллаж байсан байдлыг шүүхээс тогтоох асуудлыг 1991 онд УДШ-ээс гаргасан “Иргэдийг ажиллаж байсныг шүүхээс тогтоох тухай” 32 дугаар тогтоолоор зохицуулж, улмаар 1994 оны ИХШХШТХ-д тус ажиллагааг тусгасан ба одоо мөрдөгдөж байгаа 2002 оны ИХШХШТХ-д энэ зохицуулалтыг хэвээр үлдээсэн тул шүүх ажиллаж байсан байдлыг үргэлжлүүлэн тогтоож байна.

Ажиллаж байсан байдлыг гадаад улсад ихэвчлэн захиргааны журмаар тогтоодог ба жишээ болгож БНХАУ-д ажиллаж байсан байдлыг хэрхэн тогтоодог талаар авч үзье.

БНХАУ-д ажиллаж байсан байдлыг тогтоох явдал нь аливаа хөдөлмөрийн эрх зүйн маргаантай хамт явагддаг. Өөрөөр хэлбэл, энэ нь ажил олгогч болон ажилтны хооронд үүссэн маргааны нэг төрөлд хамаардаг. Тухайлбал, ажиллаж байсан байдлыг буруу тогтоосон бол хөдөлмөрийн маргаан таслах комисс эсвэл хөдөлмөрийн арбитра хандаж шийдвэрлүүлдэг. Хэрэв энэ шийдвэрийг эсэргүүцвэл шүүхэд ердийн журмаар шийдвэрлүүлэхээр ханддаг. Тус ажиллагаанд заавал нөгөө талын хариуцагч байдгаараа онцлогтой. Харин ажил олгогч нь татан буугдсан бол татан буулгах ажлын хэсгийг хариуцагчаар оруулдаг. Нотлох баримтаар тухайн хүний ажиллаж байсан байдлыг тогтоох явдлыг БНХАУ-д шүүхийн бус журмаар шийдвэрлэдэг. БНХАУ-д ажилласан байдал буюу ажилласан жилийг тогтооход тухайн ажилтны архив, хавтаст хэрэг нь тухайн ажилласан жилийг тодорхойлоход

хамгийн чухал ач холбогдолтой байдаг. Үүнээс гадна дараах аргуудаар ажилласан жилийг тогтоодог:¹¹⁷

- 1) Тухайн ажилтны нийгмийн даатгал төлж байсан тухай мэдээллийг авна. Энэхүү мэдээллээс тухайн ажилтан хэзээнээс ажиллаж эхэлсэн зэргийг тодорхойлох боломжтой байдаг.
- 2) Ажил олгогч ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хугацаа нь тухайн ажилтны ажиллаж байсан хугацааг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг. Учир нь хэрэв тухайн ажил олгогч нь нийгмийн даатгалыг төлөөгүй тохиолдолд хөдөлмөрийн гэрээгээр ажилласан хугацааг тодорхойлох боломжтой байдаг.
- 3) Ажил олгогчоос гаргасан “Ажилчдын нэрсийн бүртгэл”-д ажилтан хэзээнээс эхэлж бүртгэгдсэн, түүний ажиллаж эхэлсэн байдлыг тодорхойлох боломжтой байдаг.
- 4) Холбогдох хууль тогтоомжийн дагуу ажил олгогч хөдөлмөрийн гэрээг цуцалсан тухай шийдвэр, тушаалыг үндэслэн ажиллаж байсан жилийг тодорхойлно.
- 5) Хэрэв хоёр тал хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх комиссын дагуу эвлэрч, зөвшилцөлд хүрч шийдвэр гаргуулсан эсхүл шүүхийн шийдвэр гарсан бол тухайн шийдвэр, эвлэрлийн гэрээнд тусгаж, тогтоосон ажилласан жилийг баримтална.

Хэрэв дээрх баримт бичгийг гаргаж чадахгүй буюу ажилласан жилийг нотолж чадахгүй эсхүл ажилласан жилийн хугацаан дээр зөрүүтэй бөгөөд 2 тал зөвшилцөлд хүрч чадахгүй бол хөдөлмөрийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллагад ажилласан жилийг шинжлэн тогтоолгохоор хүсэлт гаргаж болдог. Хэрэв тухайн байгууллага нь оршин тогтнохоо больсон бол тухайн байгууллагын байрлаж байсан хөдөлмөрийн асуудал хариуцсан засаг захиргааны байгууллагын архив зэргээс ажиллаж байсан байдлыг гаргуулахаар хүсэлт гаргадаг бөгөөд энэ нь хөдөлмөрийн маргаанд тооцогддоггүй.¹¹⁸

Монгол Улсын нийт шүүхийн хэмжээнд хүний ажилласан жил тогтоолгох тухай 2011 онд 5116, 2012 онд 4228, 2013 онд 10569 хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн ба эдгээр статистик тоон мэдээнээс харахад ажиллаж байсан байдлыг шүүхэд хянан шийдвэрлэсэн хэргийн тоо өсч, 2013 онд зөвхөн ажилласан жилийг тогтоох хэрэг улсын хэмжээнд нийт шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 30 орчим хувийг эзэлсэн байна. Үүнээс үзэхэд онцгой ажиллагааны журмаар хүний ажиллаж байсан байдлыг тогтоох ажиллагаа нь шүүхэд хамгийн их ажлын ачаалал үүсгэж байна гэж үзэхээр байна. Түүнчлэн шүүгчдээс авсан санал асуулгын судалгаанаас¹¹⁹ үзэхэд онцгой

¹¹⁷ Ажилласан жилийг хэрхэн тогтоож, тооцох бэ? Цахим холбоос <http://china.findlaw.cn/laodongfa/html/laodongfalvwang/yuangongquanyi/gongshixiuji/nxi/18320.html> (2014-08-07)

¹¹⁸ Хөдөлмөрчний ажилласан жилийг хэрхэн тооцож, хэн нотлох бэ? Цахим холбоос <http://xfxfy.chinacourt.org/public/detail.php?id=1203> (2014-08-11)

¹¹⁹ Тус судалгааг Монгол Улсын нийслэл болон орон нутгийн анхан шатны шүүхийн нийт 65 шүүгчээс авсан болно.

ажиллагааны журмаар ажилласан жил тогтооход хугацаа их шаарддаг гэж нийт судалгаанд хамрагдсан шүүгчдийн 22.6 хувь буюу дийлэнх хувь нь үзсэн байна.

Дүгнэлт: Монгол Улсад 1990 онд өрнөсөн шилжилт өөрчлөлтийн үйл явцаас хойш нийгмийн шаардлагаар үүссэн энэ тогтолцоог цаашид үргэлжлүүлэн хадгалах шаардлагагүй бөгөөд заавал шүүхийн журмаар шийдвэрлэж шүүхэд ачаалал үүсгэх бус харин гадаад улсын ижил төстэй туршлагыг нэвтрүүлж, шүүхийн бус журмаар урьдчилан шийдвэрлэдэг болох боломжтой юм. Энэ тохиолдолд тухайн захиргааны байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрсөн, түүнд маргаан үүссэн, гуравдагч этгээдийн эрх ашиг хөндөгдсөн зэрэг нөхцөлд захиргааны хэргийн шүүх энэ асуудлыг тогтоосон журмын дагуу хянан шийдвэрлэж болно.

2.1.2. Нас тогтоох

Хүний нас нь өөрийн үйлдлээр өөртөө эрх, үүрэг бий болгох, эдгээрийг хэрэгжүүлэх эрх зүйн боломжийг иргэдэд бий болгодог.¹²⁰ Бичиг баримтын огноо болон нас нь зөрүүтэй бичигдсэн, бичиг баримтаа үрэгдүүлсэн, устгасантай холбоотой нас тогтоох үндэслэл бий болдог. Шүүх хүний насыг тогтоохдоо иргэний гэр бүлийн бүртгэлийн архивын лавлагаагаар нас нь тодорхой болсон, энэ талаар тухайн иргэн маргаан гаргаагүйгээс бусад тохиолдолд энэ тухай хүсэлтийг хянан шийдвэрлэдэг ба үүнийг шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлт, нотлох баримтад үндэслэн шийдвэрлэдэг.

Монгол Улсын онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх журамтай төстэй зохицуулалттай хуучны ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудаас түүвэрлэн авч үзвэл, 1998 оны Бүгд Найрамдах Армен Улс, 1999 оны Бүгд Найрамдах Казахстан Улс, 2002 оны Оросын Холбооны Улс, 2003 оны Бүгд Найрамдах Молдав Улс, 2009 оны Бүгд Найрамдах Беларусь Улсын Иргэний процессын тухай хуулиудад нас тогтоох тухай зохицуулалт тусгагдаагүй байна. Түүнчлэн хөрш орон болох БНХАУ-ын Иргэний заргын тухай хууль болон БНХАУ-ын Бүх улсын Ардын дээд шүүхийн тайлбарууд, бусад хууль тогтоомжид шүүхийн журмаар нас тогтоох явдлыг тусгаагүй байна.

Гадаад улсад шүүхийн журмаар нас тогтоох явдал ихэвчлэн байдаггүй ба энэ нь Монгол Улсын хувьд тухайн үеийн нийгэм, улс төрийн хүчин зүйлээс шалтгаалан архивд мэдээлэл байхгүй, эсхүл ард иргэд өөрсдөө бүртгэлээ хожим хийлгэж байсан зэрэг шалтгаантай холбоотойгоор үүдэн улсын бүртгэлд бүртгэгдсэн төрсөн он, сар, өдөр нь өөрийн бие физиологийн наснаас зөрүүтэй нөхцөл байдал үүссэн тул, шүүхийн журмаар¹²¹ насаа тогтоолгож байгаа нь шүүхэд ажлын ачаалал үүсгэж байна.

Монгол Улсын хэмжээнд шүүхээс 2011 онд 680, 2012 онд 497, 2013 онд 345 нас тогтоох хүсэлтийг хянан шийдвэрлэсэн. Санал асуулгад оролцсон нийт 65

¹²⁰ Монгол Улсын Дээд шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” Улаанбаатар, 2014 он. 352 дахь тал.

¹²¹ Монгол Улсын хувьд 1990 оноос хойш өрнөсөн нийгэм, улс төрийн өөрчлөлт, нөхцөл байдлыг харгалзан нас тогтоох явдлыг анх 1994 оны ИХШШТХ-д эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдалд хамруулан шүүхийн журмаар тогтоохоор хуульчилж өгсөн ба энэ нь тухайн үед захиргааны байгууллагаар шийдвэрлүүлэх, архиваас мэдээлэл олдох боломжгүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан насаа тогтоолгох боломжгүй болсон олон тооны иргэний эрх ашгийг хамгаалах үүднээс энэ зохицуулалтыг хуульчилж өгсөн байх боломжтой юм.

шүүгчийн 18.9 хувь нь нас тогтоох хэргийг хянан шийдвэрлэхэд багагүй хугацаа шаарддаг гэж хариулсан. Нас тогтоох нь шинжээчээр дүгнэлт гаргуулахыг шаарддаг тул хянан шийдвэрлэхэд хугацаа их авдаг байна.

Дүгнэлт: Захиргааны байгууллагаас тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхдээ иргэнийг заавал шүүхийн журмаар насаа тогтоолгохыг шаардаж, шүүхийн журмаар энэ асуудлыг шийдвэрлүүлэхээс өөр аргагүй байдалд хүргэж байгаа нь шүүхийн ажлын ачааллыг ихэсгэж байна. Энэ тохиолдолд холбогдох эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулж, урьдчилан захиргааны байгууллагын шийдвэрээр шийдвэрлүүлдэг болгож, тухайн захиргааны байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрч, маргаан үүсгэсэн, гуравдагч этгээдийн эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд захиргааны хэргийн шүүх харьяаллын дагуу энэ асуудлыг хянан шийдвэрлэдэг болох боломжтой.

2.1.3. Хамтын амьдралтай байсныг тогтоох

Монгол Улсын шүүхийн практикт ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.2.14-т зааснаар тогтоох журмыг хуульд заагаагүй, эрх зүйн ач холбогдол бүхий бусад үйл явдлыг тогтоох тухай заалтыг үндэслэн хамтын амьдралтай байсныг хүсэлт гаргагчийн хүсэлтэд үндэслэн тогтоож байна.

Шүүн таслах ажиллагааны мэдээнээс харахад Монгол Улсын хэмжээнд хамтын амьдралтай байсныг тогтоолгох тухай 2011 онд 317, 2012 онд 353, 2013 онд 390 хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн байна. Эдгээр тоон судалгаанаас үзэхэд энэ төрлийн хэрэг нь өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна. Хамтын амьдралтай байсныг тогтоох тухай тодорхой хуулийн заалт байхгүй байгаа боловч энэ төрлийн хэрэг нь онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгддэг хэргийн дотор дийлэнх хувийг эзэлж байна.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулиар хамтын амьдрал гэж нэр томъёог тодорхой тайлбарлаагүй ба хамтын амьдрал нь гэрлэлтийн үр дүнд үүсээгүй хамтын амьдрал бүхий харилцаа юм. Гэр бүлийн тухай хуулийн зүйл заалт,¹²² үзэл санаанаас харахад, гагцхүү хууль ёсны дагуу гэрлэлтээ бүртгүүлсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын хооронд гэр бүлийн эрх зүйн харилцаа үүсэхээр байна. Эрх зүйн харилцаа нь эрх зүйн хэм хэмжээ болон амьдралын тодорхой нөхцөл байдлын улмаас харилцан субьектив эрх, үүрэг бүхий эрх зүйн тодорхой субьектуудын хооронд үүссэн нийгмийн харилцааны хууль зүйн хэлбэр юм.¹²³ Эдгээрээс харахад хамтын амьдралтай байсан нь аливаа эрх зүйн харилцаа, эрх, үүрэг үүсэх үндэслэл болохгүй юм.

Хамтын амьдралтай байсан нь Гэр бүлийн тухай хуулийн дагуу албан ёсоор хууль ёсны эхнэр, нөхөр болсноос өөр ойлголт бөгөөд гэрлэгсдийн хооронд үүсдэг эрх зүйн харилцаан дахь эрх, үүргийг хамтын амьдралтай байснаар эдэлдэггүй. Харин 2014 онд УИХ-д өргөн барьсан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Хамтран амьдрах” гэж гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлээгүй ч

¹²² Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д зааснаар “Гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг хэлнэ. “Гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг хэлнэ.

¹²³ Ч.Нямсүрэн, “Эрх зүйн ерөнхий онол-Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал” Улаанбаатар, 2010 он. 305 дахь тал.

эрэгтэй, эмэгтэй хоёр харилцан тохиролцсоны үндсэн дээр гэр бүлийн харилцаа үүсгэн хамтран амьдарч байгааг хэлнэ¹²⁴ гэж заасан. Энэ харилцааг гэр бүлийн харилцаа гэж үзэх нь хэр зохистой талаар дахин эргэцүүлэн бодох шаардлагатай юм. Учир нь гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална гэж Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.11 дэх хэсэгт заасан байдаг. Гэтэл Гэр бүлийн тухай хуулийн дээрх зүйл заалтаар харилцан тохиролцсон л бол гэр бүлийн харилцаа үүснэ гэж заасан нь Үндсэн хуулийн үзэл санаатайгаа зөрчилдөж магадгүй гэж үзэхэд хүргэж байна.

Гадаад улсад хамтын амьдралын тухай нарийвчлан зохицуулсан байдаг ба гагцхүү тодорхой нөхцлийг хангасан тохиолдолд тухайн хамтын амьдралын харилцааг гэр бүлийн харилцаатай адилтган үзэж, хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал, ХБНГУ-ын гэр бүлийн эрх зүйн материаллаг хэм хэмжээ нь Монгол Улсын адил гэрлэх нөхцөл, гэрлэлтийг бүртгэх журам хоёрыг хослуулсан зохицуулалттай¹²⁵ ба гэр бүл болоход заавал бүртгэл хийлгэдэг тул бүртгэлийг хийлгээгүй бол тухайн гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж үздэг. Гэхдээ 1998 онд ХБНГУ-ын Иргэний хуулийн 1310 дугаар зүйлийн 3(3) дахь хэсэгт өөрчлөлт оруулан хүчин төгөлдөр бус гэрлэлтийг тодорхой нөхцөл хангагдсан бол гэрлэлтийг хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрөх тухай заалт оруулсан ба гэрлэлтээ батлуулаагүй эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтран амьдраад 10 жил болсон, эсхүл нэг тал нь нас барах хүртэл хамтран амьдраад 5 жил болсон бол гэр бүл гэж тооцно гэж заажээ.¹²⁶

Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд Гэр бүлийн тухай хуулийн дагуу гэрлэлтээ бүртгүүлэх бус хамтран амьдрах явдал улам их нэмэгдэж байна. Үүнээс үүдэн хамтын амьдралтай байсныг тогтоолгохоор шүүхэд хүсэлт их ирж байгаа ба голчлон гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтын амьдралаас үүссэн зөрчигдсөн эрх ашгаа хамгаалуулах хүсэлт гаргаж байна. Монгол Улсын хувьд Гэр бүлийн тухай хууль нь хэтэрхий нэг талыг баримталсан зохицуулалттай, түүнчлэн хамтын амьдрал, түүнээс үүдэн гарах үр дагаврыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байдаггүй зэргээс хамаарч тодорхой эрх ашгаа хамгаалуулж чадахгүйд хүрч, шүүхэд хандан хамтын амьдралтай байснаа тогтоолгох явдал их байна.

➤ *Шүүхээр хамтын амьдралтай байсныг тогтоосон байдалд хийсэн дүн шинжилгээ*

Дээрхээс үзвэл хамтын амьдралтай байсныг тогтоолгох хүсэлтийн үндэслэлийг сайтар нягталж шалган, ач холбогдлыг нь тодорхойлон тогтоож байх нь зүйтэй юм.

Иргэд ихэвчлэн тэжээгчээ алдсаны тэтгэмж авах хүсэлтийг захиргааны байгууллагад гаргахад гэрлэлтийн гэрчилгээ, хэрэв гэрлэлтээ бүртгүүлээгүй бол хамтын амьдралтай байсныг шүүхээр тогтоосон шийдвэрийг шаарддаг тул хамтын амьдралтай байсныг тогтоолгохоор шүүхэд ханддаг. Тэжээгчээ алдсаны тэтгэмж авах тохиолдолд эцэг, эх тогтоогдсон байж тухайн тэтгэмж авах эрх үүсдэг. Гэр бүлийн

¹²⁴ “Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”, 2014 он. 3 дугаар зүйлийн 3.1.12.

¹²⁵ Т.Мэндсайхан, “Олон Улсын хувийн эрх зүй”, Улаанбаатар, 2008 он. 173 дахь тал.

¹²⁶ ХБНГУ албан ёсны хуулийн цахим хуудас, Иргэний Хууль /Цахим холбоос http://www.gesetze-internet.de/englisch_bgb/englisch_bgb.html#p4713/ (2014-08-15)

тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт зааснаар “Хүүхдийн эцэг, эх нь гэрлэлтээ бүртгүүлсэн бол гэрлэлтийн гэрчилгээг, гэрлэлтээ бүртгүүлээгүй бол хуульд заасны дагуу захиргааны буюу шүүхийн журмаар эцэг, эхийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тогтоогдоно” гэж заасны дагуу гэрлэлтээ бүртгүүлээгүй бол шүүхийн шийдвэрээс гадна захиргааны эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тогтоож болдог. Түүнчлэн Гэр бүлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасны дагуу “Гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд нь гэрлэлтээ бүртгүүлсэн гэр бүлээс төрсөн хүүхдийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэж заасны дагуу хүүхдийн эрх ашгийг хангах үүднээс шүүх гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхдийн эрх ашгийг хангах зорилгоор хамтын амьдралтай байсан явдлыг тогтоож байна.

Түүвэр байдлаар сонгон авсан хамтын амьдралтай байсныг тогтоосон хэргүүдээс авч үзье:

Хэрэг 1: *Иргэн А шүүхэд гаргасан хүсэлтэндээ болон шүүх хуралдаанд тайлбарлахдаа: Би Б-тэй 1998 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр танилцаж улмаар нэг гэрт орж амьдарсан. Би өөрөө дагавар 3 хүүхэдтэй байсан. Б-тэй суугаад 2012 оны 3 дугаар сарын 05-ны өдөр охин О-г төрүүлсэн. Бид гэрлэлтээ батлуулж чадаагүй байтал нөхөр маань 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр өвчний улмаас нас барсан. Хүүхдийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох болсон тул бид хоёрыг 1998 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл хамтран амьдарч байсныг тогтоож өгнө үү гэсэн байна. Улмаар тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгч үндэслэхдээ А нь 1998 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл Б-тэй хамтран амьдарч байсан болох нь хүсэлт гаргаагчийн тайлбар, охин О-ийн 00 дугаартай төрсний гэрчилгээний хуулбар, өрхийн эмнэлгийн тодорхойлолт, гэрэл зургууд, гэрч Н, Э. нарын тодорхойлолт болон шүүхэд гаргасан мэдүүлэг зэрэг баримтуудаар тус тус нотлогдож байна. Охин О нь 2012 оны 3 дугаар сарын 05-ны өдөр төрсөн бөгөөд эцэг Б-ээр овоглон төрсний гэрчилгээ авсан тул хүсэлтийг хангаж, ИХШХШТХ-ийн холбогдох заалтуудыг удирдлага болгон хамтын амьдралтай байсныг нь тогтоосон байна.*

Дээрх хэргээс үзэхэд хүсэлт гаргасан иргэний хүсэлтийн үндэслэл буюу зорилго нь хамтын амьдралтай байсныг тогтоолгох бус тэжээгчээ алдсаны тэтгэмж авахтай холбоотой ба тэтгэмж авах гэж буй үр хүүхэд нь нэгэнт нас барсан иргэний нэрээр овоглосон тул тухайн тэтгэмжийг олгох эрх бүхий байгууллага хамтын амьдралтай байсныг тогтоосон шүүхийн шийдвэрээр бус иргэний бүртгэлийн лавлагаа эсхүл захиргааны байгууллагын шийдвэр зэргээр энэ асуудлыг шийдэж болох юм. Иймд шүүх энэ тохиолдолд хамтын амьдралтай байсныг тогтоох бус харин тухайн хүсэлт гаргасан иргэнд шүүхийн бус журмаар шийдвэрлүүлэх талаар зөвлөх буюу тухайн захиргааны байгууллагад энэ тухай шийдвэрийг гаргахыг даалгаж болох юм.

Түүнчлэн нас барсан иргэний нэрээр овоглуулаагүй байсан хэдий ч УДШ-ийн 2012 оны “Онцгой ажиллагааны журмаар зарим хэргийг хянан шийдвэрлэхэд

анхаарах асуудал” зөвлөмжийн дагуу гэр бүлийн баталгаагүй байхад хүүхдийн эцэг нас барвал шүүхийн журмаар эцэг тогтоосны үндсэн дээр бүртгэлийн байгууллага нас барсан этгээдийг хүүхдийн эцгээр бүртгэнэ гэж заасны дагуу шүүх хамтын амьдралтай байсныг тогтоох бус эцэг тогтоох журмаар энэ асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Хамтын амьдралтай байсныг тогтоосноос үүсэх үр дагаврын хувьд хамтын амьдралтай байх үед үүссэн эд хөрөнгийн маргааны асуудал гардаг.

Түүвэр байдлаар сонгон авсан хамтын амьдралыг тогтоосон, хамтын өмчийн маргааны 3 шатны шүүхийн шийдвэрийг авч үзье.

Хэрэг 2: Анхан шатны шүүхэд нэхэмжлэгч “Ж-тэй хамтын амьдралтай байсныг тогтоож, Х тоот 2 өрөө орон сууцны өмчлөгчөөр намайг болон 2 охиныг тогтоож өгнө үү” гэж хүсэлт гаргасан байна. Анхан шатны шүүх үзэхдээ Иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад гэрлэлтээ бүртгүүлээгүй тул дээрх 2 өрөө орон сууцыг А, Ж нарын гэр бүл болсноос хойш бий болсон хөрөнгө гэж үзэх үндэслэлгүй гэж үзсэн бол нэхэмжлэгчийн өмгөөлөгч давж заалдах гомдолдоо: “Заавал гэр бүлийн баталгаатай байж хөрөнгө хуваана гэсэн ойлголт байхгүй. Хуулийг буруу тайлбарлаж шийдсэн. Хамтран амьдарч байсныг шүүх тогтоосон хирнээ хамтын амьдралтай байх хугацаанд бий болсон үл хөдлөх хөрөнгийг нь хуваасангүй. Иймд сум дундын шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж орон сууцны үнээс А-д оногдох хэсгийг гаргаж өгнө үү” гэжээ.

Давж заалдах шатны шүүх үзэхдээ, “А, Ж нарыг хамтын амьдралтай байсныг тогтоосон боловч хамтын амьдралтай байсан хугацааг нь тогтоогоогүй байна. Зохигчид хэдээс хэдэн он хүртэл хамтран амьдарч байсныг тогтоосны эцэст маргааны зүйл болох 2 өрөө орон сууцыг тухайн хугацаанд худалдан авсан эсэхийг тодорхойлох ёстой байжээ” гэж үндэслэх хэсэгт дурджээ.

Улмаар хяналтын шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгосон байна.

Хэрэг 3: Өөр нэгэн хэрэгт нэхэмжлэгч дурдахдаа, хэрэв С байрны асуудлыг заавал шүүхээр шийдвэрлүүлэхийг хүсээд байвал миний бие хамтран амьдарч байснаа тогтоолгоод нэг өрөөг авна. Хүү Г-д нэг өрөөг нь өгнө. Энэ байр бидний 6 жил хамт амьдарч байхдаа бий болгосон дундын өмч учраас бид хоёрт хувь тэнцүүлэн хувааж эзэмших эрхээр хангаж өгнө үү гэсэн хүсэлт шүүхэд ирсэн байна. Давж заалдах шүүх үндэслэхдээ нэхэмжлэл гаргасан 2 өрөө орон сууцыг зохигчдыг хамтран амьдарч байх хугацаанд улсаас олгосон тул хамтран өмчлөх дундын өмчид тооцогдох үндэслэл байгааг анхаарах нь зүйтэй гэж үзсэн байна.

Хэрэг 4: Хяналтын шатны шүүхээс үзэхдээ, “Нэхэмжлэгч А, хариуцагч Б нар нь хамтын амьдралтай байсан боловч Гэр бүлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар гэр бүлийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүйгээс тэдгээрийн хооронд гэрлэгчдийн эрх, үүрэг үүсээгүй

байна. Иймд Иргэний хуулийн 126 дугаар зүйлийн 126.1-д заасан гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн харилцаа үүсээгүй байхад анхан болон давж заалдах шатны шүүх хууль буруу тайлбарлан хэрэглэж, Б-ийн дангаар өмчлөх орон сууцыг дундын хөрөнгөө гэж үзэж, А болон хүү Б нарт оногдох хэсгийг гаргуулж шийдвэрлэсэн нь буруу байна” гэжээ.

Дээрх хэргүүдээс үзвэл давж заалдах шатны шүүх ихэвчлэн гэр бүлээ батлуулсан эсэхийг авч үзэхээс илүүтэйгээр хамтын амьдралтай байсан гэдэг үйл баримтад тулгуурлан хамтын амьдралын үед бий болсон өмч нь дундын өмч мөн гэж тодорхойлж байна. Энэ нь хэтэрхий нэг талын материаллаг хэм хэмжээг баримтлах бус харин гэр бүлийн харилцаа бүхий хамтын амьдралаас үүссэн өмчийн харилцаанд 2 талыг эрх тэгш байдлаар оролцуулж, эрх ашгийг нь хангахад чиглэсэн байна.

Дүгнэлт: Нийгмийн хурдацтай хөгжлийн нөлөөгөөр гэр бүлийн уламжлалт харилцаа өөрчлөгдөж, гэрлэлтээ бүртгүүлэхгүйгээр хамтран амьдрах нь түгээмэл болсон тул бусад улс орнууд эрх зүйн зохицуулалтаа тухайн иргэний эрх ашгийг аль болох хамгаалахад чиглүүлж, уян хатан хэлбэрээр зохицуулсан байна. Судалгааны хүрээнд цуглуулсан шүүхийн шийдвэрийг судалж үзвэл иргэд хамтран амьдрах хугацаандаа гэрлэлтээ хуулийн дагуу бүртгүүлээгүйгээс болж хамтын амьдралтай байсныг тогтоолгохоор шүүхэд олноор хандаж байна. Энэ тохиолдолд Монгол Улс ХБНГУ-ын загварыг сонгон авч хэрэгжүүлж болох бөгөөд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаснаар хамтран амьдарснаар шууд гэр бүлийн харилцаа үүссэн гэж үзэх бус, харин тодорхой цаг хугацааны шалгуурыг хангасан тохиолдолд гэр бүл болох нөхцлийг хангасан хамтын амьдрал бүхий эсхүл хамтын амьдралтай байсан эрэгтэй, эмэгтэй хоёр хүнийг гэр бүл гэж үзэж болохоор хуульчлах нь зүйтэй юм. Гэр бүлийн эрх зүйн хүрээнд хамтын амьдралын харилцааг ийнхүү нарийвчлан зохицуулснаар энэ асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэнэ.

2.1.4. Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох

Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох тухай хүсэлт нь үрчлэлтийг дуусгавар болгоход чиглэгдэнэ. Үрчлэлтийг хүчингүйд тооцох үндэслэл нь үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьцсан, хуурамч бичиг баримт бүрдүүлж хүүхэд үрчлэх шийдвэр гаргуулсан, хүүхэд үрчлэн авч болохгүй этгээд хүүхэд үрчилсэн нь илэрсэн зэрэг нөхцөл хамаарна.¹²⁷ Үрчлэлтийг хүчингүйд тооцох үндэслэл нь хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасах зарим үндэслэлтэй байж болно. Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан гэдэг нь хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр шунахайн зорилгоор ашиглах, гэмт хэрэг, зөрчилд татан оруулах зэрэг үрчлэгчийн хууль бус үйлдлийг хамааруулан ойлгодог.¹²⁸

Монгол Улсын хэмжээнд хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай 2011 онд 146, 2012 онд 140, 2013 онд 190 хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн. Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2.2-т шаардлагатай гэж үзвэл бусад үндэслэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож болно гэж заасан байдаг тул шүүхэд дээрхээс бусад үндэслэлээр үрчлэлтийг хүчингүйд тооцуулах хүсэлт ихээр ирдэг.

¹²⁷ Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.

¹²⁸ А.Дугармаа, “Монгол Улсын гэр бүлийн эрх зүй”, Улаанбаатар, 2005 он. 94-95 дахь тал.

Одоогийн эрх зүйн зохицуулалтаар хүүхэд үрчлэлтийн харилцааг цуцлах асуудалтай холбоотой хэргийг шүүхийн журмаар шийдвэрлэж байгаа нь шүүгчид ажлын ачаалал үүсгэж байна. Тухайлбал, хүүхдийг гадаад улсад явуулахын тулд хэн нэгэн этгээдэд үрчлүүлсэн, хүүхдээ эцэг, эхдээ үрчлүүлснээ хүчингүй болгож өөрийн нэрээр овоглохыг хүссэн, хойд эцэгт үрчлүүлсэн үрчлэлтээ хүчингүй болгож төрсөн эцгээр нь овоглохыг хүссэн зэрэг үрчлүүлэх хүсэл зориг жинхэнээсээ байгаагүй, ямар нэг маргаангүй үрчлэлтийг хүчингүйд тооцуулах хүсэлт гаргаж байна.¹²⁹ Түүнчлэн, үрчилсэн хүүхдийг буцаан өгөх, хүүхдийн мөнгө авах, гэр бүл цуцлалттай холбоотой хүүхдээ үрчлүүлж, гэрлэлтээ батлуулахдаа хүүхдээ эргүүлж авах зэрэг хүсэлтийн дагуу хүүхэд үрчилснийг хүчингүй болгохоор шүүхэд ханддаг.

Монгол Улсын шүүхэд үрчлэлтийг хүчингүй болгуулахаар ирсэн дээрх маргаангүй үрчлэлтийг хүчингүйд тооцох хүсэлт нь шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж байна гэж үзэв.

Монгол Улсын үрчлэлтийн харилцааг зохицуулсан Гэр бүлийн тухай хуульд үрчлэлтийн харилцааг хэрэглэх тохиолдлуудыг тодорхой зааж, зааглаж өгөх хэрэгтэй байна. Тухайлбал, БНХАУ-д өнчин болон төрүүлсэн эцэг, эх нь асран тэжээх чадваргүй болсон хүүхдийг төрүүлсэн эцэг, эхийн төрөл садан, найз нь асран харгалзаж болно. Асран харгалзагч болон асран харгалзуулж буй хүүхдийн хоорондын харилцаанд үрчлэлтийн харилцааг хэрэглэхгүй гэж заасан.¹³⁰ Үрчлэлт нь хувь хүний эрх, үүргийг өөрчилж байгаа иргэний эрх зүйн чухал хэлцэл бол асран харгалзах гэдэг нь насанд хүрээгүй хүнийг асран харгалзах үүрэг бүхий төрөл садан эсхүл бусад этгээд тэжээн тэтгэх, асран хамгаалах болон сурган хүмүүжүүлэх хариуцлага байдаг. Асран тэтгэх харилцаа нь асран тэтгэгч болон асран тэтгүүлэгч хоёрын хооронд эцэг, эх хүүхдийн харилцаа үүсгэх зорилгогүйгээр асран тэтгэж, тэжээх харилцаа байдаг.¹³¹

Үрчлэлтийг хүчингүй болгох талаар бусад орнуудын практикаас үзвэл, Европын холбооны гишүүн Латви Улсын Иргэний процессын тухай хуулийн 263 дугаар зүйлд хүүхэд үрчилснийг хүчингүй болгох тухай заасан. Тус хуулийн 263 дугаар зүйлийн 263.1 дэх хэсэгт: “Шүүх үрчлэгч болон насанд хүрсэн үрчлүүлэгчийн хамтарсан хүсэлтийг үндэслэн үрчлэлтийг хүчингүй болгож болно” гэж заасан.¹³² Үүнээс харахад хоёр талын буюу зохигчийн хүсэлтийг үндэслэж шүүхийн журмаар үрчлэлтийг хүчингүй болгож болдог байна. Түүнчлэн үрчлэлтийг хүчингүй болгох ажиллагаа нь ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар явагддаг байна.

ОХУ-ын хуульд онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд дотор хүүхэд үрчлэлтийг хүчингүй болгох тухай зохицуулалт байдаггүй бол БНХАУ-ын Үрчлэлтийн тухай хуульд үрчлэлтийг цуцлах талаар тодорхой заасан. БНХАУ-ын Үрчлэлтийн тухай хуулийн 26 дугаар зүйлд: “Үрчлэн авагч нь үрчлүүлсэн хүүхдийг

¹²⁹ О.Номуулин, “Гэр бүлийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан үрчлэлтийг хүчингүйд тооцох зохицуулалтыг хэрэглэхэд тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлууд”, Монголын төр, эрх зүй: Үзэл бодол, тулгамдсан асуудал (тусгай дугаар), Улаанбаатар, 2014 он. 211-212 дахь тал.

¹³⁰ БНХАУ-ын Үрчилэлтийн тухай хууль, 1998 он, 17 дугаар зүйл.

¹³¹ <http://www.chinabaik.com/law/zhishi/1008/1506145.html> (2014-08-20)

¹³² Латви Улсын Иргэний Процессын тухай хууль http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=191081#LinkTarget_4790 (2014-08-21)

насанд хүрэхээс өмнө үрчлэлтийн харилцааг цуцалж үл болно, гагцхүү үрчлэн авагч, үрчлүүлэгч хоёр хэлэлцэн тохиролцож гэрээгээр цуцалж болно. Үрчилсэн хүүхэд нь 10 нас хүрсэн бол түүний зөвшөөрлийг авна” гэж заасан. Үрчлэн авагч нь тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, тарчлаан зовоосон, хүүхдээ хаяж, төөрүүлсэн зэрэг насанд хүрээгүй үрчлүүлсэн хүүхдийн хууль ёсны эрх ашигт халдсан үйлдэл гаргаж байсан бол үрчлүүлсэн этгээд, үрчлүүлэгч, үрчлэн авагч болон үрчлүүлсэн хүүхэд хоорондын үрчлэлтийн харилцааг цуцлахыг шаардаж болно. Үрчлүүлэгч, үрчлэн авагч хоёр харилцан тохиролцолд хүрч үрчлэлтийг цуцалж чадахгүй бол Ардын шүүхэд зарга үүсгэн шийдвэрлүүлнэ. Түүнчлэн БНХАУ-ын Үрчлэлтийн тухай хуулийн 27 дугаар зүйлд: “Үрчлэгч болон үрчлүүлсэн хүүхдийн хоорондох харилцаа муудсан, улмаар хамтран амьдрах боломжгүй болсон тохиолдолд гэрээний журмаар үрчлэлтийг цуцалж болно. Хэрэв тохиролцолд хүрэхгүй бол Ардын шүүхэд зарга үүсгэж болно” гэж заасан. Мөн тус хуулийн 28 дугаар зүйлд: “Зохигчид үрчлэлтийн харилцааг гэрээгээр цуцлах бол тухайн орон нутгийн Ардын засаг эрхлэх газарт очиж, үрчлэлтийн харилцааг цуцалсан бүртгэлийг хийлгэнэ” гэж заасан.¹³³

Дээрхээс харахад БНХАУ-д үрчлэлтийг хүчингүй болгох бус үрчлэлтийг цуцлах тухай ойлголт байдаг ба гагцхүү хоёр тал маргаантай тохиолдолд шүүхэд хандаж, шүүх ердийн хэрэг хянан шийдвэрлэх журмаар хэргийг хянан шийдвэрлэдэг байна.

Гадаад орнуудын практикт тулгуурлан дүгнэвэл, хүүхэд үрчилснээс үүссэн аливаа эрх зүйн харилцааг дуусгавар болгох тохиолдлыг хүүхэд үрчилснийг хүчингүй болгох болон үрчлэлтийн харилцааг цуцлах гэсэн 2 төрлөөр шийдвэрлэдэг байна.

Дүгнэлт: Хүүхэд үрчилснийг шүүхийн журмаар хүчингүй болгох тохиолдолд заавал хоёр талыг байлцуулан шийдвэрлэх ёстой ба маргаантай тохиолдолд шүүх ердийн хэрэг хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлэж байх нь зүйтэй юм. Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох тохиолдолд зөвхөн хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан тохиолдолд энэ үрчлэлтийг хууль бус гэж тооцож, онцгой ажиллагааны журмаар хүчингүй болгож болно. Үрчлэгч, үрчлэн авагч талууд үрчлэлтийн бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтэй байгаа бол гэрээгээр хоорондоо тохиролцож, захиргааны журмаар шийдвэрлүүлдэг болох боломжтой юм. Түүнчлэн Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт заасан этгээд болох нь тогтоогдсон тохиолдолд үрчлэлтийн хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж үзэн хүчингүй болгодог, харин бусад тохиолдолд нэгэнт гаргасан хүчин төгөлдөр шийдвэрийг шүүхийн журмаар хүчингүй болгох бус зөвхөн зохигчид маргаантай байгаа тохиолдолд шүүх хянан шийдвэрлэж, шинээр дахин үрчлүүлэх, төрсөн эцэг, эхэд нь шилжүүлэх, шинэ асран хүмүүжүүлэгч, харгалзан дэмжигч тогтоох зэргээр шийдвэрлэдэг болох нь зүйтэй юм. Эдгээр арга замаар нарийвчлан зохицуулж, гагцхүү маргаантай бол ердийн журмаар хэргийг хянан шийдвэрлэдэг болох нь шүүгчийн ажлын ачааллыг багасгах боломжтой болно.

2.1.5. Эрх олгосон ямар нэгэн баримт бичигт дурдсан овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшигч мөн эсэх

¹³³ <http://www.lawinfochina.com/Display.aspx?lib=law&Cqid=44778> (2014-08-23)

(ИХШХШТХ 135 дугаар зүйлийн 135.1.4) болон Эрх олгосон бичиг баримтын алдагдсан эрхийг сэргээх (ИХШХШТХ 133 дугаар зүйлийн 133.1.6) тухай ажиллагаа

- Эрх олгосон ямар нэгэн баримт бичигт дурдсан овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох

Эрх олгосон ямар нэгэн баримт бичигт дурдсан овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох ажиллагааны зорилго нь бичиг баримтаа гэсэнээс түүний хуулбар, лавлагаа нь байхгүй, бичиг баримт дээрх мэдээлэл буюу овог нэр, нэр, төрсөн он, сар, өдөр нь буруу бичигдсэн тохиолдолд тухайн бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоолгохоор шүүхэд хүсэлт гаргаж шүүхэд ханддаг ба энэхүү зохицуулалт нь 1967 оны БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх тухай хуульд¹³⁴ анх тусгагдаж, 1994, 2002 оны Иргэний процессын тухай хуульд хэвээр хадгалагдан ирсэн байна.

Гадаад улсын хувьд ОХУ-ын Иргэний процессын тухай хуулийн 264 дүгээр зүйлд энэ талаар заасан ба энэ нь мөн Монгол Улсын адил эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдалд хамаардаг. ОХУ-ын хуулийг загвар болгож, хууль тогтоомжоо боловсруулсан хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Беларусь,¹³⁵ Казахстан,¹³⁶ Гүрж¹³⁷ зэрэг улсуудын Иргэний процессын тухай хуульд мөн эрх олгосон ямар нэгэн баримт бичигт дурдсан овог, эцгийн нэр, нэр нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг онцгой ажиллагааны журмаар тогтооно гэж заасан. Монгол Улсаас ялгаатай нь тухайн бичиг баримтад дурдсан зөвхөн овог, эцгийн нэр, нэр нь тохирохгүй бол жинхэнэ эзэмшигчийг нь тогтоодог бөгөөд үүнд тухайн иргэний төрсөн он, сар, өдрийн тухай мэдээлэл хамаардаггүй байна.

Монгол Улсын хэмжээнд шүүхээр 2011 онд 195, 2012 онд 179, 2013 онд 416 эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох хүсэлт тус тус шийдвэрлэгдсэн. Түүнчлэн шүүгчдээс авсан санал асуулгаар энэ ажиллагаа нь шүүгчийн ажлын ачаалал үүсгэдэг гэж үзсэн ба судалгаанд хамрагдсан нийт шүүгчийн 75 хувь нь эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг заавал шүүхийн журмаар тогтоох шаардлагагүй бөгөөд энэ асуудлыг захиргааны журмаар шийдвэрлэгдэж болно гэж үзсэн.

¹³⁴ БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 177.4 дэх хэсэг: “Эрх олгосон ямар нэгэн бичиг баримтад /нам эвлэл, үйлдвэрчний батлах, паспорт, цэргийн албан хаагчийн үнэмлэх, гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллагаас олгосон гэрчилгээнээс бусад/ дурдсан овог нэр, төрсөн он, сар, өдөр нь паспорт буюу төрөлтийн тухай гэрчилгээнд заасантай тохирохгүй байвал түүнийг жинхэнэ эзэмшигч нь мөн эсэхийг тогтоохоор шүүх авч хэлэлцэнэ”.

¹³⁵ Бүгд Найрамдах Беларусь Улсын Иргэний процессын тухай хуулийн 364 дүгээр зүйл.

<http://pravo.kulichki.com/vip/gpk/00000022.htm> (2014-08-25)

¹³⁶ Бүгд Найрамдах Казахстан Улсын Иргэний процессын тухай хуулийн 291 дүгээр зүйлийн 291.4 дүгээр зүйл.

http://online.zakon.kz/Document/?doc_id=1013921#sub_id=2910000 (2014-08-27)

¹³⁷ Бүгд Найрамдах Гүрж Улсын Иргэний процессын тухай хуулийн 312 дугаар зүйлийн 312(2)(г).

<http://policy.mofcom.gov.cn/english/flaw!fetch.action?id=2b9d672f-b048-4493-ab27-fab761ce4886&pager.pageNo=42> (2014-08-29)

Дүгнэлт: Эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох тухай энэ зохицуулалт нь 1967 оны БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх тухай хуулиас улбаатай бөгөөд тухайн цаг үеийн нөхцөл байдалд тохирсон, тухайн үеийн нийгмийн хэрэгцээг хангах зорилго бүхий хуулийн заалтыг цаашид үргэлжлүүлэн хадгалж, эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг шүүхийн журмаар тогтоох бус харин захиргааны журмаар тогтоодог болох нь зүйтэй юм.

➤ *Эрх олгосон бичиг баримтын алдагдсан эрхийг сэргээх (ИХШХШТХ 133 дугаар зүйлийн 133.1.6) тухай ажиллагаа*¹³⁸

Эрх олгосон бичиг баримтын алдагдсан эрхийг сэргээх ажиллагаа нь онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх хэрэгт хамаардаг. Тус ажиллагааг ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн 133.1.6, 147, 148 дугаар зүйлээр тус тус зохицуулдаг ба баримт бичгийг эзэмших эрхийн талаар маргаан гарвал тухайн эрхийг сэргээн тогтоолгох тухай хүсэлтийг хуульд өөрөөр заагаагүй бол шүүхэд гаргадаг. Эзэмших эрхийг сэргээн тогтоолгохоор хүсэлт гаргасан баримт бичиг нь эдийн болон эдийн бус эд хөрөнгийн эрх олгосон баримт бичиг байх ёстой. Түүнийг үрэгдүүлж, устгасанд тооцуулсан тохиолдолд эзэмших эрхийн талаар маргаан гарсан байх ёстой байдаг.¹³⁹

Энэ зохицуулалт нь анх 1967 оны Иргэний процессын хууль буюу БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх тухай хуульд тусгагдсан. Тус хуулийн 24 дүгээр бүлэгт эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх тухай заасан ба эрх олгосон баримт бичигт хадгаламжийн кассын дэвтэр буюу мөнгө, үнэ бүхий зүйлийг авах эрх олгосон бусад бичиг баримтыг хамруулан авч үзсэн.¹⁴⁰ Харин одоо үйлчилж байгаа ИХШХШТХ-иар эрх олгосон баримт бичигт эдийн болон эдийн бус хөрөнгийн эрх олгосон баримт бичгийг хамруулсан. УДШ-ээс гаргасан ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбарт эрх олгосон баримт бичигт хадгаламжийн дэвтэр, мөнгө, үнэ бүхий зүйлсийг авах эрх олгосон баримт бичиг, даатгалын гэрчилгээ зэргийг багтаан ойлгож хэрэглэх тухай тайлбарласан.¹⁴¹

Гадаад улсын хувьд ОХУ-ын Иргэний процессын тухай хуулийн 262 дугаар зүйлд үнэт цаасыг гээн үрэгдүүлснээс алдагдсан эрхийг болон захиалсан үнэт цаасны

¹³⁸ Эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох (ИХШХШТХ 135 дугаар зүйлийн 135.1.4) болон эрх олгосон бичиг баримтын алдагдсан эрхийг сэргээх (ИХШХШТХ 133 дугаар зүйлийн 133.1.6) нь хоорондоо ялгаатай ба ялгаж ойлгох хэрэгтэй юм. Эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч гэж тухайн бичиг баримт, тухайлбал, хөдөлмөрийн дэвтэр, мэргэжлийн үнэмлэх, диплом зэрэгт дурдсан мэдээлэл буюу овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг онцгой ажиллагааны журмаар ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.1.4-ийн дагуу тогтоох ажиллагаа юм. Харин эрх олгосон бичиг баримтын алдагдсан эрхийг сэргээх гэдэг нь эрх олгосон бичиг баримт нь эдийн болон эдийн бус хөрөнгийн эрх олгосон баримт бичиг ба түүнийг үрэгдүүлсэн эрхийг нь сэргээж өгч байгаа ажиллагаа юм (ИХШХШТХ 133 дугаар зүйлийн 133.1.6).

¹³⁹ Монгол Улсын Дээд шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” Улаанбаатар, 2014 он. 367 дахь тал.

¹⁴⁰ БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 177.4 дэх хэсэг “Хадгаламжийн кассын дэвтэр буюу мөнгө, үнэ бүхий зүйлийг авах эрх олгосон бусад бичиг баримтыг үрэгдүүлсэн этгээд хуульд өөрөөр заагаагүй бол үрэгдсэн бичиг баримтыг устгагдсанд тооцуулах, түүнчлэн үрэгдсэн бичиг баримттай холбогдох эрхийг сэргээн босгуулахаар шүүхэд өргөдөл гаргаж болно”.

¹⁴¹ Монгол Улсын Дээд шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” Улаанбаатар, 2014 он. 367 дахь тал.

эзэмшигчийн эрхийг сэргээх тухай заасан ба энэ хуулийн зохицуулалт, зорилтын хувьд Монгол Улсын ИХШХШТХ-ийн үрэгдсэн баримт бичгийг устгасанд тооцуулснаас алдагдсан эрхийг сэргээх тухай зохицуулалттай адил юм. ОХУ-ын хуульд заасан үнэт цаасанд өрийн бичиг, засгийн газар, орон нутгийн засгийн газрын гаргасан өрийн хэрэгсэл, бонд, вексель, чек, хадгаламжийн бичиг, хадгаламжийн сертификат, хувьцаа зэрэг ордог.¹⁴²

Эрх олгосон бичиг баримтын алдагдсан эрхийг сэргээх тухай зохицуулалтыг 1994 оны ИХШХШТХ-д тусган оруулахдаа өмнөх БНМАУ-ын хуулийн энэ тухай зохицуулалтын үзэл санааг хэвээр үлдээж, мөн ОХУ-ын Иргэний процессын тухай хуулийн онцгой ажиллагааны журмын зүйл заалтуудыг загвар болгож хуульчилж оруулахдаа үнэт цаас гэдгийн оронд эрх олгосон баримт бичиг гэж оруулсан байна. Шүүхээс эрх олгосон баримт бичгийг тодорхойлохдоо үнэт цаасыг авч үзэж болох бөгөөд энэ нь УДШ-ээс эрхлэн гаргасан хуулийн дэлгэрэнгүй тайлбартай зөрчилдөхгүй юм.

Тухайлбал, Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд үнэт цаасанд дараах санхүүгийн хэрэгслийг авч үздэг.¹⁴³ Үүнд, хувьцаат компанийн хувьцаа, компанийн өрийн хэрэгсэл, Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, нэгж эрх, хадгаламжийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчид санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон өрийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх /варрант/; Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон энэ хуулийн дагуу санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гэж тогтоосон бусад санхүүгийн хэрэгсэл ордог.

Эрх олгосон бичиг баримтын алдагдсан эрхийг сэргээх (ИХШХШТХ 133 дугаар зүйлийн 133.1.6) тухай хүсэлт Монгол Улсын шүүхэд маш бага хэмжээгээр шийдвэрлэгддэг нь нийт шүүхээс ирүүлсэн мэдээ, шүүхийн шийдвэрийн цахим санд хийсэн судалгаанаас ажиглагдаж байгаа бөгөөд энэ төрлийн хэрэг шүүгчид ажлын ачаалал үүсгэдэггүй байна. Түүнчлэн шүүхийн статистик мэдээнд эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох (ИХШХШТХ 135 дугаар зүйлийн 135.1.4) тухай мэдээллийг баталсан маягад оруулах хэсэг байдаггүйгээс үүдэн статистик мэдээг шүүхүүдээс ирүүлэхдээ эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоосон (ИХШХШТХ 135 дугаар зүйлийн 135.1.4) шүүхийн шийдвэрийг эрх олгосон бичиг баримтын алдагдсан эрхийг сэргээх (ИХШХШТХ 133 дугаар зүйлийн 133.1.6) хэрэгт оруулан ирүүлж, статистик мэдээг гаргаснаас буруу дүн мэдээ гарч байна.

“Үнэт цаас”-тай холбоотой эрх сэргээх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн хэрэг олдоогүй ба үйлдвэрлэлийн ослын актыг үрэгдүүлсэн тул түүнийг устгагдсанд тооцуулж, сэргээн тогтоолгох тухай хүсэлтийг тус зүйл заалтын дагуу шийдвэрлэсэн

¹⁴² Цахим холбоос

http://dic.academic.ru/dic.nsf/enc_law/367/%D0%92%D0%AB%D0%97%D0%AB%D0%92%D0%9D%D0%9E%D0%95#sel=5,5:26 (2014-09-05)

¹⁴³ Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Шинэчилсэн найруулга, (2014 он), 5 дугаар зүйлийн 5.1.

байна.¹⁴⁴ Шүүгч хүсэлтийг хянаж үзээд, ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.3 дахь хэсэгт зааснаар буюу эрх зүйн үйл явдлыг батлах баримт бичгийг өөр журмаар олж авах боломжгүй буюу үрэгдсэн баримт бичгийг сэргээх боломжгүй болсон тохиолдолд шүүх хянан шийдвэрлэнэ гэсний дагуу шийдвэрлэсэн байна. Улмаар хүсэлтийг хангаж, ИХШХШТХ-ийн 148 дугаар зүйлийн 148.3 дахь хэсгийг¹⁴⁵ үндэслэн үрэгдсэн баримт бичгийн оронд шинэ баримт бичиг олгохыг уг баримт бичгийг олгосон байгууллагад даалгасан шийдвэр гаргасан байна. Үйлдвэрлэлийн ослын акт гэдэг нь албан байгууллагаас олгосон тухайн ажилтны үйлдвэрлэлийн осолд өртөж, хөдөлмөрийн чадварын тодорхой хувийг алдсаныг нотлон тодорхойлж байгаа акт юм. Энэ актын тусламжтайгаар захиргааны байгууллагаас хууль тогтоомжийн дагуу тодорхой тэтгэмж, тэтгэлгийг гаргуулж авч болно. Гагцхүү энэ үйлдвэрлэлийн ослын акт нь өөрөө эрх олгосон баримт бичигт хамаарахгүй ба энэ ажиллагаа нь ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.2.4-т заасан осол гэмтэл гарсан эсэхийг тогтоох ажиллагаа юм.

Дүгнэлт: Эрх олгосон бичиг баримт алдагдсан эрхийг сэргээх (ИХШХШТХ 133 дугаар зүйлийн 133.1.6) тухай хүсэлт Монгол Улсын шүүхийн практикт маш бага хэмжээгээр гардаг ба үнэт цаастай холбоотой эзэмших эрхийн маргаан гарах үед шүүхийн практикт хуулийг хэрэглэхэд илүү ойлгомжтой болгох үүднээс хуульд эрх олгосон бичиг баримт бус шууд үнэт цаас гэдэг үгийг оруулж, “үнэт цаасыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг болон захиалсан үнэт цаасны эзэмшигчийн эрхийг сэргээх” гэж өөрчлөн найруулж болох юм.

2.1.6. Нэхэмжлэгчийн хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах

Иргэний эрх зүйн маргаанд хариуцагчаар оролцох зохих этгээдийн оршин суугаа (оршин байгаа) газрыг нь мэдэхгүй, энэ тухай нэхэмжлэлдээ заагаагүй бол хариуцагчийн хаяг тодорхойгүй гэсэн үндэслэлээр шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг. Иймд хариуцагчаар оролцох зохих этгээдийг эрэн сурвалжлуулах шаардлага гарч, энэ тухай хүсэлтийг ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн 133.1.9-д заасан онцгой ажиллагааны журмаар шүүхэд гаргадаг бөгөөд нэхэмжлэгчийн хүсэлтээр хариуцагчийг эрэн сурвалжлуулах хэрэг шүүгчид ажлын ачааллыг үүсгэдэг байна.

ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн 133.1.9-д заасан нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах, ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлийн 80.1.6-д заасан хариуцагчийг эрэн сурвалжлах шаардлага бий болсон гэх ойлголтууд нь хоорондоо ялгаатай байдаг. Хариуцагчийг эрэн сурвалжлах шаардлага бий болсон нь иргэний хэрэг үүсгэсний дараа хариуцагч оршин сууж байсан газраасаа явсан бөгөөд түүний хаяг тодорхой бус болсны улмаас энэ иргэний хэргийг хянан

¹⁴⁴ Хүсэлт гаргагч өөр дүүрэг рүү шилжих гэхээр хувийн хэрэгт үйлдвэрлэлийн ослын акт байхгүй байгаа ба өөрт байсан хувийг үрэгдүүлсэн, улмаар олон газраас лавлагаа авсан боловч үйлдвэрлэлийн ослын акт олдохгүй байгаа тул түүнийг устгагдсанд тооцуулж, сэргээн тогтоож өгнө үү гэж шүүхэд хандаж, шүүх хүсэлтийг нь ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.3 болон 148 дугаар зүйлийн 148.3-ыг үндэслэн шийдвэрлэсэн.

¹⁴⁵ ИХШХШТХ-ийн 148 дугаар зүйлийн 148.3: “Шүүх хүсэлтийг хангавал үрэгдсэн баримт бичгийн оронд шинэ баримт бичиг олгохыг уг баримт бичгийг олгосон байгууллагад даалгасан шийдвэр гаргана”.

шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж улмаар түүнийг эрэн сурвалжлах ажиллагаа болж явагддаг.¹⁴⁶

Иргэн, хуулийн этгээд хариуцагчид нэхэмжлэл гаргахад заавал тухайн хариуцагчийн оршин суугаа газрын хаягийг мэдэх шаардлагатай байдаг тул хаягийг мэдэхгүй, эсхүл мэдэх боломжгүй бол цагдаагийн байгууллагаар хариуцагчийг эрэн сурвалжлуулдаг. Харин цагдаагийн байгууллага шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэрийн дагуу энэ ажиллагааг гүйцэтгэдэг тул иргэд, хуулийн этгээд заавал эхлээд шүүхэд энэ хүсэлтээ гаргаж, шүүгч тухайн нэхэмжлэгчийн гаргасан тайлбар, нотлох баримтад үндэслэн тухайн хэрэгт хариуцагчаар оролцох зохих этгээдийг эрэн сурвалжлуулахаар захирамж эсхүл шүүхийн шийдвэр гаргаж, цагдаагийн байгууллагад энэ ажиллагааг гүйцэтгэхийг даалгадаг.

Шүүхээс хэргийн хариуцагчийг эрэн сурвалжлуулахаар гаргасан шийдвэрийг цагдаагийн байгууллагад шилжүүлдэг хэдий ч хариуцагчийн хаяг тодорхойгүй, олдохгүй байх зэргээс үүдэн энэ ажиллагаа удааширч, хариуцагч олдохгүй байх тохиолдол их гардаг байна. Улмаар иргэд, хуулийн этгээд цаг хугацаа нилээдгүй алдаж хохирсон хохирлоо барагдуулахын тулд хариуцагчийг цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлуулахын тулд шүүхээр тэмдэгтийн хураамжийг төлж давхар хохирдог байна.

Хэргийн хариуцагчийг эрэн сурвалжлах ажиллагаагаар хариуцагчийг олоогүй тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхээ хэрэгжүүлж чаддаггүй. Учир нь хариуцагчийн хаяг, нэр нь тодорхой бус бол хэрэг үүсгэхгүй. Улмаар иргэд хариуцагчийг эрэн сурвалжлуулах шийдвэр гаргуулахаар шүүхэд хандах явдал ихсэж, шүүхийн ачааллыг бий болгож байна. Түүнчлэн иргэд оршин байгаа газраа бүртгүүлэх үүргээ биелүүлэхгүй, тухайн бүртгэлтэй хаяг дээрээ байхгүй, хаяг нь тодорхойгүй байгаа зэрэг нь холбогдох хуульд хариуцлага тооцох зохицуулалт муу хэрэгжиж байгаатай холбоотой юм.

Монгол Улсын хэмжээнд шүүхээс нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлуулахаар 2011 онд 2001, 2012 онд 863, 2013 онд 1208 хүсэлтийг шийдвэрлэсэн байна. Статистик тоон мэдээнээс харахад нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлуулах хүсэлт гаргах явдал өсч, 3 жилд нийт 4072 хэрэг шийдвэрлэгдсэн нь 3 жилийн хугацаанд шийдвэрлэгдсэн нийт онцгой ажиллагааны хэргийн 27.4 хувийг эзэлж байна. Үүнээс харахад нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах хэрэг нийт хэргийн нилээдгүй их хувийг эзэлж байна.

Нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг заавал шүүгч тус бүр дээр ажлын ачаалал үүсгэхгүйн тулд хүн ам олноор суурьшсан газар нутгийн томоохон шүүхүүд дээр хариуцагчийг эрэн сурвалжлах захирамж гаргадаг болох, эрэн сурвалжлах асуудал дагнан хариуцсан шүүгч ажиллуулах нь ачааллыг бууруулах нэг арга зам болж болно.

Түүнчлэн ИХШХШТХ-ийн 155 дугаар зүйлийн 155.3 дахь хэсэгт заасны дагуу шүүх нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийг хүлээн авч, хариуцагчийг эрэн сурвалжлах

¹⁴⁶ Монгол Улсын Дээд шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” Улаанбаатар, 2014 он. 376 дахь тал.

тухай шийдвэр гаргана гэж заасан. Аливаа этгээдийг эрэн сурвалжлах шаардлагатай эсэхийг шүүгч нэхэмжлэгчийн гаргасан хүсэлт, нэхэмжлэл, нотлох баримт зэргийг судалж, сайтар нягталж үзсэний үндсэн дээр эрэн сурвалжлах нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд шүүхийн шийдвэр гаргах бус харин захирамж гаргаж, хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлах ажиллагааг явуулах шийдвэр гаргаж байх нь зохистой юм. Шүүхийн шийдвэрүүдээс харахад хариуцагчаар оролцвол зохих этгээдийг шүүгчийн захирамжаар бус шүүхийн шийдвэрээр гаргаж байгаа нь шүүгчид ажлын ачаалал үүсгэж байна гэж үзэхээр байна. Учир нь шүүхийн шийдвэрийг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий төрийн байгууллагаас гаргадаг, эрх зүйн харилцааг тодорхойлох, түүнийг зохицуулсан хэм хэмжээг хэрэглэх хэлбэрээр тухайн хэрэг маргаанд хамааралтай этгээдэд хуулиар тодорхойлогдсон төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг акт юм. Шүүхийн шийдвэр нь шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэсэн байх учиртай бөгөөд нэхэмжлэгчийн шаардаагүй, иргэний хэрэг үүсгээгүй асуудлаар шүүх шийдвэр гаргах эрхгүй.¹⁴⁷ Үүнээс дүгнэхэд хариуцагчаар оролцвол зохих этгээдийг эрэн сурвалжлах шаардлагатай тохиолдолд шүүхийн шийдвэр гаргах бус шүүгчийн захирамж гаргадаг байх нь зүйтэй юм.

Дүгнэлт: Иргэний хэрэгт хариуцагчаар оролцох зохих этгээд мөн эсэхийг гагцхүү шүүгч хянан шалгасны үндсэн дээр эрэн сурвалжлуулах шийдвэрийг гаргаж байх нь зохистой тус ажиллагааг шүүгч тус бүр дээр ачаалал үүсгэлгүйгээр эрэн сурвалжлах асуудал дагнан хариуцсан шүүгч ажиллуулж, захирамж гаргуулдаг хувилбар байж болохоор байна. Улмаар шүүхийн шийдвэр гаргах бус захирамж гаргадаг байх нь зохистой тул ИХШХШТХ-ийн 155 дугаар зүйлийн 155.3 дахь хэсэгт шүүхийн шийдвэр гэснийг шүүгчийн захирамж болгон өөрчлөх нь зүйтэй байна. Түүнчлэн тэмдэгтийн хураамжийн хувьд энэ ажиллагааг тухайн нэхэмжлэгч этгээдийн нэхэмжлэлтэй холбоотой хэргийн нэг хэсэг гэж үзэн хэрэв хариуцагч нь эрэн сурвалжлагдсан тохиолдолд зөвхөн тухайн нэхэмжлэлтэй холбоотой хэргээс нь тэмдэгтийн хураамжийг авдаг байх нь зохистой юм.

2.2. Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгддэг, шүүгчид ажлын ачаалал бага үүсгэдэг хэргүүдэд хийсэн дүн шинжилгээ

Монгол Улсын хэмжээнд цөөн тоогоор шийдвэрлэгдсэн, шүүгчид ажлын ачаалал харьцангуй бага үүсгэдэг хэргүүдийг заавал шүүхийн журмаар хянан шийдвэрлэх нь зохистой эсэхийг судлан дараах байдлаар тодорхойлов.

1.2.4. Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах

Материаллаг эрх зүйн хувьд иргэнийг сураггүй алга болсонд тооцуулах тухай хүсэлт Иргэний хуулийн 23 дугаар зүйлд, харин иргэнийг нас барсан гэж зарлах тухай Иргэний хуулийн 24 дүгээр зүйлд тус тус тусгагдсан. Процессын хувьд тус ажиллагааг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг.

Монгол Улсад хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах тухай зохицуулалт нь анх 1967 оны БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх тухай хуульд тодорхой тусгагдсан. Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас

¹⁴⁷ Шүүхийн шийдвэрийн тухай, Улсын Дээд шүүхийн 2006 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 21 дүгээр тогтоол.

барсан гэж зарлах асуудлыг эх газрын эрх зүйн системд ихэвчлэн шүүхийн журмаар шийдвэрлэдэг ба хуучны болон одоогийн социалист эрх зүйн тогтолцоотой улсууд энэ асуудлыг ихэвчлэн онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг байна.¹⁴⁸ Тухайлбал, БНХАУ-ын одоогийн мөрдөгдөж байгаа Иргэний заргын тухай хуулийн онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэх хэрэг дотор иргэнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсныг зарлах ажиллагааг тусгасан.

Монгол Улсын хувьд иргэнийг сураггүй алга болсон гэж тооцохдоо хаана байгаа нь мэдэгдэхгүй, сураг чимээгүй 2 жил өнгөрсөн бол сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх шийдвэрлэдэг. Хуульд зааснаар сураггүй алга болсон иргэний тухай сүүлийн мэдээ авсан өдөр, хэрэв өдөр нь тодорхойгүй бол дараа сарын нэгнийг алга болсон өдөр гэж тооцно.¹⁴⁹ Иргэнийг сураггүй алга болсонд тооцох үндэслэл нь сураггүй болсон иргэнд эрхлэн хамгаалалт тогтоох, бусдад өгөх төлбөрийн асуудлыг шийдвэрлэх, тухайн иргэний асрамжид байсан бол асран хамгаалагч тогтоох зорилгыг агуулсан байдаг.

Хүснэгт 1 Монгол Улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн байдал:

Хэргийн төрөл	2011	2012	2013
Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах	37	35	35

Хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах тухай ажиллагаа нь шүүгчид ажлын ачаалал үүсгэх хэмжээнд биш байгаа нь дээрх статистик тоон мэдээнээс харагдаж байна. Шүүхээр энэ төрлийн хэрэг бага шийдвэрлэгдэж байгаа хэдий ч эх газрын эрх зүйн бүлд хамаарах гадаад улсад хүнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлахыг шүүхийн журмаар хянан шийдвэрлэж байгаагаас харахад эдгээр ажиллагаа нь заавал шүүхийн журмаар хянан шийдвэрлэгдэж байх нь зохистой юм.

1.2.5. Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэгдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох

1967 оны БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх тухай хуульд сэтгэл мэдрэлийн өвчтэй буюу ухаан солио учраас иргэнийг эрх олох, үүрэг бий болгох, чадваргүй гэж зарлах тухай зохицуулалт анх тусгагдсан байдаг. Материаллаг эрх зүйн хувьд одоо үйлчилж байгаа 2002 оны Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн дагуу шүүх холбогдох этгээдийн хүсэлтийг үндэслэн иргэнийг эрх зүйн чадамжгүйд тооцож, эрх зүйн чадамжийг хязгаарлахыг ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн 133.1.3-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэж байна.¹⁵⁰

¹⁴⁸ Түүвэр байдлаар дараах улсуудын иргэний процессын эрх зүйн холбогдох зүйл заалтыг сонгон авч судалсан болно. Үүнд: Хуучны болон одоогийн социалист эрх зүйн тогтолцоотой улсууд болох Беларусь, Казахстан, Азербайжан, Армени, Гүрж, ОХУ, БНХАУ, БНСВьетнам Улс; Эх газрын эрх зүйн бүлтэй Итали, Испани, Португали зэрэг улсууд орно. (Valbona Alikaj. "Declaring a person missing or dead", The Macrotheme Review 3(5), SI 2014.)

¹⁴⁹ Т.Мөнхжаргал, "Монгол Улсын Иргэний эрх зүй", Улаанбаатар, 2014 он. 82 дахь тал.

¹⁵⁰ Тус зүйл заалтад дараах ойлголтууд багтдаг байна:

- Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүйд тооцох;
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн хүнийг хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох;

Иргэний эрхийн чадамжийг зөвхөн шүүхийн шийдвэрээр хасаж, хязгаарлаж болно.¹⁵¹ Харин 18 насанд хүрсэн иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээдийн эрх зүйн чадамжийг шүүхээс тухайн этгээд согтууруулах ундаа болон мансууруулах бодис¹⁵² байнга хэрэглэдэг бөгөөд гэр бүлээ эд материалын хүнд байдалд оруулдаг бол сонирхогч этгээд энэ талаар шүүхэд нэхэмжлэл гаргаснаар эрхийг нь хязгаарлаж болдог.¹⁵³

ОХУ-ын 2002 оны Иргэний процессын тухай хуульд иргэнийг албадан шинжилгээ хийхээр сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх, сэтгэцийн үзлэг шинжилгээг албадан гаргуулах¹⁵⁴ асуудлыг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхээр заасан ба Монгол Улсын ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн 133.1.3-т¹⁵⁵ заасны дагуу зөвхөн сэтгэцийн өвчтэй иргэний эрхийг хязгаарлах тухай заасан нь ОХУ-ын хуульд заасан ойлголтоос хэрэглэгдэх хүрээгээрээ бага байна.

Хүснэгт 2 Монгол Улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн байдал:

Хэргийн төрөл	2011	2012	2013
Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох	35	67	11

Дээрхээс харахад энэ төрлийн хэрэг шүүхэд ачаалал харьцангуй бага үүсгэдэг бөгөөд ихэнх шүүхээр шийдвэрлэгддэггүй байна. Шүүх энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэхдээ сэтгэцийн өвчин нь түр зуурын эмгэг сааталтай холбоотой эсэхийг тогтоож, улмаар сэтгэцийн түр зуурын саатал нь иргэнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцох үндэслэл болохгүй гэж үздэг.¹⁵⁶ Гадаад улсад иргэний эрх зүйн чадамжийг гагцхүү шүүхээр хязгаарладаг ба Монгол Улсад ч мөн адил энэ асуудлыг шүүхээр шийдвэрлэж байна.

1.2.6. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох

Асран хамгаалалт, харгалзан дэмжих гэдэгт өндөр настан, эрүүл мэнд амьдралын нөхцөл байдлын хувьд эрхийн хамгаалалт зайлшгүй хэрэгтэй болсон иргэнд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр асран хамгаалах, харгалзан дэмжих этгээдийг тогтоож, тэдгээрийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, эрх

- Согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хүнийг хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох.

¹⁵¹ Т.Мөнхжаргал, “Монгол Улсын Иргэний эрх зүй”, Улаанбаатар, 2014 он. 74 дэх тал.

¹⁵² 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль”-д зааснаар “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж донтуулах болон сэтгэцэд хүчтэй нөлөө үзүүлдэг, “Мансууруулах эмийн тухай” 1961 оны НҮБ-ын Конвенци, “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” 1971 оны НҮБ-ын Конвенцийн жагсаалтад заасан хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг хэлнэ.

¹⁵³ Хуульчдын сургалт ба давтан сургалт төсөл, “Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар”, Улаанбаатар, 2006 он. 66 дахь тал.

¹⁵⁴ ОХУ-ын Иргэний Процессын тухай хуулийн 262 дугаар зүйлийн 262.4.

¹⁵⁵ ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн 133.1.3: Сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох.

¹⁵⁶ Монгол Улсын Дээд шүүхийн Дугаар 3 Зөвлөмж, “Онцгой ажиллагааны журмаар зарим хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал”, Улаанбаатар, 2012 он.

чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой харилцааг хамааруулан ойлгодог.¹⁵⁷ Эрх эдэлж, үүрэг хүлээх бүрэн чадамжгүй, бусдын дэмжлэг туслалцаа, асрамжид амьдрахаас өөр ямар ч боломжгүй этгээдэд асран хамгаалалт тогтоодог бол эрх эдэлж, үүрэг хүлээх буюу бүрэн чадамжтай хэдий ч түүнийгээ бие даан хэрэгжүүлэх боломжгүй, эсхүл иргэний эрх зүйн чадамжийг шүүхээс хязгаарласан хүмүүст харгалзан дэмжигч тогтооно.¹⁵⁸ Гадаад улсын хувьд, тухайлбал, БНХАУ-ын Иргэний хуулийн нийтлэг зарчмын 18 дугаар зүйлд “Ардын шүүх нь холбогдох хүмүүс эсхүл холбогдох байгууллагын хүсэлтийн дагуу асран хамгаалагч буюу харгалзан дэмжигчийн эрхийг цуцалж болно” гэж заасан. Түүнчлэн БНХАУ-ын Ардын дээд шүүхээс 1988 онд гаргасан “БНХАУ-ын Иргэний хуулийн нийтлэг зарчмыг дагаж мөрдөх зарим зөвлөмж” бүхий тайлбарыг гаргасан ба тус тайлбарын 20 дугаар зүйлд асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь асран хамгаалах үүргээ биелүүлээгүй эсхүл асран хамгаалуулагчийн хууль ёсны эрх ашгийг хохироосон бол Иргэний хуулийн нийтлэг зарчмын 16, 17 дугаар зүйлд заасан асран хамгаалах эрхтэй этгээд эсхүл байгууллага Ардын шүүхэд зарга мэдүүлнэ гэж заасан. Гэм хор учруулсныг нэхэмжлэх бол ердийн хэрэг хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлэнэ, харин асран хамгаалагчийг өөрчлөх тохиолдолд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг. БНХАУ-ын хууль болон Ардын дээд шүүхийн тайлбараас үзвэл, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг өөрчлөх тохиолдолд энэ асуудлыг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг байна.¹⁵⁹

Хүснэгт 3 Монгол Улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн байдал:

Хэргийн төрөл	2011	2012	2013
Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох	9	8	10

Энэ ажиллагаа нь шүүгчид ажлын ачаалал үүсгэх хэмжээнд шийдвэрлэгддэггүй нь дээрх тоон дүнгээс харагдаж байна.

1.2.7. Иргэний гэр бүлийн байдалд буруу бичигдсэнийг тогтоох

Иргэний гэр бүлийн байдалд буруу бичигдсэн гэдгийг хүсэлт гаргагчийн овог нэр, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, яс үндсийг буруу бичсэн, төрөлт, үрчлэлт, гэрлэлт цуцлалт нас барсныг бүртгэхдээ буруу бичсэн, он сар буруу зөрүү болсон эдгээр бүртгэлийн гэрчилгээг дахин олгохдоо буруу бичсэн зэргийг хэлнэ.¹⁶⁰

Харин эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал буюу төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдлыг тогтоох гэдгийг иргэний гэр бүлийн бүртгэлд иргэний төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдал, тэмдэглэл зэрэг баримт байхгүй түүнийг шүүхээс өөр байгууллага тогтоох боломжгүй болсон, иргэний бүртгүүлсэн эдгээр байдлыг иргэний гэр бүлийн байгууллага тогтоохоос татгалзсан тохиолдолд тус тус шүүхэд хүсэлт

¹⁵⁷ Монгол Улсын Дээд шүүх, “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, Улаанбаатар, 2014 он. 366 дахь тал.

¹⁵⁸ Т.Мөнхжаргал, “Монгол Улсын Иргэний эрх зүй”, Улаанбаатар, 2014 он. 76 дахь тал.

¹⁵⁹ БНХАУ-ын Ардын Дээд шүүх “БНХАУ-ын Иргэний хуулийн нийтлэг зарчим”-ыг дагаж мөрдөх зарим асуудлын зөвлөмж, 1988 оны 4 дүгээр сарын 2.

¹⁶⁰ Монгол Улсын Дээд Шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, Улаанбаатар, 2014 он. 371 дэх тал.

гарган шийдвэрлүүлнэ¹⁶¹ гэж ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.2.3 дахь хэсэгт оруулсан байна. Зохицуулж байгаа харилцааны хувьд ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн 133.1.7 дахь хэсэг ИХШХШТХ-ийн 135.2.3 дахь хэсэгт заасан зохицуулалтын агуулгыг агуулсан хэдий ч энэ хоёр зүйлийн зохицуулалт нь хоорондоо бага зэргийн ялгаатай юм. ИХШХШТХ-ийн 133.1.7 нь иргэний гэр бүлийн байдалд буруу бичигдсэнийг шүүхээс тогтоох, харин ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.2.3 нь иргэний гэр бүлийн байдлыг бүртгэсэн бүртгэл, тэмдэглэл зэрэг баримт байхгүй тохиолдолд шүүхээс тогтоох ажиллагаа юм. Энэ хоёр харилцааны зохицуулж буй объект нь адил ба 1967 оны хуулиас улбаатай энэхүү зүйл заалтын утга санаа нь өөрчлөгдөөгүйгээр тусгагдсан болно. Энэ төрлийн хэргийг захиргааны журмаар шийдвэрлэх боломжтой бөгөөд ингэснээр эдгээр ажиллагааны шүүгчийн ажлын ачаалал багасах боломжтой юм.

*Хүснэгт 4 Энэ төрлийн хэргийн талаар улсын хэмжээний статистик тоог авч үзвэл:*¹⁶²

Хэргийн төрөл	2011	2012	2013
Төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдал	229	216	229
Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох	20	22	25

Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд иргэний бүртгэлийн ажилтны эрх, үүргийг тодорхойлохдоо бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв хөтлөх, тайлан мэдээг нэгтгэж гаргах үүрэгтэй гэж заасан хэдий ч иргэний бүртгэлийн ажилтны буруутай үйлдлийн улмаас буруу бичилт хийгдсэнийг тухайн иргэн захиргааны байгууллагаар залруулах боломжгүй болсон тохиолдолд шүүхээр тогтоолгох хүсэлтээ гаргаж улмаар шүүхэд ачаалал үүсгэж байна.

1.2.8. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох хэргүүд:

➤ *Гэрлэлт хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох*

Шүүх Гэр бүлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан гэрлэгчид харшлах шалтгаантай байхад гэрлэсэн, түүнчлэн гэр бүл болох зорилгогүйгээр гэрлэсэн нөхцөлд гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцдог. Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэлд нь аливаа хууль бус үйлдлийг нуух зорилгоор гэрлэлтээ бүртгүүлсэн явдал хамаардаг. Эдгээр үндэслэлээр гэрлэгчдийн аль нэг нь, эсхүл эрх нь зөрчигдсөн бусад хүн, мөн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага шүүхэд хүсэлт гаргаж болдог. Тухайлбал, БНХАУ-д гэрлэлтийг шүүхийн журмаар хүчингүйд тооцох асуудлыг, БНХАУ-ын Гэр бүлийн тухай хууль, Ардын дээд шүүхийн тайлбарын дагуу шийдвэрлэдэг ба энэ тохиолдолд гэрлэхэд харшлах хуулиар тогтоосон шалтгаан байхад гэрлэлтээ бүртгүүлсэн бол гэрлэлтийг хүчингүйд тооцуулдаг. Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцоход өмч хөрөнгө, үр хүүхдийн

¹⁶¹ Монгол Улсын Дээд Шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, Улаанбаатар, 2014 он. 346 дахь тал.

¹⁶² Төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдлыг тогтоох хэргийн тоон мэдээг шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан мэдээний бусад гэсэн хэсэгт оруулдаг тул дээрх тоо нь тус судалгааны хүрээнд анхан шатны шүүхээс авсан мэдээнд үндэслэсэн болно.

асран хамгаалах, тэжээн тэтгэхтэй холбоотой асуудал үүсдэг тул гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцоход шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэдэг.¹⁶³ Учир нь БНХАУ-д онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд давж заалдах боломжгүй байдаг тул гэрлэлтийн харилцаатай холбоотой аливаа хэргийг шүүх ердийн журмаар хянан шийдвэрлэдэг байна.

Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох нь бусдад учруулсан материаллаг хохирлыг нөхөн төлөхөөс зайлсхийх зорилгоор гэрлэлтээ хуурамчаар цуцлуулсан эсхүл гэрлэгчид нь өөрсдийн хууль бус үйлдлээ халхавчлах үүднээс гэрлэлтээ хуурамчаар цуцлуулсан бол шүүх гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр гэж тооцдог.¹⁶⁴ Монгол Улсын хэмжээнд гэрлэлт хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох тухай хэрэг шүүхээр харьцангуй бага хэмжээгээр шийдвэрлэгддэг ба энэ нь шүүгчид ачаалал үүсгэх хэмжээнд хүрдэггүй байна.

*Хүснэгт 5 Монгол Улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн байдал.*¹⁶⁵

Хэргийн төрөл	2011	2012	2013
Гэрлэлт хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох	16	5	16

➤ *Хүүхдийн эцэг, эхийг тогтоох; хүүхдээ тэжээн тэтгэх*

Хүүхдийн эцэг, эх мөн эсэх талаар маргаантай байгаа, гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн хүүхдийн эцэг, эх хэн болохыг тогтооход түүний эцэг, эх хамтарч өргөдөл гаргахаас татгалзсан тохиолдолд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг.¹⁶⁶

Хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүйгээс эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөгч шүүхэд хүүхдийг тэжээн тэтгүүлэх хүсэлт гаргаж шийдвэрлүүлж байна. Хүүхдээ тэжээн тэтгэхдээ эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулах замаар тэтгэлэг тогтоон олгож болдог ба харилцан тохиролцоогүй бол шүүхийн журмаар шийдвэрлүүлдэг. Монгол Улсын хувьд шүүхээс онцгой ажиллагааны журмаар тэжээн тэтгүүлэх хүсэлтийг шийдвэрлүүлдэг бол гадаадын зарим улсад шүүх ердийн журмаар энэ хэргийг хянан шийдвэрлэдэг байна. Тухайлбал, Франц, Герман зэрэг улсад хүүхдийн тэтгэлгийг шүүгч тогтоодог ба хүүхдийн тэтгэлгийг олгохдоо эцэг, эхийн орлогоос хамаарч өөрөөр тогтоодог байна.

¹⁶⁷

¹⁶³ Чанг Жиэн, Ван Хао, “Иргэний хэргийн заргад ялах уу ялагдах уу: Зарга мэдүүлэх ур чадвар”, Бээжин: Хятадын хууль эрх зүйн хэвлэлийн газар, 2005 он. 215-217 дахь тал (常健, 汪灏.民事官司胜诉必读: 诉讼技巧全攻略[M].北京:中国法制出版社.)

¹⁶⁴ Монгол Улсын Дээд шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” Улаанбаатар, 2014 он. 350 дахь тал.

¹⁶⁵ Гэрлэлт хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох хэргийг Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлангийн бусад хэрэгт хамтад нь хамруулдаг тул тус мэдээг дэлгэрэнгүй харуулах зорилгоор анхан шатны шүүхээс ирүүлсэн тоон мэдээнд үндэслэн гаргав.

¹⁶⁶ Монгол Улсын Дээд шүүх, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” Улаанбаатар, 2014 он. 348 дахь тал.

¹⁶⁷ (SOCIAL POLICY AND FAMILY LAW: MARRIAGE, DIVORCE AND PARENTHOOD, Custody of children and child support/maintenance

http://www.coe.int/t/dg3/familypolicy/Source/4_2_ii%20Child%20custody%20and%20maintenance.pdf (2014-09-30)

Хүснэгт 6 Монгол Улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн байдал:¹⁶⁸

Хэргийн төрөл	2011	2012	2013
Хүүхдийн эцэг, эхийг тогтоох	200	174	200
Хүүхдээ тэжээн тэтгэх	164	164	168

Гэр бүлийн тухай хуульд заасан хүүхдийн эцэг, эхийг тогтоох, хүүхдээ тэжээн тэтгэх зэрэг асуудлыг онцгой ажиллагааны журмаар шүүхэд хянан шийдвэрлэж байгаа бөгөөд дээрх хоёр ажиллагааг нийт шийдвэрлэгдсэн хэргийн тоотой харьцуулж үзвэл нэг шүүгчид ногдож байгаа ажлын ачаалал харьцангуй бага байна.

➤ **Зарим хэргийн төрлүүд:**

Энэ хэсэгт Монгол Улсын нийт шүүхийн хэмжээнд бага тоогоор шийдвэрлэгддэг, шүүгчид ажлын ачаалал үүсгэдэггүй хэргүүдийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдлыг харуулав. Эдгээр хэргийн тоон мэдээг шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлан мэдээний бусад гэсэн хэсэгт оруулдаг тул хэргийг нэг бүрчлэн харуулах зорилгоор тус судалгааны хүрээнд анхан шатны шүүхээс авсан мэдээнд үндэслэн гаргасан болно.

Хүснэгт 7 Монгол Улсын хэмжээнд шүүхээр шийдвэрлэгдсэн байдал:

Хэргийн төрөл	2011	2012	2013
Бусдын асрамжид байгаа эсэхийг тогтоох	3	8	15
Эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх	7	2	6
Тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох	0	1	0
Хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах	1	0	0

2.3. “Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэлт” сэдвийн хүрээнд хийгдсэн фокус ярилцлагын дүн шинжилгээ

“Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэлт” сэдэвт фокус ярилцлагыг Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1, 2 дугаар шүүхийн нийт 8 шүүгчийн дунд зохион байгуулж, шүүхийн практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлов. Тус хэлэлцүүлгийн дүгнэлт, дүн шинжилгээг дараах байдлаар харуулав.

- **Хүний ажиллаж байсан байдлыг тогтоох практикийн тухайд:** Монгол Улсад хүний ажиллаж байсан байдлыг тогтоох хэрэг нь нийгмийн шилжилтийн үед баримт бичгийн бүртгэлийн систем тааруу байснаас үүдэлтэй бөгөөд ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох ажиллагаа хэрэгжиж эхэлсэнтэй холбогдон энэ төрлийн хэрэг шүүхээр ихээхэн шийдвэрлэгдэж, хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэрт тухайн байгууллагын хуучин тамга, тэмдэг дарагдаагүй, шинэ тамга, тэмдэг дарагдсан, орсон, гарсан тушаал

¹⁶⁸ Хүүхдийн эцэг, эх тогтоох болон хүүхдээ тэжээн тэтгэх хэргийг гэрлэлт хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох хэргийг Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлангийн бусад хэрэгт хамтад нь хамруулдаг тул тус мэдээг дэлгэрэнгүй харуулах зорилгоор анхан шатны шүүхээс ирүүлсэн тоон мэдээнд үндэслэн гаргав.

бичигдээгүй зэрэг үндэслэлээр шүүхээр шийдвэрлүүлж, ачаалал үүсгэж байгаа тул захиргааны байгууллагаар энэ асуудлыг шийдвэрлүүлэх нь зүйтэй юм.

- *Шүүхийн журмаар нас тогтоох практикийн тухайд*: тус ажиллагааг захиргааны байгууллагаар шийдвэрлэх боломж бүрдсэн хэдий ч хуульд энэ асуудлыг шүүх шийдвэрлэхээр заасан байгаа тул захиргааны байгууллага заавал шүүхээр шийдвэрлүүлэхийг шаардаж байна. Тухайлбал, шинжээчийн дүгнэлт гарч тухайн иргэний насыг тогтоосон байхад заавал шүүхээр дахин тогтоолгох шаардлагатай байдаг нь иргэдэд ихээхэн хүндрэлтэй байдаг.
- *Нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах практикийн тухайд*: Монгол Улсад бүртгэлийн систем төдийлөн сайн хөгжөөгүйтэй холбоотойгоор хариуцагчийн оршин байгаа газар тодорхойгүй, хаяг нь мэдэгдэхгүйгээс нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлуулах хүсэлт ихээр ирж байгаагаас үүдэн шүүгчийн ажлын ачаалал нэмэгдэж байна. Улмаар шүүхээс цагдаагийн байгууллагад эрэн сурвалжлуулах даалгавар өгдөг хэдий ч цагдаагийн байгууллага хэрхэн шийдвэрлэгдсэн талаар шүүхэд эргэн тайлагнадаггүй тул энэ механизмыг илүү уялдаа холбоотой, боловсронгуй болгох шаардлагатай байна. Түүнчлэн хариуцагчийг эрэн сурвалжлах ажиллагаа дууссаны дараа шүүхэд нэхэмжлэл гаргаж энэ ажиллагаа нь салангид явагддаг тул тус тусдаа тэмдэгтийн хураамж төлөх нь нэхэмжлэгчид зардал үүсгэдэг төдийгүй цаг хугацаа их алдахад хүргэдэг.
- *Хамтын амьдралтай байсныг тогтоохын ач холбогдлын тухайд*: гэр бүлээ бүртгүүлээгүйн улмаас хэн нэг нь нас барсан тохиолдолд тэжээгчээ алдсаны тэтгэмж гаргуулах зорилгоор хүсэлт гаргадаг бол шүүх хүүхдийн эрх ашгийг харгалзан хамтын амьдралтай байсныг тогтоож байна. Түүнчлэн хамтын амьдралын талаар эрх зүйн зохицуулалт байхгүйгээс иргэдийн дунд эд хөрөнгийн болон бусад маргаан ихээхэн гарч байгаа тул энэ харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгаж өгөх шаардлага үүсэж байна.
- *Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох практикийн тухайд*: шүүхэд хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулахаар хүүхдийн эцэг, эх, төрөл, садангийн хүмүүсийн хооронд маргаан байхгүй тохиолдолд захиргааны журмаар үрчлэлтийг хүчингүйд тооцуулж болохоор байгаа хэдий ч энэ асуудлыг шүүхээр тогтоолгож байна. Шүүхэд гаргасан хүсэлтийг шийдвэрлэхдээ үрчлэлтийг маргаантай болон маргаангүйгээр ялган зааглаж, маргаан байхгүй бол энэ асуудлыг хүүхэд үрчлүүлэх шийдвэр гаргасан захиргааны байгууллага нь шийдвэрлэдэг, маргаантай тохиолдолд зохигчийг байлцуулан шүүхээс ердийн журмаар хянан шийдвэрлэдэг байх нь зүйтэй юм.
- *Эрх олгосон ямар нэгэн баримт бичигт дурдсан овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичигдсэн тэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох практикийн тухайд*: хөдөлмөрийн дэвтэрт овог, нэрийн ганц хоёр үсэг зөрүүтэй байх тохиолдол түгээмэл байдаг тул энэ төрлийн хүсэлтийг бүгдийг нь шүүхээр шийдвэрлэх нь ихээхэн ачаалал үүсгэдэг. Үүнийг харин захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэх боломжтой ба тухайн захиргааны байгууллагын

шийдвэрийг эс зөвшөөрсөн, маргаан гарсан тохиолдолд шүүх хянан шийдвэрлэдэг байх нь зүйтэй юм.

Судалгаанд оролцсон нийт шүүгчдийн үзэж байгаагаар онцгой ажиллагааны журмаар нийт шийдвэрлэж байгаа хэргүүдээс захиргааны журмаар шийдвэрлэх боломжтой эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох хэргүүд болох хүний ажиллаж байсан байдал, нас тогтоох, хүүхдийн эцэг, эхийг тогтоох, тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох зэрэг ажиллагаа нь их гардаг тул эдгээрийг захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэдэг болох нь зохистой гэж үзэв. Түүнчлэн зарим шүүгчийн үзэж байгаагаар онцгой ажиллагааны журмаар үйл явдлыг тогтоох ажиллагаа нь нотлох баримтад тулгуурладаг тул баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлэх шаардлагатай байдаг. Иймд онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримтыг сайтар нягталж шалгах, архиваас нэмэлт лавлагаа гаргуулах зэрэг ажиллагаа нь ихээхэн ачаалал үүсгэдэг байна.

Судалгаанд оролцсон шүүгчид дээрх асуудалтай холбогдуулан дараах зүйлүүдийг боловсронгуй болгох, сайжруулах шаардлага байна гэж үзсэн. Үүнд:

- Онцгой ажиллагааны журмаар хүсэлт гаргагчийн дийлэнх хувь нь бичиг баримтын бүртгэлтэй холбоотой мэдээлэл байхгүйгээс шүүхээр шийдвэрлүүлж тогтоолгож байгаа тул Монгол Улсын бүртгэлийн системийг сайжруулах шаардлага тулгарч байна;
- Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгддэг хэргийг зааглаж заримыг нь шүүхийн бус журмаар шийдвэрлэдэг болох буюу урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хуульд тусгаж өгөх. Энэ нь хэргийн ачаалал, энэ төрлөөр шүүхэд гаргах иргэдийн хүсэлтийг бууруулах;
- Хамтын амьдралтай байсныг шүүхийн журмаар тогтоох тохиолдолд энэ асуудлыг гагцхүү хүүхдийн эрх ашгийн үүднээс тогтоож байх, улмаар хамтын амьдралын талаар эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг хуульд суулган өгөх хэрэгтэй байна;
- Шүүхэд гаргасан хүсэлтийг шийдвэрлэхдээ үрчлэлтийн талаар маргаантай болон маргаангүйгээр нь ялган зааглах хэрэгтэй. Үрчлэлтийн талаар маргаангүй тохиолдолд үрчлэлтийг бүртгэсэн байгууллага урьдчилан шийдвэрлэх шаардлагатай;
- Зарим хэрэгт улсын тэмдэгтийн хураамж их байгааг харгалзан үзэж, тухайлбал, нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлахад 70200 төгрөг авч байгаа нь их тул, төлбөрийн хэмжээг илүү уян хатан, шүүгчийн ачаалалд тулгуурлан нарийвчлан тогтоох хэрэгтэй.

Гурав. Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэлт шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж байгааг шийдвэрлэх арга зам, санал, зөвлөмж

3.1. Бодлогын хувилбарууд

Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг хэргүүд шүүхэд ачаалал үүсгэж байгаа нь түгээмэл шийдвэрлэгддэг хэргүүд болон статистик тоон мэдээнд

хийсэн дүн шинжилгээгээр тодорхойлогдсон бөгөөд шүүгчийн ажлын ачааллыг бууруулахад тус болох дараах боломжит бодлогын хувилбаруудыг танилцуулж байна.¹⁶⁹

3.1.1. Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж байгаа зарим хэргийг захиргааны журмаар шийдвэрлэдэг болох

Энэ хувилбараар одоо мөрдөгдөж байгаа ИХШХШТХ-ийн онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг зарим хэргийг шүүхийн журмаар бус захиргааны байгууллагаар шийдвэрлэх хувилбар юм. Энэ хувилбарыг хэрэгжүүлэхэд тодорхой хууль,¹⁷⁰ дүрэм, журамд¹⁷¹ өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Хэрэв тухайн шийдвэрийг эс зөвшөөрвөл, эсхүл харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгүй бол захиргааны хэргийн шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал буюу хүний ажиллаж байсан байдал, нас тогтоох, эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох зэрэг ажиллагааг шүүхийн журмаар бус, захиргааны байгууллагын шийдвэрээр тогтоодог болж, гагцхүү тухайн шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд ханддаг болно.

Энэ нь иргэний хэргийн шүүхийн ачааллыг захиргааны хэргийн шүүхэд шууд шилжүүлж байгаа хэрэг бус юм. Учир нь одоогийн хуульд урьдчилан шийдвэрлэх ажиллагааг тусгаж өгөөгүй тул иргэд шууд иргэний хэргийн шүүхэд хандаж хэргийг шийдвэрлүүлж байгаа нь иргэний хэргийн шүүхэд ачаалал үүсгэж байгаа бөгөөд урьдчилан шийдвэрлэх нөхцлийг хууль, журамд тусгаж өгснөөр энэ асуудлыг эхлээд захиргааны байгууллагаар урьдчилан шийдвэрлэж, дараа нь гагцхүү тухайн шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ. Иймд захиргааны хэргийн шүүхэд оногдох ажлын ачааллыг шууд одоогийн иргэний хэргийн шүүхийн ажлын ачаалалтай адилтгах боломжгүй юм.

Дээрхээс харахад иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг зохигч, хэргийн оролцогчид өөрсдөө цуглуулж, гаргаж өгдөг бол захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг захиргааны хэргийн шүүх өөрөө цуглуулж, нотлох үүрэгтэй байдаг тул эдгээр хэргийн харьяаллыг захиргааны хэргийн шүүхэд шилжүүлснээр иргэд, хуулийн этгээд хүндрэл, чирэгдэл багатайгаар төрийн үйлчилгээг хүртэх давуу талтай болох боломжтой юм.

¹⁶⁹ Жич: Эдгээр дэвшүүлсэн бодлогын хувилбаруудыг хэрэгжүүлэх тохиолдолд нэмэлт судалгаа хийж, дахин шүүгчийн ачааллыг нарийвчлан тогтоож, тус хувилбарыг хэрэгжүүлэх тохиолдолд гарч болох сөрөг үр дагаврыг сайтар, нарийвчлан тооцоолох шаардлагатай болно.

¹⁷⁰ Тухайлбал, ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.2.4-т заасан эрх олгосон ямар нэгэн баримт бичиг /иргэний үнэмлэх, гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллагаас олгосон гэрчилгээнээс бусад/-т дурдсан овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшигч нь мөн эсэхийг тогтоох; 135 дугаар зүйлийн 135.2.6-т заасан хүний ажиллаж байсан байдал, 135 дугаар зүйлийн 135.2.13-т заасан нас тогтоох зэрэг зүйл заалтуудад өөрчлөлт оруулж, хасах. ИХШХШТХ-ийн 150 дугаар зүйл буюу Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох тухай заалтуудыг өөрчилж хасах, түүнчлэн, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, зэрэгт өөрчлөлт оруулах шаардлагатай.

¹⁷¹ “Нотариатын үйлдэл хийх заавар”, “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулах иргэний нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх журам”, “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам” зэрэг дүрэм, журмуудын тодорхой хэсгүүдэд өөрчлөлт оруулах боломжтой юм.

3.1.2. Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж байгаа хэргүүдийг тусгайлан дагнан хариуцсан шүүгч хянан шийдвэрлэдэг болох

Монгол Улсын ИХШХШТХ-д заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг хэргийг дагнан хариуцсан шүүгч хянан шийдвэрлэдэг болсон тохиолдолд иргэний хэргийн нийт шүүгчид онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгддэг хэргүүд ажлын ачаалал үүсгэхгүй болно. Тусгайлан эрхийн маргаангүй хэргийг дагнан хариуцаж, онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэж, эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоодог шүүгчийг иргэний хэргийн шүүхүүдэд ажиллуулдаг болох боломжтой юм.

Энэ бодлогын хувилбарыг хэрэгжүүлэхэд заавал хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд зөвхөн тогтоосон орон тооны дагуу онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэдэг дагнасан шүүгчийг иргэний хэргийн шүүх тус бүрт томилох, эсхүл одоо ажиллаж байгаа шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх эрх, үүрэгт нь тодорхой өөрчлөлт оруулах замаар энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой юм. Энэ бодлогын хувилбарын давуу тал нь эрхийн маргаангүй хэргүүд болон эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох ажиллагаа, нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах зэрэг ажиллагааг дагнасан шүүгчид хариуцуулснаар бусад шүүгчдэд эдгээр хэргүүд хуваарилагдахгүй, улмаар тэдэнд бусад эрхийн маргаантай, нарийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар шаардсан хэргийг хянан шийдвэрлэхэд нөөц боломжоо гаргаж, хэргийг үр дүнтэй шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ.

➤ Гадаадын зарим орны ижил төстэй туршлага

Монгол Улсын ИХШХШТХ-д заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг хэрэг, онцгой ажиллагааны журмаар тогтоодог эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлуудтай төстэй хэргийг тусгайлан эрх олгогдсон шүүгч, зөвшөөрлийн шүүгч хэрхэн шийдвэрлэдгийг гадаадын зарим улсын туршлагаас судлан авч үзье.

Тухайлбал, Бельгийн Вант улсад шударга ёсны шүүгч (төлөөлөгч) /*Justice of the peace*/-ийн тогтолцоо байдаг ба энэ шүүгчийг Бельгийн Үндсэн хуульд заасны дагуу Хааны зарлигаар томилдог. Бельгид 187 орчим шударга ёсны төлөөлөгч байдаг бөгөөд тэдгээр нь иргэдтэй илүү ойр байдгаараа онцлогтой.¹⁷² Бельгид шударга ёсны шүүгч (төлөөлөгч) нь гэр бүлийн эрх зүй, худалдааны эрх зүй, иргэний эрх зүйн зарим хэргийг авч хэлэлцдэг. Үүнд, түрээсийн болон эзэмших эрхийн маргаан, хөршийн маргаан, орон сууцны маргаан, нас барсан гэж зарлуулах, хүүхдийн тэтгэмж, асран хамгаалалт, үрчлэлтийг тогтоох, сэтгэцийн өвчтөнүүдийн албадан хэвтүүлж эмчлүүлэх тухай болон 1860-аас доош евроны нэхэмжлэлтэй жижиг хэргийг дагнан шийдвэрлэдэг байна.

Шүүхийн тойрог бүрт нэг шударга ёсны шүүгч (төлөөлөгч) байдаг (Бельгийн Вант Улсын Иргэний процессын тухай хуулийн 59 дүгээр зүйл) бөгөөд тус шүүгч нь иргэний хэргийн шүүхэд харьяалагдаж, иргэний болон худалдааны хэргийг хянан шийдвэрлэдэг.¹⁷³ Тодруулбал, Бельгийн Иргэний процессын тухай хуулийн 590 дүгээр зүйлд шударга ёсны шүүгч (төлөөлөгч) нь иргэний болон худалдааны хэргийг

¹⁷² Hubert Bocken, Walter de Bondt, "Introduction to Belgian Law". Kluwer Law International, 2001. p. 84.

¹⁷³ http://ec.europa.eu/civiljustice/jurisdiction_courts/jurisdiction_courts_bel_en.htm

хуулийн дагуу харьяалан шийдвэрлэх боловч нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүнг 1860 еврогоос хэтрэхгүй байхаар хязгаарласан. Түүнчлэн тус хуулийн 590 дүгээр зүйлийн 590.7 дахь хэсэгт заасны дагуу Бельгийн Вант Улсын Гэр бүлийн тухай хуулийн 336 дугаар зүйлд заасан гэр бүл цуцлахтай холбоотой хэрэг болон хүүхдийн тэтгэмж тогтоохтой холбоотой бүх төрлийн хэргийг шударга ёсны шүүгч (төлөөлөгч) харьяалан шийдвэрлэдэг байна.¹⁷⁴

Австрали Улсын зарим мужид шударга ёсны шүүгч (төлөөлөгч)-ийн тогтолцоо байдаг бөгөөд үүнийг мөн адил “Justice of the Peace” гэж нэрлэдэг. Шударга ёсны шүүгч (төлөөлөгч)-д зарим иргэнийг сонгон шалгаруулж, тэдэнд онцгой эрх олгодог ба Австралийн Квинслэнд мужид шударга ёсны шүүгч (төлөөлөгч) нь шүүгчийн зарим чиг үүргийг хэрэгжүүлдэг бол Викториа муж болон нийслэлийн бүс нутагт зарим захиргааны чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.¹⁷⁵ Түүнчлэн 2004 онд Малайз Улсад шударга ёсны шүүгч (төлөөлөгч)-ийг шүүх дэх шүүгчийн ачааллыг багасгах зорилгоор магистратын¹⁷⁶ хоёрдугаар шатны шүүгчээр томилсон¹⁷⁷ бол мөн Шри Ланка Улсад шударга ёсны шүүгч (төлөөлөгч)-ийг магистратын шүүхийн шүүгчээр томилдог байна.¹⁷⁸

➤ *Монгол Улсад хэрэгжүүлж болох хувилбар*

Дээрхээс үзвэл шударга ёсны шүүгч (төлөөлөгч) гэж жижиг хэргийг шийдвэрлэдэг, зарим захиргааны шинжтэй болон шүүн таслах зарим эрхийг хэрэгжүүлэх эрх бүхий төлөөлөгч байдаг байна. Зарим улсад шударга ёсны шүүгч (төлөөлөгч) нь магистратын шүүхэд шүүгчээр ажиллах боломжтой байдаг зэрэг улс орнуудын онцлогоос харахад шүүхийн ачааллыг багасгах зорилгоор шүүхийн тодорхой зарим чиг үүргийг хэрэгжүүлэх эрхийг шударга ёсны шүүгч (төлөөлөгч)-д олгосон байна. Эдгээр улсын шударга ёсны шүүгч (төлөөлөгч) нь Монгол Улсын ИХШХШТХ-д заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг зарим хэргүүдтэй адил төстэй хэргийг шүүн таслах эрхтэйгээр хянан шийдвэрлэж байна.

Шүүхийн бус замаар буюу онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг зарим хэргийг шийдвэрлэх эрхийг Монгол Улсад эвлэрүүлэн зуучлагчаар хэрэгжүүлэн, эрх олгодог шиг иргэн хүнд эрх олгож шийдвэрлүүлдэг болгож, тухайн шийдвэрийг заавал баталгаажуулж, шүүгч захирамж гаргадаг¹⁷⁹ байхаар зохицуулж болно. Энэ хувилбар нь дээр дурдсан зарим гадаад улсын шударга ёсны шүүгч (төлөөлөгч)-тэй төстэй хувилбар юм.

Монгол Улсад дээр дурдсан гадаад улсын шударга ёсны шүүгч (төлөөлөгч)-ийн тогтолцоог нэвтрүүлж шууд шүүхийн бус журмаар, шүүхийн хяналтаас гадуур шийдвэрлүүлэх боломжгүй юм. Учир нь энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 47

¹⁷⁴ 10 Octobre 1967 – Code Judiciaire - <http://www.wipo.int/edocs/lexdocs/laws/fr/be/be136fr.pdf>

¹⁷⁵ Queensland Law Reform Commission, “The role of justices of the peace in Queensland” 1999. p.6-7. <http://www qlrc.qld.gov.au/wpapers/wp54.pdf/> (2014-10-03)

¹⁷⁶ Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэгч албан тушаалтан

¹⁷⁷ http://en.wikipedia.org/wiki/Justice_of_the_peace#Malaysia (2014-10-10)

¹⁷⁸ http://en.wikipedia.org/wiki/Justice_of_the_peace#Sri_Lanka (2014-10-10)

¹⁷⁹ Тухайлбал, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т: эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг тухайн шатны шүүгч баталгаажуулж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 74.6 дахь хэсэг, 75 дугаар зүйлд заасан журмын дагуу захирамж гаргана гэж заасан.

дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэж заасан үзэл баримтлалыг зөрчих тул тухайн эрх олгосон этгээдийн шийдвэрийг заавал шүүх баталгаажуулж байх шаардлага үүснэ. Энэ хувилбар нь дахин шүүхэд ачааллыг үүсгэх, түүнчлэн иргэдийн хувьд шууд шүүхэд хандаж нэг мөр шийдвэрлүүлдэг байсан байдлыг өөрчилж шүүхийн бус журмаар эрх олгосон этгээдээр шийдвэрлүүлж, дахин шүүхээр баталгаажуулах зэрэг шат дамжлага нь хүндрэл, чирэгдэл учруулах сөрөг үр дагаврыг үүсгэж болох юм.

Харин гадаад улсад шүүхийн ачааллыг багасгах зорилгоор тусгайлан эрх олгогдсон төлөөлөгчийг томилж, түүнд зарим шүүхийн эрхийг олгож шүүхэд шүүгчээр ажиллуулж, онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг зарим хэрэгтэй ижил төстэй хэргийг шийдвэрлэж байгаа энэхүү тогтолцооноос санаа авч, Монгол Улсад нэвтрүүлэхдээ тусгайлан эрхийн маргаангүй хэргийг дагнан хариуцаж, онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэж, эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоодог чиг үүрэгтэй шүүгчийг иргэний хэргийн шүүхүүдэд ажиллуулдаг болох боломжтой гэж үзэж байна.

3.1.3. Иргэний хэргийн дагнан шийдвэрлэдэг анхан шатны шүүхийг түшиглэж шүүхийн танхим байгуулах эсхүл “жижиг хэргийн шүүх” байгуулах

- *Иргэний хэргийн дагнан шийдвэрлэдэг анхан шатны шүүхийг түшиглэж шүүхийн танхим байгуулах*

Монгол Улсад иргэн, эрүү, захиргаа гэж 3 төрлөөр шүүхийг дагнан байгуулсан ба иргэний хэргийн шүүхэд тухайн хэрэг, маргааны төрөл, онцлогт тохируулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шинээр журамлаж, дагнасан шүүх буюу иргэний хэргийн дагнан шийдвэрлэдэг анхан шатны шүүхийг түшиглэн онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх танхимыг байгуулж болно. Үүнийг үндсэн шүүхийн хэргийн харьяаллаас гаргаж, эрхийн маргаангүй хүсэлтүүдийг хянан шийдвэрлэдэг болгосон тохиолдолд ердийн шүүхийн ачаалал багасаж, шүүгчид тодорхой маргаан, эрх зүйн асуудал дээр төвлөрөх боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Гэр бүлийн хэрэг маргааныг дагнан шийдвэрлэдэг танхим байгуулах тухай сүүлийн үед их яригдаж байгаа нь дагнасан шүүхийн тогтолцоонд тулгуурлан төрөлжсөн шүүхийн танхим байгуулах санаа, цаашдын хөгжлийн хандлагыг илэрхийлж байна. Энэ бодлогын хувилбарыг хэрэгжүүлэх нь онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэдэг дагнасан шүүх байгуулахтай харьцуулбал илүү богино хугацаанд хэрэгжих боломжтой юм. Учир нь нэгэнт хуулиар байгуулагдсан одоогийн иргэний дагнасан шүүхийг түшиглэн хэргийг хянан шийдвэрлэх чиг үүргээр нь төрөлжсөн танхимуудыг бий болгож, хэргийг дотор нь зааглан ялгаж, тухайн хэргийн онцлогт тохирсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бий болгох талаар хэлэлцэх нь цаг үеийн шаардлагад нийцсэн явдал болно.

Монгол Улсад шүүхийн шинэчлэлийн хүрээнд хүн ам ихээр суурьшсан нийслэлийн анхан шатны шүүхийг дагнасан байдлаар зохион байгуулж, шүүгчийн орон тоог хүрэлцэхүйц байхаар тогтоосон нь энэхүү тогтолцоог түшиглэн төрөлжсөн шүүхийн танхим, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бий болгон хөгжүүлэх боломжийг бүрэн нээж өгсөн бөгөөд иргэний хэргийн шүүхэд гэр бүлийн,

хөдөлмөрийн маргаан шийдвэрлэдэг танхим байгуулж, тухайн маргааны онцлог тохирсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бий болгох эрх зүйн үндэс тодорхойлогдсон.¹⁸⁰ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт анхан шатны шүүх тодорхой хэрэг, маргааны төрлөөр насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг, гэр бүл, хөдөлмөрийн маргааны зэрэг танхимтай байж болно гэж заасны дагуу хэргийг төрлөөр нь ангилан танхим байгуулж болох эрх зүйн үндэс бүрдсэн үед иргэний хэргийн төрөлжсөн танхимууд болох гэр бүлийн, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх танхимаас гадна эрхийн маргаангүй хэргийн буюу онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэх танхимыг байгуулах нь зүйтэй юм.

Энэ тохиолдолд хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Улсын дээд шүүх тухайн шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн эдгээр танхимыг байгуулах боломжтой юм.

Хэрэв онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх танхим байгуулах боломжгүй, зөвхөн гэр бүл, хөдөлмөрийн чиглэлээр танхимыг дагнан байгуулах нь зүйтэй гэдэг хувилбар хэрэгжсэн тохиолдолд хэрэг хуваарилалтын хувьд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэргүүдийг дотор нь төрлөөр нь ангилж, дээрх байгуулагдсан танхимуудын хамрах хүрээ, чиг үүрэгт нь тусгаж, ердийн шүүхийн ачааллыг багасгах боломжтой юм.

Тухайлбал, хамгийн ихээр шийдвэрлэгдэж байгаа онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгддэг зарим хэргүүдийг¹⁸¹ хөдөлмөрийн маргаан хариуцсан танхимд харьяалуулж,¹⁸² Гэр бүлийн тухай хуультай холбоотой хэргүүдийг гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх танхимд харьяалуулан хянан шийдвэрлэдэг болох боломжтой юм. Судалгаанаас үзэхэд гадаад улсад гэр бүлийн хэрэгт өмч хөрөнгө, үр хүүхдийн асуудал зэрэг олон эрх ашиг хөндөгддөг тул гэр бүлийн харилцаатай холбоотой аливаа хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэдэг.

Энэ хувилбар нь зөвхөн хөдөлмөрийн болон гэр бүлийн танхим байгуулсан тохиолдолд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж байгаа эдгээр төрлийн хэргүүдийг танхимд харьяалуулах буюу онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх танхим байгуулагдаагүй тохиолдолд өөр танхимууд байгуулж, тэдгээрт хэргийн ангилал, төрөл, онцлогоор нь харьяалуулах хувилбар юм. Энэ тохиолдолд хөдөлмөрийн болон гэр бүлийн танхим байгуулагдсан байх шаардлагатай бөгөөд одоо мөрдөгдөж байгаа ИХШХШТХ-ийн 13 дугаар бүлгийн онцгой ажиллагааны

¹⁸⁰ М.Батсуурь, "Монгол Улс дахь дагнасан шүүхийн тогтолцоо: Үр нөлөө анхаарах зарим асуудал", Шүүх эрх мэдэл (2014 он № 2), 14 дэх тал.

¹⁸¹ Хүний ажиллаж байсан байдлыг тогтоох; нас тогтоох; эрх олгосон бичиг баримт (ихэнх тохиолдолд хөдөлмөрийн дэвтэр)-д бичигдсэн иргэний мэдээлэл нь иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичигдсэнтэй тохирохгүй байвал түүний жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох, осол гэмтэл гарсан эсэхийг тогтоох гэх мэт.

¹⁸² Хамтын амьдралтай байсныг тогтоох; хүүхэд үрчилснийг хүчингүй болгох; асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох; садан төрлийн холбоо; төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдал; бусдын асрамжид байгаа эсэх; хүүхдийн эцэг, эхийг тогтоох; хүүхдээ тэжээн тэтгэх; тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох; гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох; хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах; эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх гэх мэт.

журмаар шийдвэрлэх хэргүүдийг шинж чанар, төрлөөр нь ангилан, тодорхойлж, хөдөлмөрийн болон гэр бүлийн танхимд харьяалуулан шийдвэрлүүлэх хувилбар болно.

➤ **Дагнасан шүүх буюу “жижиг хэргийн шүүх” байгуулах**

Нээлттэй, хариуцлагатай, иргэддээ ойр, мэргэшсэн шүүх ажилласнаар иргэний шударга шүүхээр шүүлгэх эрх илүү баталгаажих үндэс бүрэлдэнэ. Шүүх хариуцлагатай, хүртээмжтэй байх нэг үндсэн нөхцөл бол шүүхийг мэргэшүүлэн дагнуулах явдал юм. Дагнасан шүүх нь тодорхой хэрэг, маргааны төрлөөр дагнасан байдаг ба энэ нь нийгмээсээ урган гарсан хэрэгцээ шаардлагын хариу байдаг. Энэ тохиолдолд онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг хэргийн дагнасан шүүх байгуулах бус “жижиг хэргийн шүүх” буюу тодорхой үнийн дүнгээс доош нэхэмжлэлтэй хэрэг, эрхийн маргаангүй хэрэг буюу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгддэг хэргүүд болон эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлэх боломжгүй нэхэмжлэлтэй холбоотой хэрэг, хүсэлт, нэхэмжлэлийг дагнан хянан шийдвэрлэдэг шүүхийг байгуулах боломжтой юм.

Тухайлбал, Хойд Америк (АНУ)-т 20 дугаар зууны эхэн үед жижиг хэргийн шүүх бий болж хөгжсөн. Энэ төрлийн шүүхийг ажилчин ангид цалин мөнгөө олж авах эсхүл жижиг бизнес эрхлэгчид жижиг хэмжээний өр, зээлийг эргүүлэн олж авахад нь дөхөм болгох үүднээс байгуулсан ба энэ нь ердийн шүүхийн процессыг бодвол ээдрээ, төвөггүй, зардал чирэгдэл багатай байсан.¹⁸³ АНУ-ын Нью Йорк,¹⁸⁴ Небраска,¹⁸⁵ Колорадо¹⁸⁶ зэрэг муж улсуудад “жижиг хэргийн шүүх” байдаг ба зохион байгуулалтын хувьд эдгээр шүүх нь зарим муж улсад дагнан байгуулагдсан байдаг бол зарим муж улсад нь анхан шатны шүүх дотроо нэг салбар болон байгуулагдсан байдаг онцлогтой.

Жижиг хэрэг гэж тодорхой үнийн дүнгээс доош нэхэмжлэлтэй холбоотой хэрэг ба тухайн үнийн дүнг муж улс бүр нийгэм, эдийн засагтайгаа уялдуулан тогтоодог байна. Тухайлбал, АНУ-ын Небраска муж улсыг авч үзвэл, хуулийн дагуу тус мужийн шүүх бүр нь дэргэдээ жижиг хэргийн шүүх буюу жижиг хэмжээний нэхэмжлэлийн хэргийн шүүхтэй байдаг. Үүнд нэхэмжлэлийн үнийн дүн нь 3500 ам.доллараас хэтрэхгүй хэмжээтэй байхыг шаардана. Түүнчлэн хуанлийн жилийн долоо хоногийн дотор нэхэмжлэгч 10 болон түүнээс дээш тооны нэхэмжлэл гаргаж болдог байна. Харин Нью Йорк мужид тухайн нэхэмжлэлийн үнийн дүн 5000 ам.доллараас хэтрэхгүй байхыг шаарддаг. Жижиг хэргийн шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх нь хэргийн талуудад цаг хугацаа болон зардлаа хэмнэхээс гадна хялбаршуулсан журмаар хэргээ хурдан шуурхай шийдвэрлүүл боломжийг олгодог бөгөөд энэ нь

¹⁸³ I.Ramsay, “Small Claims Courts in Canada” in C.J. Wheelan (ed.), Small Claims Courts, Oxford: Clarendon Press, 1990. p.46; Weller, Ruhnka and Martin “American Small Claims Courts” in Whelan (note 93), p.5.

¹⁸⁴ New York state unified court system <http://www.nycourts.gov/courts/nyc/smallclaims/index.shtml> (2014-10-14)

¹⁸⁵ Official Nebraska Government Website

<https://supremecourt.nebraska.gov/self-help/7223/small-claims-court> (2014-10-11)

¹⁸⁶ Charles P. Brackney “Winning Big in Colorado Small Claims Court: How to Sue and Collect” Bradford Publishing Company, 2002. p.2.

ердийн шүүхийн ачааллыг хөнгөвчилж, шүүхэд иргэд эрхээ хамгаалуулахаар хандах бололцоог илүү дөхөм болгодог.¹⁸⁷

Гадаад улсад Монгол Улсын ИХШХШТХ-ийн дагуу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж байгаа хэргүүдийн ижил төстэй шийдвэрлэдэг хэргүүд нь эдийн бус, үнийг нь тодорхойлох боломжгүй хэргүүд байдаг ба Монгол Улсад гадаадын зарим улсад байдгийн нэгэн адил жижиг хэргийн шүүх байгуулж, нэхэмжлэлийн үнийн дүн багатай хэргүүд болон эрхийн маргаангүй, үнийн дүнг тодорхойлох боломжгүй, онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгддэг хэргүүдийг ийм төрлийн шүүхэд дагнан шийдвэрлэдэг болох боломжтой юм.¹⁸⁸ Жижиг хэргийн шүүх байгуулахын тулд жижиг хэргийн шүүх буюу бага нэхэмжлэлийн үнийн дүн багатай хэргүүдийг тодорхойлох шаардлагатай бөгөөд энэ талаар гадаад улс орны туршлагыг нарийвчлан судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжит хувилбарыг санал болгох хэрэгтэй юм. Түүнчлэн жижиг хэргийн шүүхийг иргэний хэргийн дагнасан шүүхийн танхимд байгуулах боломжтой бөгөөд энэ төрлийн бие даасан шүүхийг ч байгуулан ажиллуулж болно.

3.2. Санал, зөвлөмж

Монгол Улсын хэмжээнд 2013 оны байдлаар онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдсэн хэрэг нийт шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 44 хувийг эзэлж байгаагаас харахад онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгддэг хэргүүд шүүгчид ажлын ачаалал ихээр үүсгэж байна. Иргэний хэрэг өсч байгаа нь иргэд, хуулийн этгээдийн шүүхэд эрхээ хамгаалуулахаар хандах хандлага ихсэж байгаагийн илрэл юм. Иймд шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлж багасгах үүднээс бодлогын хүрээнд дэвшүүлсэн шийдвэрлэх арга зам, түгээмэл шийдвэрлэгдэж байгаа хэргүүдэд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан гаргасан зөвлөмжүүдийг дараах байдлаар нэгтгэн тоймлон танилцуулж байна. Үүнд:

- Нийгмийн шаардлагад тулгуурлаж бий болсон онцгой ажиллагааны журмаар тогтоодог зарим эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлууд /тухайлбал, хүний ажиллаж байсан байдлыг тогтоох/-ыг заавал шүүхийн журмаар бус, шүүхийн бус журмаар урьдчилан шийдвэрлэдэг болох.
- Захиргааны байгууллагын буруутай үйл ажиллагаанаас болсон эсхүл захиргааны байгууллага тогтоож болох боломжтой хэргүүдийг тухайн байгууллага шийдвэрлэж тогтоодог болох. Энэ тохиолдолд холбогдох хураамжаас чөлөөлдөг болох. Тогтоох боломжгүй эсхүл тухайн шийдвэрийг эсэргүүцсэн тохиолдолд шүүхэд хандаж, тухайн маргааныг хянан шийдвэрлүүлдэг болох.

¹⁸⁷ Geraint G. Howells, I. Ramsay, Thomas Wilhelmsson "Handbook of Research on International Consumer Law", Edward Elgar Publishing, 2010. p.503.

¹⁸⁸ Жижиг хэргийн шүүх байгуулах талаар шүүгчид хөндөж байсан ба Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2009 онд зохион байгуулсан шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх тухай уулзалтад шүүгчдийг төлөөлж УДШЭХТ-ын тэргүүн Д.Батсайхан нэг шүүгчид олон хэрэг ногддог, ажлын ачааллаас болж хэргийг хуулийн хугацаанд шийдэж амжихгүй тохиолдол олон гардаг учир жижиг хэргийн шүүх байгуулах нь шүүхийн байгууллагын ажлыг хөнгөвчлөх ач холбогдолтой талаар жишээгээр тайлбарласан. Цахим холбоос <http://www.president.mn/mongolian/node/432> (2014-10-17)

- Хамтын амьдралыг тодорхой шалгуур нөхцлийг хангасан буюу гэр бүл болоход харшлах зүйлгүй, тодорхой хугацаанд хамтран амьдарсан эрэгтэй, эмэгтэй хүнийг гэр бүлийн харилцаа үүссэн гэж үзэх практикийг нэвтрүүлэх. Түүнчлэн хамтын амьдралын тухай хуулийн нарийвчилсан зохицуулалтыг Гэр бүлийн тухай хуульд тусгах, Гэр бүлийн тухай хуулийн төслийн хамтын амьдралыг зохицуулсан зүйл заалтыг дахин эргэж харан дүн шинжилгээ хийж, өөрчлөн найруулах.
- Хүүхэд үрчилснийг хүчингүй болгоход үрчлэгч, үрчлэн авагч талууд үрчлэлтийн бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтэй байгаа бол гэрээгээр хоорондоо тохиролцож, захиргааны журмаар шийдвэрлүүлдэг болох. Шүүхийн журмаар хүчингүй болгох тохиолдолд заавал хоёр талыг байлцуулан шийдвэрлэдэг болох буюу онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэггүй ердийн журмаар хянан шийдвэрлэдэг болох.
- ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн 133.1.6-д эрх олгосон бичиг баримт алдагдсан эрхийг сэргээх тухай зүйлд заасан “эрх олгосон бичиг баримт” гэдэг үгийг үнэт цаас гэдэг үгээр орлуулан “үнэт цаасыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг болон захиалсан үнэт цаасны эзэмшигчийн эрхийг сэргээх” гэж өөрчлөн найруулах.
- ИХШХШТХ-ийн 155 дугаар зүйлийн 155.3 дахь хэсэгт шүүхийн шийдвэр гэснийг шүүгчийн захирамж болгон өөрчлөх. Түүнчлэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцох зохих этгээдийг эрэн сурвалжлуулах ажиллагааг тодорхой шүүгч хариуцаж захирамж гаргаж шийдвэрлэдэг болох.
- Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлуудыг тогтоохдоо тухайн зорилгод нь үндэслэж нэхэмжлэлтэй холбоотой хэрэгтэй нь хамтад нь шийдвэрлэдэг болох. Энэ нь тухайн нэхэмжлэлийг хангахад чиглэгдэж, тухайн хэрэг дотроо эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоодог болох ажиллагаа юм. Тухайлбал, хүүхдийн эцэг, эх тогтоолгох хүсэлтийг тэтгэлэг тогтоолгох нэхэмжлэлтэй хамтад нь шийдвэрлэдэг болох.
- Гэр бүлийн тухай хуульд заасан харилцаатай холбоотой зарим хэргүүдийг ердийн журмаар шийдвэрлэдэг болох. Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал дотор Гэр бүлийн тухай хуульд заасан харилцаатай холбоотой үйл явдлууд дийлэнх хувийг эзэлж байна. Эдгээр хэргүүд нь өмч хөрөнгө, хүүхэд, гэр бүлийн гишүүд зэргийн эрх ашгийг хөндөж байдаг тул эрхийн маргаангүй гэж үзэж ганцхан хүсэлтийн үндсэн дээр шийдвэрлэх бус зохигч этгээдүүдийг шүүх хуралдаанд оролцуулан мэтгэлцэх зарчмыг хангаж, ердийн журмаар хянан шийдвэрлэж байх. Тухайлбал, хүүхдийн эцэг, эхийг тогтоох; эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх; гэрлэлтийг хүчин төгөлдөр бус, гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох тухай хэрэг.
- Онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг хэргүүдийн тоог багасгаж, тэр дундаа эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлуудыг цаг үеийн шаардлагад тохируулан шинэчлэн тогтоож хуульд оруулах. Улмаар онцгой ажиллагааны журмаар тогтоож болох хэргүүдийг эрх зүйн ач холбогдол бүхий хэрэг гэж ялган

зааглах бус шинэчлэн эрхийн маргаангүй хэргүүдийг хамтад нь тусгаж оруулах. Тухайлбал, хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах, иргэний эрх зүйн чадварыг хязгаарлах буюу чадваргүйд тооцох, осол гэмтэл гарсан эсэх, тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоох гэх мэт дарааллаар эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэж ялгаж зааглахгүйгээр оруулбал хуулийг ойлгож хэрэглэхэд дөхөм, хялбар болно.

- Иргэний хэргийн дагнасан шүүхэд онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгддэг хэргүүд буюу эрхийн маргаангүй хэргийг хянан шийдвэрлэдэг дагнасан шүүгч ажиллуулдаг болох эсхүл энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэдэг дагнасан танхим байгуулах.
- Шүүн таслах ажиллагааны статистик мэдээ авдаг маягтыг боловсронгуй болгож, онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгддэг хэргүүдийг нарийвчилсан дэлгэрэнгүй маягтаар авдаг болох. Тухайлбал, хамгийн ихээр шийдвэрлэгддэг хэрэг болох эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох тухай (ИХШХШТХ 135 дугаар зүйлийн 135.1.4), төрөлт, үрчлэлт, гэрлэлт, гэрлэлт цуцлалт, нас баралтыг бүртгүүлсэн байдлыг тогтоох зэргийг маягтад оруулах.
- Төрийн байгууллагууд цахим орчинд мэдээлэл солилцдог болж архивын лавлагаа зэргийг хурдан шуурхай гаргуулж авдаг болсноор хэргийг түргэн шуурхай шийдвэрлэдэг болох тул төрийн байгууллагын цахим засаглал буюу e-governance-ийг нэвтрүүлэх ажиллагааг өргөжүүлэх.

Дүгнэлт

Монгол Улсын хэмжээнд Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх нь шүүгчийн ажлын ачаалалд хэрхэн нөлөөлж байгааг 2011, 2012, 2013 оны байдлаар харьцуулж үзэхэд эдгээр хэрэг хянан шийдвэрлэлт нь буурах бус тогтмол өсч байгаа үзүүлэлттэй гарч байна. Энэ нь онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгддэг хэргүүд ихсэж энэ хэрээр шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж байна гэж үзэж байна.

Ажиллаж байсан байдлыг тогтоох, нас тогтоох, эрх олгосон бичиг баримтын жинхэнэ эзэмшигч мөн эсэхийг тогтоох, нэхэмжлэгчийн хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах зэрэг ажиллагаа нь статистик тоон мэдээ, шүүгч нараас авсан санал асуулга, фокус ярилцлага зэргийг нэгтгэн харахад шүүгчид ажлын ачаалал үүсгэж байна гэж дүгнэж байна.

Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрхийн маргаангүй хэргүүд олноор шийдвэрлэгдэж байгаа нь шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж, эрх зүйн маргаантай хэргүүдийг шийдвэрлэхэд хангалттай цаг хугацаа, мэдлэг чадвараа зарцуулж чадахгүйд хүргэж, улмаар иргэдийн шүүхэд итгэх итгэлийг бууруулах сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм.

Улмаар онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг хэргүүд, тэр дундаа түгээмэл шийдвэрлэгддэг хэргүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд зарим хэргийн шинж чанар нь захиргааны байгууллагын хэмжээнд шийдэгдэх боломжтой хэргүүд гэж харагдаж байна. Захиргааны байгууллагад зарим эрхийг олгож, захиргааны журмаар одоогийн онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэж байгаа зарим хэргүүдийг

шийдвэрлэдэг болох, зарим хэргийг шүүхийн ердийн журмаар хянан шийдвэрлэдэг болохын тулд хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Харин зайлшгүй иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдэх ёстой хэргүүдийг дагнасан шүүгч эсхүл танхим байгуулж, тусдаа шийдвэрлэдэг болох юм бол, ердийн шүүхийн ажлын ачаалал багасаж, шүүх эрхийн маргаантай аливаа хэрэг маргааныг шуурхай, чирэгдэлгүй шийдвэрлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Түүнчлэн онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд тодорхой эрх зүйн үр дагаврыг тооцоолон тогтоодог болж, эрх зүйн үйл явдлыг тогтоохдоо тухайн зорилгод нь үндэслэж нэхэмжлэлтэй холбоотой хэрэгтэй нь хамтад нь шийдвэрлэдэг, зарим онцгой ажиллагааны хэргийг ердийн журмаар шийдвэрлэдэг болох хэрэгтэй байна.

Тус судалгааны хүрээнд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг хэргүүд шүүгчийн ажлын ачаалалд нөлөөлж байгааг багасгах боломжтой бодлогын хувилбаруудыг дэвшүүлсэн ба цаг үеийн шаардлагын дагуу холбогдох хууль, дүрэм журамд өөрчлөлт оруулж, онцгой ажиллагааны журмаар шүүх хянан шийдвэрлэх эрхийн маргаангүй хэргүүдийн төрлийг багасгаж, урьдчилан шийдвэрлэх нөхцлийг тусгах, түүнчлэн шүүхэд онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгддэг хэргүүд буюу эрхийн маргаангүй хэргийг хянан шийдвэрлэдэг дагнасан шүүгч ажиллуулдаг болох бодлогын хувилбарыг хэрэгжүүлэх нь хамгийн боломжит хувилбар бөгөөд үр дүнгээ хамгийн хурдан хугацаанд харуулж чадах болно гэж үзэж байна. Судалгааны хүрээнд дэвшүүлсэн бодлогын хувилбаруудыг тухайн цаг үеийн байдалд тохируулан дахин дүн шинжилгээ хийж, ач холбогдол, эерэг болон сөрөг үр дагаврыг тооцоолж үзэн хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд Монгол Улсад шүүхийг хэрэг маргааны харьяаллаар нь дагнан байгуулсан нь ердийн шүүхийн ачааллыг хөнгөлж, шүүх мэргэшин туршлагажиж, ур чадвар нь сайжирч, хараат бус байдал нь бэхжин, улмаар иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад түлхэц болохуйц ач холбогдолтой юм. Иймд иргэд, хуулийн байгууллагууд иргэний хэргээр шүүхэд ихээр хандаж байгаа энэ үед онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгддэг хэргүүдийг тусгайлан дагнасан шүүгч, шүүхийн танхимд хуваарилснаар ердийн шүүхийн ачаалал буурч, шүүгчийг мэргэшүүлэн туршлагажуулах боломжтой тул шүүхийн шинэтгэлийн зорилтыг хангахад ач холбогдолтой гэж үзэж байна.

Эцэст нь, хэрэг маргааныг дагнан шийдвэрлэхэд тухайн эрх зүйн салбарын нарийн мэдлэг шаардагддаг учир шүүгч мэргэшсэн байх нь нэн чухал ба мэргэшсэн шүүгчээр хэргээ шийдвэрлүүлэх нь шударга шийдвэр гарах нэг үндэс юм. Иймд шүүгчийн ажлын ачаалал буурснаар хэрэг, маргааныг нарийвчлан судлах цаг завтай болж, шүүгчид онцгой ажиллагааны журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулдаг цаг хугацааг эрхийн маргаантай хэргүүдийг шийдвэрлэхэд зарцуулдаг болж, тухайн салбар эрх зүйгээр улам мэргэшиж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн, хэргийг үнэн зөв шийдвэрлэхэд дөхөм болно гэж үзэж байна.

-оОо-

ХҮҮХДИЙН АСРАМЖЛАГЧИЙГ ТОГТООХ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭР¹⁸⁹

“Хүүхдийн асрамжлагчийг тогтоох хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр” сэдэвт бодлогын судалгааны хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын болон дотоодын эрх зүйн зохицуулалт, төрөөс баримтлах бодлого, эрх зүйн зохицуулалт, хүүхдийн эрхийг хамгаалах тухай ойлголт, Монгол Улсад хүүхдийн асрамжлагчийг тогтоож буй шүүхийн практикийг судлав. Энэ судалгаагаар сүүлийн 5 жилд Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн статистик мэдээ, 2012, 2013 онд гурван шатны шүүхээр хүүхдийн асран хамгаалагчийг тогтоохтой холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн шийдвэр, магадлал, тогтоолыг цуглуулж, дүн шинжилгээ хийн, шүүгчид гэрлэлт цуцалсантай холбоотойгоор хүүхдийн асрамжийг тогтооход анхаарах асуудлыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, зөвлөмжийг дэвшүүлэв.

Удиртгал

Гэр бүл гэдэг бол төр улсын үндэс угсаа, нийгмийн анхдагч орчин байдаг. Нийгэмд хүний эрх, эрх чөлөөний нэгэн адил хууль тогтоомж, төрийн бодлогоор хүлээн зөвшөөрөгдөж, хамгаалагдаж байж гэр бүлийн гишүүдийн ашиг сонирхол тэгш эрхтэй, хуулиар хамгаалагдсан, үнэ цэнэтэй, ач холбогдолтой болох ёстой. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-д “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан бөгөөд төрөөс гэр бүл, хүүхдийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын баримт бичгүүдийг батлан гаргасан байдаг.

Гэр бүлийн эрх зүйн хэрэг, маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрээс үзэхэд гэрлэлт цуцалсантай холбоотойгоор хүүхдийн тэтгэлэг гаргуулах, хүүхдийн асрамж тогтоох, гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө, хуваарьт хөрөнгийн маргааныг шүүхээр шийдвэрлэдэг. Сүүлийн жилүүдэд гэрлэлт цуцалсантай холбоотой эд хөрөнгө, хүүхдийн асрамжийн маргааны тоо нэмэгдэх хандлагатай байна.

Шүүхээс Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэрэгт гэрлэлт цуцалсан хэргийн тоо өндөр байх боловч давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хандсан маргааны тоо харьцангуй бага хувийг эзэлж байна. Учир нь гэр бүлийн маргаан нь тухайн гэр бүлийн гишүүд хоорондын хувийн шинжтэй байх тул шат шатны шүүхэд хандах хандлага бага байна. Харин гурван шатны шүүхэд хандсан маргааны төрлөөс үзэхэд гэрлэгчид эд хөрөнгийн харилцаанаас үүссэн асуудлаар маргах, хэргээ шийдвэрлүүлэх тохиолдол их байна. Судалгааны бүтээлүүдэд ч гэр бүл цуцалсантай холбоотой гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө, гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгийн талаар нэлээдгүй дурджээ. Харин гэр бүлийн “чухал” гишүүн болох хүүхдийг эцэг, эхийн хэний асрамжид үлдээх асуудлаар хийгдсэн судалгаа хангалттай бус байна.

¹⁸⁹ Тус судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ-ийн судалгаа хариуцсан референт Т.Түмэнцэцэг, судлаач Э.Өсөхжаргал, зөвлөхөөр Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн шүүгч Т.Ганчимэг ажиллаж, хамтран гүйцэтгэсэн болно.

Нэг. Хүүхдийн асрамжлагчийг тогтоох эрх зүйн зохицуулалт

1.1. Хүүхдийн асрамжлагчийг тогтоох Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт "...үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн", түүнчлэн Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй гэрлэгчид энэ тухай тус тусдаа бичиж, гарын үсэг зурсан хүсэлтээ иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад гаргана" гэсэн нь гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцлийг бүрдүүлэх, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх талаар зохицуулсан байна. Түүнчлэн гэрлэлтийг шүүхээс цуцлах боловч эцэг, эх үр хүүхдийн хоорондын тэжээн тэтгэх, асран халамжлах, өсгөн хүмүүжүүлэх харилцаа үргэлжлэн, эрх үүрэг хэвээр хадгалагддаг тул цаашид хүүхдэд тавих анхаарал, халамж сулрах ёсгүй юм.

Гэр бүлийн харилцаа дуусгавар болох тухай ойлголт аль ч нийгмийн үед байсан бөгөөд хүүхдийн асрамжийн асуудлыг мөн шийдвэрлэж байсан. Тухайлбал, БНМАУ-ын Дээд шүүхийн Бүгд хурлын 1961 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 2/11 тоот тогтоолд "Эцэг, эхээс хоорондоо марган булаацалдаж байгаа хүүхдийг эцэг, эхийн алины асрамжид байлгахад хүүхдийн эрх ашигт тохирохыг иргэний байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар хүүхдийн эх, эмч, хүүхдийг сурган хүмүүжүүлэх мэргэжлийн хүмүүсээр бүрдсэн экспертизийг шүүхийн магадлалаар томилж экспертизийн шинжилгээ дүгнэлт, саналыг гаргуулан шийдвэрлэнэ"¹⁹⁰ гэж заасан. Үүнээс гадна БНМАУ-ын Гэр бүлийн хуулийн зарим заалтыг шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай 1973 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 10/30-р тогтоолд зааснаар "Гэрлэлт цуцлах үед эцэг, эх нь хүүхдийн асрамжийн талаар тохиролцож болох боловч хүүхдийн эрх ашгийн үүднээс дор дурдсан нөхцөл байдлыг хянан үзэж шүүх өөрөөр шийдвэрлэх эрхтэй" гээд үүнд:

- Хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ эцэг, эх нь үр хүүхдээ асран хамгаалах талаар адил тэгш эрх, үүрэгтэй гэдгийг удирдлага болгох боловч шүүх эцэг, эхийн аль нь хүүхдэдээ илүү анхаарал тавьдаг, хэн нь сайн хүмүүжил олгох чадвар бололцоотой, хүүхдийн насны байдал, үр хүүхэд нь эцэг, эхийнхээ хэнд нь илүү дассан зэрэг байдлыг шалган тогтоосны эцэст хүүхдэд ашигтай талыг харгалзан эцэг, эхийн хэнд асрамжлуулах асуудлыг шийдвэрлэж байвал зохино.
- Эцэг, эхийн аль нэг нь материалын болон орон сууц ахуйн нөхцөлөөр нөгөөгөөсөө илүү байгаа байдлаар хүүхдийг түүний асрамжид үлдээх үндэс болно гэж үзэж болохгүй.
- Шүүх хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ асрамжлах ба харгалзан дэмжигч байгууллагын төлөөлөгч, прокурорыг оролцуулж байх хэрэгтэй. Шаардлагатай гэж үзвэл 9 наснаас дээш хүүхдийг шүүх хурлын өмнө тусгай байранд урьж ирүүлж маргаж байгаа эцэг, эхээс тусад нь сурган хүмүүжүүлэгч буюу насанд

¹⁹⁰ Монгол Улсын Дээд шүүх, "Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл", Улаанбаатар, 2013 он, 48 дахь тал.

хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комиссын гишүүд, хуулийн зөвлөгчийг байлцуулан саналыг асуух, зарим тохиолдолд эмч, сурган хүмүүжүүлэгч, туршлагатай хүмүүсээс бүрдсэн эксперт томилж хүүхдийн асрамж хүмүүжлийн байдлын талаар дүгнэлт гаргуулж болохыг тайлбарласугай”¹⁹¹ гэж заажээ.

Түүнчлэн БНМАУ-ын Гэр бүлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд шүүхээс хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ “хүүхдийн нас, эцэг, эхийн хайр халамж, хүүхдээ сайн хүмүүжүүлж чадах бололцоог харгалзан шийдвэрлэнэ”¹⁹² гэж зохицуулсан зэрэг нь хүүхдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг нэн чухалд тооцох, эд хөрөнгөөс илүүтэй, хүүхдийн халамж, анхааралд илүү ач холбогдол өгч байжээ. Энэ тухай тус хуулийн тайлбарт “шүүх ийнхүү өөрийн үзэмжээр шийдвэр гаргахдаа эцэг, эхийн хэн нь хүүхдээ асран хүмүүжүүлэхэд илүү анхаарал тавьж халамжилдаг, хүүхдийн насны онцлог, дассан байдал, эцэг, эхийн хувийн зан чанар, хүмүүжүүлэх нөхцөл байдлыг хангах боломж зэргийг тал бүрээс нь нарийн шалгаж шийдвэрлэх боловч эцэг, эхийн хэн нэгний материаллаг хангамжийн давуу тал хүүхдийн асрамжийг тогтоох гол нөхцөл болохгүй гэдгээс үндэслэж байвал зохино” гэснээс тодорхой харагдаж байна.

УИХ-аас 1999 онд батлагдан одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д “гэрлэгчид энэ хуулийн 14.5-д заасны дагуу тохиролцоогүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, тэтгэлэг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэнэ”¹⁹³ гэж асрамжлагчийг тогтоохдоо Гэр бүлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарласан 46 дугаар тогтоолд заасны дагуу “эцэг, эхийн халамж- буюу хүүхдийн хүмүүжил, эрүүл мэндэд тавих анхаарал, “ахуйн нөхцөл, бололцоо” буюу хүүхдийн өсч бойжих орчин, орон сууц, эд хөрөнгийн байдал, “ёс суртахууны байдал” буюу эцэг, эхийн өөрсдийн хүмүүжил, боловсрол, аливаа муу зуршилтай эсэх, хүүхдийг болон гэр бүлийн бусад гишүүдийг эд хөрөнгийн болон сэтгэл санааны дарамтад байлгадаг эсэх, эрх чөлөөнд халдаж, эрүүл мэндэд гэм хор учруулж байсан эсэх”¹⁹⁴ асуудлыг харгалзан шүүх хүүхдийг эцэг, эхийн хэний асрамжид үлдээх асуудлыг шийдвэрлэж байгаагаас харахад гэр бүлийн харилцаанд эд хөрөнгөнөөс илүүтэй, эцэг, эх, үр хүүхэд хоорондын харилцаа, хандлага, ёс суртахууны байдалд анхаарал хандуулан авч үздэг байна.

Харин шүүхээс хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ 7 ба түүнээс дээш насны хүүхдээс эцэг, эхийн хэнтэй нь амьдрах талаар асууж саналыг харгалздаг. БНМАУ-ын Гэр бүлийн тухай хуульд “9 буюу түүнээс дээш насны хүүхэд эцэг, эхийнхээ хэний асрамжид үлдэх хүсэлтэй байгааг эцэг, эхийн дэргэд нь буюу түүнийг сурган хүмүүжүүлэгч, хуульчийг хамтад нь байлцуулан санал асуух”¹⁹⁵ зохицуулалттай байсан нь нийгмийн хөгжлийн явцад өөрчлөгдөж хүүхдийн насны

¹⁹¹ Мөн тэнд, 127 дахь тал.

¹⁹² Х.Дамдин, “БНМАУ-ын Гэр бүлийн хуулийн тайлбар”, Улаанбаатар, 1988 он, 59 дэх тал

¹⁹³ Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, 1999 он.

¹⁹⁴ Гэр бүлийн болон Иргэний бүртгэлийн тухай хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай, Улсын Дээд шүүхийн 46 дугаар тогтоол, 2008.11.25.

¹⁹⁵ БНМАУ-ын гэр бүлийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар, 1988 он.

байдал болон хүүхдийг хэний асрамжид үлдэх хүсэлтэйг асуух гэсэн зохицуулалтаар өөрчлөгджээ.

Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдээ хэний асрамжид үлдээх болон бусад зарим асуудлаар харилцан тохиролцоо эрхтэй гэж хуульчилсан боловч энэхүү эрх нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хөндсөн, хуулиас гадуур, бодит байдалд хэрэгжүүлэх боломжгүй шийдвэр байж болохгүй. Шүүх гэрлэгчдийн гэрлэлтийг Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар цуцална. Ингэхдээ тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасны дагуу “Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх энэ хуулийн 14.2-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална”. Үүнээс бусад тохиолдолд шүүхээс эхлээд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагдсаны дараа иргэний хэрэг үүсгэнэ. Харин талууд хамт амьдрах боломжгүй гэдгээ илэрхийлсэн ямар ч хүсэлтийг шүүх хүлээн авч шийдвэрлэнэ. Хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд шүүгчид хүүхдийн өссөн орчин, эцэг, эхийн хэнд нь ээнэгшин дассан байдал, цаашид хүүхдийн өсч, хүмүүжүүлэх боломжийг зайлшгүй судалж, хэний асрамжид хүүхдийг үлдээвэл зохистой талаар шийдвэр гаргана. Энэхүү шийдвэрийг гаргахад шүүгчид хүүхдийн талаарх нөхцөл байдал тогтоох үнэлгээ хийх асуудалтай тулгардаг. Иймд шүүгч энэ талаарх ажиллагаа хийлгэхээр “шинжээч томилох” буюу “хүүхдийн нөхцөл байдлыг тогтоох” үнэлгээ хийлгэдэг. Тус үнэлгээг сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч болон өөр нарийн мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулан зохион байгуулна.

Энэ тухай өмнөх хуулийн зохицуулалтад тусгагдсан байсан бөгөөд шинжээчийг томилохдоо “асрамж тогтоолгож буй хүүхдийг өсгөж, хүмүүжүүлэхэд гэрлэгчдийн эцэг, эхээс үзүүлсэн туслалцаа, оролцоо, хүүхэд эмээ, өвөөгийн хэний асрамжид өссөн, хүүхдийн амьдарч буй орчны байдлыг тодорхойлоход харгалзан үзэх үндэслэл мөн боловч энэ нь хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд гол ач холбогдолтой нөхцөл биш бөгөөд эцэг, эх хүүхдээ асрамжлах үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүйг анхаарвал зохино”, мөн “хүүхдийн асрамжийн талаар эцэг, эх эрс зөрүү маргаантай нөхцөлд хүүхдийг эцэг, эхийн хэний асрамжид үлдээхийг зориуд томилогдсон эмч, сурган хүмүүжүүлэгч, хуульч, туршлагатай эцэг, эх зэргээс бүрдсэн шинжээчийн дүгнэлт гаргуулж болно”¹⁹⁶ гэжээ.

Түүнчлэн Монгол Улс хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа халдлага, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдэн орсон олон улсын гэрээний үүргээ биелүүлэх ёстой. Энэ тухай Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. Монгол Улсын хувьд хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд олон улсын хүний эрхийн 46-н гэрээ конвенцид нэгдэн орсон.¹⁹⁷ Хүүхдийн эрхийн тухай 1989 оны конвенцийн 3 дугаар зүйлд “Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн

¹⁹⁶ Х.Дамдин, “БНМАУ-ын Гэр бүлийн хуулийн тайлбар”, Улаанбаатар, 1988 он, 60 дахь тал.

¹⁹⁷ Ю.Бадамханд, “Хүүхдийн эрхийг хамгаалах салбар дахь олон улсын хэм хэмжээ, стандартууд Монгол Улсын хууль тогтоомжид тусгалаа олсон байдал”. Монголын төр, эрх зүй сэтгүүл, 2012 он, №4(70), 20 дахь тал.

байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна”¹⁹⁸ гэсэн нь шүүхээс хүүхдийн эрх ашиг хөндөгдөж болох маргааныг хянан шийдвэрлэхэд тухайн хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангаж ажиллах ёстой гэж заажээ. Иймд олон улсад хүүхдийн эрх ашгийг хамгаалах “the best interests of the child” буюу “хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах” зарчмыг баримтлан ажиллаж байна.

1.2. Хүүхдийн асрамжлагчийг тогтоох олон улсын болон гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт

1.2.1. Олон улсын эрх зүйн зохицуулалт:

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц болон дэлхийн зарим улс орнууд хүүхдийн эрх ашиг, сонирхол хөндөгдсөн аливаа асуудлыг шийдвэрлэхэд “the best interests of the child” буюу “хүүхдийн дээд ашиг сонирхол”¹⁹⁹ зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүүхдийн дээд ашиг сонирхол гэдэг нь хүүхдийн эрх ашгийг өргөн хүрээнд хамгаалах тухай ойлголт юм. Шүүхээс гэр бүлийн маргааныг хянан шийдвэрлэхэд хүүхдийн эрх ашигтай холбоотой тэтгэлэг тогтоох, дундын өмчлөлийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээс гадна хүүхдийн асрамжлагчийг тогтооход энэ зарчмыг зайлшгүй баримтлан ажилладаг.²⁰⁰ Иймд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөн энэ зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай юм.

*Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчим шүүх дээр хэрэгжих байдал:*²⁰¹ Шүүгч энэ стандартыг баримтлан гэр бүлийн маргааныг хуулийн хүрээнд, өөрийн дотоод итгэл үнэмшлээр шийдвэрлэх боловч дараах хүчин зүйлсийг анхаарч үзэж, хэргийг шийдвэрлэнэ. Үүнд:

1) Хүүхдийн нас:

Шүүхээс хүүхдийн асрамжлагчийг тогтооходоо бага насны хүүхдийг ихэнх тохиолдолд эхийн асрамжид үлдээх шийдвэр гаргах хандлагатай байна. Ялангуяа, энэ нь хүүхэд эхтэйгээ хамт байх нь тэднийг асрах, сувилах, хамт амьдрахад илүү ач холбогдолтой гэж үзэж байгаатай холбоотой.

2) Эцэг, эхийн амьдрах орчин, нөхцөл:

Хүүхдийн асрамжлагчийг тогтооход эцэг, эхийн амьдарч байгаа орчин ихээхэн чухал нөлөө үзүүлдэг. Хүүхдийг хэний асрамжид үлдээх талаар зохицуулахдаа өдөр тутмын амьдрал цаашид хэвийн үргэлжлэх, таатай байх нөхцөл, эцэг, эхийн аль нэг нь хүүхэдтэйгээ илүү их хугацааг өнгөрүүлэх боломжтой, түүнчлэн хүүхдийн сургууль, цэцэрлэг, сургалтын төв зэргийг харгалзан үздэг.

3) Хүүхдийн сонголтыг хүндэтгэх:

Шүүгч 12 болон түүнээс доош настай хүүхдийн саналыг асууж хэд хэдэн уулзалтыг зохион байгуулна.

4) Тасралтгүй, тогтвортой байдал:

¹⁹⁸ 1989 оны НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 3 дугаар зүйл.

¹⁹⁹ D.Kelly Weisberg, Susan Frelich Appleton “Modern Family Law”, Fifth edition, New York, 2013. p.671.

²⁰⁰ Gillian Douglas, Jonathan Herring, Rebecca Probert, “Child and Family Law Quarterly”, Vol.25, No1, 2003, p.4.

²⁰¹ <http://www.divorcenet.com/> (2014-10-30)

Гэр бүл цуцлалт хүүхдийн сэтгэхүйд нөлөөлж, хүнд цохилт болдог учраас хүүхдийн орчин, амьдрах нөхцөлд гэнэтийн өөрчлөлт оруулахыг дэмждэггүй. Иймд аль болох хэвийн амьдралыг үргэлжлүүлэхийг илүүд үзнэ.

5) *Хүүхэдтэй зүй бусаар харьцах:*

Хүүхдийг аливаа хэлбэрээр хүчирхийлэх, зүй бусаар харьцах тохиолдолд шүүхээс эцэг, эх хүүхдийн харилцаанд тодорхой хязгаарлалт тавьдаг.

“Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах” зарчмыг хүүхдийн эрх, ашиг сонирхол хөндөгдсөн буюу шүүх дээр хэрэг, маргаан шийдвэрлэх тохиолдолд хэрэгжүүлнэ.

1.2.2. *Япон Улсын Гэр бүлийн хуулийн хүүхдийн асрамжийн зохицуулалт:*

Япон улсын Иргэний хуулийн 763 дугаар зүйлд зааснаар эхнэр, нөхөр хоёр харилцан тохиролцон²⁰² гэрлэлтээ цуцлуулж болно. Ингэхдээ иргэний бүртгэлийн тухай хуульд заасны дагуу өргөдлөө гаргаснаар гэрлэлт цуцлалтыг шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд хүүхдийг асран хамгаалах талаар тохиролцон шийдвэрлэж болно.²⁰³

Хүүхдийн асрамжийн ойлголтыг хоёр хүрээнд авч үздэг. Үүнд:

- *Shinken* буюу хүүхдийг хууль ёсоор төлөөлөх, хүүхдийн өмнөөс шийдвэр гаргах;
- *Kangoken* буюу өдөр бүр хүүхдийг халамжлах, боловсролд нь анхаарах гэсэн хэлбэртэй.

Тус хуулийн 766 дугаар зүйлд зааснаар гэрлэгчид гэр бүлээ цуцлуулж байгаа тохиолдолд хүүхдийг асран хамгаалах, шаардлагатай бүхий л асуудлыг гэрээгээр зохицуулна. Тус гэрээг хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчмын хүрээнд баримтлан шийдвэрлэнэ. Хэрвээ тус гэрээг талууд байгуулаагүй бол шүүхээс тогтооно.

Түүнчлэн Япон улсад гэр бүл цуцлалтыг захиргааны журмаар болон шүүхийн журмаар цуцалдаг. Захиргааны журмаар гэрлэлтээ цуцлуулахыг Гэр бүлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д зааснаар гэрлэгчид харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй гэрлэгчид энэ тухай тус тусдаа бичиж, иргэний бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байхыг ойлгодог. Шүүхээс гэрлэлтийг цуцлуулахдаа гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлийн дагуу гэрлэлт цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

Япон улсын хувьд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа гэр бүлийн маргааныг шийдвэрлэхэд амжилттай хэрэгждэг бөгөөд гэр бүлээ цуцлуулахад эхлээд гэр бүлийн хэргийн эвлэрүүлэн зуучлалд өргөдөл гаргасан байх ёстой байдаг. Хэрэв гэр бүлийн шүүхэд өргөдөл гаргахгүйгээр хэрэг үүсгэсэн байвал тухайн хэргийг шүүхээс эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар оруулах тохиромжгүй гэж дүгнэснээс бусад тохиолдолд заавал гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалд шилжүүлдэг. Япон улсын хуулиар гэрлэлт цуцлах үйл ажиллагааны статистик мэдээг дараах байдлаар

²⁰² GIZ, JICA, Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй ба эвлэрүүлэн зуучлал, Шүүгчийн 2014 оны сургалтын гарын авлага, Улаанбаатар, 2014 он. 69 дэх тал.

²⁰³ Civil Code of Japan, article 766.

гаргасан байна. Үүнээс үзэхэд гэр бүл цуцалсан хэргийн 53,5% нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай хэрэгжсэн байна.²⁰⁴

1.2.3. АНУ-ын эрх зүйн зохицуулалт /Калифорни муж/:

АНУ-ын Калифорни мужийн Гэр бүлийн хуульд хүүхдийн эрх ашиг сонирхол хөндөгдсөн хэргийг хянан шийдвэрлэх тохиолдолд шүүхээс “хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах” зарчмыг баримтлан ажилладаг. Тухайлбал, Калифорни мужийн Гэр бүлийн тухай хуулийн 2310 дугаар зүйлд “Гэрлэлт цуцлалт болон хууль ёсны дагуу тусдаа амьдрах асуудлыг зохицуулсан ба гэр бүлийн маргааны улмаас гэрлэлтийг үргэлжлүүлэх боломжгүй, эрх зүйн бүрэн чадамжгүй /сэтгэцийн өвчтэй/ тохиолдолд гэрлэлтийг шууд цуцлахаар зохицуулсан. Түүнчлэн, тус хуулийн 3011 дүгээр зүйлд шүүхээс хүүхдийн эрх ашигтай холбоотой шийдвэр гаргахдаа хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалахын зэрэгцээ дараах хүчин зүйлсийг анхаарна. Үүнд: Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн хамгаалал; хүүхдийг асрамжиндаа авах хүсэлтэй хүн нь аливаа хэлбэрээр хүчирхийлэл үйлдэж байгаагүй байх; эцэг, эхийн аль алиных нь мөн чанар, шинж байдал; согтууруулах ундаа байнга хэтрүүлэн хэрэглэх, эсхүл байнгын хүчирхийлэлд байсан эсэх²⁰⁵ зэрэг асуудлыг илүүтэй анхаарч хэргийг шийдвэрлэдэг.

АНУ-ын хувьд “Хүүхдийг эцэг, эх хамтран асрах” /Joint custody/ байдлаар шүүхээр хэргийг шийдвэрлэх тохиолдол цөөнгүй гардаг. Энэ арга нь хүүхдийн хүмүүжил, асрамжид эцэг, эхийн аль аль нь оролцох боломжийг олгодог давуу талтай ч хүүхдийг асрамжлахад цаг хугацааны хувьд богино, бүрэн ойлголцох боломжгүй, мөн бага насны буюу нярай хүүхдийн хувьд асарч хүмүүжихэд орчин нь солигдох, анхаарал халамж сулрах, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай²⁰⁶ гэсэн сөрөг хандлагууд байдаг.

1.2.4. ОХУ-ын эрх зүйн зохицуулалт:²⁰⁷

ОХУ-ын Гэр бүлийн тухай хуулийг 1995 оны 12 дугаар сарын 29-ны өдөр Төрийн Думаас баталсан бөгөөд үүгээрээ төрөөс гэр бүл, эцэг, эх, хүүхдийн эрхийг хамгаалахаар үзэл баримтлалдаа оруулсан. ОХУ-ын хувьд гэр бүлийн харилцааны зохицуулалт нь Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай төстэй шинжтэй байна. ОХУ-ын Гэр бүлийн тухай хуулийн 16 зүйлд гэр бүл цуцлах үндэслэлийг заасан байдаг. Үүнд:

- 1) Гэрлэгчдийн хэн нэг нь нас барснаар эсхүл гэрлэгчдийг салсныг шүүхээс зарласны үндсэн дээр гэр бүл цуцална;
- 2) Гэрлэгчдийн хэн нэгний гэр бүл цуцлуулах хүсэлтийн дагуу, эсхүл шүүхээс эрх зүйн чадамжгүй гэдгийг тогтоосон гэрлэгчдийн асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу гэр бүлийг цуцална.

Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлахад, өмч хөрөнгийг хуваах, хөдөлмөрийн чадваргүй, орон гэргүй эхнэр, нөхөрт туслалцаа болох төлбөр, түүнчлэн

²⁰⁴ GIZ, JICA, Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй ба эвлэрүүлэн зуучлал”, Шүүгчийн 2014 оны сургалтын гарын авлага, Улаанбаатар, 2014 он. 71 дэх тал.

²⁰⁵ California Family Code. <http://www.leginfo.ca.gov/cgi-bin/calawquery?codesection=fam> (2014-11-04)

²⁰⁶ D.Kelly Weisberg, Susan Frellich Appleton “Modern Family Law”, fifth edition, New York, 2013. p.706.

²⁰⁷ Family Code of the Russian Federation

шүүхээр хуулийн дагуу чадваргүй эсвэл гэмт хэрэг үйлдэж гурваас дээш жилээр хорих ял авсан (мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.) гэдгийг шүүхээр тогтоосон эхнэр, нөхрийн хооронд үүсэх хүүхэдтэй холбогдох маргааныг гэр бүлийн хэргийг захиргааны байгууллага цуцлах зохицуулалтаас гадна шүүхээр хянан шийдвэрлэнэ.

Гэрлэлт цуцлалттай холбоотойгоор хүүхдийн тэтгэлэг, асрамжийн асуудлыг шийдвэрлэдэг. Гэр бүлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд “гэрлэлт цуцалсан тохиолдолд дараах асуудлыг шүүхээс шийдвэрлэнэ” гэжээ.²⁰⁸ Үүнд, дундын өмч, хүүхдийн асуудал, төлбөрийн чадваргүй байдал, шүүхээс эрх зүйн чадамжгүйг тогтоосон, 3 жилээс дээш хугацаагаар эрүүгийн гэмт хэрэгт холбогдон ял эдэлж байгаа зэрэг асуудлыг шүүх шийдвэрлэхээр тус тус зохицуулжээ. Тус хуулийн 23 дугаар зүйлд гэрлэгчдийн хооронд гэрээ байгуулагдсан тохиолдолд гэрлэлтийг хэрхэн цуцлах болон бусад асуудлаар тусгайлан зохицуулсан байна.

1.2.5. БНХАУ-ын эрх зүйн зохицуулалт:

БНХАУ-ын 1980 онд батлагдсан Гэр бүлийн тухай хуульд гэр бүл, эхнэр, нөхрийн үүрэг, үр хүүхдээ тэжээн тэтгэх харилцаа зэрэг гэр бүлийн өргөн хүрээний асуудлыг зохицуулжээ. Тус хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэрлэлтээ цуцлуулснаас хойш гэрлэгчдийн нэг тал нь хүүхдээ тэжээн тэтгэх, амьжиргааны зардал болон боловсролын зардлын зарим хэсэг, бүхлээр нь хариуцах талаар талууд гэрээгээр тохиролцох, тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэхээр зохицуулсан байна. Мөн тус хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т зааснаар хүүхдийн амьжиргааны зардлын талаар гэрээгээр, шүүхийн шийдвэрээр тохирсон хэдий ч энэ зардал нь тухайн дүнгээс илүү гарсан тохиолдолд зохих ёсны шаардлагын дагуу хүүхдэд илүү зардал гаргахаар зохицуулжээ.

Тус хуулийн 38 дугаар зүйлээр гэр бүл цуцалсны дараа эцэг, эх болон хүүхдийн харилцааны талаар зохицуулсан байна.²⁰⁹ Үүнд:

1. Гэрлэлт цуцалсны дараа хүүхдийг шууд асран хамгаалахгүйгээр эцэг, эх нь үр хүүхдээ эргэж харах, уулзах эрхтэй бөгөөд нөгөө тал нь энэ талаарх бололцоогоор хангах үүрэгтэй.
2. Гэр бүлээ цуцлуулсны дараа эцэг, эх нь хүүхдийн асрамж, тэтгэлэг болон бусад асуудлыг гэрээгээр зохицуулж болно. Харин гэрээгээр тохирч чадаагүй тохиолдолд Ардын шүүхээр шийдвэрлүүлэхээр тус тус заажээ.

Хоёр. Шүүхийн практик


2.1. Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээ

Иргэний эрх зүйн маргаанаас Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн хэргийн тоо сүүлийн 5 жилд нийт шийдвэрлэсэн хэргийн 12-14 хувийг тус тус эзэлж байна. 2012-2013 онд гэр бүлийн маргааны нийт шийдвэрлэгдсэн хэргийн 80 хувийг гэрлэлт цуцлах маргаан эзэлж байна. Эндээс гэр бүлийн эрх зүйн маргаан, тэр дундаа

²⁰⁸ Family Code of the Russian Federation

²⁰⁹ http://www.npc.gov.cn/englishnpc/Law/2007-12/13/content_1384064.htm (2014-11-06)

гэрлэлт цуцлалттай холбоотой шийдвэрлэсэн хэргийг судлах шаардлага, ач холбогдол өсч байгааг харж болно.



Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн хэргийн тоо 2011 онд 4449 буюу нийт шийдвэрлэсэн хэргийн 14.7 хувь, 2012 онд 3878 хэрэг буюу 14 хувийг эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 571 хэргээр буурчээ. Харин 2013 онд 4276 гэр бүлийн холбогдолтой хэрэг, маргааныг шийдвэрлэсэн нь нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн 12.1 хувийг тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 1

Гэр бүлийн тухай хуулиар шийдвэрлэсэн байдал

Д/д	Гэр бүлийн тухай хуулиар	2009	2010	2011	2012	2013
1	Гэрлэлт цуцалсан	3295	3856	3642	3100	3382
2	Эцэг тогтоосон	436	382	325	278	313
3	Эцэг, эх байх эрх хассан	16	6	7	4	6
4	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	414	354	364	370	454
5	Тэтгэлэг тогтоолгосон хүүхдийн тоо*	1069	2079	1932	786	998
6	Гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох	8	3	9	11	11
7	Бусад	125	131	102	115	110
8	Бүгд	4294	4732	4449	3878	4276

Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн маргааныг шийдвэрлэсэн хэргийн тоо анхан шатны шүүх дээр өндөр үзүүлэлттэй боловч давж заалдах болон хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо харьцангуй бага байна. Тухайлбал, УДШ-ээс хүүхдийн асрамжтай холбоотой 2012 онд 28 хэрэг, 2013 онд 40 хэрэг шийдвэрлэсэн байна.

2.2. Хүүхдийн асрамжлагчийг тогтоосон шүүхийн практик

Шүүхээс хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, 14.6 дахь хэсэгт заасны дагуу хянан шийдвэрлэж байна. Түүнчлэн “Гэр бүлийн болон Иргэний бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” УДШ-ийн 2008 оны 46 дугаар тогтоол, УДШ-ийн 2007 оны “Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай” зөвлөмж зэрэг нь гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэхэд ач

* Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2008 онд баталсан ШС-2 маягтын дагуу хүүхдийн тэтгэлэг тогтоосон тоо нь Гэр бүлийн тухай хуулиар нийт шийдвэрлэсэн хэргийн тоонд ордоггүй болно.

холбогдолтой байдаг. Нөгөөтээгүүр, шүүхээс гэрлэлт цуцлалт, хүүхдийн тэтгэлэг, асрамж тогтоох, гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгө, гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгөтэй холбоотой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд анхаарах цөөнгүй асуудал байна. Үүнд:

- Хуулийн холбогдох зохицуулалтыг хэрэглэхгүй байх;
- Хуулийн зохицуулалтыг хэрэглэхдээ буруу тайлбарлах;
- Тухайн харилцаанд хамааралгүй хуулийн зохицуулалтыг хэрэглэх зэрэг болно.

Судалгааны хүрээнд 2012-2013 онд хүүхдийн асрамж тогтоох хэргийг хянан шийдвэрлэсэн 204 шийдвэр, магадлал, тогтоолд дүн шинжилгээ хийв. Үүнээс цаашид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарвал зохих зарим тохиолдлыг авч үзье:

- Хүүхдийн асрамж тогтоох тухай иргэний хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэхдээ Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7 дахь хэсэгт зааснаар нөхцөл байдлыг үл харгалзан зохигчид тохиролцсон баримтыг үндэслэн хэргийг шийдвэрлэсэн;
- Анхан шатны шүүх хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн зохицуулалтыг харгалзан үзээгүй;
- Хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг нарийвчлан авч үзэлгүйгээр хэргийг шийдвэрлэсэн. Мөн шүүх Хүүхдийн эрхийн тухай хамгаалах конвенц, Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3 заалт, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 заалт, 12.2 дахь хэсгийг буруу тайлбарлан хэрэглэсэн;
- Давж заалдах шатны журмаар хэрэг хэлэлцэхэд Хүүхдийн эрхийн тунхаглалын “Хүүхдийг бага насанд нь аюулгүй байдлын онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд эхээс нь салгаж үл болно” гэх заалтыг хүүхдийн асрамжийг эцэг, эхийн хэнд нь ногдуулах асуудлыг хянан шийдвэрлэж буй шүүхийн ажиллагаанд хамааруулсан нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг буруу тайлбарлаж хэрэглэсэн;
- Анхан шатны шүүхээр гэр бүл цуцлах хүүхдийн асрамж тогтоох тухай нэхэмжлэлийг хянан үзэхдээ хүүхдийг долоо, долоо хоногоор ээлжлэн асрамжид байлгахгаар заасан нь Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан “эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ” гэснийг зөрчсөн.

Жишээ 1: Хан-Уул дүүргийн шүүхийн 2013 оны 1 сарын 14-ний өдрийн 125 дугаар шийдвэр

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгч Г нь гэрлэлтээ цуцлуулж, хүүхдийн асрамж тогтоолгох тухай нэхэмжлэлийг гаргажээ.

Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн байдал: Анхан шатны шүүхээс Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу гэрлэлтийг цуцалж, 14.5-д зааснаар хүүхдийг эхийн асрамжид үлдээж, 26 дугаар зүйлийн 26.1, 26.4, 26.5-д зааснаар хүүхдийг 7, 7 хоногоор ээлжлэн асрамжид байлгахгаар шийдвэрлэжээ.

Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ: Анхан шатны шүүхээс Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д зааснаар харилцан тохиролцож болно гэсний дагуу гэрлэгчдийн гэрлэлтийг цуцалж, хүүхдийн асрамжийг бодит байдалд хэрэгжүүлэх боломжгүй шийдвэрийг гаргажээ. Энэ нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцээгүй байна.

Жишээ 2: Баянзүрх дүүргийн шүүхийн 2013 оны 4 сарын 03-ны өдрийн 803 дугаар шийдвэрт

Хэргийн товч агуулга: Нэхэмжлэгч М нь хариуцагч Н-ээс гэрлэлтээ цуцлуулах, хүүхдийн асрах болон тэтгэлэг тогтоолгох тухай нэхэмжлэлийг гаргажээ.

Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн байдал: Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу гэрлэлтийг цуцалж, 14.6-д зааснаар хүүхдийг эхийн асрамжид үлдээж, 40 дүгээр зүйлийн 40.1.1, 40.1.2-т зааснаар тэтгэлэг гаргуулах, 26 дугаар зүйлийн 26.4, 26.6-д зааснаар эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрхтэй болохыг дурдаж хэргийг шийдвэрлэжээ.

Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ: Анхан шатны шүүхээс хүүхдийн асрамжийн талаар дүгнэлт гаргуулахаар Хүүхдийн эрхийн үндэсний төвийг шинжээчээр томилжээ. Хүүхдийн эрхийн үндэсний төвийн тэргүүн, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нарыг оролцуулан шинжээчийн дүгнэлтийг ирүүлсэн байх бөгөөд нэхэмжлэгчийн зүгээс тус дүгнэлтийг эргэлзээтэй гэж үзэн дахин шинжээч томилуулсан байна.

Дахин томилсон шинжээчдийн багт Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга, мэргэжилтэн, хуулийн зөвлөх болон өрхийн эмч нарыг оролцуулсан. Өөрөөр хэлбэл, шинжээчээр дахин томилох тохиолдолд шууд харьяалах байгууллага байхгүйгээс тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй асуудлаар дүгнэлт гаргуулжээ. Хэдийгээр шинжээчээс гарсан дүгнэлт шууд нотлох баримт болохгүй боловч шүүгчид хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой байх ёстой юм.

Гурав. Хүүхдийн асрамжлагчийг тогтоох хэргийг хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам

3.1. Тулгамдаж буй асуудал

Гэр бүлийн харилцаанаас үүсэх маргааны тоо буурах нь нийгэмд ач холбогдол өндөртэй боловч хамт амьдрах, эвлэрэх боломжгүй тохиолдолд шүүхээс гэрлэлтийг цуцлах арга хэмжээ авч, хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

Шүүгчид хүүхдийн асрамжлагчийг тогтооход ач холбогдол бүхий дүгнэлт гаргаж өгөх чиг үүрэг бүхий шинжээч, мэргэжилтэн шаардлагатай байна. Хэдийгээр УДШ-ийн тогтоолд “хүүхдийн асрамжлагчийн асуудлыг шийдвэрлэхэд шүүх сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч болон өөр нарийн мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, дүгнэлт гаргуулж болно”, мөн хүүхдийн нас буюу бага насны эсвэл насанд хүрээгүй байдал, цэцэрлэгт хүмүүжиж эсвэл сургуульд сурч байгаа зэргээс шалтгаалан тухайн

насны онцлогийг шүүх харгалзан үзнэ. Эцэг, эхийн халамж буюу хүүхдийн хүмүүжил, эрүүл мэндэд тавих анхаарал, ахуйн нөхцөл бололцоо, хүүхдийн өсч бойжих орчин, тухайлбал, орон сууц, эд хөрөнгийн байдал, ёс суртахууны байдал буюу эцэг, эхийн өөрсдийн хүмүүжил, боловсрол, аливаа муу зуршилтай эсэх, хүүхдийг болон гэр бүлийн бусад гишүүдийг эд хөрөнгийн болон сэтгэл санааны дарамтад байлгадаг эсэх, эрх чөлөөнд халдаж, эрүүл мэндэд гэм хор учруулж байсан эсэхийг шүүх анхаарна²¹⁰ гэсэн боловч энэ нөхцөл байдлыг тогтоож буй шинжээчийн дүгнэлтийн агуулга ач холбогдол багатай байна.

Тухайлбал, АНУ-ын хүүхдийн асрамж тогтооход шүүгчид үнэлгээ гаргаж өгөх процесс дараах байдлаар хэрэгждэг байна.

Үнэлгээнд дараах зарчмыг баримтална:

1. Үнэлгээ тогтоогч нь нээлттэй, шударгаар ажиллах;
2. Мэдээллийн бүхий л эх үүсвэрийг ашиглах боломжтой;
3. Үнэлгээний явцад шаардлагатай тохиолдолд өмгөөлөгчийн хамт уулзах;
4. Сургууль, эрүүл мэндийн талаар нэмэлт асуулт асуух;
5. Тэмдэглэгээ заавал хийх.

Хүүхдийн асрамж тогтооход үнэлгээ хийх:²¹¹ Гэрлэгчид гэр бүлээ цуцлуулж буй тохиолдолд хүүхэдтэйгээ уулзах, халамжлах, асран хамгаалагчийг тогтоох асуудалд илүүтэй өмгөөлөгчөөс зөвлөгөө авдаг байна. Хэрвээ эцэг, эх хүүхдийн асрамж дээр тохиролцож чадаагүй бол шүүхээс тухайн хэргийг шийдвэрлэнэ. Шүүх хуралдаанаас өмнө шүүгч хүүхдийн асрамж тогтоохоор үнэлгээний байгууллагыг татан оролцуулж болно. Тухайн үнэлгээ нь гэр бүлийн гишүүдийн талаарх мэдээллийг шүүгчид өгч, шүүгч хэрэг хянан шийдвэрлэхдээ хүүхдийн эрх ашгийг хангасан шийдвэр гаргахад туслах дүгнэлтийг гаргана.

“Хүүхдийн асрамжлагчийг тогтоох үнэлгээ”²¹² нь ярилцлагын олон хэсгээс бүрдэнэ. Эцэг, эхийн хамт болон ганцаарчилсан ярилцлага хийх замаар үнэлгээг тогтоодог. Энэ нь эцэг, эхийн талаар ярилцах боломжийг олгох төдийгүй хүүхэдтэй түүний хамт амьдардаг гэр бүлийн бусад гишүүд болон хөршүүдтэй нь гэрт нь эсвэл ажлын байран дээрээ ярилцлага хийж болдог онцлогтой.

Мэдээлэл цуглуулах: Үнэлгээ гаргаж буй этгээд нь сургууль, эрүүл мэндийн байгууллага, нийгмийн халамжийн байгууллага, цагдаагийн байгууллага зэргээс гэр бүлийн гишүүдийн мэдээллийг гаргуулна. Мөн гэрлэгчидтэй хамаарал бүхий бусад этгээдээс мэдээлэл цуглуулах болон ярилцах байдлаар нэмэлт мэдээлэл цуглуулна.

Сэтгэл зүйн үнэлгээ тогтоох: Шүүгч сэтгэл зүйчийн бэлтгэсэн туршилтын аргаар эцэг, эхийн сэтгэл зүйн байдлын талаар мэдээлэл авах зорилгоор шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйн үнэлгээ тогтоодог.

Талууд үнэлгээ тогтооход оролцох: Талуудын үнэлгээ тогтооход хүүхдийн ашиг, сонирхол хөндөгддөг учраас үнэлгээний процесст эцэг, эхийн аль аль нь оролцдог төдийгүй шүүхээс талуудын аль нэг нь оролцоогүй үнэлгээг бүрэн бус гэж

²¹⁰ Ч.Отгонбаяр. “Гэр бүлийн эрх зүй”, Улаанбаатар, 2006 он. 37 дахь тал.

²¹¹ Guidelines for Child Custody Evaluations in Family Law Proceedings. American Psychological Association.

²¹² www.afccnet.org/resource-center/resources-for-families/pamphlet-information (2014-11-14)

үздэг. Нөгөөтээгүүр, үнэлгээ тогтоох нь цаг хугацаа, санхүүгийн дарамт үүсгэж, хүүхдэд стресс болдог байна.

Үнэлгээ хийх ажиллагаа: Энэхүү үнэлгээний ажиллагааг хувийн байгууллага хийдэг төдийгүй үүнд ихэвчлэн итгэмжлэгдсэн сэтгэл судлаач, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд оролцдог. Түүнчлэн эдгээр мэргэжилтнүүд сэтгэцийн эрүүл мэндийн талаарх сургалт, хүүхдийн асрамжийн үнэлгээ тогтоох болон гэр бүлийн хуулийн зохицуулалт, эрх зүйн ойлголт, гэр бүл салалтын хүчин зүйл, нөлөөлөл, хүүхдийн хөгжил, хэрэгцээ, шаардлагын талаарх ойлголтуудыг эцэг, эхчүүдэд өгдөг. Түүнчлэн асрамж тогтоох үнэлгээ гаргаж буй этгээдээс сургалт, туршлага, мэргэжилтэй холбоотой асуудлаар чөлөөтэй асуулт тавьж болдог байна.

Хүүхдийн асрамжийн талаар үнэлгээ тогтоох байгууллагын ажилтнууд хүүхдэд тухтай, аюулгүй орчинд уулзалтыг зохион байгуулна. Гэрлэлт цуцлах асуудал хүүхдэд хүнд тусдаг тул тэдний сэтгэл зүйн байдлыг мэдэх зорилгоор зураг зурах, тоглох, түүх ярих зэргээр санаа бодлыг нь сонсдог байна. Эцэг, эхчүүдийн зүгээс ихэвчлэн хүүхэд хэнтэй амьдрахыг хүсч байгааг хүүхдээс асуу гэсэн байр суурьтай байдаг ч хүүхдийн санаа бодол, мэдрэмжид шууд халдах нь тийм ч зохистой зүйл биш учраас хүүхдийн талаар дүгнэлт гаргах мэргэжилтнүүд шууд хүүхдээс энэ талын асуултыг асуудаггүй байна.²¹³

Үнэлгээний тайлан гаргах: Хүүхдийн асрамжийн талаар үнэлгээ гаргаж буй байгууллага өөрсдийн хийсэн үнэлгээний тайланг бичгээр бэлтгэж шүүхэд хүргүүлнэ. Энэхүү тайлангаас шүүгч тухайн гэр бүлийн талаар тодорхой дүр зургийг авч, хүүхдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох боломжтой болдог. Гэхдээ энэ тайлан нь шүүгчид хандсан зөвлөмжийн шинжтэй байна. Хэрвээ шүүгч болон өмгөөлөгч тус тайлангийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй гэж үзвэл тухайн газраас нэмэлт тайлбар хүсэж, гаргуулдаг байна.

Үнэлгээ тогтооход гарах төлбөрийн хэмжээ: Хэрвээ гэрлэгчид шүүх дээр хэрэгждэг үнэлгээний хөтөлбөрт хамрагдан үнэлгээ хийлгэж байгаа бол тухайн шүүхээс үнэлгээний хөлсийг тогтооно. Харин хувийн үнэлгээний байгууллагын хувьд харьцангуй төлбөр өндөртөйд тооцогддог бөгөөд цагаар тохирч үйлчилгээний хөлсийг авдаг. Хувийн үнэлгээний байгууллагын төлбөр өндөр учраас эцэг, эхчүүд хувааж төлөх байдал түгээмэл байдаг.

Үнэлгээний явцад тохиролцоонд хүрэх: Гэрлэгчдийн зүгээс үнэлгээ хийлгэх явцад хүүхдийн асрамжийн талаар тохиролцох боломжтой байдаг. Хэрвээ эцэг, эхийн зүгээс хүүхдээ хэний асрамжид үлдээх талаар тохиролцоонд хүрч чадвал өмгөөлөгчдөө хандан шүүхэд энэ талаарх хүсэлтээ явуулна. Өөрөөр хэлбэл, заавал шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх боломжтой болдог.²¹⁴

3.2. Дүгнэлт, санал

Шүүхийн шийдвэрээс үзэхэд гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэхэд материаллаг хуулийн болон процессын алдааг цөөнгүй гаргажээ. Гэхдээ судлаачдын зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчлөөс илүүтэй

²¹³ www.afccnet.org/resource-center/resources-for-families/pamphlet-information/categoryid/1/productid/9 (2014-11-20)

²¹⁴ www.afccnet.org/resource-center/resources-for-families/pamphlet-information/categoryid/1/productid/9 (2014-11-21)

эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах механизмыг тодорхойлоход анхаарал хандуулан авч үзлээ. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарсан алдаа, зөрчлийг багасгах, эдгээрийг арилгах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болох юм.

5. Шүүх гэр бүлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх танхим байгуулах:

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т “Анхан шатны шүүх тодорхой хэрэг, маргааны төрлөөр насанд хүрээгүй хүмүүсийн хэргийн, гэр бүлийн, хөдөлмөрийн маргааны зэрэг танхимтай байж болно” гэсэн байх тул дагнасан шүүхийн танхим байгуулах асуудлыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм. Монгол Улсын хувьд гэр бүлийн чиглэлээр дагнасан шүүх байгуулах хэрэгцээ шаардлага нь хэргийн тоо, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зэрэг олон хүчин зүйлээс хамаарах тул өнөөгийн нөхцөлд тохиромжтой хувилбар нь гэр бүлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх танхим байгуулах явдал юм.

Гэр бүлийн хэргийг шийдвэрлэх танхим байгуулснаар шүүгчид гэр бүлийн харилцаанаас үүсэн маргааныг хянан шийдвэрлэхэд мэргэжил, ур чадварын хувьд мэргэших, хууль хэрэглээний болон процессын алдаа зөрчил багасах, хүүхдийн эрх, ашиг хөндөгдсөн хэргийг шийдвэрлэхэд бүрэн бодитой, үнэн зөв шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой. Түүнчлэн шүүхээс гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэхэд талууд болон хүүхэдтэй уулзаж, ярилцах орчинг тодорхой хэмжээнд бүрдүүлэх боломжтой болно.

6. Гэр бүлийн тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох:

1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хууль болон холбогдох хуулиудад хүүхдийн асрамж тогтоох процессыг илүү нарийвчлан тусгах, ялангуяа, хүүхдийн асрамж тогтооход шинжээч томилох процесс, үнэлгээ хийх байгууллага, эрх, үүргийн талаар тодорхой зохицуулалтыг оруулах шаардлагатай байна. Тухайлбал, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэрлэлт цуцлалттай холбоотой хүүхдийн асрамж тогтоох ажиллагааг тодорхой хуульчилж оруулах шаардлагатай юм.

Гэр бүлийн харилцаа нь сэтгэл зүй, харилцаа, хандлагатай ихээхэн холбоотой байхад гэр бүлийн маргааныг шийдвэрлэх шүүх, хүүхдийн төлөө, гэр бүлийн төлөө ажиллах төрийн байгууллагад мэргэшсэн сэтгэл зүйч алга байна. Иймд гэр бүлийн мэргэшсэн сэтгэл зүйн салбарыг хөгжүүлэх шаардлага нийгмийн хэрэгцээ, шаардлагын хүрээнд урган гарч байна. Цаашид хүүхдийн асрамж тогтоох үнэлгээг Хүүхдийн төлөө байгууллагын дэргэд мэргэшсэн сэтгэл зүйч, мэргэжилтний баг дүгнэлт гаргах, эсхүл хувийн мэргэшсэн сэтгэл зүйн төв энэ талаарх дүгнэлт гаргах зохицуулалтыг бий болгох шаардлагатай. Ингэснээр шүүгчид гэрлэгчдийн талаар, тэдний ахуй нөхцөл, хүүхдийн өссөн орчны талаарх бүрэн мэдээлэл цуглуулж, хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой дүгнэлтийг гаргана.

7. Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг баримтлах, хэрэгжүүлэх:

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд байгаа “хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах” зарчмын хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна. Учир нь Монгол Улсын соёрхон баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенцид энэ зарчмыг тусгасан бөгөөд шүүх,

захиргааны, хууль тогтоох, төрийн болон төрийн бус байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд уг зарчим шууд хамааралтай юм.²¹⁵ Иймд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг шүүхэд хамгаалах асуудалд конвенцийн хэрэгжилтийг хангаж ажиллах хэрэгтэй байна.

Түүнчлэн “хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах” тухай ойлголтыг Монгол Улсын хэмжээнд тодорхойлж, цаашид бүхий л шатанд хэрэглэх шаардлагатай байна. Зарим улс оронд энэ зарчмыг дараах ойлголтын хүрээнд хамааруулан авч үздэг байна.²¹⁶ Үүнд:

- Хүүхэд эцэг, эхийн хайр халамжаар хайрлуулах эрхтэй. Хөндлөнгийн оролцоогүйгээр эцэг, эхдээ хандах эрхтэй;
- Хүүхэд эцэг, эх хоорондын зөрчил, маргааны улмаас хохирох ёсгүй;
- Хүүхэд аюулгүй орчинд амьдарч, бие махбодь, сэтгэл санааны, бэлгийн аливаа хүчирхийллээс хамгаалуулах эрхтэй;
- Хүүхдийн хэрэгцээ, шаардлага тэдний насны байдлаас хамаарч өөр өөр байдаг тул насны байдлаас хамааран эцэг, эх хоорондоо тохиролцож болохгүй;
- Хүүхдийн төлөө ажилладаг аливаа байгууллага нь хүүхдийн сургууль, гэр, орчин тойрны асуудлыг тусгайлан анхааралдаа авч үзэх ёстой;
- Эцэг, эхчүүд хүүхэдтэй салшгүй холбоотой байх.

8. *Гэр бүлийн хуулийн дагуу хэрэг хянан шийдвэрлэхэд хууль хэрэглээний алдаа гаргахаас сэргийлэх:*

Хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ эцэг, эхийн хоорондын тохиролцоог баримтлан шийдвэрлэхээс илүүтэйгээр хууль ёсны дагуу, бодит байдалд нийцэхүйц шийдвэр гаргахад анхаарал хандуулах нь зүйтэй юм. Энэ талаар шүүгчдийн сургалтын хөтөлбөрт тусгаж, гэр бүлийн маргааныг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлаар шүүгчдийн дунд сургалтыг зохион байгуулах шаардлагатай байна.

-oOo-

²¹⁵Ю.Бадамханд, “Хүүхдийн эрхийг хамгаалах салбар дахь олон улсын хэм хэмжээ, стандартууд, Монгол Улсын хууль тогтоомжид тусгалаа олсон байдал”, Монголын төр, эрх зүй, 2012 он №4(70). 20 дахь тал.

²¹⁶<http://www.divorcenet.com/resources/divorce/divorce-and-children> (2014-11-25)



ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ



НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗАРТАЙ ХОЛБОГДОХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙН ПРАКТИК²¹⁷

Удиртгал

Газрын эрх зүйн харилцаа нь Монгол Улсын эрх зүйн бие даасан салбар болох газрын эрх зүйн анхдагч шинжтэй институт бөгөөд түүнийг хэрхэн боловсронгуй болгохоос энэхүү салбар эрх зүй бүхэлдээ, түүний бусад институтийн төлөвшил, хөгжил шууд хамаарна. Сүүлийн жилүүдэд хот, тосгон, бусад суурины хүн амын төвлөрөл эрс нэмэгдсэн, газрын өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбогдуулан газрын хөрсний бохирдол, эвдрэл ихэссэн зэрэг олон сөрөг асуудал бий болж, үүнийг төрөөс шийдвэрлэх арга хэмжээ авч байгаа хэдий ч тодорхой үр дүн, өргөн хүрээг хамарч чадахгүйгээс болж хот, тосгон, суурины газрын харилцаанд олон асуудлууд гарсаар байна. Тухайлбал, нийтийн эдэлбэр газрыг зөвшөөрөлгүй эзэмших, ашиглах, зориулалтыг дур мэдэн өөрчлөх, гэр хорооллыг барилгажуулах ажлын хүрээнд нийтийн эдэлбэр газарт зөвшөөрөлгүй орон сууц, барилга барих, нийтийн эдэлбэр газрын орц, гарцыг хаах, хаших зэрэг нийтлэг зөрчлүүд гардаг. Эдгээр зөрчлийг газрын тухай хууль тогтоомжуудад нарийвчлан зохицуулж байгаа эсэх, шийдвэрлэх төрийн байгууллагын албан тушаалтны шийдвэр хуульд нийцэж байгаа эсэх зэргийг судлах нь нийгэм, эдийн засаг, эрх зүйн төдийгүй хүрээлэн буй орчныг хамгаалах чухал ач холбогдолтой юм.

Нэг. Нийтийн эдэлбэр газрын эрх зүйн зохицуулалт, нийтийн эдэлбэр газарт холбогдсон эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа

1.1. Нийтийн эдэлбэр газрын эрх зүйн зохицуулалт

Газрын эрх зүйгээр зохицуулах нэгэн төрлийн харилцаа нь Монгол Улсын газрын нэгдмэл сан бөгөөд газрын нэгдмэл сангийн бүрэлдэхүүнд хот, тосгон суурины газар орно. Энэ ангиллын газарт 4 төрлийн газар орох ба түүний бүрэлдэхүүнд нийтийн эдэлбэр газар орохоор хуульчилсан тогтоосон. Судалгааны ажлын суурь асуудал болох нийтийн эдэлбэр газрыг Монгол Улсын газрын харилцааг төрөлжүүлэн зохицуулахаар батлагдсан хууль тогтоомжоор хэрхэн тодорхойлж байсныг авч үзвэл:

- 1) Газрын харилцааг төрөлжүүлэн зохицуулахаар батлагдсан анхны хууль болох 1942 оны БНМАУ-ын Газар эдэлбэрийн тухай хуулиар /1942 оны Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 8 дугаар тогтоолоор баталсан/²¹⁸ газрыг доорх байдлаар хуваасан нь газар эдэлбэрийн эрх зүйн харилцааны анхны ангилал байсан. Үүнд:
 - Хувийн аж ахуйтнуудын хөдөлмөрийн газар эдэлбэрийн эрх;

²¹⁷ Тус судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ-ийн судлаач Ц.Мандах /LL.D/, судлаач Г.Солонго, гэрээт судлаач МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, судлаач С.Энхмэнд, Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шүүгч Э.Лхагвасүрэн нар хамтран гүйцэтгэсэн болно.

²¹⁸ БНМАУ-ын Газар эдэлбэрийн тухай хууль, 1942 он, 4 дүгээр зүйл. (ХЗҮХ, ШУА-ын ФСЭЗХ, МУИС-ийн Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төв, "Харьцуулсан эрх зүй", олон улсын эрх зүйн судалгааны төв, "Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл" 4 дүгээр боть. Улаанбаатар, 2010 он. 207 дахь тал.)

- Артель, олон нийтийн газар эдэлбэрийн эрх;
- Улсын аж ахуйтан, станц, аж үйлдвэр, албан байгууллагуудын газар эдэлбэрийн эрх.

Дээрх ангилал субъектийг шалгуур болгосон бөгөөд тухайн үеийн нийгэм, эдийн засгийн амьдралаас хамаарч холимог маягийн субъектүүд газрын харилцаанд оролцож байсныг харуулдаг. Эдгээр ангиллаас хоёр ба гурав дахь ангиллын газарт олон нийтийн газар эдэлбэрийг хамааруулж байв. Хоёр дахь ангилал болох артель ба олон нийтийн эдэлбэр газарт хадлан, тариалангийн зориулалтын газар хамрагдаж, энэ төрлийн газрыг нийтээр ашиглахаар, харин гурав дахь төрлийн газар болох улсын шууд мэдлийн газарт хот, суурины дэвсгэр газар хамрагдаж байв.

- 2) Газрын харилцааг зохицуулсан 2 дахь хууль буюу 1971 онд БНМАУ-ын АИХ-аас баталсан БНМАУ-ын Газар эдэлбэрийн хууль.

Тус хуулиар газрыг зориулалтаар нь 6 ангилсан²¹⁹ бөгөөд хот, суурины эдэлбэрийн газрыг хамааруулсан. Хот, суурины эдэлбэр газарт ямар төрлийн газар хамрагдах, тус газрыг эдлэх журам болон ногоон бүсийн газарт хамаарах газар, амины орон сууц баригчдад олгох газар, зуслангийн байр барих газар олгох журмыг тус хуулийн 3 дугаар бүлэгт хуульчлан тогтоосон байна.

- 3) Газрын харилцааг зохицуулсан 3 дахь хууль буюу 1994 оны Газрын тухай хууль.

Тус хуулиар хот, тосгон бусад суурины газарт нийтийн эдэлбэр газрыг хамааруулсан. Өмнөх хуулиас онцлог нь хот, тосгон, бусад суурины газар 4 төрлийн газраас бүрдэх ба үүний нэг нь нийтийн эдэлбэр газар юм. Хуулиар нийтийн эдэлбэр газар гэдгийг “хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна” гэж тодорхойлсон.²²⁰ Эдгээрээс нийтийн эдэлбэр газарт амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар,²²¹ хог хаягдлын цэг,²²² цэвэршүүлэх талбай гэсэн 7 төрлийн газар хамрагдах ба эдгээр газар нь нийтэд зориулагдсан буюу нийтээрээ ашиглах газар юм.

- 4) Одоо мөрдөгдөж байгаа 2002 онд шинэчлэн батлагдсан “Газрын тухай хууль”.

Тус хуулиар хот, тосгон бусад суурины газарт нийтийн эдэлбэр газрыг хамааруулаад, нийтийн эдэлбэр газарт хамаарах газрыг өмнөх хуультай адил байдлаар хуульчилсан.²²³ Шинэчлэн найруулсан Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “хуульд өөрөөр заагаагүй бол дараах газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглах” ба ийм газар нь 6 дугаар

²¹⁹ БНМАУ-ын Газар эдэлбэрийн хууль, 1971 он, 4 дүгээр зүйл. (ХЗҮХ, ШУА-ын ФСЭЗХ, МУИС-ийн Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төв, Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төв, “Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл” 6 дугаар боть. Улаанбаатар, 2010 он. 38 дахь тал.)

²²⁰ Монгол Улсын Газрын тухай хууль, 1994 он, 12 дугаар зүйл.

²²¹ Хамгаалалтын бүс эргэн тойрон 300 метр байна. (Оршуулгын газрын хамгаалалтын бүс тогтоож, ажиллах журам, НИТХ-ын 245 тоот тогтоол, 2005 он)

²²² Төвлөрсөн хогийн цэгийн хамгаалалт 300 метр байна. (Хогийн цэгүүдийн хамгаалалтын бүсийг тогтоож ашиглах журам, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 246 тоот тогтоол, 2005 он)

²²³ Монгол Улсын Газрын тухай хууль, 2002 он, 12 дугаар зүйл.

зүйлийн 6.2.2-т заасны дагуу “хот, тосгон, бусад суурины нийтийн эдэлбэр газар”-т орж, хамаарагдан нийтээрээ ашиглах зориулалттай байна.

1994, 2002 оны Газрын тухай хуулиудаар нийтийн эдэлбэр газрыг хот, тосгон, бусад суурин газрын бүрэлдэхүүнд тодорхойлон хуульчилсан байна. Үг зүйн утгын хувьд эдэлбэр газар гэж ямар нэгэн зориулалтаар ашиглаж байгаа газрыг хэлнэ²²⁴ хэмээн тайлбарлажээ. Газрын тухай хуулиар нийтийн эдэлбэр газарт ямар төрлийн газар байхыг тодорхойлсон. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулиар /1999 он/ “эдлэн газар гэж Газрын тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд эзэмшүүлэх, ашиглуулах зорилгоор олгосон газар”²²⁵ гэж тодорхойлжээ. Эндээс үзэхэд, нийтийн эдэлбэр газар нь зөвхөн зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай гэсэн тусгай зориулалтаар төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалтаар зөвхөн нийтээрээ ашиглах бол, эдлэн газар гэдэг нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гэсэн тодорхой субъектэд эзэмшүүлж, ашиглуулж байгаа газар юм. Гол ялгаа нь эдэлбэр газрыг ашиглах ба эдлэн газрыг эзэмшиж, ашиглах юм.

Гадаад улсын хувьд, ОХУ болон Япон улсад нийтийн эдэлбэр газрыг хэрхэн тодорхойлсныг авч үзвэл:

Нийтийн эдэлбэр газрыг ОХУ-ын Газрын тухай хуулийн 85 дугаар зүйлд тодорхойлохдоо, нийтийн эдэлбэр газар гэдэг нь хот, тосгон, суурины хүн амын хэрэгцээнд нийтээрээ ашиглахад зориулагдсан газрыг хэлнэ, үүнд талбай, гудамж, нарийн гудамж, зам, явган зам, гарц, засмал эрэг, парк, ойн цэцэрлэг, цэцэрлэгт талбар, таримал гудамж, цэцэрлэгт гудамж, жалга, усан сан, тэнгисийн хаялга, оршуулгын газар, хогийн төвлөрсөн газар хамаарна²²⁶ гэж заасан байна. Үүнээс харахад ОХУ-ын Газрын тухай хуульд заасан нийтийн эдэлбэр газарт орох төрлийг Монгол Улсын хууль тогтоомжид тодорхойлсонтой харьцуулбал илүү өргөн хүрээгээр, тодорхой байдлаар тогтоосон байна. Нийтийн эдэлбэр газрын харилцааг Газрын тухай хууль, Иргэний хууль, Хот байгуулалтын тухай хууль, Захиргааны хуулиудаар тус тус зохицуулдаг. Нийтийн эдэлбэр газрыг төрийн ба нутгийн захиргааны байгууллагын шийдвэрээр зөвхөн зориулалтын дагуу ашигладаг ба ашиглалтад тавих хяналтыг нутгийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ. Нийтийн эдэлбэр газрын хилийн хэмжээг нутгийн захиргааны байгууллагын шийдвэрээр тогтоодог байна.

Харин Япон Улсад Газрын тухай хууль байхгүй ба нийтийн эдэлбэр газар гэсэн ангилал байдаггүй. Нийтийн эзэмшлийн газрын өмчлөгч нь улс, муж, хот байдаг байна. Япон Улсын хууль тогтоомжийн дагуу газар нь өмч болох учраас тэнд өмчийн эрх үүсэх бөгөөд өмчлөгч нь хувь хүн, улс, муж, хот байх ба хувь этгээд болон төрийн гэж онцгойлон ангилдаггүй. Энэ нөхцөлд өмчлөгч нь улс, муж, хот, тосгон байвал гол төлөв улсын өмчийн газар, мужийн өмчийн газар, хотын өмчийн газар гэж нэрлэдэг.

Японы үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд өмчлөгч нь улс байсан ч бүртгэлжүүлж нээлттэй байлгадаг. Улсын өмчийн газрын тухайд өмчлөгч нь улс хэдий

²²⁴ Б.Баярсайхан, “Монгол хэлний хураангуй тайлбар толь”, Улаанбаатар, 2009 он.

²²⁵ Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3.

²²⁶ http://www.consultant.ru/popular/earth/17_22.html#p2276 (2014-12-14)

ч улсын өмч гэдэг утгаараа бүртгэл хийхдээ өмчлөгч нь “Сангийн яам” гэж бүртгэх, авто замын хувьд “Зам тээврийн яам” гэхчлэн бодит байдал дээр харьяалагдаж буй захиргааны байгууллагын нэрээр бүртгэдэг. Аливаа маргаан гарсан нөхцөлд тухайн байгууллага руу хандаж шийдвэрлүүлдэг байна. Газар нь өмчийн нэг төрөл бөгөөд маргаан гарсан нөхцөлд Иргэний хуулиар зохицуулахаар тусгасан. Тариалангийн газрын хувьд “Тариалангийн газрын тухай хууль”, барилга байгууламж барихтай холбоотойгоор газар түрээслэх бол Газар, байшин түрээслэх тухай хууль зэрэг тухайн газрын зориулалтаас нь шалтгаалан тус тусын салбар хуулиар зохицуулагдсан байдаг.²²⁷ Түүнчлэн улсын өмчийн газартай холбоотой маргааны тухайд худалдах-худалдан авах, ашиглалттай холбоотой маргаанд орж, Иргэний хуулиар зохицуулагддаг.

Дээрхээс харахад, Япон улсын эрх зүйд нийтийн эдэлбэр газар гэсэн тодорхойлолт байдаггүй бөгөөд газартай холбоотой харилцааг салбарын холбогдох хуулиудаар зохицуулдаг онцлогтой.

Япон улсад газрыг дараах үндсэн 5 бүсэд хуваадаг:

- Хот суурин газрын бүс
- Хөдөө аж ахуйн зориулалттай газрын бүс
- Ойн сан бүхий газрын бүс
- Байгалийн цэцэрлэгт хүрээлэнгийн газрын бүс
- Байгаль орчныг хамгаалах газрын бүс

Япон улсад “Газар ашиглалтын суурь төлөвлөгөө” гэж батлагддаг ба энэхүү төлөвлөгөөнд тулгуурлан дээрх 5 бүсийн ангиллын дагуу дараах салбарын хуулиудтай уялдан хэрэгжинэ. Үүнд:²²⁸

- Хот төлөвлөлтийн тухай хууль
- Тариалангийн бүс нутгийг хөгжүүлэх тухай хууль
- Ойн тухай хууль
- Байгалийн цэцэрлэгт хүрээлэнгийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Бусад хууль тогтоомж зэрэг салбарын хууль.

Улсын болон мужийн өмчийн зэрэг нийтийн эдэлбэр газрын тухайд газрын зориулалт гэсэн хэсэгт зам талбай, цэцэрлэгт хүрээлэн гэж тэмдэглэгдэх ба тэмдэглэгээ байхгүй нөхцөлд ихэнхдээ нийтийн эдэлбэр газар буюу аль нэг захиргааны байгууллагын өмчийн газар гэж ойлгодог байна.

Монгол Улсын хувьд бусад төрлийн газартай харьцуулахад нийтийн эдэлбэр газрын онцлог нь тус газар хувийн өмчид хамаарахгүй бөгөөд хот, нийтийн аж ахуйд харьяалагдаж аль нэг байгууллага мэдэлдээ байлгах боловч хот, тосгон, бусад суурины хүн амын хэрэгцээнд ашиглагдана. Нийтийн эдэлбэр газрын эрх зүйн зохицуулалтыг Газрын тухай хууль, бусад хууль тогтоомжоор хэрхэн зохицуулсныг тоймлон авч үзвэл:

²²⁷ Laws Related to Real Estate Transactions in Japan <http://www.mlit.go.jp/common/001050448.pdf> (2014-12-18)

²²⁸ Мөн тэнд.

- 1) Газрын тухай хуулиар нийтийн эдэлбэр газар гэдгийг агуулгын талаас шууд тодорхойлоогүй, харин ямар ангиллын газарт хамааралтай байхыг тодорхойлсон. Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т хот, тосгон, бусад суурин газрын нэг бүрэлдэхүүнд нийтийн эдэлбэр газар байх бөгөөд амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай бүхий газар нь нийтийн эдэлбэр газарт хамаарна. Эндээс үзэхэд, нийтийн эдэлбэр газрын объект буюу дээр дурдсан 7 төрлөөр ашиглагдах газар бол нийтийн эдэлбэр газар юм.
- 2) Нийтийн эдэлбэр газрын гол онцлог нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд хамаарагддаггүй, зөвхөн тодорхой зориулалтаар ашиглагдах газар байна. Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т зааснаар хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг гаргаж хэрэглэхийг газар ашиглах гэнэ. Тэгвэл Газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан нийтийн эдэлбэр газрыг тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т зааснаар газар өмчлөгч, эзэмшигчтэй гэрээний үндсэн дээр амралт, зугаалга, биеийн тамирын газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбайн зориулалтаар ашигтай байдлаар ашиглана.
- 3) Нийтийн эдэлбэр газрын харилцаанд оролцох эрх бүхий субъект нь 18 насанд хүрсэн эрх зүйн чадамжтай Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харъяалалгүй хүн тодорхой зориулалт, хугацаа, болзол, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу газар ашиглагч байж болно.²²⁹ Гол нь эдгээр субъект холбогдох хуулиудын дагуу эрх зүйн статусыг бүрдүүлсэн байхыг Газрын тухай хууль шаардана. Учир нь энэ төрлийн газрын харилцаа гэрээний үндсэн дээр ашиглах байдлаар үүснэ.
- 4) Нийтийн эдэлбэр газар нь хот, тосгон, бусад суурины бүрэлдэхүүн газар тул Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, Газрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2-т заасны дагуу ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байдаг төрийн өмч бөгөөд иргэдэд өмчлүүлэхгүй газар юм. Эдгээр газар хувийн өмчид хамаарахгүй бөгөөд хот, нийтийн аж ахуйд хамаарч аль нэг байгууллага мэдэлдээ байлгах боловч хот, тосгон, бусад суурины хүн амын хэрэгцээнд ашиглагдана. Нийтийн эдэлбэр газрын төлөвлөлтийг нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр тогтоох ба Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1-т зааснаар нийслэлийн Засаг дарга дүүрэг бүрээр боловсруулж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /НИТХ/ батална. Нийтийн эдэлбэр газрыг ашиглах шийдвэрийг тухайн ашиглах зориулалтаас нь хамаарч нийслэл, дүүргийн Засаг дарга гаргана. 2005 онд Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж тус хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т Сууц Өмчлөгчдийн Холбоо /СӨХ/-нд орчны газрыг ашиглуулах харилцааг хуульчилсан. Нийслэл, дүүргийн СӨХ тухайн шатны Засаг даргатай 15 жилийн

²²⁹ Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг.

хугацаатай гэрээ байгуулж орчны газраа ашиглана. Гэтэл тус газар нь нийтийн эзэмшлийн газарт хамаарагдахаар газар тул 2005 онд Нийслэлийн Засаг даргын 499 дүгээр захирамжийн дагуу нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орчны газарт үйл ажиллагаа явуулж байгаа СӨХ-ны ашиглаж байгаа газарт тооллого явуулж, бүртгэсэн байна. Тооллого явуулж, бүртгэсэн нь нийтийн эдэлбэр газар тухайлбал, зам, биеийн тамирын талбай, цэцэрлэгийн газар тодорхой байдлаар эзэнтэй болж, үүнийг даган зориулалтын дагуу ашиглалт, хамгаалалтын харилцаа тогтоогдсон байна. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар “Хот, тосгон нь эдэлбэр газартай байна, түүнчлэн хот, тосгоны захирагч хот, тосгоны эдэлбэр газрын ашиглалтыг төлөвлөх бүрэн эрхтэй” тухай заасан.

- 5) Нийтийн эдэлбэр газрын ашиглалтад Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т зааснаар төрийн зохих шатны байгууллага хяналт тавих ба мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т зааснаар Засгийн газар, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, түүний тэргүүлэгчид, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дагуу хяналт тавина.
- 6) Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг нийтийн эдэлбэрт ашиглаж болно. Үүнийг Засгийн газар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар эзэмшигч, ашиглагчтай урьдчилан тохиролцож, гэрээ байгуулсны үндсэн дээр төлбөртэй буюу төлбөргүйгээр ашиглаж болно.²³⁰ Тус харилцааг Газрын төлбөрийн тухай хуулиар /1997 он/ зохицуулна.
- 7) Нийтийн эдэлбэр газрын ашиглалтыг зохион байгуулах, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах ажлыг хорооны Иргэдийн Нийтийн Хурал /ИНХ/ зохион байгуулна.²³¹ Харин нийтийн эдэлбэр газрын ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуй, ариун цэврийн асуудлыг хорооны Засаг дарга хариуцна.²³² Энэ талаар хийсэн ажлаа хорооны ИНХ-д тайлагнах үүрэгтэй.
- 8) Нийтийн эдэлбэр газраас зорчих, орох, гарах, зугаалахад ерөнхий журмаар ямар нэг төлбөр авахгүй боловч тусгай зориулалттай үйлчилгээ үзүүлэхэд зарим төлбөр авч болно. Тухайлбал, цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоом, усан сангаар үйлчлүүлэх гэх мэт.
- 9) Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.-т “Хот байгуулах зориулалтаар хотын ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдож, нийслэлийн ИТХ-аар баталсан гортиг бүхий газрыг нийслэл хотын эдэлбэр газар гэнэ” гэж заасан. Энэ төрлийн газрыг Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1-т зааснаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тогтоогдоно. Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Хот байгуулалтын тухай” /2008 оны/ хуулиар зохицуулна.

²³⁰ Газрын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь хэсэг.

²³¹ Газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, 22.1.2 дахь хэсэг.

²³² Газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.3 дахь хэсэг.

10) Нийтийн эдэлбэр газрын ашиглах эрхийг дүүргийн болон нийслэлийн Засаг дарга Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 40 дүгээр зүйлийн 40.1.1-т заасан эрх хэмжээний хүрээнд хүчингүй болгоно.

11) Нийтийн эдэлбэр газарт хашаа, хайс барьж хамгаалах ба үүнийг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 115 тоот тогтоолоор батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа барьж ашиглах тухай журам”-аар зохицуулна.

1.2. Нийтийн эдэлбэр газартай холбогдох газрын эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа

Нийтийн эдэлбэр газрыг ашиглах явцад газрын тухай хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гарсан тохиолдолд Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д зааснаар газар ашиглах эрхийг дуусгавар болгоно, харин мөн хуулийн 40 дугаар зүйлд зааснаар Засаг дарга газар ашиглах эрхийг хүчингүй болгоно. Мөн газар ашиглахтай холбогдож үүссэн зөрчлийг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 30 тоот тогтоолоор батлагдсан “Нийслэлийн хэмжээнд газар ашиглалттай холбогдон үүссэн зөрчлийг арилгахад баримтлах журам”-аар зохицуулна.

Нийтийн эдэлбэр газрын хэмжээг доорх хүснэгтээр харуулбал: ²³³

Хот тосгон, бусад суурины газар	2000 онд	2005 онд	2010 онд
	416.4 га	466.0 га	620.6 га
<i>Нийтийн эдэлбэр газар</i>	302.9 га	295.5 га	318.3 га

Тус хүснэгтээр хот тосгон, бусад суурин газрын нийтийн эдэлбэр газар нь бусад төрлийн газар болох барилга, байгууламжийн дэвсгэр газар, үйлдвэрийн газар, уурхайн газар, гэр хорооллын газартай харьцуулахад хамгийн их хэмжээ буюу дийлэнх хувийг эзэлж байна.

Нийтийн эдэлбэр газрын маргаан гэдэг нь хот, тосгон, суурины иргэд нийтээрээ эзэмших, ашиглах зориулалттай газрыг эзэмших, ашиглах явцад үүссэн газрын эрх зүйн маргааныг хэлнэ.²³⁴ Уг маргаан газрын харилцаатай холбоотой эрх нь зөрчигдсөн гэж үзсэн этгээд энэ талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол, нэхэмжлэл гаргаж өөрийн зөрчигдсөн эрхээ сэргээхийг шаардах үед үүсдэг. Газрын маргааны онцлог шинж нь маргааны зүйлийн талаарх маргалдагч талуудын байр суурь объектив байдлаар илэрхийлэгдсэн байхыг шаарддаг. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрөлгүй нийтийн эдэлбэр газрыг эзэмших, ашиглах, нийтийн зориулалтаар эзэмших, ашиглах газрын зориулалтыг өөрчлөх, хуулийн журам, нөхцлийг өөрчлөх, бусдын эзэмшлийн болон нийтийн эдэлбэр газар, зам талбайн орц, гарцыг хааж хашаа хатгах зэрэг маргаан, зөрчлүүд нийтлэг байдлаар гарч байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх бүхий субъект өмчлөл, эзэмшлийн газрын хэмжээг дур мэдэн өөрчилж нийтийн эдэлбэр газарт хамааруулан улмаар энэ төрлийн газрын зориулалтыг өөрчилсөн; шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгдөг төрийн захиргааны байгууллагын албан тушаалтан хууль зөрчиж хууль бус шийдвэрээр нийтийн эдэлбэр газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд олгосон зэрэг

²³³ Газрын нэгдмэл сангийн тайланг үндэслэв.

олон төрлийн зөрчлүүд юм. Тухайлбал, Улаанбаатар хот дахь Дуурь бүжгийн эрдмийн театрын хажуу талын цэцэрлэгт хүрээлэнгийн газраас тодорхой хэмжээний газрын зориулалтыг өөрчлөн аж ахуйн нэгжид эзэмшүүлэх шийдвэрийг Улаанбаатар хотын Засаг дарга гаргасан байдаг.

Газрын маргаан нь эсрэг тэсрэг шинжтэй, шийдвэрлэх боломжгүй зөрчилдөөн биш юм. Нэгэнт маргаан гарч болзошгүй байдаг тул түүнийг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид тодорхой заасан байдаг. Тухайлбал, Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлд: “Газрын маргаан нь өөр өөр арга, зарчмаар шийдвэрлэгдэх тул төрөл болгон ангилж болно” гэж заасан. Дээрх хуулийн 60 дугаар зүйлээр хуульчлагдсан газрын маргаан нь захиргааны болон иргэний эрх зүйн харилцааны явцад үүсдэг. Захиргааны эрх зүйн харилцаанаас үүссэн маргааны төрөлд:

- *Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, Засаг даргын хооронд үүссэн маргаан.* Энэ маргаан нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг Засаг дарга зөрчсөн гэж үзсэнээр үүсдэг.
- *Төрийн бусад байгууллага, албан тушаалтан болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүссэн маргаан.* Энэ маргаанд төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/ нь газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэх талаарх маргаан, мөн иргэн газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн байгууллага, албан тушаалтан хууль бусаар саад учруулснаас үүсэх маргаан хамаарна.

Нэгэнт бий болсон газрын маргааныг хуульд заасан үндэслэлээр хянан шийдвэрлэх хэрэгтэй бөгөөд энэ нь процессын ажиллагааны үр дүнгээр хэрэгжинэ. Газрын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндсийг Газрын тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /ЗХХШТХ/-ууд бүрдүүлж байна. Газрын маргааныг Захиргааны хэргийн шүүх байгуулагдахаас өмнө эрүү болон иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэж байсан ба Захиргааны хэргийн шүүх байгуулагдсанаар шүүхийн ачаалал харьцангуй жигдэрч, захиргааны байгууллага, албан тушаалтны газрын эрх зүйн харилцааны акттай холбоотой гарсан маргааныг харьяаллын дагуу хянан шийдвэрлэж байна.

Монгол Улсад Газрын тухай хуулиар маргааныг хүчингүй болгох үндэслэл болон шүүхээр харьяалагдах маргааны төрлийг тодорхой заасан. Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдлээрээ газрын тухай хууль тогтоомж, газар эзэмшигч, ашиглагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол тус байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан эсхүл шүүх тус хууль бус шийдвэрийг хүчингүй болгоно гэж заасан.

Газрын нэгдмэл сан дахь газрын эрх зүйн зөрчлийн дийлэнх хувийг нийслэл хотын газрын зөрчил эзэлдэг. Зөрчлийг Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.

Нийтийн эдэлбэр газрын харилцаанд гарч буй зөрчлийг шийдвэрлэхээр нийслэлийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтнаас Газрын тухай хууль, Засаг, захиргаа, нутаг

дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуульд заасан эрх хэмжээний дагуу тогтоол, захирамж баталж тодорхой байдлаар журамлан зохицуулж байна. 2012 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр НИТХ-ын “Газрын харилцаа, хот төлөвлөлт, барилгажилтад гарч буй зөрчлийг таслан зогсоох, цаашид авах арга хэмжээ”-ний талаар 3/10 тоот тогтоол батлагдсан.

- Нийслэлийн нутаг дэвсгэрт орон сууц, олон нийтийн барилга байгууламж орчмын нийтийн эзэмшлийн зам талбай, машины зогсоол, явган хүний зам, цэцэрлэгжилтийн талбай, орц, гарц, СӨХ, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн эдэлбэр газар, авто замын улаан шугам, инженерийн байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүс, ундны усны эх үүсвэрийн тэжээлийн муж болон барилгын норм, дүрэм зөрчиж газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгосон, эрх шилжүүлсэн, барилга байгууламж барих зөвшөөрөл олгосон Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжийг судалж хүчингүй болгох,
- Бусдын эзэмшил, ашиглалт, өмчлөлд олгогдоогүй газар болон нийтийн эдэлбэрийн газрыг гэрчилгээжүүлэн газрын улсын бүртгэлд бүртгэх г.м.

Газрын маргааныг Газрын тухай хуулийн 60 дугаар зүйл болон ЗХХШТХ-д зааснаар 2 хэлбэрээр шийдвэрлэнэ. Үүнд:

1. Газрын маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагаагаар хянан шийдвэрлэх;
2. Газрын маргааныг захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэх;

1. Нийтийн эдэлбэр газартай холбогдсон газрын маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагаагаар хянан шийдвэрлэх:

Захиргааны хэргийн шүүх нь газрын маргааны асуудлаар гаргасан нэхэмжлэл, гомдлыг хүлээн авахдаа ЗХХШТХ-ийн дагуу ихэнх тохиолдолд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийлгэсэн байхыг шаарддаг. Шаардах үндэслэл нь Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлээр газрын эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх байгууллага, албан тушаалтныг тодорхойлон зааж өгсөн. Ийнхүү шийдвэрлэсэн захиргааны албан тушаалтны шийдвэрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эс зөвшөөрвөл дээд шатны албан тушаалтан болон шүүхээр шийдвэрлүүлэх сонголт бүхий заалтыг хуульчилсан. Эндээс захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэх асуудал бий болох ба энэ нь захиргааны актыг хууль бус гэж үзэж, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар гаргасан гомдлыг тухайн захиргааг шууд харьяалах дээд шатны захиргаа нь ЗХХШТХ-д заасан журмын дагуу хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хэлнэ.²³⁵

Нийтийн эдэлбэр газрын эрх зүйн зохицуулалтын хувьд газар эзэмших, ашиглах шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан, тухайлбал нийслэлийн Засаг дарга Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д заасны дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож батлагдсан хотын ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу нийтийн эдэлбэр газраас тодорхой зориулалтаар газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгох шийдвэрийг гаргадаг. Ийнхүү гаргахдаа дүүргийн Засаг даргаас

²³⁵ А.Эрдэнэцогт, “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”, Улаанбаатар, 2012 он, 105 дахь тал.

санал аваагүй, эсхүл санал авсан боловч дүүргийн Засаг дарга газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үндэслээгүй санал өгч болно. Нийтийн эдэлбэр газарт гарч буй газрын маргааны агуулга нь дээрх үндэслэлээр түгээмэл гардаг байна. Энэ шийдвэрийн хэрэгжилтийн хохирогч нь хот, тосгоны оршин суугчид бөгөөд тэдний нийтийн эзэмшлийн талбайд амрах, зугаалах боломж нь багасаж, талбайн хэмжээ хумигддаг. Түүнчлэн Газрын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2-т зааснаар “Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар эзэмшигч, ашиглагчтай урьдчилан тохиролцож, гэрээ байгуулсны үндсэн дээр бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг тодорхой хугацаатайгаар нийтийн эдэлбэр газарт төлбөртэй буюу төлбөргүйгээр ашиглаж болох ба үүнийг нийгмийн зайлшгүй шаардлагыг үндэслээд захиргааны журмаар шийдвэр гаргаж болно” гэсэн зохицуулалтыг хуульчилсан. Үүнийг дээр дурдсанаар Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д зааснаар газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөгөөр тусгагдана.

2. Газрын маргааныг захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэх:

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны газрын эрх зүйтэй холбоотой гаргасан захиргааны акт, үйл ажиллагааны талаарх гомдлоо захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах замаар шийдвэрлүүлнэ. Захиргааны хэргийн шүүх нь Газрын тухай хууль тогтоомжийг зөрчсөн эсэх талаарх нийтийн эдэлбэр газартай холбоотой дараах захиргааны хэргийг нэхэмжлэлийн үндсэн дээр хүлээн авч шийдвэрлэдэг. Үүнд:

- Газар эзэмших, ашиглах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон Засаг даргын хооронд үүссэн маргааныг дээд шатны Засаг дарга хянан шийдвэрлээд гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн нэхэмжлэлийн шаардлага;
- Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг хүчингүй болгуулахаар гаргасан нэхэмжлэлийн шаардлага.

Нийтийн эдэлбэр газар нь нийтээрээ ашиглах боловч өмчлөгч нь төр байдаг. Нийтийн эдэлбэр газрын харилцааны маргаанд гарч буй нийтлэг нэг асуудал нь эзэмшигч, ашиглагчтай өөрийнх нь өмчийн талаар маргаж буй явдал юм. Тухайлбал, Улаанбаатар хотын нэгэн дүүргийн ногоон байгууламж болох мод, зүлэг, явган хүний зам, хайс бүхий нийтийн эдэлбэр газрын зориулалтыг өөрчилж иргэний эзэмшилд шилжүүлсэн газрын маргааныг захиргааны хэргийн шүүхийн хоёр шатаар шийдвэрлэсэн байдлаас үзэхэд нийтийн эзэмшлийн газрыг бусад субъектын эзэмшилд шилжүүлэхэд баримтлах шалгуурыг хуулиар тогтоогоогүй тул үүнийг ашиглан иргэнд газар эзэмшүүлэхтэй адил байдлаар буюу Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т заасан хүсэлт гаргасан газрын байршил нь аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж болохоор заагдсан байна гэсэн ерөнхий заалтыг үндэслэн шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2004 онд байгуулагдсанаасаа хойш 2013 оны байдлаар нийт 7441 хэргийг хянан шийдвэрлэсэн бөгөөд захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн хэргийн 21.3 хувийг Газрын тухай

хуулиар шийдвэрлэсэн маргаан эзэлж байна.²³⁶ Нийтийн эдэлбэр газартай холбоотойгоор:

- Нийтийн эзэмшлийн зам талбайд орон сууц, барилга барих зөвшөөрөл олгосон, зөвшөөрлийг цуцалсантай холбоотой үүссэн маргаан;
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгогдоогүй байхад дур мэдэн газар ашигласантай холбоотойгоор үүссэн маргаан;
- Газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй байхад нийтийн эдэлбэр газар буюу гудамж талбайд, мөн газрын дуудлага худалдаа, төсөл шалгаруулалтгүйгээр олгосонтой холбоотой маргаан тус тус их гарсан байна.

Газрын маргааныг хянан шийдвэрлэж буй бусад улсын туршлагаас үзэхэд:

ОХУ-д газар иргэний гүйлгээнд ордоггүй байхад газрын маргааныг захиргааны журмаар хянан шийдвэрлэж байв. Зах зээлийн харилцаанд шилжсэнээр газрын харилцааны асуудлыг эргэн харж, зохих өөрчлөлтүүд хийж эхэлжээ.

1993 оны 12 дугаар сарын 24-нд ОХУ-ын Ерөнхийлөгч “Газрын тухай хууль тогтоомжийг шинэ Үндсэн хуульд нийцүүлэх тухай” зарлиг гаргаснаар 1991 оны Газрын тухай хуулийн 115-123 дугаар зүйл буюу газрын маргааныг хянан шийдвэрлэх журам бүхэлдээ өөрчлөгдсөн.²³⁷ ОХУ-ын шинэ Үндсэн хуулиар газрыг иргэдэд өмчлүүлэх болсноор газар бусад үл хөдлөх хөрөнгийн нэгэн адил иргэний гүйлгээнд идэвхтэй орж, төрөл бүрийн газрын маргаан гарах болсон. Ердийн шүүх иргэд, хуулийн этгээдийн нэхэмжлэлтэй холбоотой газрын маргааныг шийдвэрлэх бол ОХУ-ын Арбитрын шүүх хувиараа бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжийн нэхэмжлэлтэй хэрэг маргааныг шийдвэрлэнэ. Харин энэ тохиолдолд нэхэмжлэгч өөрийн шаардлагыг үндэслэн маргаж буй мөнгөн дүнг нарийвчлан тусгах шаардлагатай байдаг байна.

Их Британий Англи болон Уэлст нийтийн эдэлбэр газар болон түүнд холбогдсон маргааныг хэрхэн шийдвэрлэдэг талаар авч үзвэл, Англи болон Уэлст нийтийн эдэлбэр газар буюу хот, тосгон, суурин газрын ногоон байгууламжийн талаар 1965 онд батлагдсан Нийтийн бүртгэлийн тухай хуулиар /Commons Registration Act, 1965/ зохицуулдаг байна. Энэ хуулиар нийтийн эдэлбэр газрыг бусдын эзэмшилд шилжүүлэх тухай зохицуулсан ба тус хуулийн 6 дугаар зүйлээр маргааныг шийдвэрлэх талаар тусгажээ. Газрын маргааныг шийдвэрлэхэд нийтийн бүртгэлийн төлөөлөгч буюу комиссар газартай холбоотой хүсэлтийг харгалзан газрын төрлийн зориулалтад өөрчлөлт оруулах, эсхүл хэвээр нь батлах, мөн татгалзаж шийдвэрлэнэ. Хэрэв татгалзсан тохиолдолд дараах үндэслэлээр шийдвэрийг хүчингүй болгоно. Үүнд:²³⁸

- Зөвшөөрсөн эсхүл татгалзсан шийдвэрт гомдол гаргах хугацаанд давж заалдаагүй;
- Гомдлыг эцэслэн шийдвэрлэсний дараа давж заалдсан бол.

²³⁶ Монгол Улсын Дээд шүүх, Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн шүүхийн тойм 2004-2014 он.

²³⁷ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_2888/ (2014-12-12)

²³⁸ http://www.legislation.gov.uk/ukpga/1965/64/pdfs/ukpga_19650064_en.pdf (2014-12-22)

Шийдвэр нь зөвшөөрөгдсөн эсхүл татгалзсан тохиолдолд үндэслэлийг тодорхой тусгана. Нийтийн эдэлбэр газрын бүртгэл хүчингүй болсон тохиолдолд тус газрын өмчлөгчийн эрхийг бүртгэлийн газраас цуцална. Хуулиар нийтийн эдэлбэр газрын маргааныг шүүхээр шийдвэрлэдэг байна.

Хоёр. Маргаан хянан шийдвэрлэж байгаа өнөөгийн байдал

2.1. Нийтийн эдэлбэр газартай холбогдох газрын эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэж буй байдал

Шүүн таслах ажиллагааны мэдээнээс харахад газар эзэмших, өмчлөхтэй холбоотой маргаан нь 2013 онд Монгол Улсын хэмжээнд шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхийн нийт хэргийн 25,5 хувийг, 2014 онд 32,5 хувийг тус тус эзэлж байна. Захиргааны хэргийн шүүхээр 2014 онд шийдвэрлэгдсэн газрын тухай маргааныг 2013 онтой харьцуулахад 37,8 хувийн өсөлттэй гарсан нь энэ төрлийн хэрэг маргаан цаашдаа өсөх хандлагатай байгаа нь илэрхийлэгдэж байна.²³⁹

Газрын тухай хуульд зааснаар аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга эрх хэмжээний хүрээнд иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах, өмчлөх асуудлыг шийдвэрлэдэг бөгөөд захиргааны хэргийн шүүхээр хянагдаж байгаа маргааны хариуцагчийн дийлэнх нь эдгээр албан тушаалтан байдаг.

Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлд зааснаар тухайн шатны болон дээд шатны засаг дарга өөрийн болон доод шатны Засаг даргын шийдвэрийг хүчингүй болгох байдлаар хууль бусаар гаргасан шийдвэрээ хуульд нийцүүлэх боломжтой. Энэ хүрээнд сүүлийн 2 жилийн хугацаанд дүүрэг, нийслэлийн Засаг дарга нийтийн эдэлбэрийн газарт бусдад эзэмшүүлэх эрх олгосон өмнөх Засаг даргын захирамжийг хууль бус гэж үзэн хүчингүй болгох байдал гарсан байна. Тухайлбал, Улаанбаатар хотын Нацагдоржийн номын сангийн баруун талын газарт, Саппорогийн урд талын газарт, Худалдаа хөгжлийн банкны төв байрны замын урд талын газарт, Төрийн ордны хойд талын орон сууцны хорооллын доторх зам талбайд, Аса циркийн хойд талын цэцэрлэгт гудамжинд, мөн авто замын, инженерийн шугам сүлжээний, төмөр замын гэх зэрэг холбогдох хууль тогтоомжоор тогтоосон хамгаалалтын бүсэд хамаарах газарт газар эзэмшүүлсэн байсныг нийслэлийн Засаг даргаас “нийтийн эдэлбэрийн газарт газар олгосон” гэх үндэслэлээр хүчингүй болгосон байна.

Дээд шатны Засаг даргаас ийнхүү доод шатны Засаг даргын шийдвэрийг хууль бус гэж үзэн хүчингүй болгоход тухайн газрыг нийтийн эдэлбэрт хамаарах болохыг тогтоох нь шийдвэр гаргах гол хүчин зүйл юм. Үүнд тодорхой нэр бүхий иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг онцгойлж авч үзэх, нэр дурдах, зөрчигдсэн гэх эрх ашгийг тодорхойлох, цаашлаад уг хууль бус шийдвэрийн улмаас хэн нэгний эрх, ашиг сонирхол зөрчигдсэн эсэхийг дүгнэх шаардлага байхгүй юм. Үүнтэй холбоотойгоор “нийтийн эдэлбэр”-ийн гэх газрыг эзэмшиж байсан иргэн, хуулийн этгээдээс өөрийн газар эзэмших эрхийг зөрчлөө гэж үзэн Засаг даргын захирамжийг хүчингүй болгуулахаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах явдал хэвшиж байна.

²³⁹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, Монгол Улсын шүүхийн тайлан (2014 он), Улаанбаатар, 2015 он. 190 дэх тал.

Энэ тохиолдолд шүүхээс тухайн нэхэмжлэгчийн газар эзэмших эрх зөрчигдсөн эсэх, эзэмшүүлсэн газар нь нийтийн эдэлбэр газарт хамаарах эсэхэд дүгнэлт өгөх байдлаар маргааныг шийдвэрлэдэг.

Газрын тухай хуулийн 44¹ дүгээр зүйлд СӨХ-д харьяалагдах орон сууцны орчны газрыг ашиглуулахаар, мөн Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4-т аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад СӨХ-д орчны газрыг тодорхой болзолтойгоор, гэрээний дагуу ашиглуулах эрхтэй байхаар тус тус зохицуулсан. Энэ хүрээнд СӨХ-ны ашиглаж буй, эсхүл ашиглах боломжтой орчны газарт газар эзэмшүүлсэн шийдвэртэй холбогдуулан СӨХ дангаараа, эсхүл иргэдийн итгэмжлэлээр зарим тохиолдолд хамтарч нийтийн эдэлбэр газарт хамаарах орчны газартай холбоотой нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүхэд гаргаж, шүүхээс тус маргааныг шийдвэрлэх тохиолдол багагүй гарсан нь шүүхийн шийдвэрүүдээс харагдаж байна.

Харин орчны газрыг хуульд заасан журмын дагуу ашиглаж эрх үүсээгүй байгаа СӨХ дангаар нэхэмжлэгч болох эсэх, мөн тухайн газрыг ашиглах эрхтэй эсэхээс үл хамааран оршин суугчдыг төлөөлөх итгэмжлэлийг СӨХ хэрхэн олж авах, тухайн итгэмжлэл нь итгэмжлэл олгосон оршин суугчдын тооноос хамаарах эсэх нь зарим тохиолдолд маргаан дагуулж байна. Энэ төрлийн маргааны хувьд шүүхээс газрын давхцал, барилгын норм ба дүрэмд заасан стандарт хангагдсан эсэх, орон сууцны орц гарц, галын аюулгүй байдал, орчны газар, зам талбай, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбайн шаардлага хангагдсан эсэхэд дүгнэлт өгөх байдлаар маргааныг шийдвэрлэж байна.

2.2. Нийтийн эдэлбэр газартай холбогдох газрын маргааныг шийдвэрлэхэд үүсч буй зарим асуудал

ЗХХШТХ-ийн Хоёрдугаар бүлэгт зааснаар урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад нийтийн эдэлбэр газартай холбоотой маргааныг шийдвэрлэх боломжтой. Захиргааны хэргийн шүүхээс маргааныг хянан шийдвэрлэхдээ нэгэн адил захиргааны байгууллагаас нэр бүхий гомдол, хүсэлт гаргагчийн тухайн актын улмаас зөрчигдсөн аливаа эрх, хууль ёсны ашиг сонирхлыг онцолж анхаарах шаардлагагүй. Харин тус захирамж холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, захирамж гаргасан албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлсэн эсэх зэрэг илүү хяналтын маягийн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд нийтийн эдэлбэр газартай холбогдох маргааныг шийдвэрлэх боломжтой. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагын зүгээс нийтийн эдэлбэр газарт газар эзэмшүүлсэн нь хуульд нийцсэн эсэхийг шийдвэрлэх эрх хэмжээ нь шүүхийн хяналтаас илүү өргөн хүрээнд хэрэгжих боломжтой бөгөөд шүүхийн хяналт нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд л хязгаарлагдаж байна.

“Нийтийн эдэлбэр газрын маргаантай асуудлын талаар эрх ашиг нь зөрчигдсөн эсэхээс үл хамааран сонирхсон хэн боловч энэ талаар шүүхэд хандах эрхтэй” гэсэн агуулгаар хуульчлагдаагүй, шууд зохицуулалт хуульд тусгагдаагүй боловч тухайн “нэхэмжлэлийн үндэслэл”-ээс хамааран нийтийн эдэлбэр газрыг шүүхийн журмаар хамгаалж, түүнийг нийтээр ашиглах бололцоог бий болгож буй тохиолдол харьцангуй их байна. Тухайлбал, оршин суугчдын хууль тогтоомжоор

олгогдсон эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд тэдний итгэмжлэлээр, эсхүл СӨХ-ны нэхэмжлэлээр, мөн тухайлсан иргэн дангаар, эсхүл иргэд хамтарч нийтийн эдэлбэр газартай холбогдох асуудлаар нэхэмжлэл гаргаж байна. Гэвч нийтийн эдэлбэр газрын нэгдсэн бүртгэл байхгүй, нийтийн эдэлбэрийн тухай тодорхойлолт ойлгомжтой бус, хамрах хил хязгаарыг тодорхойлоогүй, нийтийн эдэлбэр газрын талаарх эрх зүйн зохицуулалт дутмаг, сонирхогч этгээд энэ төрлийн асуудлаар нэхэмжлэл гаргах, гаргасан нэхэмжлэл хангагдах боломж өнөөгийн нөхцөлд хязгаарлагдмал байна гэж үзэж болохоор байна.

Дүгнэлт

Судалгаанаас харахад, эрх зүйн зохицуулалтын хувьд урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад нийтийн эдэлбэрийн газрын маргааныг шийдвэрлэх боломж шүүхийн хяналтаас илүү хэрэгжих боломжтой болох нь харагдаж байна. Харин урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад шийдвэрлэгдээгүй, мөн ийм ажиллагаа хийгдэх боломжгүй тохиолдолд захиргааны хэргийн дагнасан шүүхийн чиг үүргийн хүрээнд нийтийн эдэлбэрийн газартай холбоотой асуудлыг шүүхийн хяналтад бүрэн утгаар нь оруулах, энэ талаарх маргааныг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай нь харагдаж байна.

Үүний тулд Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийтийн эдэлбэр газрын талаар тодорхой нарийвчлан тусгах, нийтийн эдэлбэрийн газрыг нийтээр, чөлөөтэй ашиглах, түүнд газар эзэмшүүлэх асуудлыг хуулиар хязгаарлах зохицуулалтыг илүү дэлгэрэнгүй, нарийвчлан тусгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа зөвхөн тухайн нэхэмжлэгчийн эрх ашиг зөрчигдсөн эсэхэд дүгнэлт гаргахаас гадна нийтийн эрх ашиг зөрчигдсөн эсэхэд дүгнэлт өгөх бололцоог эрх зүйн хувьд бодитоор бүрдүүлэх, процессын зохицуулалтыг илүү уян хатан тусгах хэрэгтэй.

Түүнчлэн тухайн актыг хянаж, хүчингүй болгох, илт хууль бус байдлыг тогтоох төдийхнөөр маргааныг дуусгавар болох бус харин нийтийн эдэлбэр газарт бусдад газар эзэмшүүлэх шийдвэр гаргасан албан тушаалтанд хууль бус шийдвэр гаргасантай холбогдуулж хүлээлгэх хариуцлагыг тодорхой, бодитой болгох шаардлагатай байна.

Нийтийн эдэлбэр газрын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Газрын тухай хуулиар нийтийн эдэлбэр газрын тухай нарийвчлан хуульчлах;
- Нийтийн эдэлбэр газрын зориулалтад орох газруудын эрх зүйн үндсийг бүрдүүлэх. Үүнд: амралт, зугаалга, биеийн тамирын талбай, цэцэрлэгт гудамж, цэвэршүүлэх талбай, явган хүний зам дагуух газрыг тодорхойлж, хэмжээ, зааг, зориулалт, нөхцөл, журмыг хуульчлан тогтоох;
- Нийтийн эдэлбэр газрыг бүртгэлжүүлэх, тэмдэгжүүлэх, гэрчилгээ олгох;
- Нийтийн эдэлбэр газрын талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй байлгах;

- Нийтийн эдэлбэр газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зориулалтын дагуу ашиглуулах бол дуудлага худалдаа, төслийн журмаар ил тод шийдвэрлэх, мэдээллэх, иргэдээс санал авах;
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийтийн эдэлбэр газрыг тогтоохдоо нийслэлийн өмчийн газраас гадна кадастрын зураглал, бүртгэлийн байгууллагаар заавал баталгаажуулах, эсхүл эдгээр байгууллагын тодорхойлолтыг үндэслэж тогтоодог байх;
- Нийтийн эдэлбэр газрын зориулалтыг өөрчлөхөөр бол Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан үндэслэл буюу улсын тусгай хэрэгцээг үндэслэж, шилжүүлж болохоор тодорхой хуульчлах;
- Нийтийн эдэлбэр газрыг бусдын ашиглалтад шилжүүлэх шийдвэр гаргасан Засаг даргын шийдвэрийг дээд шатны Засаг дарга заавал хянадаг байх, дээд шатны Засаг даргын дэргэд зөвлөл, хороо зэрэг институтийг мэргэжлийн байгууллагын удирдах ажилтны бүрэлдэхүүнтэй байгуулж, бүрэн эрхийг нь Газрын тухай хуулиар олгох;
- Нийтийн эдэлбэр газрын зориулалтыг хууль зөрчин шийдвэрлэсэн албан тушаалтан, хууль бусаар эзэмшиж, ашиглаж байгаа албан тушаалтан, иргэнд Газрын тухай хуулиар тодорхой хариуцлагыг хүлээлгэдэг байхаар хуульчлах. Торгох хариуцлагын мөнгөн дүнг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шалгуур болгох, хариуцлагыг ялгамжтай хүлээлгэхдээ газарт учруулсан хохирлын хэмжээг үндэслэн нөхөн олговрыг хүлээлгэдэг байх;
- Оюуны өмч, татвар зэрэгтэй адил нийтийн эдэлбэр газрын маргааныг хянан шийдвэрлэх тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

-оОо-

ШҮҮХ СУДЛАЛ



**ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ, ШҮҮГЧИЙН СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТ, ШҮҮХИЙН ЭДИЙН ЗАСАГТАЙ ХОЛБООТОЙ
ЗАРИМ ЛАВЛАГАА²⁴⁰**

**Нэг. Шүүхийн иргэдийн төлөөлөгч: Тайваний шүүхийн иргэдийн төлөөлөгчийн
тогтолцооны хэтийн төлөв**

Шүүхийн захиргааны удирдлага нь шүүхийн шинэчлэл, захиргааны удирдлага, зохион байгуулалтын стратегийг төлөвлөх, тайлагнах, бодлогын удирдамжаар хангах, шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоо, шүүхийн дотоод зохион байгуулалтыг боловсронгуй болгох, шүүхийн иргэдийн төлөөлөгч, эвлэрүүлэн зуучлалын зөвлөл, эвлэрүүлэн зуучлагчийг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах, хэргийн хөдөлгөөний нэгдсэн стандартыг тогтоож, энэ ажиллагаанд тавих хяналтыг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргүүдийн нийлбэр юм.

Шүүх нь төрийн бусад эрх мэдлийн бусад байгууллагуудын нөлөөлөл, хяналтаас ангид гагцхүү хууль тогтоогчийн баталсан хэм хэмжээ, үндсэн хуульт ёсны зарчимд үндэслэн аливаа эрх зүйн маргааныг шийдвэрлэх үүргийг ард түмний өмнө хүлээдэг. Шүүхийн үйл ажиллагаанд олон нийтийн хурц хараа, хяналтан дор ил тод байх зарчим үйлчилж байгаа ч улам бүр нээлттэй, хүртээмжтэй байх шаардлага онцгойлон тавигдсаар байна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо нь шүүх шударга ёсны үйлчилгээнийхээ үнэ цэнэ, ач холбогдлыг олон нийтэд таниулахын тулд тэдэнд ажлаа тайлагнах, ил тод үйл ажиллагаа бүхий шударга ёсны шалгуур болдог.

Монгол Улсын иргэн шүүх хуралдаанд оролцож, шүүгчтэй адил Монгол Улсын нэрийн өмнөөс хэрэг шийдвэрлэх, шүүн таслах эрхийг эдлэх боломжийг Иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар олгосон байдаг. Энэхүү хууль нь шүүхийн ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох зэрэг давуу талыг бий болгосон гэж үздэг. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2014 оны 01 тоот дүгнэлтээр Иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.4, 9 дүгээр зүйлийн 9.3, 12 дугаар зүйлийн гарчиг болон заалтад орсон "... шүүх бүрэлдэхүүнд ..." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн хэмээн үзэж, хүчингүй болгосноор иргэдийн төлөөлөгч дээрх эрхийг эдэлж чадахгүйд хүрсэн.

Шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцох ёстой, оролцох ёсгүй гэдэг дээр хуульч судлаач, эрдэмтдийн дунд маргаантай асуудал байсаар байна. Улмаар тус асуудлын хүрээнд гадаад улсын адил төстэй туршлагыг судалж, шүүх хуралдаан болон шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг хэрхэн оролцуулж, шүүхийн ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгодог талаар судлах нь чухал ач холбогдолтой

²⁴⁰ Тус лавлагааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ-ийн судлаач, хууль зүйн ухааны доктор Ц.Мандах /LL.D/ хийж гүйцэтгэсэн болно.

юм. Энэ удаа Тайваний шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцоо, хэтийн төлөвийг судалсныг тоймлон хүргүүлж байна.

Тайваньд өнгөрсөн олон арван жилийн хугацаанд хуульчийн шалгалтад тэнцсэн, хууль эрх зүйн мэргэжлийн сургалтад хамрагдсан мэргэжлийн шүүгч шүүн таслах эрхийг хэрэгжүүлж, зөвхөн шүүгч хэргийг хянан шийдвэрлэдэг. Гэвч иргэд хууль, шүүхийн байгууллагын талаарх мэдлэг дутмаг байдгаас тэдний шүүхэд итгэх итгэл нь төдийлөн сайн биш, шүүн таслах ажиллагааны үйл явцыг буруу ойлгох үзэгдэл гарсаар байна.

Тайваньд иргэд шүүн таслах ажиллагаанд оролцож, шүүхийн шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцох нь Тайваний Үндсэн хуульд Шүүгч нь хуулийн дагуу бие дааж шүүн таслах эрхтэй байж, хэн ч хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно²⁴¹ гэж заасныг зөрчих тул Тайваний Шүүх яам /*The Judicial Yuan*-аас 1988 оноос эхлэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд ардын төлөөллийг оролцуулах тухай судалж, улмаар энэ чиглэлээр хэрэгжүүлэх хэд хэдэн журмын төслийг боловсруулсан. Үүнд “Эрүүгийн хэрэгт шүүн таслах ажиллагаанд оролцуулах тухай туршилтын журам” (1988 оноос 1998 он хүртэл), “Мэргэжилтнийг шүүн таслах ажиллагаанд оролцуулах тухай туршилтын журам” (2000 оноос - 2006 он хүртэл) орно. Эдгээр төслүүд нь тодорхой ялгаатай хэдий ч хэрхэн иргэдийг хэрхэн мэргэжлийн шүүгчтэй хамтран шүүн таслах ажиллагаанд оролцох, тухайн гэмт хэргийн нотлох баримтыг дүгнэх, хууль, ялын төрөл, хэм хэмжээ зэргийг хэрэглэх талаарх үзэл санаа, зорилгоороо адил болно.²⁴²

Шүүх яам /*The Judicial Yuan*-аас хамгийн сүүлд 2012 оны 1 дүгээр сард “Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааныг ажиглах тухай журам”-ын төслийг Гүйцэтгэх яаманд /*The Executive Yuan*/ өргөн барьсан. Энэхүү “ажиглагч-иргэдийн төлөөлөгч” хуулийн төсөл нь туршилтын хөтөлбөрт хамаарах бөгөөд үүнийг Гүйцэтгэх яамнаас 5 дугаар сард хүлээн зөвшөөрч, одоогоор хууль тогтоох яам /*The Legislative Yuan*-д хэлэлцэгдэн хянагдаж байна. Тус акт батлагдвал туршилтын хөтөлбөр нь Тайваний 21 районы шүүхүүд /*district courts*/ дотроос өмнөд Тайваний Чиаи районы шүүх болон Тайбэй хотын Шилин районы шүүхэд гурван жилийн хугацаатай хэрэгжинэ.²⁴³ (*тус шүүхийн загварчилсан зургийг жишээ болгож Зураг 1-д үзүүлэв*)

²⁴¹ Тайваний Үндсэн хуулийн 80 дугаар зүйл.

²⁴² <http://www.judicial.gov.tw/Guan-Shen/intro01.asp> (2014-11-17)

²⁴³ <http://taiwanreview.nat.gov.tw/ct.asp?xItem=194416&CtNode=1446> (2014-11-18)

Зураг 1 Тайбэй хотын Шилин районы шүүхийн загварчилсан танхим



Тайваний одоогийн шүүхийн тогтолцоогоор хүнд гэмт хэргийг гурван районы шүүгчид хамтран хэлэлцдэг ба “хөндлөнгийн шүүгч”-ийн журмаар яллагч (прокурор) болон өмгөөлөгчийн гаргасан тайлбар, хууль зүйн асуултуудыг анхааралтайгаар хэлэлцдэг байна. Хэрэв яллагдагч гэм буруутай нь тогтоогдвол шүүгч ялын хэмжээг тогтоодог.

Энэхүү туршилтын хөтөлбөрөөр, таван иргэдийн төлөөлөгч нь ажиглагчаар долоон жил буюу түүнээс дээш хугацаагаар шоронд хорих эсвэл цаазаар авах ял оногдуулах хүнд гэмт хэрэгт хамаарах хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгчидтэй хамт сууж хэлэлцэнэ. Иргэдийн төлөөлөгчид нь 23 ба түүнээс дээш настай сугалаагаар сонгогдсон иргэдээс бүрдэнэ. Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд шүүгчтэй хамт зөвлөлдөх, яллагдагч, гэрч, хохирогчоос асуулт асуухыг зөвшөөрдөг. Яллагч болон өмгөөлөгчийн мэтгэлцээн, гэрч шүүх хуралдаанд оролцох, хохирогч мэдүүлэг өгөх зэрэг аливаа шүүх хуралдааны явцыг иргэдийн төлөөлөгч нь ажиглаж, шийдвэр гаргах хэлэлцүүлгийн үед хэргийг сайтар нягталж судалсны үндсэн дээр яллагдагчийг гэм буруутай эсэх талаар мөн ямар ял оногдуулах тухай саналаа өгнө. Иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэрийг шүүгч харгалзан үзэж болно. Гэхдээ тухайн хэрэгт ял оногдуулах эсэх болон эцсийн шийдвэр гаргах эрх нь шүүгчид хадгалагдана. Хэрэв шүүгч иргэдийн төлөөлөгчдийн шийдвэрийг эс зөвшөөрвөл, тайлбараа амаар болон бичгээр гаргана.²⁴⁴

Энэ тогтолцооны зорилго нь шүүх хуралдаан болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн ажиглагч-иргэдийн төлөөлөгч биечлэн оролцож, тухайн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, улмаар хэргийн нотлох баримтыг үнэлэх, хууль хэрэглэх, ялын хэмжээг тогтоох зэрэг ажиллагааны талаар цогц ойлголттой болгоход оршино. Түүнчлэн шүүгч ажиглагч-иргэдийн төлөөлөгчийн зүгээс гаргасан олон хувилбарт саналыг харгалзан үзэж, хуулийн зорилгод тулгуурласан, ард иргэдийн хууль зүйн сэтгэлгээнд илүү тохирсон шийдвэр гаргах боломжтой юм.²⁴⁵

²⁴⁴ <http://taiwanreview.nat.gov.tw/ct.asp?xItem=194416&CtNode=1446> (2014-11-18)

²⁴⁵ http://www.rmjcw.cn/gtfz/201203/t20120314_825595.html (2014-11-18)

Энэ тогтолцоо нь дэлхийн улс орны хууль эрх зүйн хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзсэний үндсэн дээр Тайваний одоогийн эрх зүйн тогтолцоон дээр тулгуурлан судалж, нэвтрүүлсэн энгийн ард иргэдийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжийг хангаж, түүнчлэн Тайваний Үндсэн хуульд үл харшлах тогтолцоо юм.²⁴⁶

Тайваний Шүүх яам /*Judicial Yuan*/-аас дэвшүүлсэн шүүх хуралдааныг ажиглах тогтолцоо нь тодорхой шалгуур, журмаар иргэдийн төлөөлөгчийг ард иргэдийн дундаас сонгон шүүх хуралдааныг ажиглуулахаар томилдог тогтолцоо юм. Тус ажиглагч хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд эхнээс нь дуустал оролцдог ба шүүгчийг шийдвэрээ гаргахад нь таслах эрхтэй оролцдоггүй хэдий ч шүүгч шийдвэрээ гаргахад нь харгалзан үзэж болох саналыг дэвшүүлдэг. Шүүгч саналыг харгалзан үзэхдээ:²⁴⁷

1. Энгийн ард иргэдийг шүүх хуралдаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах бололцоогоор хангадаг байх,
2. Энгийн ард иргэдийг шүүх хуралдааны шийдвэр гаргах явцад саналаа илэрхийлж, тухайн саналыг шүүгч шийдвэрээ гаргахад харгалзан үздэг байх зорилготой юм.

Тайваньд Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааныг ажиглах тогтолцоог тодорхойлохдоо дараах 3 төрлийн онцлогийг тодотгосон: нэгдүгээрт, шүүхийн ил тод байдлыг дээшлүүлж, ард иргэд шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг байх; хоёрдугаарт, шүүх хуралдаан олон төлөөллөөс бүрдсэн байх тул шүүхийн шийдвэр иргэдийн хүсэл зоригт илүү ойр байх; гуравдугаарт, хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлж, иргэдийн шүүхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зэрэг болно.

2012 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр өргөн барьсан нийт 81 зүйл бүхий “Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааныг ажиглах тухай журам”-ын төсөл нь дараах агуулгатай байна.²⁴⁸ Үүнд:

1. Энгийн иргэдээс ажиглагч-иргэдийн төлөөлөгчийг сонгох бөгөөд үүнд 23 нас хүрсэн, тухайн шүүхийн нутаг дэвсгэрийн харьяанд 4 сараас дээш хугацаагаар оршин суусан, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн ажиглагч-иргэдийн төлөөлөгчөөр эсвэл ажиглагч-иргэдийн төлөөлөгчийн нөөцөд орохоор сонгогдож болно. Тус ажиглагч-иргэдийн төлөөлөгч нь тухайн хэргийн талаарх нууцыг хадгалах, шүүх хуралдаанд ирэх тухай тангараг өргөх үүрэгтэй байдаг.
2. Зарчмын хувьд иргэдийн төлөөлөгч зөвхөн хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг ажиглана. Иргэдийн төлөөлөгчийн шүүх хуралдааныг ажиглах хөтөлбөр нь эхлэл төдий тул ач холбогдол, зардал зэргийг харгалзан үзэхдээ ажиглагч-иргэдийн төлөөлөгчийг гагцхүү хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд ажиллуулахаар болсон байна.
3. Ажиглагч-иргэдийн төлөөлөгчтэй шүүх хуралдаан 3 мэргэжлийн шүүгч болон 5 иргэдийн төлөөлөгчөөс бүрдэнэ. Энэ загвар нь Япон улстай адилхан ба ажиглагч-иргэдийн төлөөлөгч нь шүүгчидтэй хамт суудаг байна. Ийнхүү шүүгч нь иргэдийн


²⁴⁶ <http://www.judicial.gov.tw/Guan-Shen/intro01.asp> (2014-11-18)

²⁴⁷ <http://www.judicial.gov.tw/Guan-Shen/intro01.asp> (2014-11-18)

²⁴⁸ http://www.rmjcw.cn/qtfz/201203/t20120314_825595.html (2014-11-19)

төлөөлөгчтэй хамт сууснаар илүү нягт хамтарч, гэмт хэргийн нотлох баримтыг үнэлэх, хууль хэрэглэх болон ялын хэмжээг тогтоох зэрэг ажиллагааг явуулснаар иргэдтэй илүү ойр гэдгээ харуулдаг. Шүүхээс шаардлагатай тохиолдолд 1-ээс 4 хүртэлх ажиглагч-иргэдийн төлөөлөгчийг сонгон нөөцөд оруулдаг.

Зураг 2 Ажиглагч Иргэдийн төлөөлөгчтэй шүүх хуралдааны загварчилсан танхим



4. Ажиглагч-иргэдийн төлөөлөгч нь зөвхөн шүүх хуралдаанд оролцдог ба шүүх хуралдааны бэлтгэл ажилд оролцдоггүй. Учир нь ажиглагч-иргэдийн төлөөлөгчийг энгийн иргэдээс сонгодог тул цаг завьг нь харгалзан үзэж, зөвхөн шүүх хуралдаанд оролцохыг шаарддаг.
5. Шүүх нь хүсэлтийн дагуу эсхүл эрхийнхээ хүрээнд ажиглагч-иргэдийн төлөөлөгч оролцох ёстой шүүх хуралдааныг иргэдийн төлөөлөгчгүйгээр явуулж болно. Иргэдийн төлөөлөгч нь хэргийн зохигчтой ямар нэг холбоотой, ашиг сонирхлын зөрчилтэй байх, түүнчлэн тухайн хэрэг ээдрээ төвөгтэй, олон төрлийн нарийн мэргэжлийн мэдлэг шаардсан зэрэг шалтгаанаар шүүх иргэдийн төлөөлөгчтэй шүүх хуралдааныг явуулахад тохиромжгүй гэж үзвэл шүүх хуралдааныг иргэдийн төлөөлөгчгүйгээр явуулж болно.
6. Шүүх хуралдаан дууссаны дараа ажиглагч-иргэдийн төлөөлөгч зөвхөн саналаа илэрхийлэх эрхтэй ба эцсийн шийдвэр гаргахад санал өгөх эрх эдэлдэггүй. Иргэдийн төлөөлөгчдийн олонхийн саналтай шүүгчийн санал зөрсөн тохиолдолд шүүгч шийдвэртээ тайлбар бичнэ. Шүүгч санал зөрсөн тохиолдолд татгалзсан

үндэслэл болон тайлбараа тодорхой бичих шаардлагатай тул иргэдийн төлөөлөгчийн саналыг тодорхой хэмжээгээр харгалзан үзэх боломж бүрэлддэг.

7. Энэ хөтөлбөр нь одоогоор туршилтын хэлбэрээр явагдаж байгаа ба тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөтөлбөрийн давуу болон сөрөг талыг тодорхойлох боломж бүрдэх юм. Тус хөтөлбөрийг туршилтын журмаар хэрэгжүүлэх 2 шүүхийг сонгохдоо нэг шүүхийг хүн ам ихээр суурьшсан томоохон хотын анхан шатны районы шүүхээс, нөгөө нэг шүүхийг орон нутгийн төвийн анхан шатны районы шүүхээс сонгохоор болсон байна.

Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааныг ажиглах тогтолцоог туршилтын журмаар нэвтрүүлснээр энгийн иргэд шүүн таслах ажиллагаанд оролцож, саналаа илэрхийлэх эрхийг эдлэх юм. Хэрэв шүүгч нь иргэдийн саналыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзвэл, тус саналд нь хүндэтгэлтэй хандаж, шийдвэртээ тусгадаг ба санал зөрсөн тохиолдолд Үндсэн хуульд тусгасан зарчмын дагуу бие дааж хэргийг шийдвэрлэдэг. Энэ тогтолцоо нь мэргэжлийн бус шүүгчийг шүүх хуралдаанд оролцуулснаас үүсэх үл итгэлцэл, Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчинө гэсэн хардлагаас сэргийлж байдгаараа онцлогтой.

Хоёр. Шүүгчийн сонгон шалгаруулалт: Шүүгчийн сонгон шалгаруулалтад жендэрийн харьцааг харгалздаг олон улсын туршлага

Хуульчдаас шүүгчийг шилж, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх чиг үүргийг шүүхийн хүний нөөцийн удирдлага хэрэгжүүлдэг тул энэ хүрээнд гадаад улс орнуудын, тэр дундаа олон улсын эрх зүйд шүүгчийг сонгон шалгаруулахдаа жендэрийн харьцааг хэрхэн харгалзан үздэг талаар олон улсын туршлагаас энэ удаа судлан тоймлон хүргүүлж байна.

Нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрхэлж буй ажил, тэдний нийгмийн баялаг, нөөцөөс хүртэх боломж, нөөцийг хянах ба шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоо харилцан адилгүй бөгөөд цаг хугацааны явцад өөрчлөгдөж, улс орон бүрт харилцан адилгүй илэрхийлэгдэж байна. Ажил хөдөлмөр дэх жендэрийн хуваарилалт нь мөн адил харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны явцад өөрчлөгдсөөр байдаг. Харин шүүх бүрэлдэхүүнд шүүгчийн жендэрийн харьцааг харгалзаж үзэх тал дээр олон улсын хамтын нийгэмлэгээс онцгойлон анхаарч, энэ асуудлыг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгуулж ирсэн ба улс орнуудад энэ талаар уриалан, тодорхой зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Олон улсын шүүхүүдийн шүүгчийн томилгоонд жендэрийн харьцааг харгалзан үзэх асуудлаар, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гишүүн улсуудад хандан “Олон Улсын Шүүх болон төрөлжсөн шүүхийн шүүгч болон бусад удирдах албан тушаалтнуудыг томилох, сонгоход эмэгтэй нэр дэвшигчдийг олноор нь тодорхойлох буюу нэр дэвшүүлэхийг илүүтэйгээр дэмжих болно” гэж онцолсон байна.²⁴⁹ Түүнчлэн НҮБ-ын систем дотор хүйсийн харьцааг 50/50 хувьд хүргэх зорилго тавих, зорилгодоо хүрэх алхмуудыг нарийвчилж тодорхой болгох, тусгай арга хэмжээ авах, бодлогын

²⁴⁹ UN General Assembly resolution, Improvement of the status of women in the United Nations system, UN Doc. A/RES/56/127, 30 January 2002.

түвшинд гаргаж ирэх зэрэг зорилтыг тавьсан байна.²⁵⁰ Үүний дээр, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс гишүүн орнуудад хандан олон улсын байгууллагад урьдчилан сэргийлэх механизм, менежмент болон зөрчил шийдвэрлэх асуудлаар бүх шийдвэр гаргах төвшний эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, жендэрийн тэгш харьцааг хангахыг уриалсан байна.²⁵¹

• **Олон Улсын Эрүүгийн Шүүх болон бусад олон улсын төрөлжсөн шүүхийн шүүгчийг сонгон шалгаруулахад жендэрийн харьцааг харгалзаж үзэх нь**

Олон Улсын Эрүүгийн Шүүх /цаашид ОУЭШ гэх/ нь шүүгчийг сонгон шалгаруулах буюу нэр дэвшүүлэхдээ хүйсийн харьцааны тэгш байдлыг харгалзан үзэж хангадаг томоохон үлгэр жишээ болохуйц байгууллага юм. ОУЭШ-ийн Ромын дүрмийн 36 дугаар зүйлд “Шүүгчдэд тавих шаардлага, шүүгчдийг нэр дэвшүүлэх ба сонгох” гэсэн заалт байдаг ба тус дүрмийн 36 дугаар зүйлийн 36.8.(а)-д “Оролцогч улсууд шүүгчдийг сонгохдоо шүүхийн гишүүдийн бүрэлдэхүүнд дараах нөхцөл хангагдсан байх шаардлагыг анхаарна. Үүнд, шүүхийн бүрэлдэхүүнд эрэгтэй, эмэгтэй шүүгчийн шударга төлөөллийг оруулна” гэж заасан. Эрэгтэй, эмэгтэй шүүгчийн хүйсийн төлөөлөл шударга байх гэдэг нь яг тэнцүү гэсэн ойлголт биш харин хамгийн багаар тэнцүүлэх гэсэн утга санааг илэрхийлнэ. Шүүх тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарч шаардлагатай гэж үзвэл шүүгчийн төлөөллийг өөрчлөн тогтоож болдог. ²⁵²

ОУЭШ-ээс 2014 оны 01 сарын 24-ний өдөр 6 сул орон тоонд шүүгчийн нээлттэй сонгон шалгаруулалт зарласан бөгөөд энэ нь ОУЭШ-ийн Ромын дүрмийн 36 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулахыг онцолсон байна. ²⁵³ Тус сонгон шалгаруулалтын Хавсралт 1-ийн Б хэсэгт шүүгчийн сонгон шалгаруулалтыг нарийвчлан тусгасан ба 19 дүгээр зүйлд: “Нэр дэвшигчдээс шүүгчийг сонгон шалгаруулахдаа эрэгтэй, эмэгтэй шүүгчийн шударга төлөөлөл, газар зүйн байршлын шударга төлөөлөл, дэлхийн эрх зүйн тогтолцоо тус бүрээс шударга төлөөллийг оруулах тухай заасан байна.²⁵⁴ Түүнчлэн Хавсралт 4-т нэр дэвшигчдийн жагсаалтыг хүйсийн харьцаагаар ангилж гаргасан бөгөөд үүнд нэр дэвшигчдийн 12 нь эрэгтэй, 5 нь эмэгтэй байна.²⁵⁵ Одоогийн байдлаар ОУЭШ-д ажиллаж байгаа 17 шүүгчийн 10 нь эмэгтэй, 7 нь эрэгтэй шүүгч байна.²⁵⁶

Ромын дүрэмд заасан эрэгтэй, эмэгтэй шүүгчийн төлөөлөл шударга байх тухай шаардлага нь олон улсын төвшинд тархан дэлгэрч байна. Тухайлбал, Бээжингийн тунхаглалд улс орны засгийн газар болон олон улсын байгууллагуудад хандан уриалахдаа, “Олон улсын байгууллага, тухайлбал Хуучин Югославын асуудлаарх олон улсын эрүүгийн хэргийн шүүх /цаашид Хуучин Югославын шүүх гэх/

²⁵⁰ UN General Assembly resolution, Improvement of the status of women in the United Nations system, UN Doc. A/RES/55/69, 8 February 2001.

²⁵¹ Security Council Resolution 1325(2000), 31 October 2000.

²⁵² http://www.pict-pcti.org/publications/ICC_paprs/election.pdf (2014-09-19)

²⁵³ Эцсийн сонгон шалгаруулалт нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 30 дугаар хуралдааны үеэр буюу 2014 оны 12 сарын 8-аас 17-ны хооронд Нью-Йорк хотод байрлах НҮБ-ын төв байран дээр зохион байгуулахаар болсон.

²⁵⁴ Annex I. Procedure for the nomination and election of judges, the Prosecutor and Deputy Prosecutors of the International Criminal Court.

²⁵⁵ http://www.icc-cpi.int/iccdocs/asp_docs/ASP13/ICC-ASP-13-3-ENG.pdf (2014-10-17)

²⁵⁶ <http://www.icc-cpi.int/> ICC » Structure of the Court » Chambers » The Judges

Руандагийн олон улсын эрүүгийн шүүх, ОУЭШ-ийн шүүгчийн албан тушаал болон шүүхийн бусад албан тушаалд нэр дэвшүүлэх эсхүл дэмжихэд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгыг баримтлахыг онцолсон байна”.²⁵⁷

ОУЭШ-ээс гадна хоёр ч олон улсын төрөлжсөн шүүхээс шүүгчийг сонгон шалгаруулах болон нэр дэвшүүлэх үйл ажиллагаанд хүйсийн тэгш харьцааг харгалзахыг зорьж байна. Тухайлбал, Африкийн хүний болон иргэний эрхийн шүүх, Хуучин Югославын шүүхийг дурдаж болно.²⁵⁸ Энэ нь Хуучин Югославын шүүх, Руандагийн олон улсын эрүүгийн шүүхээс хуримталсан туршлага болон ОУЭШ-ийн шүүхийн харьяаллын дагуу гэмт хэргүүдээс улбаатай юм.²⁵⁹ Тухайлбал, Руандагийн олон улсын эрүүгийн шүүхийн шүүгч Пиллай /Pillay/ нь Акаесүгийн хэрэгт /Akayesu case/ эмэгтэй шүүгч бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийг шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо жендэрийн мэдрэмжтэй ханддагийг батлан харуулсан байна.²⁶⁰ Хуучин Югославын шүүхийн **Ad litem** шүүгчид дөрвөн нэр дэвшигч байх ёстой бөгөөд үүнээс гадна “Эрэгтэй, эмэгтэй нэр дэвшигчдийн шударга төлөөлөл байх нь маш чухал үзүүлэлт” гэж заасан.²⁶¹

Түүнчлэн Африкийн хүний болон иргэний эрхийн шүүх нь Ромын дүрэмтэй төстэй байдлаар өөрийн нэмэлт протоколыг боловсруулсан ба үүнд дараах байдлаар хүйсийн тэгш харьцааг тусгажээ. Тус протоколын 12 дугаар зүйлийн 12.2-т “шүүгчийг нэр дэвшүүлэх явцад эрэгтэй, эмэгтэй хүйсийн зохистой харьцааг харгалзан үзэх”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “шүүгчийг сонгон шалгаруулах явцад Ассамблейгаас эрэгтэй, эмэгтэй хүйсийн зохистой төлөөлөл байх ёстой” гэж тус тус заажээ.²⁶² Энэ протоколын үзэл санаанд тулгуурлан, Африкийн хүний болон иргэний эрхийн шүүхийн дүрмийн 13 дугаар зүйлд Шүүхийн оролцогч улсууд хамгийн боломжит хэмжээгээр хүйсийн тэнцвэртэй төлөөллийг хангах чиглэлээр боломжит бодлогыг явуулна гэж тусгасан.²⁶³ Эрэгтэй, эмэгтэй шүүгчийн шударга төлөөлөл байх шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх асуудал байсаар байгаа бөгөөд олон улсын төрөлжсөн шүүхүүд газар зүйн байрлалын төлөөлөл тэнцвэртэй байх буюу бүс нутаг бүрээр суудлыг хуваарилах зарчмыг хэрэгжүүлэхийг шаарддаг байна. Үүний нэгэн адил эрэгтэй, эмэгтэй шүүгчийн шударга төлөөллийг хангахыг шаарддаг байна.²⁶⁴

- **Европын Хүний эрхийн шүүхийн шүүгчийг сонгон шалгаруулахад жендэрийн харьцааг харгалзан үзэх нь**

²⁵⁷ Report of the fourth world conference on women, Beijing 4-15 September 1995, UN.Doc. A/CONF.177/20, 17 October 1995, para. 142(b) <http://www.un.org/esa/gopher-data/conf/fwcw/off/a--20.en> (2014-10-21)

²⁵⁸ Thordis INGADOTTIR, THE INTERNATIONAL CRIMINAL COURT NOMINATION AND ELECTION OF JUDGES, ICC Discussion Paper #4, 2002. p.18.

²⁵⁹ Cate Steains, Gender Issues, in the International Criminal Court, the Making of the Rome Statute: Issues, Negotiations, Results (Roy S. Lee ed., 1999), pp. 376-377.

²⁶⁰ http://www.pict-pcti.org/publications/ICC_paprs/election.pdf (2014-10-22)

²⁶¹ Security Council Resolution 1329(2000), 30 November 2000, and article 13 of the ICTY Statute.

²⁶² <http://www.achpr.org/instruments/court-establishment/> (2014-10-18)

²⁶³ AFRICAN COURT ON HUMAN AND PEOPLES' RIGHTS, RULES OF COURT http://www.african-court.org/en/images/documents/Court/Interim%20Rules%20of%20Court/Final_Rules_of_Court_for_Publicatio_n_after_Harmonization_-_Final_English_7_sept_1_.pdf (2014-10-19)

²⁶⁴ Thordis INGADOTTIR, THE INTERNATIONAL CRIMINAL COURT NOMINATION AND ELECTION OF JUDGES, ICC Discussion Paper #4, 2002.p.18.

Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей нь Европын Хүний эрхийн шүүхийн шүүгчдийг сонгодог. Европын Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Конвенц /Хүний эрхийн Европын Конвенц/-ийн дагуу шүүгчид нь “өндөр ёс суртахуунтай байх, шүүхийн өндөр албан тушаалд томилогдох ур чадварыг эзэмшсэн байх эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн хуульч байх” ёстой.²⁶⁵ Эдгээр шаардлагыг хангахын тулд конвенцийн оролцогч улсын шүүгчид нэр дэвшигч дараах хоёр үе шаттайгаар сонгон шалгаруулалтад оролцоно. Нэгдүгээрт, оролцогч улсын үндэсний сонгон шалгаруулах журмаар шүүгчийн 3 нэр дэвшигчийг шалгаруулна. Хоёрдугаарт, Европын Зөвлөлийн Парламентын Ассамблейгаас явуулах сонгуульд парламентын гишүүд нэг нэр дэвшигчийг сонгож, шүүгчээр томилохоос өмнө 3 нэр дэвшигчийн ур чадварт үнэлгээ өгнө. Нэр дэвшигчдийн жендэрийн харьцааг хангах асуудлыг үндэсний сонгон шалгаруулалтын үед харгалзаж үзэх бөгөөд ба тухайн оролцогч улс хамгийн багадаа нэг нэр дэвшигчийг “бага төлөөллийн хүйс” буюу Европын Хүний эрхийн шүүхийн шүүгчийн дунд хүйсийн харьцаагаараа бага байгаа хүйсийн төлөөллийн нэр дэвшигчийг сонгож, дэвшүүлдэг байна.

2004 оны 01 дүгээр сард Европын Зөвлөлийн Парламентын Ассамблейгаас 1366 дугаар шийдвэр (2004) болон 1649 дүгээр зөвлөмж (2004)-ийг тус тус баталсан. Эдгээр баримт бичигт нэгэнт тогтсон шүүгчийн сонгон шалгаруулалтыг хэвээр хадгалах, шүүгчийн эрхийг хэрэгжүүлэх шалгуурыг хангасан болон хүйсийн тэнцвэртэй харьцааг хангасан нэр дэвшигчийг хүлээн авах тухай заасан байна. Эдгээр шаардлагыг хангаагүй нэр дэвшигчийн нэрсийг авч хэлэлцэхгүй гэж шийдвэрлэсэн байна. 2004 оны 1366 дугаар шийдвэрт 2005, 2008 онд тус тус өөрчлөлт оруулж, нэг нэр дэвшигчийн хүйс нь “бага төлөөллийн хүйс” буюу нийт шүүгчийн 40 хувиас бага байдаг хүйс бүхий нэр дэвшигч бол тухайн нэр дэвшигчийг хүлээн авахаар болсон байна. Үүний дээр энэ дүрмийн үйлчлэлийг бууруулах онцгой нөхцөл бий болсон тохиолдолд тухайн нэр дэвшигчийг хүлээн авна.²⁶⁶ Онцгой нөхцөл гэж тухайн конвенцийн оролцогч улс “бага төлөөллийн хүйс”-ийн нэр дэвшигчийг нэр дэвшүүлэх талаар шаардлагатай бүхий л арга хэмжээ авсан хэдий ч шаардлага хангах тухайн хүйсийн төлөөлөл болох нэр дэвшигч олдоогүй тохиолдлыг хэлнэ.²⁶⁷ Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд одоогийн байдлаар Европын Хүний эрхийн шүүхийн нийт шүүгчийн 40 хувь нь эмэгтэй шүүгч байна.²⁶⁸

• **Гадаадын зарим улс орнуудын үндэсний шүүхийн шүүгчийн жендэрийн харьцаа**

Европын болон бусад зарим улсын шүүхийн мэргэжлийн шүүгчийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцааг 2012 оны байдлаар хүснэгт 1-д харуулав. Тус хүснэгтээс харахад, дунджаар нийт шүүгчийн 50.7% нь эрэгтэй, 49.3% нь эмэгтэй байгаа нь ерөнхийдөө эрэгтэй, эмэгтэй шүүгчийн харьцаа улсуудын хувьд харьцангуй тэнцвэртэй байгааг харуулж байна. Эдгээр улсаас 17 улсын хувьд эрэгтэй, эмэгтэй шүүгчийн хүйсийн харьцаа 40/60 байх нь зохистой хэмжээнд нийцсэн байна. Харин

²⁶⁵ <http://website-pace.net/web/as-jur/echr-judges-election> (2014-10-20)

²⁶⁶ http://assembly.coe.int/CommitteeDocs/2010/20100504_ajdoc12rev.pdf (2014-10-25)

²⁶⁷ <http://assembly.coe.int/Mainf.asp?link=/Documents/AdoptedText/ta08/ERES1627.htm> (2014-10-25)

²⁶⁸ <http://website-pace.net/web/as-jur/echr-judges-election> (2014-10-25)


21 улсын нийт шүүгчийн 50-аас илүү хувь нь эмэгтэй шүүгчид байгаа бол зарим улсын хувьд, жишээ нь Словени, Латви, Румын зэрэг улсад 70 гаруй хувь нь эмэгтэй шүүгч байна. Үүнтэй эсрэгээр 20 улсын хувьд 50 гаруй хувь нь эрэгтэй шүүгч байдаг ба үүний дотор 6 улсын хувьд 70 гаруй хувийг нь эрэгтэй шүүгч эзэлж байна.²⁶⁹

Хүснэгт 1

*Зарим улс орны шүүхийн шүүгчийн жендэрийн харьцаа
(2012 оны байдлаар)*



²⁶⁹ http://www.coe.int/t/dghl/cooperation/cepej/evaluation/2014/synthese2014_en.pdf (2014-10-27)



Гурав. Шүүхийн төсөв: Шүүхийн төсвийг боловсруулж, батлуулж байгаа гадаад орны туршлага

Шүүгчийн эдийн засгийн баталгаа нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах гол нөхцөл болдог. Шүүх бие даасан, шүүгч хараат бусаар ажиллах нөхцөл, боломжоор хангагдсан байх нь шударга ёс, хуулийн засаглалыг бэхжүүлэх төдийгүй хүний эрх, эрх чөлөөний тулгуур зарчмуудыг хэрэгжүүлэх үндэс суурь юм. Шүүхийн эдийн засгийн бие даасан байдлыг хангахын тулд зарим улсад шүүхийн төсвийг улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгож, түүний хэмжээг тодорхойлох хандлага байдаг. Энэ нь нэг талаар шүүхийг бусад эрх мэдлээс хараат бус байлгах, шүүх чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгийг бэхжүүлэх зорилготой юм. Шүүхийн төсвийг боловсруулах, батлах талаар гадаад улс орны туршлагыг судалж, Монгол Улсын хууль тогтоомжид нарийвчлан зохицуулж оруулах шаардлага байгаа тул энэ удаа шүүхийн төсвийг хэрхэн боловсруулж, аль субъект өргөн барьж батлуулж байгаа талаар гадаадын зарим улсын туршлагаас судалсныг тоймлон хүргүүлж байна.

Шүүхийн төсвийг батлах тусгай процесс байдаг ба төсвийн төслийг төлөвлөх, санал болгох эрхийг Ерөнхий шүүгчийн ажлын алба, шүүхийн зөвлөл, засгийн газрын мэргэшсэн агентлаг, гүйцэтгэх засаглалын сайд нь бие даан боловсруулдаг загвар байдаг бол шүүх нь өөрөө парламентад шууд өргөн мэдүүлдэг процесс ч бас байдаг байна.²⁷⁰ Түүнчлэн өргөн барьсан шүүхийн төсвийн төслийг гүйцэтгэх эрх мэдлээр дамжуулж өргөн барихдаа гүйцэтгэх эрх мэдлээс шүүхийн төсвийг бууруулахгүй байх зарчмыг зарим орон баримталдаг байна. Шүүхийн төсвийг хэрхэн боловсруулж, батлуулж байгаа гадаадын зарим орны туршлагаас судалсныг танилцуулж байна.

1. АНУ:

АНУ-д Төсөв болон нягтлан бодох бүртгэлийн тухай хууль */Budget and Accounting Act of 1921/*, Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтад хяналт тавих тухай хууль */Congressional Budget and Impoundment Control Act of 1974/* болон бусад төсвийн хууль тогтоомжоор шүүхийн төсвийг зохицуулдаг.

Төсөв болон нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу Ерөнхийлөгчийн улам бүр нэмэгдэх болсон нөлөөллөөс болгоомжилж, Конгресс тус хуульд томоохон өөрчлөлт оруулахыг зорьсон. Учир нь 1921 оны хуулийн дагуу байгуулагдсан Төсвийн товчоо нь (хожим нь, 1971 онд Удирдлага болон төсвийн алба */Office of Management and Budget/* нэртэй болсон) төсвийн талаарх мэдээллийг Ерөнхийлөгчид бэлтгэн хүргүүлдэг ба энэ нь Ерөнхийлөгчид улсын төсвийн талаарх мэдээллийг “өмчлөх, хянах” бололцоог олгож байв. Харин Конгресст төсөв, эдийн засгийн мэдээллийг нэгтгэн боловсруулдаг, засгийн газраас хараат бус, бие даасан судалгаа шинжилгээ хийдэг, засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөлд төвийг сахисан, үнэн бодит, шинжлэх ухааны үндэслэлтэй дүн шинжилгээ хийдэг, Конгрессын гишүүд болон байнгын хороодод төсөвтэй холбоотой шаардлагатай бусад мэдээ мэдээллийг гаргаж өгдөг байгууллага үгүйлэгдэж байв. Тухайн үед Конгрессын гишүүд Ерөнхийлөгч асан Ричард Никсоныг төсвийн нөөц хөрөнгийг Конгрессоос баталсан

²⁷⁰ A.Seibert (ed), *Judicial Independence in Transition*, Springer press, 2012. p.57.

төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулахад хойрго хандаж байгааг буруушааж байв. Түүнчлэн зарим гишүүд гүйцэтгэх засаглалын боловсруулж, Конгрессод оруулж ирсэн төсвийн тухай мэдээллийг үнэн зөв гэдэгт эргэлзэж байгаага ч илэрхийлж байсан. Эдгээр болон бусад шалтгаанаар 1974 онд Конгрессын төсөв болон төсвийн зарцуулалтад хяналт тавих тухай хуулийг баталжээ. Тус хуулиар Ерөнхийлөгчийн төсөв хөрөнгийг захиран зарцуулахад хяналт тавих шинэ процедурыг хуульчилж өгсөн. Тус хуулиар Ерөнхийлөгчөөс хамаарахгүйгээр Конгресс шаардлагатай гэж үзэж байгаа төсвийн тэргүүлэх чиглэлийг өөрөө тодорхойлж, хэрэгжүүлэхэд нь хяналт тавих боломжтой болсон байна.²⁷¹

АНУ-ын Шүүхийн захиргааны газар /*Administrative Office of the United States Courts*/-ын Гүйцэтгэх хороо /*Executive Committee*/ нь Конгрессын баталсан төсөвт тулгуурлан Үндэсний шүүхийн санхүүгийн төлөвлөгөөг боловсруулан санхүүгийн жилийн эхэнд баталдаг. Шүүхүүдийн захиргааны газар нь Шүүхийн бага хурлаар баталсан төсвийн төслийн саналыг Удирдлага болон төсвийн алба /*Office of Management and Budget*/-нд 10 дугаар сард буюу санхүүгийн жилийн эхэнд явуулж, шүүхийн төсвийг Ерөнхийлөгч Конгресст өргөн барих нэгдсэн төсөвт тусгуулдаг байна. Үүний дараа Ерөнхийлөгчийн өргөн барьснаар Конгресс баталдаг. Төсвийн удирдлагын газар нь Шүүхүүдийн захиргааны газраас ирүүлсэн төсвийн саналыг өөрчлөлт оруулалгүйгээр өргөн мэдүүлдэг байна.²⁷² 2013 оны байдлаар АНУ-ийн шүүхийн төсөв нь үндэсний нийт төсвийн 1 хувь /36.5 тэрбум доллар/-ийг эзэлж байна.²⁷³ /Хүснэгт 1/

Хүснэгт 1 АНУ-ын шүүхийн төсөв (тэрбум ам.доллар-аар):

Салбар	Өргөн мэдүүлсэн төсвийн санал	Зайлшгүй шаардлагатай төсвийн хэмжээ	Нийт	Нийт хувиар
Хууль зүйн салбар	23.9	12.7	36.5	1.0%

2. Оросын Холбооны Улс:

ОХУ-ын Үндсэн хуулийн 124 дүгээр зүйлд шүүхийн төсвийг зөвхөн холбооны улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан байдаг. Түүнчлэн шүүхийн төсвийн асуудлыг ОХУ-ын Холбооны төсвийн тухай хууль, Шүүхийг санхүүжүүлэх тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулдаг. ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, Арбитрын дээд шүүхийн үйл ажиллагааг хангахын тулд Холбооны төсвийн тухай хуульд төсвийн бие даасан байдлыг хангах тухай эрх зүйн зохицуулалтыг оруулсан. Тухайлбал, шүүхүүдийн тухайн жилийн санхүүгийн, эсхүл дараагийн жилийн баталсан төсвийг танах бол зөвхөн ОХУ-ын Шүүхийн зөвлөлийн зөвшөөрөлтэйгээр

²⁷¹ УИХ-ын тамгын газар Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв, “Төсвийн харилцааны зохицуулалт, бусад орнуудын туршлага, хараат бус, бие даасан байгууллагуудын төсвийн харилцаа, өнөөгийн байдал” харьцуулсан судалгаа, Улаанбаатар, 2009 он. 16-17 дахь тал.

²⁷² https://bulk.resource.org/courts.gov/ao/Understanding_Judiciary_Budget_Process.pdf (2014-10-10)

²⁷³ http://en.wikipedia.org/wiki/2013_United_States_federal_budget (2014-10-10)

5-аас илүүгүй хувийг хасах, мөн дээрх байгууллагууд нь төсвөө бие даан зарцуулах зэрэг зохицуулалтыг тусгасан байдаг. Түүнчлэн ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, Арбитрын дээд шүүх зохион байгуулалт, санхүү, материаллаг болон техник хангамжийн хувьд бусад байгууллагаас хараат бус байх, энэ төсвийг бие даан зарцуулах зохицуулалтыг ОХУ-ын Үндсэн хууль, Холбооны улсын төсвийн тухай хуульд тусгасан бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн төсвийн дүнг өмнөх жилийн дүнгээс хасаж, бууруулж болохгүй талаар мөн тусгажээ.

ОХУ-ын Засгийн газар, Шүүхийн дээд зөвлөлийн даргатай хамтран тухайн жилдээ дараагийн жилийн шүүхийн санхүүжилтийн төсвийн төслийг боловсруулдаг. Улмаар ОХУ-ын Төрийн дум шүүхийн төсвийг баталдаг. Хэрэв төслийг боловсруулахад саналын зөрүү гарах тохиолдолд Засгийн газар төсөлдөө шүүхийн төсөвтэй холбогдох төслийн саналыг хавсаргаж өгөх ёстой байдаг.²⁷⁴ ОХУ-ын 1998 оноос 2004 оны хооронд шүүхийн төсвийн зарцуулалтыг нийт улсын төсөвт үзүүлж байгаа хувиар харуулбал:²⁷⁵ 1998 онд 0,9%, 2000 онд 1,0%, 2002 онд 1,0%, 2003 онд 1.1%, 2004 онд 1,2% тус тус эзэлсэн бөгөөд 2012 онд 2.1% болж өсчээ.

3. Канад Улс:

Үндсэн хуулийн акт */The Constitution Act, 1867/* болон Дээд шүүхийн акт */Supreme court act/*-аар Канад улсын шүүхийн бие даасан байдал, төсвийн харилцааг зохицуулсан.²⁷⁶ Канад улсын Холбооны шүүхийн комиссарын газар */Office of the Commissioner for Federal Judicial Affairs Canada/* нь Хууль зүйн яаманд ажлаа тайлагнадаг ба шүүхийн бие даасан байдлыг хангах баталгааг хэрэгжүүлдэг ба шүүгчид албан үүргээ Хууль зүйн яамнаас хамааралгүйгээр хэрэгжүүлдэг. Энэ газар нь Канадын Шүүхийн зөвлөлийн */Judicial Council/* төсвийн төслийг боловсруулдаг.²⁷⁷ Шүүхийн төсвийг батлахад Засгийн газар нөлөө үзүүлэх хэмжээнд оролцдоггүй. Шүүх нь төсвөө боловсруулж Холбооны Улсын Засгийн газрын Сангийн хороо */Treasury Board/*-нд өргөн мэдүүлдэг. Шүүх нь өөрөө бус харин Засгийн газар нь улсын төсвийн зарцуулалтыг татвар төлөгчид тайлагнадаг. Засгийн газар нь санхүүгийн эрх мэдлээ ашиглан шүүхийн шүүн таслах ажиллагаанд нөлөөлөх гэж оролддоггүй байна.²⁷⁸ Шүүхийн төсвийг Парламент нь баталдаг.²⁷⁹

4. Бүгд Найрамдах Итали Улс:

Итали Улсад шүүхийн үйл ажиллагааны зардал улсын төсвөөс гардаг ба Шүүхийн дээд зөвлөлийн эрх хэмжээнээс бусад зохион байгуулалт болон захиргаатай холбоотой бүхий л үйл ажиллагааны төсвийн асуудлыг Хууль зүйн сайд хариуцдаг. Хууль зүйн яам болон Сангийн яам шүүхийн төсвийг боловсруулж, Парламентад өргөн барьдаг. Яамд нь шүүх тус бүрээр нь төсвийг хуваарилж, зохицуулдаг. Үндсэн хуулийн шүүх нь өөрөө бие дааж төсвөө боловсруулж,

²⁷⁴ http://uristprosto.ru/?page_id=141 (2014-10-10)

²⁷⁵ http://www.telenir.net/delovaja_literatura/gosudarstvennye_i_municipalnye_finansy/p8.php (2014-10-13)

²⁷⁶ http://www.venice.coe.int/wccj/rio/papers/can_binnie_e.pdf (2014-10-17)

²⁷⁷ <http://www.fja.gc.ca/home-accueil/index-eng.html> (2014-10-17)

²⁷⁸ Fabien Gйlinas, "Judicial Independence in Canada: A Critical Overview" in Anja Seibert-Fohr, ed., *Judicial Independence in Transition – Strengthening the Rule of Law in the OSCE Region* (Heidelberg: Springer)

http://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=1577842 (2014-10-18)

²⁷⁹ http://www.cba.org/cba/groups/pdf/judicialcomp_general3.pdf (2014-10-19)

Парламентаар батлуулахаар өргөн барьдаг.²⁸⁰ Шүүхийн төсвийн тухай хуулийг батлах процесс нь хууль батлах процесстэй адил ба тус хуулийн төслийг Засгийн газар өргөн мэдүүлж Итали Улсын Парламент баталдаг.²⁸¹ Итали Улс 2010 онд бүх шүүхүүдэд 3,051,375,987 евро хуваарилж өгсөн байна. Энэ нь хууль зүйн туслалцаа болон прокурорын зардал ороогүй мөнгөн дүн юм.²⁸²

5. ХБНГУ:

ХБНГУ-д Холбооны төсвийн тухай хууль тогтоомжоор шүүхийн төсвийг зохицуулдаг. Засгийн газрын төвшинд бүх шүүхийн барилга, тоног төхөөрөмж, туслах ажилтнуудын зардал, төсвийн хуваарилалтыг хариуцдаг. Жилийн төсвийн тооцоог Холбооны засгийн газрын төвшинд Хууль зүйн яам бэлтгэж танилцуулдаг байна. Төсвийг Засгийн газар хэлэлцэж баталсны дараа Парламент нэг бол өөрчлөлт оруулж, нэг бол эцэслэн баталдаг. Харин Үндсэн хуулийн шүүх нь төсвөө өөрөө боловсруулж, Сангийн Яамаар дамжуулан Засгийн газарт өгч батлуулан, Засгийн газар нь Парламентаар эцэслэн батлах төсвийг өргөн барьдаг байна.²⁸³

6. Швед Улс:

Швед Улсын Шүүхийн захиргаа /Domstolsverket/ болон Засгийн газар зөвшилцөн шүүхийн төсвийн хуваарилалтын асуудлыг шийдвэрлэдэг. Шүүхийн захиргаа нь Засгийн газарт төсвийн удирдлагын талаар тайлагнах ёстой байдаг. Засгийн газрын шийдвэрээр Шүүхийн захиргааны гишүүдийг томилдог тул шүүхийн төсвийг батлахад тодорхой хэмжээгээр Засгийн газар оролцож, улмаар Швед Улсын Парламент шүүхийн төсвийг баталдаг байна.²⁸⁴

Хүснэгт 3 *Швед Улсаас жил бүр батлан гаргадаг шүүхийн нийт төсөв болон улсын төсөвт эзлэх хувь:*

Шүүхийн төсөв, хуваарилалт	Төсөв /Евро/	Төсөв еврогоор /Нэг хүн амд ногдох/	Засгийн газрын нийт зардалд эзлэх %
Бүх шатны шүүхийн үйл ажиллагаанд хуваарилсан жилийн нийт батлагдсан төсөв	557,260,358	59.2	0.30%
Төрөөс жил бүр (нийт) цалинд хуваарилсан төсөв	394,206,713	41.9	0.22%
Төрөөс жил бүр мэдээллийн автоматжуулалтад хуваарилсан төсөв (тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ)	13,108,158	1.4	0.01%

²⁸⁰ <https://www.ucl.ac.uk/constitution-unit/research/judicial-independence/judicial-independence-in-europe.pdf> (2014-10-20) 32 дахь тал.

²⁸¹ <http://blogs.loc.gov/law/2013/06/the-italian-legislative-procedure/> (2014-10-20)

²⁸² The functioning of judicial systems and the situation of the economy in the European Union Member States, 296 дахь тал.

Цахим холбоос http://ec.europa.eu/justice/effective-justice/files/cepej_study_justice_scoreboard_en.pdf (2014-10-21)

²⁸³ <https://www.ucl.ac.uk/constitution-unit/research/judicial-independence/judicial-independence-in-europe.pdf> (2014-10-21)

²⁸⁴ <https://www.ucl.ac.uk/constitution-unit/research/judicial-independence/judicial-independence-in-europe.pdf> (2014-10-21)

Төрөөс жил бүр шүүхийн байгууламжид хуваарилсан төсөв (засвар үйлчилгээ, үйл ажиллагааны зардал)	78,077,930	8.3	0.04%
Төрөөс жил бүр сургалт, судалгаа, боловсролд хуваарилагдах төсөв	6,873,752	0.7	0.00%

Шүүхийн нэгдсэн төсөв нь 4.064.159.050 евро байна. Үүнд шүүхийн төсөв, хууль зүйн туслалцаа үзүүлэх зардал, прокурор, хорих байгууллагын зардал, үйлчилгээ, насанд хүрээгүй этгээдийн хамгаалах зардал болон бусад төсвийн зардлыг багтаадаг.

Хэдийгээр тус лавлагаанд цөөн тооны улсыг жишээ болгон судалсан²⁸⁵ хэдий ч ерөнхий чиг хандлагаас нь харахад гадаад улсууд шүүхийн төсвийг боловсруулах, төлөвлөх зэргээрээ өөр хоорондоо ялгаатай байна. Түүнчлэн тухайн улс орон шүүх эрх мэдэлдээ хэр их төсвийг хуваарилдаг, энэ нь тухайн улс орны нийт жилийн төсвийн хэдэн хувийг эзэлдэг зэрэг үзүүлэлтийг тухайн улсын шударга ёсны хэмжүүр болгож авч үздэг байна. Ийнхүү шүүхийн төсөв тухайн улс орны төсвийн хэдэн хувийг эзэлдэг талаар Европын холбооны улсуудын тоон мэдээллийг График 1-д харуулав.²⁸⁶




²⁸⁵ Шүүхийн төсөв батлахтай холбоотой бусад улсын туршлага болон холбогдох мэдээллийг ШСМСХ-гээс 2013 онд гүйцэтгэсэн “Шүүхийн төсвийг батлах: Шүүхийн хараат бус байдлыг хангах нь” лавлагаанаас үзнэ үү.

Цахим хаяг: <http://www.judoinstitute.mn/content/7976.shtml?sel=4008&subsel=4328&type=0> (2014-10-21)

²⁸⁶ http://ec.europa.eu/justice/effective-justice/files/cepej_study_justice_scoreboard_en.pdf (2014-10-22)

График 1



-oOo-

Хавсралт

“Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь цагдан хорих арга хэмжээ ба хүний эрх, тулгамдсан асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмж

2014 оны 6 дугаар сарын 9

Улаанбаатар хот

Халдашгүй, чөлөөтэй байх нь хүний төрөлхөөс заяасан эрх мөн бөгөөд хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баривчлах, цагдан хорихыг олон улсын болон үндэсний эрх зүйгээр хориглодог билээ. Хүний эрх, эрх чөлөөнд халдаж буй аливаа ажиллагаа хангалттай үндэслэл, нотлох баримтад тулгуурлаж, хууль, шударга ёсонд нийцсэн байхыг тэмдэглэж, “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь цагдан хорих арга хэмжээ ба хүний эрх, тулгамдсан асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгээс дараах зөвлөмжийг гаргаж байна:

1. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, өмгөөлөгч Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд цагдан хорих арга хэмжээг хэрэглэхдээ хүний эрх, хууль ёсыг дээдлэх, хуульд заасан үндэслэл, журмыг заавал баримтлах, хараат бус байх, мэргэжлийн ёс зүйг чанд сахих.
2. Хүнийг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур баривчлах, цагдан хорих, удаан хугацаагаар хорьж цагдах зэргээр хүний эрхийг зөрчиж байгаа байдлыг таслан зогсоохын тулд Хууль зүйн яамнаас Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлийн 68.1, 68.2 дахь хэсэгт заасан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлийг олон улсын нийтлэг жишиг, өөрийн орны шүүхийн үйл ажиллагаанд тогтож, хэвшсэн эерэг өөрчлөлтийг тусгаж, нарийвчлан зохицуулсан төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барих.
3. Шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авах, сунгах тухай хүсэлтийг шийдвэрлэхдээ прокурор, өмгөөлөгчийн тайлбар, хүсэлтийг сонсох, мэтгэлцэх нөхцлөөр хангах, холбогдох нотлох баримтыг шинжлэн судлах, хууль ёсны нотлох баримтын хүрээнд хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гаргах зэргээр зайлшгүй ажиллагааг явуулж хэвших.
4. Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд хуулийн дагуу мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, зохих цаг хугацаанд хүсэлт, гомдол, тайлбар, нотлох баримт гаргах, шүүхийн ажиллагаанд биечлэн оролцох зэргээр үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг тууштай хамгаалах.
5. Гэм буруу нь шүүхээр тогтоогдоогүй тохиолдолд аливаа этгээд, тэр дундаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн үйлдэл, гэм буруугийн талаар олон нийтэд мэдээлэх, хэвлэлийн бага хурал хийх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрхийг зөрчих, шүүхэд хөндлөнгөөс нөлөөлөх үр дагавартай тул ийм үйлдэл хийхгүй байх.
6. Гэмт хэргийг хянан шийдвэрлэх болон Хууль сахиулах үйл ажиллагааны хуулийн төслүүдэд цагдан хорих арга хэмжээнээс өмнө хэрэглэж болох

- таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, хэлбэрийг олшруулах, журам заавар зэрэг эрх зүйн актаар зохицуулж байгаа үйл ажиллагааг хуульчлах.
7. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дээр цагдан хорих асуудлыг дагнан хариуцаж байгаа шүүгчдийн тоог нэмэгдүүлж, тойргоор хуваарилах журамд шилжих.
 8. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс цагдан хорих арга хэмжээг хэрэглэж буй шүүхийн практикт судалгаа, үнэлгээ хийж, үр дүнг шүүгч, өмгөөлөгч, прокурор, судлаач эрдэмтэн, олон нийтэд мэдээлж байх.
 9. Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын 2008 онд хамтран баталсан “Баривчлах, цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай” журам хуульд нийцэж байгаа болон хуулиар тогтоосон хэм хэмжээнээс илүү хүчин чадалтай үйлчилж байгаа эсэхийг нягтлан үзэж, шаардлагатай өөрчлөлтийг тусгах.
 10. Цагдан хоригдогчийн хорих үндэслэлийг шалгах шийдвэр *Writ of Habeas Corpus*-т гаргасан хүсэлтийг шүүх хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн шуурхай шийдвэрлэх.
 11. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагчтай зүй бус харьцах, эрүүдэн шүүх явдлаас сэргийлэхийн тулд олон улсын жишгийн дагуу гомдол гаргах, шийдвэрлэх бодитой хамгаалалтыг процессын эрх зүйгээр хангаж мөрдүүлэх.
 12. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран 2005 онд баталсан “Цагдан хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх” тухай журмыг нийслэл дэх цагдан хорих төв, баривчлах байр, аймаг, орон нутгийн цагдан хорих, баривчлах байр зэрэг цагдан хорих бүхий л газруудад хэрэгжүүлэх, хэрэгжилтэд ШШГЕГ болон Эрүүл мэндийн яамнаас тогтмол хяналт, мониторинг хийж, цагдан хоригдогсдын эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах.

Хэлэлцүүлэгт оролцогчид:

- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Шүүгчдийн төлөөлөл
- Хүний эрхийн үндэсний комисс
- Хууль зүйн яам
- Улсын ерөнхий прокурорын газар
- Цагдаагийн ерөнхий газар
- Монголын Хуульчдын холбооны Өмгөөлөгчдийн хороо
- Авлигатай тэмцэх газар
- Эрдэмтэн судлаачид
- Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл

-оОо-